


ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ



(ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ, НИЙТЛЭЛ)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

1993 оны 6, 9-р сар № 4-5 (15-16)

ГАРЧИГ

1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Гадаададаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсынсын хууль 447.

Хуулуулль хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсынсын хууль 457.

Эрүүүүүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухакахай Монгол Улсын хууль 458.

Монгонгол Улсын Патентын тухай хууль 479.

Хуулуулийн зарим хэсэг, зарлиг хүчингүй болсонд тооцоцох тухай Монгол Улсын хууль 490.

Монгонгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хууль 490.

Хуулуулийн зарим хэсгийг хүчингүй болсонд тооцоцох тухай Монгол Улсын хууль 501.

Шудуударга бус өрсөлдөөнийг хориглох тухай Монгонгол Улсын хууль 501.

Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт өөрчөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 508.

Монгонгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалтгалын хууль 514.

Эрүүүүлийг хамгаалах хуулийн зарим заалтыг хүчүүчингүй болгох, өөрчлөлт оруулах тухай Монгонгол Улсын хууль 521.

12. Улсын хилийг хамтран шалгахад баримтлах чиглэлийн тухай Монгол Улсын хууль 521.

13. Монгол Улсын 1993 оны улсын төвлөрсөн төсөвт тодотгол хийх тухай хууль 522.

14. Монгол Улсын Гаалийн хуульд нэмэлт оруулах тухай хууль 524.

15. Монгол Улсын Тэмдэгтийн хураамжийн хууль 525.

16. Иргэний байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 535.

17. Хууль, зарлиг, тэдгээрийн болон дүрмийн заалт хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль 537.

18. Монгол Улсын Хилийн тухай хууль 538.

19. Хууль хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын хууль 555.

20. Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын хуульд нэмэлт оруулах тухай хууль 556.

21. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын хууль 557.

22. Монгол Улсын Батлан хамгаалахын тухай хууль 558.

2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

23. Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн тухай N59 568.

24. Шүүхийг өөрчлөн байгуулсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай N60 572.

25. Төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай N61 574.

26. Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай N62 575.

27. Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулж авах арга хэмжээний тухай N63 576.

28. Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай N64 577.

29. Ажлын хэсэг байгуулах тухай N65 578.

30. Хүний эрхийн дэд хороо байгуулах тухай N66 579.

31. Хээл хахуул авах, албан тушаалаа урвуулан ашиглах явдалтай тэмцэх дэд хороо байгуулах тухай N67 580.

32. Өмч хувьчлах тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай N68 581.

3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

33. Б.Дашцэрэнг элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай N1 583.

34. Б.Должинцэрэнг элчин сайдаар томилох тухай N2 583.

35. Шүүгчийн тангараг өргөх журмыг батлах тухай N3 584.

36. Г.Бахдалыг улсын ерөнхий прокурорын албан тушаалаас чөлөөлөх тухай N4 586.

37. Улсын Ерөнхий прокурорыг томилох тухай N5 586.

38. Ц.Сакейг найрамдал медалиар шагнах тухай N6 587.

39. Дээд шүүхийн дарга, орлогч дарга, коллегийн дарга, гишүүдийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай N7 587.

40. Улсын дээд шүүхийн шүүгчдийг томилох тухай N8 588.

41. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчдийг томилох тухай N9 589.

42. Б.Түмэнг албан тушаалаас нь чөлөөлөх тухай N11 589.

43. М.Энхсайханыг Тамгын газрын даргаар томилох тухай N12 590.

44. М.Одонхүүг албан тушаалаас нь чөлөөлөх тухай N13 590.

45. М.Алтанхуягийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай N14 591.

46. Зарим хүнд Монгол Улсын Гавьяат жүжигчин цол олгох тухай N16 591.

47. М.Цэрэнхандад Монгол Улсын Гавьяат багш цол олгох тухай N17 592.

48. М.Шатарыг "Шударга журам" медалиар шагнах тухай N18 592.

49. Цагдаагийн байгууллагын зарим хүнийг одон, медалиар шагнах тухай N19 593.

50. Ж. Энхнасанг Улсын ерөнхий прокурорын орлогчоор томилох тухай N20 594.

51. Дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай N21 595.

52. Аймаг, нийслэл, хот, тусгай шүүхийн болон хэсэг, дүүрэг, орон нутгийн хотын шүүхийн дарга, орлогч дарга, гишүүн, шүүгчдийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай N22 595.

53. Аймаг, нийслэл, Дархан, Эрдэнэт хотын давж заалдах шатны шүүхийн шүүгчид, сум, сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчдийг томилох тухай N23 599.

54. Давж заалдах шатны болон сум, сум дундын, дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчдийг томилох тухай N24 607.

55. Т.Лувсанцэрэнд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол олгох тухай N25 610.

56. Зарим хүнд Монгол Улсын Гавьяат зүтгэлтэн цол олгох тухай N26 611.

57. Төв аймгийн зарим хүнийг шагнах тухай N27 611.

58. Зарим хүнд Монгол Улсын Гавьяат зүтгэлтэн цол олгох тухай N28 621.

59. Хэнтий аймгийн зарим хүнийг шагнах тухай N29 622.

60. Зарим хүнийг "Шударга журам" медалиар нэхэн шагнах тухай N30 626.

61. Зарим хүнийг медалиар шагнах тухай N31 627.

62. Түр зөвлөлийн дүрэм, бүрэлдэхүүнийг батлах тухай N32 628.

63. Дайн, байлдаанд оролцсон ахмад дайчдын талаар авах арга хэмжээний тухай N33 635.

64. Б.Намжилд Монгол Улсын Хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч цол олгох тухай N34 636.

65. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай N35 637.

66. Ш.Цэрэнхүүг "Алтан гадас" одонгоор шагнах тухай N36 638.

67. Ц.Жамсран, Ж.Мягмар нарыг Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнах тухай N37 638.

68. Тогтоол батламжлах тухай N38 639.

69. Б.Доржсамбуу д Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол олгох тухай N39 639.

70. Зарим хүнд Монгол Улсын Гавьяат зүтгэлтэн цол олгох тухай N40 640

71. Завхан аймгийн зарим хүнийг шагнах тухай N41 640.

72. Зарим хүнд Монгол Улсын Гавьяат зүтгэлтэн цол олгох тухай N42 649.

73. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай N43 650.

74. Т.Сугарт Монгол Улсын Гавьяат нисгэгч цол олгох тухай N46 654.

75. Эрдэнэ-Очирт Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн цол олгох тухай N47 655.

76. Хилийн цэргийн зарим хүнийг одон, медалиар шагнах тухай N48 655.

77. Монгол Улсын Зэвсэгт хүчний ерөнхий штабын даргыг томилох тухай N49 663.

78. Тусламж олгож байх тухай N50 664.

79. Цагдаагийн болон хорих ял эдлүүлэх байгууллагын талаар авах зарим арга хэмжээний тухай N51 664.

80. Ш.Юмжавыг элчин сайдаар томилох тухай N52 665.

81. Лувсандоржийн Мундагбаатарыг элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай N53 666.

82. Х.Бэхбатыг элчин сайдаар томилох тухай N54 666.

83. Лувсандоржийн Мундагбаатарыг элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлөх тухай N55 667.

84. Х.Бэхбатыг элчин сайдаар томилох тухай N56 667.

85. Зарим шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай N60 668.

86. Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай N61 668.

87. Зарим шүүхийн ерөнхий шүүгчийг томилох тухай N62 669.

88. Г.Эрдэнэжавыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай N65 670.

89. Ш.Батбаярыг "Алтан гадас" одонгоор шагнах тухай N66 670.

90. Д.Т.Цыремпиловыг "Найрамдал" медалиар шагнах тухай N69 671.

91. Дүрэм батлах тухай N73 671.

92. Зарлигийн заалтыг хүчингүй болсонд тооцох тухай N74 675.

93. Зарим шүүгчийг албан тушаалаас нь чөлөөлөх тухай N75 675

94. Зарим шүүхийн шүүгчийг томилох тухай N76 676

95. Ерөнхий шүүгчийг томилох тухай N77 677

96. Дүрэм батлах тухай N80 677

97. Журам батлах тухай N81 680

98. Д.Баттөмөр, Г.Алтанхуяг нарт Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн цол олгох тухай N82 682

99. А.Долгорт Монгол Улсын Гавьяат жүжигчин цол олгох тухай N83 683

100. Урлагийн байгууллагын зарим хүнийг одон, медалиар шагнах тухай N84 683

101. Лхасрангийн Пэрэнлэйд Монгол Улсын Хөдөлмөрийн баатар цол олгох тухай N85 684

102. Гомбын Дашнямд Монгол Улсын Гавьяат эмч цол олгох тухай N86 685

103. Агчбазарын Ёндондоржид Монгол Улсын Малын гавьяат эмч цол олгох тухай N87 686

104. Гэндэнгийн Батсүхэд Монгол Улсын Гавьяат зоотехникч цол олгох тухай N88 686

104. Мал аж ахуйн мэргэжилтэн зарим хүнийг одон, медалиар шагнах тухай N89 687

4. МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН СОЁРХОЛ ХҮРТЭЭХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

106. Монгол Улсын 1993 оны Төрийн соёрхол хүртээх тухай N03 698

5. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

107. Ажлын хэсэг байгуулж ажиллуулах тухай N30 700

6. НИЙТЛЭЛ, ТЭМДЭГЛЭЛ

108. Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулийн тухай /тайлбар зөвлөмж/ 702

109. Иргэдийн эрэлт хүсэлтийг сонсоход 711

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулан дэмжих, хөрөнгө оруулагчийн эрх, эд хөрөнгийг хамгаалах болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж

1.Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо

1."Гадаадын хөрөнгө оруулалт" гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр аж ахуйн нэгж байгуулах, эсхүл Монголын аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах зорилгоор гадаадын хөрөнгө оруулагчаас Монгол Улсад оруулж буй эд хөрөнгийн болон оюуны үнэт зүйлсийг хэлнэ.

2."Гадаадын хөрөнгө оруулагч" гэж Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж буй гадаадын хуулийн этгээд, хувь хүн /Монгол Улсад байнга оршин суудаггүй гадаадын иргэн болон харьяалалгүй хүн, түүнчлэн гадаадад байнга оршин суудаг Монгол Улсын иргэн/-ийг хэлнэ.

3."Монголын хөрөнгө оруулагч" гэж хөрөнгө оруулалт хийж буй монголын хуулийн этгээд, хувь хүн /Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суудаг гадаадын иргэн болон харьяалалгүй хүн/-ийг хэлнэ.

4 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалт хийх хүрээ

1.Монгол Улсын хууль тогтоомжоор хориглосон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхээс бусад хүрээнд гадаадын хөрөнгө оруулалт хийж болно.

2.Монгол Улсын хууль тогтоомжоор үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхийг хориглосноос бусад нутаг дэвсгэрт гадаадын хөрөнгө оруулалт хийж болно.

5 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын төрөл

Гадаадын хөрөнгө оруулагч дараахь төрлийн хөрөнгө оруулалт хийж болно:

1/чөлөөтэй хөрвөх валют, хөрөнгө оруулалтын үр дүнд төгөрөгөөр олсон орлого;

2/хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө, тэдгээртэй холбогдсон эд хөрөнгийн эрх;

3/оюуны болон аж үйлдвэрийн өмчийн эрх.

6 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтыг хэрэгжүүлэх хэлбэр

Гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол Улсад дараахь хэлбэрээр хэрэгжүүлнэ:

1/гадаадын хөрөнгө оруулагч дангаараа аж ахуйн нэгж байгуулах, салбар нэгжээ нээн ажиллуулах;

2/гадаадын хөрөнгө оруулагч монголын хөрөнгө оруулагчтай хамтран аж ахуйн нэгж байгуулах;

3/гадаадын хөрөнгө оруулагч тус улсын аж ахуйн нэгжийн ногдол хувь, хувьцаа, бусад үнэт цаасыг, түүний дотор Монгол Улсын Өмч хувьчлах тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр худалдсан аж ахуйн нэгжийн ногдол хувь, хувьцаа, бусад үнэт цаасыг чөлөөтэй хөрвөх валютаар, эсхүл хөрөнгө оруулалтын үр дүнд төгрөгөөр олсон орлогоороо худалдаж авах замаар шууд хөрөнгө оруулалт хийж оролцох;

4/байгалийн баялгийг ашиглах, боловсруулах талаар хууль тогтоомж, гэрээний дагуу эрх олж авах.

7 дугаар зүйл. Хувьцаа, бусад үнэт цаас худалдаж авах

Гадаадын хөрөнгө оруулагч Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжийн хувьцаа, бусад үнэт цаасыг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу худалдан авч болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Гадаадын хөрөнгө оруулалтыг хамгаалах

8 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалтын эрх зүйн баталгаа

1.Гадаадын хөрөнгө оруулалт нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомж болон Монгол Улсын олон улсын гэрээгээр баталгаажсан эрх зүйн хамгаалалттай байна.

2.Гадаадын хөрөнгө оруулалтыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нийгэмчлэх, хууль бусаар хураан авахыг хориглоно.

3.Гадаадын хөрөнгө оруулагчийн хөрөнгийг гагцхүү нийтийн ашиг сонирхлын үүднээс, зөвхөн хуульд заасан журмын дагуу, ялгаварлан гадуурхахгүй байх зарчмын үндсэн дээр, бүрэн хэмжээгээр нөхөн төлөх нөхцөлөөр дайчлан гаргуулж болно.

4.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол дайчлан гаргуулсан эд хөрөнгийн нөхөн төлбөрийн хэмжээг түүнийг дайчлан гаргуулсан буюу дайчлан гаргуулах тухай нийтэд мэдэгдэх үеийн үнэлгээгээр тодорхойлно. Нөхөн төлбөрийг саадгүй гүйцэтгэнэ.

5.Монгол Улсад онц болон дайны байдал бий болсноос гадаадын хөрөнгө оруулагчид учирсан хохирлыг монголын хөрөнгө оруулагчтай адил нөхцөлөөр шийдвэрлэнэ.

9 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулагчдад олгох нөхцөл

Монгол Улс нь гадаадын хөрөнгө оруулагчдад оруулсан хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулахад Монголын хөрөнгө оруулагчдад олгодгоос дутуугүй тааламжтай нөхцөл олгоно.

10 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулагчийн эрх, үүрэг

1.Гадаадын хөрөнгө оруулагч дараахь эрх эдэлнэ:

1/эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, түүний дотор аж ахуйн нэгжийн дүрмийн санд хувь хөрөнгө болгон оруулсан эд хөрөнгөө гадаадад буцаан гаргах;

2/гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг удирдах буюу удирдахад оролцох;

3/бусад этгээдэд хууль тогтоомжийн дагуу эрх, үүргээ шилжүүлэх;

4/дараахь орлого, ашгаа гадаадад саадгүй гуйвуулах:

а/өөрт ногдох хувь хүртэгчийн орлого, хувьцааны ногдол ашиг;

б/эд хөрөнгө, үнэт цаасаа борлуулсан, эд хөрөнгийн эрхээ бусдад шилжүүлсэн болон аж ахуйн нэгжээс гарсан, түүнийг татан буулгаснаас өөрт нь ногдох орлого;

5/хууль тогтоомжид заасан бусад эрх.

2.Гадаадын хөрөнгө оруулагч дараахь үүрэг хүлээнэ:

1/Монгол Улсын хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

2/гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах тухай гэрээ, дүрмээр хүлээсэн үүргээ биелүүлэх;

3/байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4/Монголын ард түмний үндэсний ёс заншлыг хүндэтгэх.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа

11 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж

1.Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдсан, дүрмийн сангийн 20-иос доошгүй хувь нь гадаадын хөрөнгө оруулагчийн хувь хөрөнгөөс бүрдсэн аж ахуйн нэгжийг гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж гэнэ.

2.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь бүртгүүлсэн өдрөөсөө эхлэн Монгол Улсын хуулийн этгээд болох бөгөөд үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу явуулна.

12 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахыг зөвшөөрөх

1.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрлийг гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэх төрийн захиргааны төв байгууллага /цаашид "Худалдаа, үйлдвэрийн яам" гэх/ хөрөнгө оруулагчдын өргөдлийн үндсэн дээр олгоно.

2.Хөрөнгө оруулагчдын өргөдөлд дараахь зүйлийг тусгана:

1/хөрөнгө оруулагчдын нэр, хаяг, үндэсний харьяалал;

2/хөрөнгө оруулалтын төрөл, хэмжээ;

3/аж ахуйн нэгжийн хэлбэр;

4/хөрөнгө оруулах үндсэн салбар, эрхлэх үйлдвэр үйлчилгээ;

5/хөрөнгө оруулах, хэрэгжүүлэх үе шат, хугацаа.

3.Өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

1/хөрөнгө оруулагчдын тухай танилцуулга хуулийн этгээдийн гэрчилгээний хуулбар;

2/гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах тухай гэрээ;

3/гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дүрэм;

4/хөрөнгө оруулалттай холбогдолтой маркетинг, менежмент, технологийн болон бусад хэлэлцээр;

5/техник, эдийн засгийн тооцоо;

6/хөрөнгө оруулагчдын төлбөрийн чадварын тухай үйлчлэгч банкны нотолгоо;

7/байгалийн баялаг эрж хайх, олборлох, боловсруулах, газар ашиглах болон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхэлбэл зохих үйлдвэрлэл, үйлчилгээний талаар Монгол Улсын эрх бүхий байгууллагуудын зөвшөөрөл.

4.Өргөдлийг, түүнд хавсаргасан баримт бичгийн хамт хүлээн авсан өдрөөс хойш 60 хоногийн дотор мэргэжлийн байгууллагуудын дараахь дүгнэлтийн үндсэн дээр Худалдаа, үйлдвэрийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ:

1/хууль тогтоомжид нийцэж буй эсэх;

2/байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл;

3/эрүүл ахуйн шаардлагад нийцэж буй эсэх;

4/технологийн түвшингийн үнэлгээ.

5.Энэ зүйлийн 4 дэх хэсгийн 2,3-т заасан дүгнэлтийг гаргахдаа олон улсын болон Монгол Улсын стандартыг баримтална.

6.Энэ зүйлийн 4 дэх хэсгийн 4-т заасан дүгнэлтийг Монгол Улсын Засгийн газраас баталсан журмын дагуу гаргана.

7.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахыг зөвшөөрвөл Худалдаа, үйлдвэрийн яам гэрчилгээ олгоно.

8.Гадаадын хөрөнгө оруулалттай байгуулах аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа Монгол Улсын хууль тогтоомж, байгаль орчин, эрүүл ахуйн болон технологийн шаардлагад нийцэхгүй гэж үзвэл зохих үндэслэлийг тодорхойлж зөвшөөрөл олгохоос татгалзана.

9.Энэ зүйлд заасан хөрөнгө оруулагчдын өргөдөл, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахыг зөвшөөрсөн гэрчилгээний загварыг Худалдаа, үйлдвэрийн сайд батална.

10.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж дүрмийн сан, гэрээ, дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулах бол энэ тухай 30 хоногийн өмнө Худалдаа, үйлдвэрийн яаманд мэдэгдэнэ. Худалдаа, үйлдвэрийн яам дээрх нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг энэ зүйлд заасны дагуу хянаж 30 хоногийн дотор шийдвэрлэнэ.

13 дугаар зүйл. Эд хөрөнгө, оюуны үнэт зүйлсийг үнэлэх

1.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дүрмийн санд хөрөнгө оруулагчдаас оруулах эд хөрөнгө, оюуны үнэт зүйлсийг чөлөөтэй хөрвөх валютаар болон төгрөгөөр үнэлгээний адил зарчим баримтлан хөрөнгө оруулагчид харилцан тохиролцож үнэлнэ.

2.Төгрөгийг Монгол банкнаас тогтоосон тухайн үеийн ханшийг баримтлан чөлөөт валютад хөрвүүлж тооцно.

14 дүгээр зүйл. Худалдаа, үйлдвэрийн яамны гадаадын хөрөнгө оруулалтын бодлогыг хэрэгжүүлэхтэй холбогдсон бүрэн эрх

Худалдаа, үйлдвэрийн яам гадаадын хөрөнгө оруулалтын бодлогын талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих;

2/гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах асуудлаар холбогдох мэргэжлийн байгууллагуудаар энэ хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан дүгнэлт гаргуулах ажлыг зохион байгуулах;

3/гадаадын хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл зарлах, шалгаруулах;

4/гадаадын хөрөнгө оруулагчдын хэрэгжүүлэхээр санал болгосон төслүүдэд сонгон шалгаруулалт хийх;

5/гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахыг зөвшөөрөх, эсхүл татгалзах;

6/гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр буюу бүрмөсөн зогсоох;

7/хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

15 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг бүртгэх

1.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг Худалдаа, үйлдвэрийн яамнаас олгосон гэрчилгээг үндэслэн Улсын татварын ерөнхий газар бүртгэж, нийтэд мэдээлнэ.

2.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дүрмийн сан, гэрээ, дүрэмд орсон нэмэлт, өөрчлөлтийг Худалдаа, үйлдвэрийн яамнаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр Улсын татварын ерөнхий газар бүртгэнэ.

16 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсоох

1.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг Монгол Улсын аж ахуйн нэгжийн тухай хуульд заасан үндэслэлээр зогсооно.

2.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь энэ хуулийн 12 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан дүгнэлтийн аль нэгийг зөрчиж байгаа нь нотлогдвол Худалдаа, үйлдвэрийн яам уул аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг түр буюу бүрмөсөн зогсоож болно.

17 дугаар зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг татан буулгах

1.Үйл ажиллагаа нь зогссон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж энэ тухай шийдвэрийг уул шийдвэр гарснаас хойш 14 хоногийн дотор Худалдаа, үйлдвэрийн яаманд ирүүлнэ.

2.Татан буугдаж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь төлбөр тооцоог бүрэн дуусгасан, байгаль орчныг нөхөн сэргээх үүргээ Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэсэн тухай холбогдох байгууллагын баталгааг Худалдаа, үйлдвэрийн яаманд ирүүлнэ.

3.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж татан буугдаж байгаа бол Худалдаа, үйлдвэрийн яам уул аж ахуйн нэгжийг байгуулахыг зөвшөөрсөн зөвшөөрлөө хүчингүй болгож, энэ тухай Улсын татварын ерөнхий газарт мэдэгдэнэ.

4.Улсын татварын ерөнхий газар энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэдэгдлийг үндэслэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг улсын бүртгэлээс хасч, нийтэд мэдээлнэ.

5.Татан буугдаж байгаа гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж эцсийн тооцоо хийж дууссаны дараа гадаадын хөрөнгө оруулагч энэ хуулийн 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан орлого, ашгаа гуйвуулж болно.

18 дугаар зүйл. Татвар ногдуулах

1.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу татвар ногдуулна.

2.Гадаадын хөрөнгө оруулагчдад болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид Монгол Улсын татварын хууль тогтоомжид зааснаас илүү таатай нөхцөл олгох асуудлыг энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаар шийдвэрлэнэ.

19 дүгээр зүйл. Гаалийн болон худалдааны албан татвараас чөлөөлөх

1.Худалдаа, үйлдвэрийн яамнаас гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулахыг зөвшөөрсөн өдрөөс эхлэн гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн дүрмийн санд оруулах технологийн тоног төхөөрөмжид гаалийн болон худалдааны албан татвар ногдуулахгүй.

2.Худалдаа нийтийн хоолноос бусад салбарын гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн зориулалтаар оруулах түүхий эд, материал, эд анги, сэлбэг хэрэгсэлд тухайн аж ахуйн нэгж Улсын татварын ерөнхий газарт бүртгүүлсэн өдрөөс эхлэн 5 жилийн хугацаанд гаалийн албан татвар ногдуулахгүй.

20 дугаар зүйл. Орлогын албан татварын хөнгөлөлт

1.Дараахь салбар дахь гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн өдрөөс орлогын албан татварын дор дурдсан хөнгөлөлт үзүүлнэ:

1/цахилгаан, дулааны станц, цахилгаан, дулаан дамжуулах шугам сүлжээ, авто, төмөр зам, агаарын тээврийн болон инжене-

рийн барилга байгууламж, телекоммуникацийн үндсэн сүлжээний салбарт 10 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө;

2/үнэт металлаас бусад эрдсийн түүхий эд, нефть, хатуу түлш олборлох, боловсруулах, металлург, хими, төмөрлөг, машины үйлдвэрлэл, электроникийн салбарт 5 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 5 жилд 50 хувиар хөнгөлнө.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт дурдсанаар бусад салбарт байгуулагдсан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийхээ 50-иас дээш хувийг экспортолж байвал тухайн аж ахуйн нэгжийг орлогын албан татвараас 3 жилийн хугацаанд чөлөөлж, дараагийн 3 жилд 50 хувиар хөнгөлнө.

3.Энэ зүйлд дурдаагүй салбарт байгуулагдах гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид орлогын албан татварын хөнгөлөлт үзүүлж болно. Уул асуудлыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тухай бүр шийдвэрлэнэ.

4.Гадаадын хөрөнгө оруулагч өөрт ногдох орлогоос тухайн аж ахуйн нэгжид дахин хөрөнгө оруулалт хийвэл оруулсан хөрөнгийн хэмжээгээр уул аж ахуйн нэгжийн албан татвар ногдуулах орлогыг багасгаж тооцно.

5.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хэд хэдэн салбарыг хамарч байвал уул нэгжид үзүүлэх орлогын албан татварын хөнгөлөлтийг үйл ажиллагааны үндсэн салбараар нь тодорхойлно.

6.Монгол Улсын Өмч хувьчлах тухай хуулийн дагуу хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр худалдсан аж ахуйн нэгжийн ногдол хувь, хувьцаа, бусад үнэт цаасыг худалдаж авах хэлбэрээр байгуулагдах гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид энэ зүйлийн 1,2 дахь хэсэгт заасан хөнгөлөлт, чөлөөлөлт хамаарахгүй.

21 дүгээр зүйл. Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулах

1.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газрыг Монгол Улсын газрын тухай хууль тогтоомжид заасан болзол, журмын дагуу төлбөртэйгээр, гэрээний үндсэн дээр ашиглуулна.

2.Гэрээнд газар ашиглуулах нөхцөл, хугацаа, байгаль орчны унаган төрхийг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ, газар ашигласны төлбөр, хоёр талын хүлээх хариуцлагыг тусгана.

3.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулах гэрээг дараахь журмаар байгуулна:

1/Монгол Улсад гадаадын хөрөнгө оруулагч дангаараа байгуулсан аж ахуйн нэгжид төрийн өмчийн газар ашиглуулах гэрээг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Тэр-

гүүлэгчдийн зөвшөөрснөөр Монголын талын өмчлөгч гадаадын хөрөнгө оруулагчтай;

2/монголын хөрөнгө оруулагч оролцсон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид төрийн өмчийн газар ашиглуулах гэрээг тухайн шатны иргэдийн Төлөөгчдийн Хурал болон Тэргүүлэгчдийн зөвшөөрснөөр Монголын талын өмчлөгч уул аж ахуйн нэгжийн удирдлагатай;

3/монголын хөрөнгө оруулагч оролцсон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид хувийн өмчийн газар ашиглуулах гэрээг төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр уул газрын өмчлөгч гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн удирдлагатай.

4.Энэ зүйлийн 3 дахь хэсгийн 2,3-т заасан гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн удирдлагын байгуулсан газар ашиглах гэрээнээс үүсэх хариуцлагыг монголын хөрөнгө оруулагч болон гадаадын хөрөнгө оруулагч аж ахуйн нэгжийн дүрмийн санд оруулсан хувь хөрөнгөтэйгээ тэнцүү хувь хэмжээгээр хүлээнэ.

5.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид газар ашиглуулах гэрээний үндсэн хугацаа тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа явуулах хугацаагаар тодорхойлогдоно. Газар ашиглах гэрээний үндсэн хугацаа эхний ээлжинд 60 жилээс илүүгүй байна. Газар ашиглуулах гэрээний хугацааг гэрээнд заасан анхны нөхцөлөөр нэг удаа 40 хүртэл жилээр сунгаж болно.

6.Газар ашиглуулах гэрээний хугацаа дуусахаас өмнө гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж татан буугдсан бол газар ашиглуулах гэрээний хугацаа нэгэн зэрэг дуусгавар болно.

7.Улсын тусгай хэрэгцээг үндэслэн газрыг солих буюу эгүүлэн авч болно. Энэ тухай шийдвэрийг гагцхүү Засгийн газар гаргана. Үүний улмаас гадаадын хөрөнгө оруулагчид учирсан хохирлын нөхөн төлбөрийг саадгүй гүйцэтгэнэ. Нөхөн төлбөрийн хэмжээг газрыг солих буюу эгүүлэн авах үеийн үнэлгээг үндэслэн тодорхойлно.

8.Газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль орчин, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал газар ашиглуулах гэрээг цуцална.

22 дугаар зүйл. Санхүү, зээл, бүртгэл, хяналт

1.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь санхүү, татвар, зээл, тооцоо, валютын гүйлгээтэй холбогдолтой үйл ажиллагаагаа Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу явуулна.

2.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцлээ Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хөтөлнө.

3.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн санхүүгийн болон арилжааны үйл ажиллагааг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу улсын санхүүгийн хяналтын байгууллага, эсхүл хяналтын зохих эрх бүхий хөндлөнгийн байцаагч хянан шалгана. Шаардлагатай гэж үзвэл гадаадын хөндлөнгийн хяналтын байгууллагыг оролцуулж болно.

23 дугаар зүйл. Даатгал

Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж нь Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Монголын даатгалын байгууллагад даатгуулж болно.

24 дүгээр зүйл. Хөдөлмөр, нийгэм хангамжийн харилцаа

1.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж Монгол Улсын иргэдийг тэргүүн ээлжинд авч ажиллуулна. Нарийн мэргэшил, мэргэжлийн өндөр ур чадвар шаардагдах ажилд гадаадаас хүн авч ажиллуулж болно. Уул асуудлыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамтай зөвшилцөн шийдвэрлэнэ.

2.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ажиллаж байгаа Монгол Улсын Иргэдтэй холбогдсон хөдөлмөр, нийгэм хангамжийн харилцааг Монгол Улсын хөдөлмөрийн болон нийгмийн даатгалтай холбогдсон хууль тогтоомжоор зохицуулна.

3.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ажиллахаар гадаадаас ирсэн хүн хөдөлмөрийн хөлс, бусад орлогоосоо Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татвар төлөх бөгөөд үлдсэн орлогоо гадаадад гуйвуулах эрхтэй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

25 дугаар зүйл. Маргаан шийдвэрлэх

Гадаадын хөрөнгө оруулагч болон монголын хөрөнгө оруулагчийн хооронд, түүнчлэн гадаадын хөрөнгө оруулагч болон монголын хуулийн этгээд, хувь хүний хооронд гадаадын хөрөнгө оруулалт, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдон үүссэн маргааныг Монгол Улсын олон улсын гэрээ, талуудын хооронд байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын шүүх шийдвэрлэнэ.

26 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1993 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын
газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

1993 оны 5 дугаар
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 5 дугаар
сарын 10 өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол улсын хууль батлагдсантай холбогдуулан 1990 оны 3 дугаар сарын 23- ны өдөр батлагдсан БНМАУ-ын гадаадын хөрөнгө оруулах тухай хуулийг 1993 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын
газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 6 дугаар
сарын 7 өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуульд Эрүүгийн хуулийг нийцүүлэх зорилгоор Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Эрүүгийн хуульд "БНМАУ" гэснийг "Монгол Улс" гэж өөрчилсүгэй.

2.Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 1 дүгээр зүйл, 2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6 дугаар зүйл, 19 дүгээр зүйл, 20 дугаар зүйл, 21 дүгээр зүйл, 22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 23 дугаар зүйл, 32 дугаар зүйл, 46 дугаар зүйл, 49 дүгээр зүйл болон 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 51 дүгээр зүйлийн "е" заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1 дүгээр зүйл:

"1 дүгээр зүйл. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт

1.Монгол Улсын Эрүүгийн хуулийн зорилт нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт болон үндэсний аюулгүй байдал, хүний амь бие, эрүүл мэнд, түүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, түүнчлэн эрх зүйн журмыг гэмт халдлагаас хамгаалахад оршино.

2.Монгол Улсын Эрүүгийн хууль энэ зорилтыг хэрэгжүүлэхийн тулд нийгэмд аюултай ямар хэрэг гэмт хэрэг болохыг тодорхойлж, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуул бал зохих ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг тогтооно."

2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Эрүүгийн ял болон эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээг зөвхөн хуульд нийцүүлэн гаргасан шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор оногдуулна."

5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт болон үндэсний аюулгүй байдал, хүний амь бие, эрүүл мэнд, түүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, түүнчлэн, эрх зүйн журамд халдсан бөгөөд Эрүүгийн хуульд заасан, нийгэмд аюултай хэрэг /үйлдэл, эс үйлдэхүй/-ийг гэмт хэрэг гэж үзнэ."

6. дугаар зүйл:

"6 дугаар зүйл. Гэмт хэргийн ангилал

Гэмт хэргийн шинж чанар, хор аюулын хэр хэмжээг харгалзан хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг гэж ангилна:

а/энэ хуулийн тусгай ангид хоёр жилээс дээшгүй хугацаатай хорих ял буюу өөр төрлийн ял оногдуулахаар заасан санаатай гэмт хэрэг, түүнчлэн таван жилээс дээшгүй хугацаатай хорих ял буюу өөр төрлийн ял оногдуулахаар заасан болгоомжгүй гэмт хэргийг хөнгөн гэмт хэрэг гэж үзнэ;

б/энэ хуулийн тусгай ангид таван жилээс дээшгүй хугацаатай хорих ял оногдуулахаар заасан санаатай гэмт хэрэг түүнчлэн таваас дээш жилийн хугацаатай хорих ял оногдуулахаар заасан болгоомжгүй гэмт хэргийг хүндэвтэр гэмт хэрэг гэж үзнэ;

в/энэ хуулийн тусгай ангид арван таван жил хүртэл хугацаатай хорих ял оногдуулахаар заасан санаатай гэмт хэргийг хүнд гэмт хэрэг гэж үзнэ;

г/энэ хуулийн тусгай ангид хорин таван жил хүртэл хугацаатай хорих ял буюу цаазаар авах ял оногдуулахаар заасан санаатай гэмт хэргийг онц хүнд гэмт хэрэг гэж үзнэ."

19 дүгээр зүйл:

"19 дүгээр зүйл. Ял, түүний зорилго

1.Ял нь гэмт хэрэг үйлдэж, гэм буруутайд тооцогдсон этгээдийн эрх, эрх чөлөөнд энэ хуульд заасны дагуу шүүхийн таслан шийдвэрлэх тогтоолоор хязгаарлалт тогтоосон төрийн албадлагын арга хэмжээ мөн.

2.Ялын зорилго нь гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, засан хүмүүжүүлэх, түүнчлэн ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд оршино.

3.Ял нь хүнлэг бус, хүнд хэрцгий хандах, нэр төрийг нь доромжлох зорилго агуулж болохгүй.

4.Гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээдэд оногдуулсан ялыг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саднд нь халдаан хэрэглэхийг хориглоно."

20 дугаар зүйл:

"20 дугаар зүйл. Ялын төрөл

1.Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд дор дурдсан төрлийн ялыг хэрэглэж болно:

а/торгох;

б/тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах;

в/эд хөрөнгө хураах;

г/засан хүмүүжүүлэх ажил хийлгэх;

д/хорих;

е/цаазаар авах.

2.Торгох, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, хорих, цаазаар авах ялыг үндсэн ялын чанартай; тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах ялыг үндсэн болон нэмэгдэл ялын чанартай; эд хөрөнгө хураах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартай хэрэглэнэ."

21 дүгээр зүйл:

"21 дүгээр зүйл. Ялын дээд хэмжээ-цаазаар авах ял

1.Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд цаазаар авах-буудан алах ял оногдуулна.

2.Цаазаар авах ял шийтгүүлсэн этгээдийн амийг уучилсан тохиолдолд хугацаагүй хорих ялаар солино.

3.Арван найман насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдсэн этгээд, түүнчлэн эмэгтэйчүүд, жараас дээш насны эрэгтэйчүүдэд цаазаар авах ял оногдуулж болохгүй."

22 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Хорих ялын үндсэн хугацаа зургаан сараас арван таван жил хүртэл байна. Онц хүнд гэмт хэрэг үйлдсэн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хорин таван жил хүртэл хугацаатай хорих ял оногдуулна."

23 дугаар зүйл:

"23 дугаар зүйл. Онц аюултай гэмт хэрэгтэн.

1.Дараахь этгээдийг шүүх онц аюултай гэмт хэрэгтнээр тооцно:

а/хүнд гэмт хэрэг үйлдэж урьд нь хорих ялаар хоёр удаа шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа буюу эдэлсний дараа дахин хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн этгээд;

б/хүнд буюу онц хүнд гэмт хэрэг үйлдэж урьд нь хорих ялаар шийтгүүлж, уг ялаа эдэлж байхдаа буюу эдэлсний дараа дахин онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлсэн этгээд;

в/урьд нь хорих ял шийтгүүлж байгаагүй боловч удаа дараа онц хүнд гэмт хэрэг үйлдэж хорих ял шийтгүүлсэн этгээд.

2.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцоход болон давтан үйлдсэн гэмт хэргийн тоонд энэ хуулиар тогтоосон журмаар ял шийтгэлгүйд тооцсон буюу ял шийтгэлгүй болсныг оруулан тооцохгүй.

3.Онц аюултай гэмт хэрэгтний үйлдсэн гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэхээр заасан энэ хуулийн тусгай ангийн зүйлийг уг этгээд тухайн гэмт хэргийг үйлдэхээс өмнө хуульд заасан журмаар онц аюултай гэмт хэрэгтнээр тооцогдсон тохиолдолд хэрэглэнэ.

4.Шүүх тухайн этгээдийг онц аюултай гэмт хэрэгтнээр тооцох болсон үндэслэлээ таслан шийдвэрлэх тогтоолд заана.

5.Онц аюултай гэмт хэрэгтнээр тооцсон нь уг этгээдийг ял шийтгэлгүйд тооцсон буюу тухайн этгээд ял шийтгэлгүй болсон үед хүчингүй болно."

32 дугаар зүйл:

"32 дугаар зүйл. Эд хөрөнгө хураах

1.Гэмт үйлдийн улмаас бий болгосон эд зүйл, түүнчлэн гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, хэрэгсэл, гэмт үйлдлийн замаар олсон ашиг, орлого болон тэдгээртэй адилтган үзэх бусад эд зүйлийг үнэ төлбөргүйгээр албадан гаргуулж улсын орлогод шилжүүлэхийг эд хөрөнгө хураах гэнэ.

2.Шүүх ял оногдуулахдаа эд хөрөнгө хураах ял оногдуулах эсэхийг тухай бүрд нь хянан шийдвэрлэж, ямар эд зүйл, хөрөнгө, хураахыг таслан шийдвэрлэх тогтоолдоо тодорхой заана.

3.Эд хөрөнгө хураах ялыг зөвхөн нэмэгдэл ялын чанартай оногдуулна."

46 дугаар зүйл:

"46 дугаар зүйл. Эрүүгийн хариуцлага болон ялаас чөлөөлөх

1.Шүүх гэмт хэрэг үйлдсэн этгээдийг энэ хуульд заасан тохиолдолд эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, ял оногдуулахгүйгээр даалтад өгч, оногдуулсан ялыг эдлэхээс хугацааны өмнө суллаж болно.

2.Хэрэв хэргийг шүүхээр хянан хэлэлцэх үед цаг үеийн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас гэм буруутай этгээдийн үйлдсэн гэмт хэргийн шинжийг агуулсан хэрэг нийгэмд аюултай шинж чанараа алдсан буюу уг этгээд нийгэмд аюулгүй болсон нь тогтоогдвол шүүх түүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлж болно."

49 дүгээр зүйл:

"49 дүгээр зүйл. Ял оногдуулахгүйгээр даалтад өгөх

1.Шүүх хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээдийг ял хэрэглэхгүйгээр засан хүмүүжүүлэх боломжтой гэж үзвэл түүнд ял оногдуулахгүйгээр бусдын хүсэлтээр тэдний даалтад өгч болно.

2.Хэрэв даалтад шилжсэн этгээд нэг жилийн дотор шүүх болон даалтад авагчийн итгэлийг хөсөрдүүлбэл уг этгээдэд үйлдсэн хэрэгт нь ял оногдуулах тухай асуудлыг даалтад өгсөн шүүх шийдвэрлэнэ."

50 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Хорих, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгүүлсэн этгээд болон энэ хуулийн 51 дүгээр зүйлд зааснаас бусад ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллаж буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар сольж болно."

51 дүгээр зүйлийн "е" заалт:

"е/шүүхээс оногдуулсан ялаас хугацааны өмнө хорих газраас тэнсэн суллагдсаны дараа эдлээгүй үлдсэн ялын хугацаанд гэмт хэрэг дахин санаатай үйлдсэн этгээд."

3.Эрүүгийн хуулийн ерөнхий ангид дор дурдсан агуулгатай 1',16',50' дүгээр зүйл, 29 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг нэмсүгэй:

1' дүгээр зүйл:

"1' дүгээр зүйл. Монгол Улсын Эрүүгийн хуулийн зарчим

1.Монгол Улсын Эрүүгийн хууль нь шударга, энэрэнгүй ёс, хуулийг чанд сахих, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх, хариуцлага гарцаагүй байх зарчимд үндэслэнэ

2.Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд түүний үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролыг үл харгалзан энэ хуульд заасны дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ."

"16' дүгээр зүйл:

"16' дүгээр зүйл. Гэмт хэрэг үйлдсэн зохион байгуулалттай бүлэг

1.Гэмт хэрэг үйлдэхийн тулд урьдчилан нэгдэж, зохион байгуулагдсан бөгөөд тогтвортой ажилладаг хоёр буюу түүнээс дээш этгээдийг зохион байгуулалттай бүлэг гэнэ.

2.Зохион байгуулалттай бүлэг этгээдэд хүлээлгэх эрүүгийн хариуцлагыг энэ хуулийн тусгай ангид тогтооно."

50' дүгээр зүйл:

"50' дүгээр зүйл. Хугацаагүй хоригдож буй этгээдийг ялаас чөлөөлөх

Хугацаагүй хоригдож буй этгээд гучаас доошгүй жилийн хорих ял эдэлсний дараа нийгэмд аюулгүй болсон онцгой тохиолдолд түүнийг ялаас чөлөөлөх эсэх асуудлыг шүүх шийдвэрлэнэ."

29 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл шүүх торгуулийг нэг сараас зургаан сар хүртэл хугацаагаар хорих ялаар сольж болно."

4.Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 23 дугаар зүйлийг өөрчлөн найруулсантай холбогдуулан Эрүүгийн хуулийн ерөнхий болон тусгай ангид заасан "онц аюултай рецидив гэмт хэрэгтэн" гэснийг "онц аюултай гэмт хэрэгтэн" гэж өөрчилсүгэй.

5.Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

а/22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "арван жилээс" гэснийг "арван таван жилээс";

22 дугаар зүйлийн 5,8 дахь хэсэгт "Хүнд биш" гэснийг "Хөнгөн буюу хүндэвтэр";

22 дугаар зүйлийн 5,6,8,9,11 дэх хэсэгт "хүнд гэмт хэрэгт" гэснийг "хүнд буюу онц хүнд гэмт хэрэгт";

22 дугаар зүйлийн 12 дахь хэсэгт "хүнд гэмт хэрэг" гэснийг "хүнд буюу онц хүнд гэмт хэрэг";

38 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "арван жилээс" гэснийг "арван таван жилээс"; "арван таван жилээс" гэснийг "хорин таван жилээс";

42 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 51 дүгээр зүйлийн "б" заалтад "/60-69 дүгээр зүйл/" гэснийг /60-68 дугаар зүйл/";

9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 51 дүгээр зүйлийн "в", 53 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "б" заалтад "/85,86 дугаар зүйл/" гэснийг "/86 дугаар зүйл/" гэж тус тус өөрчлөх;

б/29 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "гэм буруутай этгээдийн" гэсний дараа "эд хөрөнгийн";

50 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн эхэнд "Хар тамхи, мансууруулах болон хордуулах бодис, буу, зэвсэг хууль бусаар хил нэвтрүүлэх /74 дүгээр зүйл/;

Мөн зүйлийн 6 дахь хэсэгт "/112 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг/" гэсний дараа "хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах /179/ дүгээр зүйлийн хоёр дахь хэсэг/" гэж тус тус нэмэх;

в/29 дүгээр зүйлийн 4 дэх хэсгээс "торгуулийг хорих ялаар,";

24 дүгээр зүйлээс "социалист";

38 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 50 дугаар зүйлийн 7 дахь хэсгээс "нутаг заах, уг нутгаас зайлуулах";

45 дугаар зүйлийн 2 дахь хэсгээс "эсхүл гурван жилээс доошгүй хугацаагаар нутаг заах буюу уг нутгаас зайлуулах";

50 дугаар зүйлийн 8 дахь хэсгээс "нутаг заах, уг нутгаас зайлуулах буюу";

54 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "е" заалтаас "болон уг нутгаас зайлуулах, нутаг заах";

43 дугаар зүйлийн 1 дэх хэсгээс "сахилгажуулах ангид явуулах";

50 дугаар зүйлийн 3 дахь хэсгээс "хөдөлмөрт заавал татан оролцуулахаар хорих ял нь тэнсэгдсэн болон хорих газраас тэнсэн суллагдсан этгээдийн хувьд ажиллаж байгаа газрын захиргаа, олон нийтийн байгууллага, цагдаагийн байгууллагын саналаар, сахилгажуулах ангид ял эдэлж байгаа этгээдийн хувьд уг ангийн захирагчийн саналаар";

50 дугаар зүйлийн 6 дахь хэсгээс "Монгөн тэмдэгт үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах /81 дүгээр зүйл/; хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар валютын гүйлгээний журам зөрчих, валютын үнэт зүйл, үнэт цаасыг дамлан худалдах /82 дугаар зүйлийн хоёр дахь хэсэг/";

54 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "д" заалтад "олон нийтийн өмнө буруушаах" гэснийг тус тус хасах.

6.Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан дараахь төрлийн ялыг хүчингүй болсонд тооцсугай:

1/нутаг заах;

2/уг нутгаас зайлуулах;

3/сахилгажуулах ангид явуулах;

4/олон нийтийн өмнө буруушаах;

5/цэргийн болон тусгай алдар цолыг хасах.

7.Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн дараахь зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

24 дүгээр зүйл /Ялтныг хөдөлмөрт заавал татан оролцуулахаар хорих ялыг тэнсэх/; 25 дугаар зүйл /Нутаг заах/; 26 дугаар зүйл /Уг нутгаас зайлуулах/; 27 дугаар зүйл 3,5 дахь хэсэг; 29 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг; 30 дугаар зүйл /Сахилгажуулах ангид явуулах/; 31 дүгээр зүйл /Олон нийтийн өмнө буруушаах/; 33 дугаар зүйл /Цэргийн болон бусад цол, түүнчлэн одон , медаль, хүндэт алдар цолыг хасах/; 38 дугаар зүйлийн 3,5 дахь хэсэг; 43 дугаар зүйлийн 2 дахь хэсэг; 47 дугаар зүйл /Эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, захиргааны хариуцлагад татах/; 48 дугаар зүйл /Эрүүгийн хариуцлагаас чөлөөлж, хэргийг нь олон нийтийн шүүхэд шилжүүлэх/; 51 дүгээр зүйлийн "г" заалт; 52 дугаар зүйл /Ялтныг хөдөлмөрт заавал татан оролцуулахаар хорих газраас тэнсэн суллах/; 54 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "в" заалт, мөн зүйлийн 2 дахь хэсэг.

8.Эрүүгийн хуулийн тусгай ангийн 60 дугаар зүйл, 70 дугаар зүйл, 74 дүгээр зүйл, 111 дүгээр зүйл, 123 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 124 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 126 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 133 дугаар зүйл, 196 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 234 дүгээр зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

60 дугаар зүйл:

"60 дугаар зүйл. Эх орноосоо урвах

Эх орноосоо урвасан, өөрөөр хэлбэл, Монгол Улсын иргэн Монгол Улсын тусгаар тогтнол, төрийн бүрэн эрхт болон нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, батлан хамгаалах хүчин чадварт хохирол учруулахын тулд төрийн нууцыг гадаад улсад өгсөн, Монгол Улсын эсрэг дайсагнасан үйл ажиллагаа явуулж буй

гаДаад улс, түүний байгууллагатай хамтран ажилласан бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

70 дугаар зүйл:

'70 дугаар зүйл. Үндэсний эв нэгдлийг бусниулах

Хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны онгөөр ялгаварлан гадуурхах, дайсагнуулах зорилгоор ухуулсан, сурталчилсан, заримынхнь эрхийг хязгаарласан, тэдэнд давуу байдал тогтоосон бол таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

74 дүгээр зүйл:

"74 дүгээр зүйл. Хар тамхи, мансууруулах болон хордуулах бодис, буу, зэвсэг хууль бусаар хил нэвтрүүлэх

1.Хар тамхи, мансууруулах, хордуулах болон цацраг идэвхт бодис, галт зэвсэг /ангийн буунаас бусад/, байлдааны хэрэгсэл болон тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлсэн бол наймаас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ хэргийг давтан буюу зохион байгуулалттай бүлэг этгээд, эсхүл албан тушаалтан албан тушаалынхаа байдлыг урвуулан ашиглаж үйлдсэн бол арван таваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

111 дүгээр зүйл:

"111 дүгээр зүйл. Бусдыг садар самуунд уруу татах

1.Насанд хүрээгүй хүнийг садар самуунд уруу татсан бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих буюу арван мянгаас тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Биеэ байнга үнэлж явалдсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу хорин таван мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

3.Бусдыг биеэ байнга үнэлж явалдахыг зохион байгуулсан, биеэ байнга үнэлж явалдахад насанд хүрээгүй хүнийг татан оруулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу тавин мянгаас нэг зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

123 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг этгээд буюу онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, эсхүл их хэмжээтэй хулгайлсан бол таваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

124 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

4.Энэ хэргийг зохион байгуулалттай бүлэг этгээд буюу онц аюултай гэмт хэрэгтэн үйлдсэн, эсхүл их хэмжээтэй булаасан

бол зургаагаас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

126 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

"3.Энэ зүйлийн нэг, хоёр дахь хэсэгт заасан үйлдлийн улмаас бусдад их хэмжээтэй хохирол учирсан, эсхүл зохион байгуулалттай бүлэг этгээд үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасаж гүйгээр таваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

133 дугаар зүйл:

"133 дугаар зүйл. Эрчим хүч ашиглах журам зөрчих

Цахилгааны болон дулааны эрчим хүчийг шунахай зорилгоор ашигласны улмаас бусдад их хэмжээний хохирол учирсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл тавин мянгаас нэг зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ."

196 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Энэ үйлдлийг удаа дараа, эсхүл хээл хахуулийн хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд буюу зохион байгуулалттай бүлэг этгээд хийсэн бол гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

234 дүгээр зүйл:

234 дүгээр зүйл. Мөрийтэй тоглох

Төрийн зохих байгууллагаас зөвшөөрөгдөөгүй мөрийтэй тоглоом тоглосон, зохион байгуулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу тавин мянгаас хоёр зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ."

9.Эрүүгийн хуулийн тусгай ангийн нэгдүгээр бүлгээс 81, 82 дугаар зүйлийг хасаж 176,179 дүгээр зүйл болгон зургадугаар бүлэгт; хоёрдугаар бүлгээс 122 дугаар зүйлийг хасаж 145 дүгээр зүйл болгон дөрөвдүгээр бүлэгт тус тус оруулж тухайн бүлэгт зааснаар өөрчлөн найруулсугай.

10.Эрүүгийн хуулийн тусгай ангийн 85,86 дугаар зүйлийг 86 дугаар зүйл болгон нэгтгэж дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"86 дугаар зүйл. Хүнийг санаатай алах

1.Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хүндрүүлэх нөхцөл байдалгүйгээр хүнийг санаатай алсан бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Хүнийг:

а/шунахай сэдэлтээр;

б/танхай сэдэлтээр;

в/өс хонзонгийн сэдэлтээр;

г/өөр бусад жигшүүрт зорилгоор;

д/албаны болон олон нийтийн журамт үүргээ биелүүлж байгаатай нь холбогдуулан;

е/онц харгис хэрцгийгээр;

ж/олон хүний амь биед аюултай аргаар;

з/хохирогчийн жирэмсэн болон бие эхамгаалж чадахгүй байгааг мэдсээр байж;

и/хүнийг санаатай алах гэмт хэргийг давтан үйлдсэн /энэ хуулийн 87,89 дүгээр зүйлд хамаарахгүй/;

к/зохион байгуулалттай бүлэг этгээд;

л/онц аюултай гэмт хэрэгтэн;

м/өөр гэмт хэргийг нуун далдлах буюу үйлдэхэд хялбар болгохоор;

н/урьдчилан төлөвлөж;

о/нэг амиар хоёр буюу түүнээс олон хүнийг санаатай алсан бол хориос хорин таван жил хүртэл хугацаагаар хорих буюу цаазаар авах ял шийтгэнэ."

11.Эрүүгийн хуулийн тусгай ангийн дөрөвдүгээр бүлгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

ХҮНИЙ УЛС ТӨРИЙН БОЛОН БУСАД ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

140 дүгээр зүйл. Иргэдээс сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд саад хийх

Монгол Улсын иргэдээс сонгуулийн эрхээ хэрэгжүүлэхэд нь хүч хэрэглэх, заналхийлэх, хуурч мэхлэх зэргээр санаатайгаар саад хийсэн, санал худалдаж авсан, бусад хэлбэрээр эд хөрөнгөөр татсан, сонгуулийн хорооны гишүүнд хүч хэрэглэн дарамт үзүүлсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу таван мянгаас хоёр зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

141 дүгээр зүйл. Сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санал хураалтын дүнг буруу гаргах

Сонгуулийн хорооны гишүүн буюу бусад албан тушаалтнаас сонгуулийн баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, санал хураалтын дүнг зориуд буруу гаргасан, сонгогчоос саналаа нууцаар гаргах, саналаа чөлөөтэй илэрхийлэхэд ноцтой саад учруулах замаар

сонгуулийн дүнд ноцтой нөлөөлсөн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу наян мянгаас гурван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

142 дугаар зүйл. Эмэгтэйчүүдийн тэгш эрхийг зөрчих

Эмэгтэйчүүдээс улс төр, эдийн засаг, нийгэм, соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцоход нь хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж тэгш эрхийг нь ноцтой зөрчсөн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу хорин таван мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

142[1] дүгээр зүйл. Иргэний эвлэлдэн нэгдэх эрхийг зөрчих

Хууль ёсны нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхаж эрхийг нь хязгаарласан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу таван мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

143 дугаар зүйл. Шүүмжилсэн иргэнийг мөрдөн хавчих

1.Шүүмжилсэн, тогтоосон журмын дагуу санал, өргөдөл, гомдол гаргасан иргэнийг мөрдөн хавчиж, түүний эрх, хуулиар хамгаалсан ашиг сонирхлыг албан тушаалтан санаатай хохироосон бол гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хорин мянгаас дөчин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Энэ үйлдлийн улмаас иргэдийн эрх, хуулиар хамгаалсан ашиг сонирхолд бага бус гэм хор учирсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл гучин мянгаас жаран мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

144 дүгээр зүйл. Иргэний орон байрны халдашгүй байдлыг зөрчих

Орон байранд хууль бусаар нэгжлэг хийх, орон байрнаас хууль бусаар гаргах буюу хууль бус бусад үйлдлээр иргэний орон байрны халдашгүй байдлыг зөрчсөн бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу арван мянгаас тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

145 дугаар зүйл. Хүчингүй.

145[1] дүгээр зүйл. Иргэнийг хууль бусаар хорих

1.Иргэнийг хууль бусаар хорьсон, чөлөөтэй зорчих эрхийг нь хууль бусаар ноцтой хязгаарласан нь албан тушаалын буюу шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэргийн шинжгүй бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу хорин таван мянгаас наян мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Энэ хэргийг хохирогчийн амь бие, эрүүл мэндэд аюултай аргаар үйлдсэн буюу уг хэргийг үйлдэхдээ хохирогчийн бие махбодийг тарчлаан зовоосон бол зургаан жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

146 дугаар зүйл. Иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчих

Иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу арван мянгаас жаран мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

146[1] дүгээр зүйл. Иргэний хувийн болон гэр бүлийн нууцыг задруулах

Мэргэжлийн болон албан үүргээ гүйцэтгэх явцад иргэний хувийн болон гэр бүлийн нууцыг итгэмжлэгдэн мэдсэн этгээд түүнийг задруулж ноцтой хор уршигт хүргэсэн бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу хорин мянгаас наян мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

147 дугаар зүйл. Хөдөлмөрийн хууль тогтоомж зөрчих

Улсын болон хувийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагын албан тушаалтан хууль бусаар ажлаас халсан ажилтныг ажилдань эгүүлэн тогтоосон шүүхийн хүчин төгөлдөр болсон шийдвэрийг биелүүлээгүй, эсхүл өөр хэлбэрээр хөдөлмөрийн хууль тогтоомжийг санаатайгаар ноцтой зөрчсөн бол хоёр жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх эрхийг хасах буюу хорин таван мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

148 дугаар зүйл. Хөдөлмөр хамгааллын журам зөрчих

1.Улсын болон хувийн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөр хамгааллын журмыг сахин хангуулах эрх бүхий этгээд буюу аж ахуйн нэгжийн эзэн энэ үүргээ биелүүлээгүй буюу хөдөлмөр хамгааллын журам зөрчигдөж байгааг таслан зогсоох талаар тодорхой арга хэмжээ аваагүйн улмаас хүний бие махбодид хөнгөн буюу хүндэвтэр гэмтэл учирсан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу тавин мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Энэ хэргийн улмаас хүний амь хохирсон буюу хүнд гэмтэл учирсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ хэргийн улмаас хоёр буюу түүнээс дээш хүний амь хохирсон бол таваас арван таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

149 дүгээр зүйл. Жирэмсэн, хөхүүл хүүхэдтэй эмэгтэй хүнийг ажлаас халах

Эмэгтэй хүнийг жирэмсэн, хөхүүл болон нэг нас хүрээгүй хүүхэдтэй гэсэн шалтгаар ажлаас халсан бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу хорин мянгаас наян мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

150 дугаар зүйл. Зохиогчийн болон шинэ бүтээл, нээлтийн эрхийг зөрчих

1.Бусдын туурвисан шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүтээлийг өөрийнхөө нэрээр гаргасан, тэдгээр бүтээлийн зохиогчийн эрхийг бусад хэлбэрээр завшсан, уг бүтээлийг хууль бусаар хуулбарлан нийтлүүлсэн, тараасан, борлуулсан, хамтран зохиогч болохоор албадсан бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу тавин мянгаас нэг зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Бусдын зохиосон шинэ бүтээл, гаргасан нээлтийг тэдний зөвшөөрөлгүйгээр урьдчилан тараасан, шинэ бүтээл зохиогч, нээлт гаргагчийн эрхийг завшсан, хамтран зохиогч болохоор албадсан бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу жаран мянгаас хоёр зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

151 дүгээр зүйл. Хүчингүй.

151' дүгээр зүйл. Хүний шашин шүтэх, эс шүтэх эрхийг зөрчих

Хүнийг шашин шүтэх, эс шүтэх эрхээ эдлэхэд хүч хэрэглэж буюу хүч хэрэглэхээр заналхийлж саад хийсэн бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу арван мянгаас хорин таван мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

152 дугаар зүйл. Хүчингүй.

152' дүгээр зүйл. Шүтэж буй шашнаар нь хүнийг ялгаварлан гадуурхах

Хүмүүсийг шүтэж буй шашнаар нь ялгаварлан гадуурхах тэдэнд хүч хэрэглэсэн буюу хүч хэрэглэхээр заналхийлсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу хорин таван мянгаас тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

12.Эрүүгийн хуулийн тусгай ангийн зургадугаар бүлгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

АЖ АХУЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРЭГ

163 дугаар зүйл. Стандартын болон хэрэглээний шаардлага хангаагүй, чанар муутай, иж бүрдэл дутуу чанарын баталгаагүй бүтээгдэхүүн үйлдвэрлэ

1.Стандартын болон хэрэглээний шаардлага хангаагүй, техникийн нөхцөлд тохироогүй, технологийн горим зөрчсөн, чанар муутай, иж бүрдэл дутуу, чанарын баталгаагүй бүтээгдэхүүн их хэмжээтэй буюу удаа дараа үйлдвэрлэсэн бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу тавин мянгаас хоёр зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Энэ хэргийг онц их хэмжээгээр үйлдсэн, эсхүл энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг зуун мянгаас таван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

164 дүгээр зүйл. Улсын тайлан мэдээг санаатай худал гаргаж мэдээлэх

Улсын тайлан мэдээг санаатай худал гаргаж мэдээлсэн бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу хорин таван мянгаас тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

165 дугаар зүйл. Чанар муутай барилга бариулах, ашиглалтад оруулах

Ажил гүйцэтгэх гэрээгээр барилга барьж байгаа барилгын байгууллагын эрх баригч /удирдлага/, түүнчлэн уг барилгын чанарт хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтан болон ажил гүйцэтгэгч чанар муутай, дутуу буюу батлагдсан зураг төсөлд тохироогүй барилга бариулсан, ашиглалтад оруулсны улмаас хүнд хор уршиг учирсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу жаран мянгаас хоёр зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

166 дугаар зүйл. Малтай хатуу ширүүн харьцах

Малтай байнга хатуу ширүүн харьцсан, эсхүл уг хэргийн улмаас бага бус гэм хор учирсан бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу арван мянгаас хорин таван мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

167 дугаар зүйл. Мал эмнэлгийн журам зөрчих

Хуулиар тогтоосон мал эмнэлгийн журам зөрчсөний улмаас малын гоц халдварт өвчин тархсан буюу хүнд хор уршиг учирсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу гучин мянгаас нэг зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

168 дугаар зүйл. Хадлан, тариалан, суулгац, тарьцыг санаатай устгах

Бэлтгэсэн хадлан, тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан оруулан давтуулах, идүүлэх зэргээр таримал, жимс, жимсгэний болон бусад суулгац, тарьцыг санаатай устгасан буюу гэмтээсний улмаас их хэмжээний хохирол учирсан бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу тавин мянгаас хоёр зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

169 дүгээр зүйл хүчингүй

169[1] дүгээр зүйл. Бараа, бүтээгдэхүүний чанар, нэр төрлийг хуурамчаар тодорхойлох

Бараа, бүтээгдэхүүний чанар, нэр төрөл, хаяг, шошгыг залилан мэхэлж хуурамчаар үйлдэх, гадаад улсын болон эх орны ижил нэрийн бүтээгдэхүүний таних тэмдэг, барааны тэмдэг, шошгыг хууль бусаар хэрэглэх буюу бусад аргаар их хэмжээний бараа, бүтээгдэхүүнийг хуурамчаар тодорхойлон нийлүүлсэн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу тавин мянгаас нэг зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

170 дугаар зүйл. Хэрэглэгчийг хуурч мэхлэх

1.Худалдаа, үйлчилгээний болон бусад байгууллагад барааг дутуу хэмжих, жинлэх, дүнг өсгөж бодох, баталгаагүй буюу баталгааны хугацаа дууссан эсхүл буруу заалттай хэмжүүр ашиглах, хэмжих хэрэгслийн заалтыг санаатайгаар өөрчлөх буюу бусад аргаар хэрэглэгчийг их хэмжээтэй буюу удаа дараа хуурч мэхэлсэн бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу жаран мянгаас нэг зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Энэ хэргийг урьдчилан тохиролцсон бүлэг этгээд буюу онц их хэмжээгээр үйлдсэн бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг зуун мянгаас таван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

171 дүгээр зүйл. Стандартын болон хэрэглээний шаардлага хангаагүй, чанар муутай, иж бүрдэл дутуу, чанарын баталгаагүй бараа, бүтээгдэхүүнийг худалдаанд гаргах

1.Стандартын болон хэрэглээний шаардлага хангаагүй, чанар муутай, иж бүрдэл дутуу, чанарын баталгаагүй бараа, бүтээгдэхүүнийг удаа дараа буюу их хэмжээтэй худалдаанд санаатай гаргасан буюу гадаадаас оруулсан бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах

буюу хасахгүйгээр нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу тавин мянгаас хоёр зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Энэ хэргийг онц их хэмжээгээр үйлдсэн, эсхүл хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ зүйлд заасан хэргийг болгоомжгүй үйлдсэн бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу хорин таван мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

171[1] дүгээр зүйл. Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүнийг худалдаалах

1.Хүний амь нас, эрүүл мэндэд гэм хор учруулахуйц хүнсний бүтээгдэхүүнийг их хэмжээтэй буюу удаа дараа худалдсан, худалдаанд гаргасан бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу хоёр зуун тавин мянгаас таван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр гурваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

172 дугаар зүйл. Хүчингүй.

172[1] дүгээр зүйл. Эд зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх

1.Хориглосон буюу хязгаарласан эд зүйл болон их хэмжээний валют, валютын үнэт зүйл, эрдсийг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлсэн бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу хорин таван мянгаас хоёр зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Энэ хэргийг давтан буюу зохион байгуулалттай бүлэг этгээд, эсхүл албан тушаалтан албан тушаалынхаа байдлыг урвуулан ашиглаж үйлдсэн, түүнчлэн цул алт, эртний амьтан, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, музейн үнэт үзмэр, түүх, археологийн дурсгалт зүйлийг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлсэн бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг зуун мянгаас таван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

173 дугаар зүйл. Хясан боогдуулж хууль бус шан харамж авах

Төрийн байгууллагын ажилтан өөрийн албан үүргийн хүрээнд багтдаг зорчигчийн билет түгээврийн болон түүнтэй адилтгаж бусад ажил гүйцэтгэх буюу үйлчилгээ үзүүлэхийн тулд хясан боогдуулах замаар иргэдээс их хэмжээтэй буюу удаа дараа

хууль бус шан харамж авсан бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу хорин таван мянгаас жаран мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

174 дүгээр зүйл. Бензин болон шатах тослох бусад материалыг хууль бусаар олгох

Төрийн байгууллагын мэдлийн бензин болон шатах тослох бусад материалыг ашиглан шамшигдуулсан шинжгүйгээр бусдад хууль бусаар их хэмжээтэй буюу удаа дараа олгосон бол нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх буюу гурван жил хүртэл хугацаагаар тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах, эсхүл тавин мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

175 дугаар зүйл. хүчингүй.

175[1] дүгээр зүйл. Хориглосон үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэх

1.Хориглосон үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг их хэмжээтэй явуулсан бол таван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг зуун мянгаас хоёр зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Энэ хэргийг онц их хэмжээгээр буюу зохион байгуулалттай бүлэг этгээд үйлдсэн бол таваас арван жил хүртэл хугацаагаар хорих буюу хоёр зуун тавин мянгаас таван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

176 дугаар зүйл. Хүчингүй.

176[1] дүгээр зүйл. Банкны үйл ажиллагааг хууль бусаар явуулах

Банкны тухай хууль тогтоомжоор хориглосон үйл ажиллагаа явуулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу хоёр зуун тавин мянгаас таван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

176 дугаар зүйл. Валютын гүйлгээний журам зөрчих

Валютын гүйлгээний журам ноцтой зөрчсөн бол хоёроос найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

177 дугаар зүйл. Хүчингүй.

177[1] дүгээр зүйл. Санаатайгаар дампууруулах буюу дампуурснаа мэдэгдэхгүй байх

1.Шунахай буюу байгууллагын явцуу эрх ашиг, сонирхлын үүднээс өөрийнхөө, эсхүл аж ахуйн бусад нэгжийг санаатайгаар дампууруулсан бол тодорхой албан тушаал эрхлэх буюу тодорхой үйл ажиллагаа явуулах эрхийг хасах буюу хасахгүйгээр гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг зуун мянгаас таван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

2.Аж ахуйн нэгжийн эзэн буюу эрх баригч нь төлбөрийн чадваргүй болсон тухайгаа шүүх болон харилцагч талд мэдэгдээгүйгээс харилцагч талд их хэмжээний хохирол учирсан бол нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу тавин мянгаас нэг зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

177[2] дугаар зүйл. Гэрээний тухай хууль тогтоомж зөрчих

Гэрээний талууд үгсэн тохирч хуурамч хэлцэл хийж, гэрээний тухай хууль тогтоомж санаатайгаар зөрчсөнөөс гурав дахь этгээдэд их хэмжээний хохирол учирсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг зуун мянгаас гурван зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

178 дугаар зүйл. Согтууруулах ундааг хориглосон зүйлээр бэлтгэх, борлуулах

Согтууруулах ундааг борлуулах зорилгоор хориглосон зүйлээр бэлтгэсэн, хадгалсан мөн зорилгоор түүнийг бэлтгэх хэрэгсэл бий болгосон, хадгалсан, түүнчлэн бэлтгэсэн согтууруулах ундаа болон түүнийг бэлтгэх хэрэгслийг борлуулсан бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэх, эсхүл хорин таван мянгаас тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

179 дүгээр зүйл. Шуудангийн төлбөрийн тэмдэгтийг хуурамчаар үйлдэх

Шуудангийн марк, шуудангийн төлбөрийн бусад тэмдэгтийг хуурамчаар их хэмжээтэй буюу удаа дараа үйлдсэн, хуурамчаар үйлдсэнийг мэдсээр байж гүйлгээнд оруулсан бол хоёр жил хүртэл хугацаагаар хорих буюу нэг жил зургаан сар хүртэл хугацаагаар засан хүмүүжүүлэх ажил хийлгах, эсхүл тавин мянгаас нэг зуун тавин мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

179[1] дүгээр зүйл. Мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах

1.Үндэсний болон гадаад улсын мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдсэн, хуурамчаар үйлдсэнийг мэдсээр байж борлуулсан бол таваас арван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ хэргийг их хэмжээтэй буюу зохион байгуулалттай бүлэг этгээд, эсхүл энэ хэрэгт урьд нь ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

180 дугаар зүйл. Зорчигчийн билетийг хуурамчаар үйлдэх, борлуулах

Зорчигчийн болон ачааны билет, зорчигч болон ачааг тээх бусад баримт бичгийг хуурамчаар их хэмжээтэй буюу удаа дараа үйлдсэн, хуурамчаар үйлдсэнийг мэдсээр байж борлуулсан бол

нэг жил хүртэл хугацаагаар хорих буюу хорин таван мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

13.Эрүүгийн хуулийн тусгай ангид дор дурдсан агуулгатай 60¹,79¹,106¹ дүгээр зүйл нэмсүгэй:

60¹ дүгээр зүйл:

60¹ дүгээр зүйл Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах хуйвалдаан зохион байгуулах

Төрийн эрх мэдлийг Үндсэн хуулийн бус аргаар авах зорилго бүхий хуйвалдаан зохион байгуулсан бол арваас хорин таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах зорилгоор бэлтгэж буй хуйвалдааныг төрийн зохих байгууллага буюу албан тушаалтанд сайн дураараа мэдэгдсэн этгээдийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлнө.

79¹ дүгээр зүйл:

"79¹ дүгээр зүйл. Улсын хилийн дэглэм зөрчих

Монгол Улсын хилийн багана, тэмдгийг санаатай устгах, гэмтээх, түүнчлэн улсын хилийн ус болон шугам огтлон гарсан зам, гүүр, холбооны байгууламжийг ашиглах журмыг ноцтой зөрчсөн бол гурван жил хүртэл хугацаагаар хорих буюу дөчин мянгаас хоёр зуун мянга хүртэл төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

106¹ дүгээр зүйл:

"106¹ дүгээр зүйл. Дархлалын олдмол хомсдолын өвчнийг бусдад халдаах

1.Өөрийн биед дархлалын олдмол хомсдлын өвчин байгааг мэдсээр байж хурьцал үйлдэх буюу өөр замаар бусдад халдаасан бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Үйлдвэр, худалдаа, эм хангамжийн болон бусад байгууллагын албан тушаалтан, иргэн дархлалын олдмол хомсдлын өвчний вирус илрүүлэх шинжилгээг хийлгээгүй цус, цусан бүтээгдэхүүн, эд эрхтэн борлуулсны улмаас тухайн өвчны халдвар бусдад тараасан бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Эмч болон эмнэлгийн байгууллагын ажилтан үүрэгт ажилдаа хариуцлагагүй хандсаны улмаас дархлалын олдмол хомсдлын өвчний халдвар бусдад тараасан бол дөрвөн жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

14.Эрүүгийн хуулийн тусгай ангийн дараахь зүйл, хэсэгт дор дурдсан хэмжээний торгох ял нэмсүгэй:

79 дүгээр зүйлд: нэг зуун мянгаас дөрвөн зуун мянга хүртэл төгрөг;

96 дугаар зүйлд: арван таван мянга хүртэл төгрөг;

97 дугаар зүйлд: арван мянга хүртэл төгрөг;

109 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт: арван мянгаас гучин мянга хүртэл төгрөг;

114 дүгээр зүйлд: хорин таван мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөг;

115 дугаар зүйлд: хорин таван мянгаас тавин мянга хүртэл төгрөг;

116 дугаар зүйлд: гучин мянгаас жаран мянга хүртэл төгрөг;

119 дүгээр зүйлд: тавин мянгаас нэг зуун мянга хүртэл төгрөг;

120 дугаар зүйлд: арван мянгаас гучин мянга хүртэл төгрөг;

257 дугаар зүйлд: хорин мянгаас жаран мянга хүртэл төгрөг.

15.Тухайн төрлийн ялыг хүчингүй болгосонтой холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн зүйл, хэсэгт заасан нутаг заах, уг нутгаас зайлуулах, сахилгажуулах ангид явуулах, олон нийтийн өмнө буруушаах, цэргийн болон бусад цол, түүнчлэн одон медаль, хүндэт алдар цолыг хасах ялыг тус тус хассугай.

16.Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийг өөрчлөн найруулсантай холбогдуулан мөн хуулийн тусгай ангийн зүйл, хэсэгт "эд хөрөнгө хурааж" буюу "эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр" гэж заасныг тус тус хассугай.

17.Эрүүгийн хуулийн тусгай ангийн дараахь зүйл, хэсэг, заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

а/87 дугаар зүйлд "найман жил хүртэл", 123 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "зургаан жил хүртэл", 126 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "долоон жил хүртэл", 127 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "зургаан жил хүртэл", 130 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "зургаан жил хүртэл", 202 дугаар зүйлд "хоёр жил хүртэл", 253 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "хоёр жил хүртэл" гэснийг "таван жил хүртэл";

61 дүгээр зүйлд "долоогоос арван таван жил хүртэл", 62 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "арваас арван таван жил хүртэл", 63 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "арваас арван таван жил хүртэл", 64 дүгээр зүйлд "наймаас арван таван жил хүртэл", 73 дугаар зүйлд "таваас арван таван жил хүртэл", 125 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "наймаас арван таван жил хүртэл", 195 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "дөрвөөс арван таван жил хүртэл", 222 дугаар зүйлд "таваас арван таван жил хүртэл", 245 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "зургаагаас арван таван жил хүртэл", 254 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "зургаагаас арван таван жил хүртэл", 268 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "таваас арван таван жил хүртэл" гэснийг "арваас хорин таван жил хүртэл";

105 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "хоёр жил хүртэл" гэснийг "зургаан жил хүртэл";

105 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "таван жил хүртэл" гэснийг "арван хоёр жил хүртэл";

253 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "гурван жил хүртэл" гэснийг "таваас арван таван жил хүртэл";

84 дүгээр зүйл "контрабанд хийх /74 дүгээр зүйлд/" гэснийг "хар тамхи, мансууруулах болон хордуулах бодис, буу, зэвсгийг хууль бусаар хил нэвтрүүлэх /74 дүгээр зүйл/";

125 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 130 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 195 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 245 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 254 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "урьдчилан тохиролцсон бүлэг этгээд" гэснийг "зохион байгуулалттай бүлэг этгээд";

199, 200 дугаар зүйлд "бусдыг санаатай алах /85,86 дугаар зүйл/" гэснийг "бусдыг санаатай алах /86 дугаар зүйл/" гэж тус тус өөрчлөх;

б/83,84 дүгээр зүйлд "эх орноосоо урвах /60 дугаар зүйл/" гэсний дараа "төрийн эрх мэдлийг хууль бусаар эвах хуйвалдаан зохион байгуулах /60 дүгээр зүйл/;

199 дүгээр зүйлд "бусдын эд хөрөнгийг дээрэмдэх /125 дугаар зүйл/" гэсний дараа "мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах 179 дүгээр зүйл;

200 дугаар зүйлд "хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар бусдын эд хөрөнгийг ашиглан шамшигдуулах /123 дугаар зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 124 дүгээр зүйлийн хоёр, гурав, дөрөв дэх хэсэг, 125,126,127 дугаар зүйл/" гэсний дараа "мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах/ 179 дүгээр зүйл/" гэж тус тус нэмэх;

в/83 дугаар зүйлээс "мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах /81 дүгээр зүйл/";

84 дүгээр зүйлээс "мөнгөн тэмдэгт, үнэт цаасыг хуурамчаар үйлдэх, борлуулах /81 дүгээр зүйл/ валютын гүйлгээний журам зөрчих, валютын үнэт зүйл, үнэт цаасыг дамлан худалдах /82 дугаар зүйл/";

200 дугаар зүйлээс "хүндрүүлэх нөхцөл байдалтайгаар дамын худалдаа хийх /169 дүгээр зүйлийн хоёр, гурав дахь хэсэг/" гэснийг тус тус хасах.

18.Эрүүгийн хуулийн тусгай ангийн дараахь зүйл, хэсгийг хүчингүй болсонд тооцсугай:

66 дугаар зүйл /БНМАУ-ын эсрэг ухуулах, сурталчлах/; 69 дүгээр зүйл /хөдөлмөрчдийн засаг төр бүхий бусад улсын төрийн эсрэг онц аюултай гэмт хэрэг үйлдэх/; 79 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг; 145 дугаар зүйл /Үйлдвэрчний эвлэлийн хууль ёсны ажиллагаанд саад хийх/; 151 дүгээр зүйл /Шашныг төрөөс болон сургуулийг шашнаас тусгаарласан хууль тогтоомж зөрчих /;

152 дугаар зүйл /Шашны зан үйл үйлдэхэд саад хийх/; 169 дүгээр зүйл /Дамын худалдаа хийх/; 172 дугаар зүйл /Худалдааны журам зөрчих/; 175 дугаар зүйл /Улс, хоршоолол, олон нийтий үйлдвэр, албан газар, байгууллагын нэрээр халхавчилж хувийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх/; 176 дугаар зүйл /Хувийн хөдөлмөрийн хориглосон үйл ажиллагаа явуулах/; 177 дугаар зүйл /Согтууруулах ундаа худалдах журам зөрчих/; 189 дүгээр зүйл /Үслэг ангийн үнэт арьсыг худалдах, худалдан авах, арилжих/ 214 дүгээр зүйл /Нутаг заагдсан этгээд оргох, нутаг зайлуулагдсан этгээд орших суухыг хориглосон газар дур мэдэн эргэж ирэх/ 215 дугаар зүйл /Хөдөлмөр-эмчилгээ, хөдөлмөр-хүмүүжлийн байгууллагаас буюу тэдгээрт очих замаас оргох/; 217 дугаар зүйл /БНМАУ-ын нийгэм төрийн байгууламжийг гутаасан гүжирдлэгийг зориуд тараах/; 229 дүгээр зүйл /Иргэний паспортын журам зөрчих/; 235 дугаар зүйл /Нийгмийн тустай хөдөлмөрөөс ноцтой зайлсхийх, бусдын хүчийг сорон мөлжих/.

19.Эрүүгийн хуулийн тусгай ангийн 61,73,222 дугаар зүйл, 268 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан цаазаар авах ял, 95 дугаар зүйл, 109 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 115 дугаар зүйл, 257 дугаар зүйлд заасан хорих ялыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

20.Энэ хуулийг 1993 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

Монгол Улсын Их Хурлын дарга Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга Н.РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ПАТЕНТИЙН ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, онцлогтой санал зохиогч болон патент эзэмшигчийн эрхийг хам-

гаалах, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Патентийн тухай хууль тогтоомж

1.Патентийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон Монгол Улсын хууль тогтоомжийн холбогдох бусад актаас бүрдэнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын патентийн тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

Энэ хуульд:

1/"шинэ бүтээл" гэж байгалийн хуульд тулгуурлан анх сэдэж, үндэслэлийг нь нээн илрүүлсэн үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүнд хамаарах цоо шинэ шийдлийг;

2/"бүтээгдэхүүний загвар" гэж үйлдвэрлэлийн аргаар хийх боломжтой бүтээгдэхүүний хэлбэр, хийцэд хамаарах өвөрмөц, цоо шинэ шийдлийг;

3/"оновчтой санал" гэж тухайн байгууллагад шинэ, үйлдвэрлэх арга ажиллагаа болон бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн зохион байгуулалтад хамаарах оновчтой шийдлийг;

4/"патент" гэж тухайн шийдэл нь шинэ бүтээл, эсхүл бүтээгдэхүүний загвар болохыг тодорхойлж зохиогч нь тодорхой хугацаанд түүнийг өмчлөх онцгой эрхтэй болохыг хүлээн зөвшөөрч төрийн эрх бүхий байгууллагаас олгож байгаа баримт бичгийг;

5/"оновчтой саналын гэрчилгээ" гэж оновчтой санал зохиогчийг хүлээн зөвшөөрсөн баримт бичгийг;

6/"лиценз" гэж патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг бусдад ашиглуулах зөвшөөрлийг;

7/"анхдагч огноо" гэж шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлгийг патентийн байгууллагад, оновчтой саналын мэдүүлгийг тухайн байгууллагад анх өгч бүртгүүлсэн он, сар, өдрийг;

8/"давамгайлах огноо" гэж мэдүүлгийнхээ анхдагч огнооноос өмнө аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисийн конвенцийн гишүүн аль нэг оронд уг шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг мэдүүлж бүртгүүлсэн мэдүүлгийн он, сар, өдрийг тус тус ойлгоно.

4 дүгээр зүйл. Патент олгох зүйл, шалгуур

1.Шинэ бүтээлийн түвшин агуулсан, үйлдвэрлэлд ашиглах боломжтой, цоо шинэ үйлдвэрлэх арга ажиллагаа буюу бүтээгдэхүүн /шинэ бүтээл/ зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдэд патент олгоно.

2.Шинэ бүтээл нь тухайн мэргэжлийн хүнд ялгагдах давуу шинж чанартай байвал түүнийг шинэ бүтээлийн түвшин агуулсан

гэж үзнэ. Шинэ бүтээлийн түвшинг патентийн байгууллагаас эрх олгосон шинжээч тодорхойлно.

3.Үйлдвэрлэлийн аргаар хийж, үйлдвэрлэлд нэвтрүүлж болох шинэ бүтээлийг үйлдвэрлэлд ашиглах боломжтой гэж үзнэ.

4.Техникийн тухайн үеийн түвшингээс давуутай нь нотлогдсон үйлдвэрлэх арга ажиллагаа буюу бүтээгдэхүүнийг цоо шинэ гэж үзнэ.

5.Дараахь зүйлийг шинэ бүтээлд тооцохгүй:

1/нээлт, шинжлэх ухааны онол, математикийн арга;

2/цахим тооцоолуурын хөтөлбөр, алгоритм;

3/аж ахуйн үйл ажиллагаа, оюуны үйлдэл, тоглоом зэрэгт хамаарах хуваарь, дүрэм, аргачлал;

4/нийгмийн дэг журам, зан суртахуун, байгаль орчин, хүний эрүүл мэндэд харш шийдэл.

6.Мэдүүлэг хүлээн авах хүртэл дэлхийн аль нэг оронд хэвлэгдээгүй, тус улсад ямар нэг замаар тархаж мэдэгдээгүй, үйлдвэрлэлийн аргаар хийх боломжтой бүтээгдэхүүний хэлбэр, хийцэд хамаарах өөрмөц, цоо шинэ шийдэл /бүтээгдэхүүний загвар/ зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээдэд патент олгоно.

5 дугаар зүйл. Патентийн байгууллага

1.Монгол Улсад шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналын ажлыг патентийн асуудал эрхлэх байгууллага /цаашид "патентийн байгууллага" гэх/ хариуцана.

2.Патентийн байгууллага нь дараахь чиг үүрэг гүйцэтгэнэ:

1/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг хүлээн авч хянан шийдвэрлэх;

2/патент, оновчтой саналын гэрчилгээ олгох;

3/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой санал, барааны тэмдэг, лицензийн гэрээний улсын бүртгэл хотлөх;

4/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой санал, барааны тэмдэгтийн мэдээллийг нэгдсэн сан бүрдүүлэх;

5/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой санал, барааны тэмдэгтийн тухай мэдээллийг хэвлэн нийтлэх;

6/патенттай холбогдсон маргааныг шийдвэрлэхэд лавлагаа гаргаж өгөх;

7/патент, оновчтой саналын гэрчилгээний загварыг тогтоох.

3.Патентийн байгууллагын дүрмийг Засгийн газар батална.

4.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагууд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналын ажлыг технологийн бодлогынхоо бүрэлдэхүүн хэсэг болгон явуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналын мэдүүлэг гаргах, түүнд шүүлт хийх

6 дугаар зүйл.

1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлгийг зохиогч буюу түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн, хуулийн этгээд патентийн байгууллагад гаргана.

2.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар тус бүрд мэдүүлэг гаргана. Нэг зориулалттай, нэгдмэл байдлаар ашиглагдах шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт нэг мэдүүлэг гаргаж болно.

3.Шинэ бүтээлийн мэдүүлэг нь өргөдөл, шинэ бүтээлийн тодорхойлолт, томъёолол, товч тайлбараас бүрдэнэ. Шаардлагатай бол түүнд холбогдох зураг, магадлагааг хавсаргана.

4.Бүтээгдэхүүний загварын мэдүүлэг нь өргөдөл, бүтээгдэхүүний загварын зураг, тодорхойлтоос бүрдэнэ. Шаардлагатай бол зураг, тодорхойлолтод холбогдох бусад материалыг түүнд хавсаргана.

5.Өргөдөлд шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар зохиогч, мэдүүлэг гаргагч, тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, хаяг, мэдүүлэг гаргасан огноо, патент авах хүсэлт, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын нэрийг тусгана. Мэдүүлэг гаргагч нь шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар зохиогч биш байвал шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент авах эрхээ нотолсон баримтыг хавсаргана.

6.Мэдүүлэг гаргагч өргөдөлдөө үндэсний, бүсийн, олон улсын мэдүүлгийн огноог давамгайлах огноогоор тогтоолгох тухай хүсэлтээ илэрхийлж болно. Энэ тохиолдолд холбогдох баримт бичгийг мэдүүлэгт хавсаргана.

7.Мэдүүлэг гаргагч тус улсын нутаг дэвсгэрт байнга оршин суудаггүй буюу аж ахуйн үйл ажиллагаа суурин эрхэлдэггүй бол тус улсад тогтмол үйл ажиллагаа явуулдаг итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр өөрийгөө төлөөлүүлнэ.

8.Мэдүүлгийг монгол хэлээр үйлдэнэ. Хэрэв өөр хэлээр үйлдсэн бол мэдүүлэг гаргагч патентийн байгууллагад уг мэдүүлгийг ирүүлсэн өдрөөс хойш 2 сарын дотор монгол хэлнээ хөрвүүлж өгнө.

7 дугаар зүйл. Оновчтой саналын мэдүүлэг гаргах

Оновчтой саналын мэдүүлгийг зохиогч, түүнээс эрх шилжүүлэн авсан хувь хүн холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын захир-

гаанд гаргана. Мэдүүлэг нь өргөдөл, оновчтой саналын тодорхойлолт, нотлох баримт зэргээс бүрдэнэ.

8 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлгийн анхдагч огноог тогтоох

1.Патентийн байгууллага шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэг хүлээн авсан өдрөөс хойш 20 хоногийн дотор түүний бүрдлийг хянаж шаардлага хангасан гэж үзвэл мэдүүлэг хүлээн авсан одрөөр анхдагч огноог тогтооно.

2.Патентийн байгууллага мэдүүлэг шаардлага хангаагүй гэж үзвэл түүнд нэмэлт, засвар хийх шаардлагатайг мэдүүлэг гаргагчид мэдэгдэнэ.

3.Мэдүүлэг гаргагч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш 3 сарын дотор холбогдох нэмэлт, засварыг хийж өгвөл патентийн байгууллага мэдүүлгийг анх хүлээн авсан одрөөр түүний анхдагч огноог тогтооно. Хэрэв 3 сарын дотор нэмэлт, засвар хийж ирүүлээгүй бол тухайн мэдүүлгийг хэрэгсэхгүй.

9 дүгээр зүйл. Оновчтой саналын мэдүүлгийн анхдагч огноог тогтоох

Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа оновчтой саналын мэдүүлгийг хүлээн авсан өдрөөр түүний анхдагч огноог тогтооно.

10 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийх

1.Мэдүүлгийг анхдагч огноог тогтоосны дараа патентийн байгууллага тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар энэ хуулийн 4 дүгээр зүйлд заасан шалгуур хангасан эсэхэд шүүлт хийнэ.

2.Мэдүүлэг гаргагч мэдүүлсэн шинэ бүтээл буюу түүнтэй мөн чанарааараа ижил бүтээлийг гадаадад патент буюу өөр ямар нэг эрхийн баримт авахаар мэдүүлсэн талаар патентийн байгууллагад түүний хүсэлтээр мэдээлэл гаргаж өгнө.

3.Шүүлт хийх явцад мэдүүлэг гаргагч анхныхаа ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүйгээр мэдүүлэгтээ нэмэлт, өөрчлөлт хийж болно.

4.Шүүлт хийх явцад мэдүүлэг гаргагч анхныхаа ирүүлсэн тодорхойлолтын агуулгын хүрээнээс халихгүйгээр мэдүүлгээ 2 буюу түүнээс дээш мэдүүлэг болгон салгаж болно. Энэ тохиолдолд салгасан мэдүүлгийн анхдагч огноо буюу давамгайлах огноог анхны мэдүүлгийнхээр тогтооно.

5.Патентийн байгууллага мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 9 сарын дотор шүүлтийн дүгнэлтийг үндэслэн патент олгох эсэх талаар шийдвэр гаргана. Шаардлагатай гэж үзвэл патентийн байгууллага энэ хугацааг 12 хүртэл сараар сунгаж болно.

6.Патент олгохоор шийдвэрлэсэн шинэ бүтээлийн ном зүй, томъёолол, бүтээгдэхүүний загварын зургийг патентийн хэвлэлд нийтэлж зарлана.

7.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар болох нь нотлогдоогүй бол шүүлтийн дүгнэлтийн хуулбарыг уг дүгнэлт гарсан өдрөөс хойш 30 хоногийн дотор мэдүүлэг гаргагчид хүргүүлж, мэдүүлгийг патентийн санд хадгална.

11 дүгээр зүйл. Оновчтой саналын мэдүүлэгт шүүлт хийх

1.Аж ахуйн нэгж, байгууллага оновчтой саналын мэдүүлгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор уг оновчтой санал тухайн байгууллагад шинэ, үр ашиг өгөх эсэхэд шүүлт хийж дүгнэлт гаргана.

2.Шүүлтийн дүгнэлт гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа оновчтой саналыг хэлэлцэж түүнийг батлах эсэх талаар шийдвэр гаргана.

3.Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа оновчтой саналыг баталбал энэ тухай шийдвэр гарсан өдрөөс хойш 14 хоногийн дотор уг шийдвэрийг оновчтой саналын мэдүүлгийн хуулбарын хамт патентийн байгууллагад хүргүүлнэ.

4.Аж ахуйн нэгж, байгууллагын захиргаа оновчтой саналыг батлаагүй бол энэ тухай шийдвэр, шүүлтийн дүгнэлтийн хуулбарыг уг шийдвэр гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор мэдүүлэг гаргагчид хүргүүлнэ. Энэ шийдвэрийг мэдүүлэг гаргагч зөвшөөрөхгүй бол тухайн шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

5.Оновчтой саналыг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш 3 сар өнгөрсний дараа гаргасан мэдүүлгийг хэрэгсэхгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Патент, оновчтой саналын гэрчилгээ олгох

12 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент олгох

1.Шинэ бүтээлийн ном зүй, томъёолол, бүтээгдэхүүний загварын зургийг патентийн хэвлэлд нийтэлсэн өдрөөс хойш 3 сарын дотор патентийн байгууллагад няцаасан нотолгоо ирээгүй, маргаан гараагүй бол патентийн байгууллага патент олгоно.

2.Няцаасан нотолгоо ирсэн, маргаан гарсан тохиолдолд тэдгээрийг зохих журмын дагуу шийдвэрлэх хүртэл патент олгохыг хойшлуулна.

3.Патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг улсын бүртгэлд бүртгэж, мэдүүлгийг нь патентийн санд хадгална.

13 дугаар зүйл. Оновчтой саналын гэрчилгээ олгох

1.Оновчтой саналыг баталсан шийдвэрийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор патентийн байгууллага уг оновчтой саналыг улсын бүртгэлд авч зохиогчид гэрчилгээ олгоно.

2.Урьд өөр байгууллагад гарч улсын бүртгэлд авсан оновчтой санал зохиогчид гэрчилгээ олгохгүй.

14 дүгээр зүйл. Патент, оновчтой саналын гэрчилгээний хүчинтэй байх хугацаа

Мэдүүлгийн анхдагч огнооноос эхлэн шинэ бүтээлийн патент 20 жил, бүтээгдэхүүний загварын патент 10 жил, оновчтой саналын гэрчилгээ 5 жилийн хугацаанд тус тус хүчинтэй байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой санал зохиогч болон патент эзэмшигчийн эрх

15 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар зохиогчийн эрх

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар зохиогч дараахь эрх эдэлнэ:

1/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвараа өмчлөх;

2/патент авах эрхээ бусдад шилжүүлэх;

3/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвартаа нэр өгөх;

4/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын технологийн баримт бичиг боловсруулах, тэдгээрийг турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажилд оролцож зохиогчийн хяналт тавих.

2.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар хамтран сэдэж бүтээсэн зохиогчид патент авах эрхийг хамтран эдэлнэ.

Хамтран зохиогч бусдынхаа зөвшөөрөлгүйгээр патент авах эрхээ бусдад шилжүүлж болохгүй.

3.Ижил шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг тусдаа сэдэж бүтээсэн бол мэдүүлгээ патентийн байгууллагад түрүүлж өгсөн зохиогч, харин давамгайлах огноо мэдүүлсэн тохиолдолд түрүү давамгайлах огноотой мэдүүлэг өгсөн зохиогч патент авах эрх эдэлнэ.

4.Албан үүргээ гүйцэтгэх буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх явцад сэдэж бүтээсэн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент авах эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол ажил гүйцэтгүүлэгч /санхүүжүүлэгч/ этгээд эдэлнэ.

16 дугаар зүйл. Оновчтой санал зохиогчийн эрх

Оновчтой санал зохиогч дараахь эрх эдэлнэ:

1/оновчтой саналын технологийн баримт бичиг боловсруулах, түүнийг турших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх ажилд оролцож зохиогчийн хяналт тавих;

2/оновчтой саналаа ашиглуулсны төлбөр авах.

17 дугаар зүйл. Патент эзэмшигчийн эрх

1.Патент эзэмшигч шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвараа ашиглах онцгой эрх эдэлнэ.

2.Патент бүхий шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг зөвхөн патент эзэмшигчийнх нь зөвшөөрлөөр ашиглана.

3.Патент эзэмшигч патент эзэмших эрхээ бусдад шилжүүлэх эрх эдэлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналыг ашиглах

18 дугаар зүйл. Патент бүхий шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашиглах

1.Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэх, худалдах, хэрэглэх болон энэ зорилгоор хадгалах, гадаадаас оруулах үйлдлийг шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашигласан гэж үзнэ.

2.Патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг дараахь байдлаар ашиглавал патент эзэмшигчийн онцгой эрхийг зөрчсөн гэж үзэхгүй:

1/патент эзэмшигч өөрөө, эсхүл түүний зөвшөөрөлтэйгээр бусад этгээд тус улсын зах зээлд гаргасан бүтээгдэхүүнийг ашиглах;

2/тус улсад эрдэм шинжилгээ, сорилт туршилтын ажилд ашиглах;

3/тус улсын нутаг дэвсгэрт түр буюу тохиолдлоор орж ирсэн бусад орны тээврийн хэрэгсэлд ашиглах;

3.Мэдүүлгийг анхдагч огнооноос өмнө өөр этгээд тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашиглаж байсан буюу ашиглах бүх нөхцөлийг урьдчилан бүрдүүлсэн бол тэдгээрийг патент эзэмшигчийнх нь зөвшөөролгүй ашиглаж болно. Харин тухайн шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашиглах хэмжээ, хүрээг өргөтгөж болохгүй.

19 дүгээр зүйл. Лицензийн гэрээ

Сонирхогч этгээд патент бүхий шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг патент эзэмшигчтэй лицензийн гэрээ байгуулан ашиг-

лана.

2.Лицензийн гэрээнд дараахь зүйлийг тусгана:

1/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашиглах арга, хэлбэр хэмжээ, хүрээ, хугацаа;

2/гэрээний талуудын эрх, үүрэг;

3/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг ашигласны төлбөрийн хэмжээ, түүнийг олгох журам.

3.Лицензийн гэрээг патентийн байгууллагад бүртгүүлнэ.

4.Патент эзэмшигч нь Монгол Улсын иргэн буюу хуулийн этгээд байх тохиолдолд төрийн хяналтад зайлшгүй байх шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварыг гадаадад лицензээр ашиглуулах гэрээ байгуулахын өмнө патентийн байгууллагаас зөвшөөрөл авна.

5.Хүн, мал амьтныг эмчлэх, оношлох, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга, ургамлын сорт, мал амьтны үүлдэр, тэдгээрийг бий болгох биологийн арга, бичил биетний омог, түүнийг өсгөвөрлөх орчинтой холбогдсон шинэ бүтээлийг ашиглах лицензийн гэрээг төрийн захиргааны холбогдох төв байгууллагаас зөвшөөрөл авч байгуулна.

6.Лицензийн гэрээний талууд гэрээний нууцыг хадгална.

20 дугаар зүйл. Лиценз албадан хэрэглэх

1.Патент бүхий шинэ бүтээл сонирхогч этгээдийн хүсэлтийн дагуу патентийн байгууллагын шийдвэрээр дараахь тохиолдолд лиценз албадан хэрэглэж болно:

1/шинэ бүтээлийг үндэсний аюулгүй байдал, хүн амын хүнсний хангамж, эрүүлийг хамгаалах зэрэг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн заавал ашиглавал зохих;

2/мэдүүлгийн анхдагч огнооноос хойш 4 жил буюу патент олгосон өдрөөс хойш 3 жил /аль сүүлд дууссан хугацааг тооцно/-ийн хугацаанд шинэ бүтээлийг огт ашиглаагүй тохиолдолд тухайн шинэ бүтээлийг Монгол Улсад ашиглах нөхцөл байгаагүйг патентийн байгууллагад патент эзэмшигч нотолж чадаагүй;

3/шинэ бүтээлийн патент эзэмшигч нь хүлээн зөвшөөрөх боломжгүй нөхцөлөөр шинэ бүтээлээ ашиглуулах болзол тавьсан.

2.Лиценз албадан хэрэглэх тухай патентийн байгууллагын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй бол патент эзэмшигч гомдлоо шүүхэд гаргаж болно.

21 дүгээр зүйл. Оновчтой саналыг ашиглах

Оновчтой саналыг батлсан аж ахуйн нэгж, байгууллага нь түүнийг ашиглахдаа зохиогчтой гэрээ байгуулна. Гэрээнд оновчтой санал ашигласны төлбөрийн хэмжээ, түүнийг олгох журмыг заана. Зохиогч бусад аж ахуйн нэгж, байгууллагатай гэрээ байгуулан тэдэнд оновчтой саналаа ашиглуулж болно.

22 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой санал ашиглах аж ахуйн нэгж, байгууллага болон патент эзэмшигчийн үүрэг

1.Аж ахуйн нэгж, байгууллага шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, оновчтой саналыг ашиглахдаа олсон ашгийг санхүүгийн тайлан тэнцэлд тусгаж үйлдвэрлэлийн нууцыг хадгална.

2.Патент эзэмшигчийн нэр, хаяг нь өөрчлөгдвөл энэ тухай патентийн байгууллагад бичгээр мэдэгдэж бүртгүүлнэ.

23 дугаар зүйл. Улсын нууцад холбогдох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар

Улсын нууцад холбогдох шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт хамаарах харилцааг хуулиар зохицуулна.

24 дүгээр зүйл. Патент, лицензийн хураамж

1.Патентийг хүчинтэй байлгах, лицензийн гэрээг бүртгүүлэхэд хураамж төлнө. Хураамжийг патентийн байгууллага хураана.

2.Хураамжийн хэмжээг хуулиар тогтооно.

25 дугаар зүйл. Патентийн хураамж төлөх хугацаа

1.Патентийг хүчинтэй байлгах хураамжийг тогтоосон хугацаагаар төлнө.

2.Патентийг хүчинтэй байлгах эхний 3 жилийн хураамжийг патент олгох шийдвэр гарсан өдрөөс хойш 6 сарын дотор, дараахь хугацааны хураамжийг тухайн хугацаа эхлэхээс 6 сарын өмнө тус тус төлнө.

3.Хэрэв патент эзэмшигч энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд патентийг хүчинтэй байлгах хураамжийг төлөөгүй бол хугацаа өнгөрснөөс хойш 6 сарын дотор төлж болно. Энэ тохиолдолд тухайн хугацааны хураамжтай тэнцэх хэмжээний төлбөр нэмж төлнө.

26 дугаар зүйл. Патентийг хүчингүйд тооцох

1.Сонирхогч этгээд патентийг хүчингүй болгох тухай шүүхэд өргөдөл гаргаж болно.

2.Энэ хуулийн 4,6,8,10,12 дугаар зүйлд заасныг зөрчиж патент олгосон байвал шүүх патентийг хүчингүй болгоно. Энэ тохиолдолд патентийн байгууллага шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын улсын бүртгэлд зохих өөрчлөлтийг оруулж патентийн хэвлэлд нийтэлнэ.

3.Патент эзэмшихээс болон патентийн хураамж төлөхөөс татгалзсан, хураамжийг энэ хуулийн 25 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацаанд төлөөгүй тохиолдолд патентийн байгууллага патентийг хүчингүй болгоно. Энэ тохиолдолд төрийн хяналтад зайлшгүй байх шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын патент эзэмших эрх төрийн захиргааны холбогдох төв байгууллагад шилжинэ.

. ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

27 дугаар зүйл. Гомдол, маргаан шийдвэрлэх

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварын мэдүүлэгт шүүлт хийхтэй холбогдон гарсан гомдлыг патентийн байгууллага хянаж шийдвэрлэнэ. Бусад асуудлаар гарсан гомдол, маргааныг шүүх шийдвэрлэнэ.

28 дугаар зүйл. Патентийн тухай хууль тогтоомж, зохиогч болон патент эзэмшигчийн эрхийг зөрчсөнд хүлээлгэх хариуцлага

1.Патентийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 25000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл оногдуулна.

2.Зохиогч болон патент эзэмшигчийн эрхийг зөрчсөн этгээдэд Монгол Улсын хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

3.Патент эзэмшигчийн эрхийг зөрчсөнөөс учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлөх асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.

29 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

1.Энэ хууль 1993 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2.Энэ хуулийг буцааж хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурлын
дарга Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга Н.РИНЧИНДОРЖ

1993 оны 6 дугаар сарын 25-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСЭГ, ЗАРЛИГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хууль батлагдсантай холбогдуулан Иргэний хуулийн "Зохиогчийн эрх" гэсэн V хэсэг, "БНМАУ-ын Иргэний хуульд зарим нэмэлт оорчлолт оруулах тухай" БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1987 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 43 дугаар зарлигийг Монгол Улсын Зохиогчийн эрхийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н.РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗОХИОГЧИЙН ЭРХИЙН ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь зохиогчийн эрхийг хамгаалах, зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг ашиглахтай холбогдож үүссэн харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомж

1.Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон Монгол Улсын хууль тогтоомжийн холбогдох бусад актаас бүрдэнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Зохиогчийн эрхэд хамаарах бүтээл

1.Зохиогчийн эрхэд агуулга, зориулалт, хэлбэр, чансаа, бүтээсэн болон хүртээл болох аргаасаа үл шалтгаалан дараахь бүтээл хамаарна:

1/шинжлэх ухаан, уран зохиолын зэрэг утга зохиолын аман буюу бичмэл бүх төрлийн бүтээл;

2/хөгжмийн урлагийн бүх төрлийн бүтээл;

3/дүрслэх урлагийн болон хавсарга урлагийн бүх төрлийн бүтээл;

4/архитектурын бүтээл, барилга байгууламжийн зураг төсөл:

5/бүжгийн урлагийн бүх төрлийн бүтээл, уран нугаралт, пантомим:

6/жүжгийн бүх төрлийн бүтээл;

7/кино урлагийн болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан бүх төрлийн бүтээл;

8/гэрэл зургийн болон түүнтэй төсөөтэй аргаар туурвисан бүх төрлийн бүтээл;

9/шинжлэх ухаан, техникийн холбогдолтой төсөл, зураг, бүдүүвч, загвар;

10/цахим тооцоолуурын хөтөлбөр;

11/дуу авиа, дүрс бичлэгийн бүтээл;

12/урьд туурвисан бүтээлийг ашиглан түүний үндсэн дээр бий болгосон үүсмэл бүтээл;

13/зохиогчийн оюуны бүтээлч үйл ажиллагааг илэрхийлж чадахуйц бусад бүтээл;

/Зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг энэ хуульд цаашид "бүтээл" гэнэ/.

2.Хууль тогтоомж, эрх зүйн акт, шүүхийн шийдвэр, албан баримт бичгийг бүтээлд тооцохгүй.

3.Ардын уран бүтээлийг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулна.

4.Нээлтийн эрх, түүнтэй холбогдох харилцааг зохих хууль тогтоомжоор зохицуулна.

4 дүгээр зүйл. Зохиогч

1.Бүтээл туурвисан этгээдийг зохиогч гэнэ.

2.Бие даасан хэсэгт хуваагдахгүй хамтын бүтээл туурвисан хоёр буюу түүнээс дээш этгээдийг хамтарсан зохиогчид гэнэ.

Хамтарсан зохиогчид тухайн бүтээлийн зохиогчийн эрхийг хамтран эдэлнэ.

3.Бие даасан хэсэгт хуваагдах хамтын бүтээл туурвисан хоёр буюу түүнээс дээш этгээдийг нэгдсэн зохиогчид гэнэ. Нэгдсэн зохиогчид тухайн бүтээлийн зохиогчийн эрхийг хамтран эдлэхээс гадна өөрт хамаарах хэсэгт зохиогчийн эрхийг бусад зохиогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр дангаар эдэлж болно.

5 дугаар зүйл. Зохиогчийн эрх эдлэх этгээд

1.Зохиогчийн эрхийг дараахь этгээд эдэлнэ:

1/бүтээл туурвисан Монгол Улсын иргэн, тус улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүн;

2/Монгол Улсад бүтээлээ анх удаа нийтийн хүртээл болгосон гадаадын иргэн. Гадаадын иргэн бүтээлээ өөр улсад нийтийн хүртээл болгосон өдрөөс хойш 30 хоногийн дотор Монгол Улсад нийтийн хүртээл болгосон бол Монгол Улсад анх удаа бүтээлээ нийтийн хүртээл болгосонтой адилаар үзнэ;

3/уран баримал, уран барилга болон барилга байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг болох дүрслэх урлагийн бүтээлээ тус улсын нутаг дэвсгэрт байнга байрлуулсан зохиогч;

4/зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжоор тогтоосон нөхцөл, хэмжээ хязгаарын дотор зохиогчийн эрх эдлэх хуулийн этгээд.

2.Албан үүргээ гүйцэтгэх журмаар туурвисан зохиогч тухайн байгууллагатай хийсэн гэрээ, хэлцэлд заасан болзол, нөхцөлийн хүрээнд уг бүтээлийнхээ зохиогчийн эрхийг эдэлнэ.

6 дугаар зүйл. Зохиогчийн эрхийн байгууллага

1.Бүтээл зохиогчийн эрхээр хамгаалагдсаныг баталгаажуулах зорилго бүхий Засгийн газрын бус зохиогчийн эрхийн байгууллага /цаашид "зохиогчийн эрхийн байгууллага" гэнэ/ байна.

2.Зохиогчийн эрхийн байгууллага нь дараахь үүрэг гүйцэтгэнэ:

1/тогтоосон журмын дагуу бүтээлийг бүртгэх, бүртгэлийн хураамжийг хураах. Бүтээл бүртгэх журмыг Засгийн газар тогтооно;

2/бүтээлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх;

3/бүтээл бүртгэсэн тухай мэдээллийг хэвлэн нийтлэх;

4/зохиогчийн эрхтэй холбогдсон маргааныг шийдвэрлэхэд тухайн байгууллагын хүсэлтээр холбогдох нотолгоо, сонирхогч этгээдийн хүсэлтээр лавлагаа гаргаж өгөх;

5/бүтээл ашиглахтай холбогдсон аргачилсан зөвлөмж гаргах;

6/зохиогчийн хүсэлтээр түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр эх бүтээл хадгалах, хамгаалахтай холбогдсон арга хэмжээ авах;

7/тодорхой бүтээлийн зохиогчийн эрхийг өөрийн болон гадаад улсад төлөөлөн хамгаалах.

3.Засгийн газар нь зохиогчийн эрхийн байгууллагатай энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан болон бусад үүргийг гүйцэтгүүлэх талаар Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гэрээ байгуулна. Зохиогчийн эрхийн байгууллага нь уг гэрээний биелэлтийг Монгол Улсын Соёлын сайд, улмаар Засгийн газрын өмнө хариуцна.

4.Зохиогчийн эрхийн байгууллагыг санхүүжүүлэх болон түүний үйл ажиллагаанд хяналт тавих журмыг Засгийн газар тогтооно.

5.Оюуны үнэт зүйлсийг хамгаалах сайн дурын байгууллага нь энэ хуулийн дагуу зохиогчийн эрхийг хэрэгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх зорилгоор зохиогчийн эрхийн байгууллагатай хамтран ажиллаж болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Зохиогчийн эдлэх эрх

7 дугаар зүйл. Зохиогчийн эдлэх эрх

Зохиогч бүтээлийнхээ хувьд эд хөрөнгийн бус амины эрх болон бүтээл ашиглах онцгой /эд хөрөнгийн/ эрх эдэлнэ.

8 дугаар зүйл. Эд хөрөнгийн бус амины эрх

Зохиогч бүтээлийнхээ хувьд эд хөрөнгийн бус амины дараахь эрх эдэлнэ:

1/нэр хэрэглэх. Зохиогч бүтээлээ өөрийн буюу зохиомол /нууц/ нэрээр, эсхүл нэргүйгээр нийтийн хүртээл болгох эрхтэй. Уг нэрийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөх, задруулахыг хориглоно;

2/нэрээ дурдуулах. Зохиогч бүтээлээ нийтийн хүртээл болгосон тохиолдолд тухай бүр нэрээ дурдуулах эрхтэй;

3/бүтээл нь халдашгүй байх. Бүтээл, бүтээлийн нэрийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр аливаа арга, хэлбэрээр хувиргах, гажуудуулахыг хориглоно.

9 дүгээр зүйл. Бүтээл ашиглах онцгой /эд хөрөнгийн/ эрх

1.Зохиогч бүтээлийнхээ хувьд бүтээл ашиглах дараахь онцгой /эд хөрөнгийн/ эрх эдэлнэ:

1/хуулбарлах, олшруулах. Зохиогч эх бүтээлээ хэвлэх, зурах сийлэх, цутгах, гэрэл зураг авах, дуу авиа, дүрс бичлэг хийх болон бусад аргаар хуулбарлах, олшруулах онцгой эрхтэй;

2/өөрчлөх, засварлах, орчуулах. Зохиогч өөрийн бүтээл, бүтээлийн нэрийг өөрчлөх, бүтээлээ засварлах, орчуулах онцгой эрхтэй;

3/нийтийн хүртээл болгох. Зохиогч эх бүтээл болон хуулбарласан, олшруулсан өөрийн бүтээлийг худалдах, шилжүүлэх зэргээр нийтийн хүртээл болгох онцгой эрхтэй;

4/танилцуулах. Зохиогч бүтээлээ зохиогчийн эрхийг шилжүүлэхгүйгээр аливаа арга хэлбэрээр бусдад танилцуулах онцгой эрхтэй.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхийг гагцхүү зохиогчийн зөвшөөрлөөр бусдад шилжүүлнэ.

3.Зохиогчийн бүтээлээ үнэлэх, бүтээлээ бусдад ашиглуулсны төлөө үнэ хөлс авах эрх эдэлнэ.

10 дугаар зүйл. Бүтээлд хэрэглэх таних тэмдэг

Бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигч нь нийтийн хүртээл болгосон бүтээлийн зохиогчийн эрх нь хамгаалагдсаныг илэрхийлэх дугуй хүрээтэй "С" гэсэн латин үсэг бүхий таних тэмдэг хэрэглэж болно. Уг таних тэмдгийн хамт бүтээлийг анх нийтийн хүртээл болгосон он, бүтээл ашиглах онцгой эрх эзэмшигчийн нэрийг бичнэ.

11дүгээр зүйл. Бүтээл ашиглах онцгой эрхээ бусдад шилжүүлэх

1.Бүтээлээ ашиглах онцгой эрхийг гагцхүү бичгээр үйлдсэн гэрээний үндсэн дээр бүрэн буюу хэсэгчилсэн бусад этгээдэд шилжүүлнэ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэрээнд дараахь зүйлийг заавал тусгана:

1/бүтээл ашиглах арга, хэлбэр, хугацаа;

2/зохиогчийн эдлэх эрх, хүлээх үүрэг;

3/бүтээлийг ашиглах этгээдийн эдлэх эрх, хүлээх үүрэг;

4/бүтээл ашигласны үнэ хөлсний хэмжээ, түүнийг олгох журам.

12 дугаар зүйл. Бүтээлийн зүйлийн өмчлөгч

1.Бүтээл илрэлээ олсон эд юмсыг бүтээлийн зүйл гэнэ. Бүтээлийн зүйлийг өмчлөгч этгээд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхдээ тухайн бүтээлийн зохиогчийн эрхийг хөндөхгүй.

2.Зохиогчийн худалдсан дүрслэх урлагийн болон хавсарга урлагийн бүтээлийн зүйлийг дуудлагын худалдаагаар худалдах буюу зуучлан дахин борлуулсан бол зохиогч тухай бүр борлуулсан үнийн 5 хувийг авах эрхтэй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бүтээлийг дайчлан авах, зохиогчийн зөвшөөрөлгүйгээр ашиглах

13 дугаар зүйл. Бүтээлийг дайчлан авах

1.Төр, түүний эрх бүхий байгууллага нь бүтээлийг нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн зохиогчтой гэрээ байгуулах үндсэн дээр худалдан авч болно. Хэрэв хоёр тал энэ талаар харилцан тохиролцоонд хүрээгүй бол төр, түүний эрх бүхий байгууллага нь уг бүтээлийг дайчлан авах эрхтэй.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тохиолдолд үнэ, нөхөх олговор болон бүтээл ашигласны үнэ хөлсийг төр, түүний эрх бүхий тухайн байгууллага олгоно.

Энэ талаар гарсан маргааныг шүүх шийдвэрлэнэ.

3.Дайчлан авсан бүтээлийг ашиглах журмыг Засгийн газар тогтооно.

14 дүгээр зүйл. Бүтээлийг нийтийн тусад нийцүүлэн нийтэд танилцуулах

1.Нийтийн хүртээл болсон бүтээлийг нийтийн тусад нийцүүлэн зохиогчийн нь зөвшөөрөлгүй, түүнд үнэ хөлс төлөхгүйгээр дараахь тохиолдолд зохиогчийн нэр болон бүтээлийн эх сурвалжийг дурдаж нийтэд хэсэгчлэн танилцуулж болно:

1/сургалтад ашиглах;

2/олон нийтийг хамарсан арга хэмжээний явцад орлого олох зорилгогүйгээр ашиглах;

3/албан ёсны болон нийтийг хамарсан хурал, цуглаан дээр хэлсэн үгийг тогтмол хэвлэл, радио, телевизээр дамжуулан нийтэд танилцуулах.

2.Энэ хуулийн 16 дугаар зүйлийн 5,7-д заасан тохиолдолд бүтээлийг хуулбарласан, олшруулсан этгээд нь зохиогчийн зөвшөөрөлгүй, түүнд хөлс төлөхгүйгээр бүтээлийг нийтэд танилцуулж болно.

15 дугаар зүйл. Бусдын бүтээлийг амины хэрэгцээнд зориулан хуулбарлах

1.Нийтийн хүртээл болсон бусдын бүтээлийг зохиогчийн зөвшөөрөлгүй, түүнд үнэ хөлс төлөхгүйгээр зөвхөн амины хэрэгцээнд зориулан хуулбарлаж болно.

2.Архитектурын бүтээл, барилга байгууламжийн зураг төслийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр амины хэрэгцээнд зориулан хуулбарлаж барилга барихыг хориглоно.

16 дугаар зүйл. Бүтээлийг нийтийн тусад нийцүүлэн хуулбарлах, олшруулах

Нийтийн хүртээл болсон бүтээлийг нийтийн тусад нийцүүлэн зохиогчийн нь зөвшөөрөлгүй, түүнд үнэ хөлс төлөхгүйгээр дараахь тохиолдолд зохиогчийн нэр болон бүтээлийн эх сурвалжийг дурдан хэсэгчлэн хуулбарлах буюу олшруулах болно:

1/архив, музей, номын санд тавигдсан бүтээлийг орлого олох зорилгогүйгээр ашиглах;

2/сургалтад ашиглах;

3/радио, телевизийн байгууллага тухайн бүтээлийг нэвтрүүлэгтээ ашиглах;

4/хараагүй хүмүүст зориулах;

5/судалгаа, шинжилгээ, шүүмжид зориулах;

6/болсон үйл явдлыг нийтэд мэдээлэхтэй холбогдуулан дүрслэх урлагийн болон хавсарга урлагийн бүтээлийг тогтмол хэвлэлд нийтлэх;

7/бүтээлийг гудамж, талбай зэрэг олон нийтийн газар байршуулсан бол. Харин түүнийг орлого олох зорилгоор ашиглавал зохиогчийн зөвшөөрлийг урьдчилан авч, түүнд төлөх үнэ хөлсний хэмжээг тохиролцсон байвал зохино;

8/худалдахаар буюу нийтэд үзүүлэхээр бэлтгэсэн бүтээлийг сурталчлах, зарлах;

9/хэвлэлд нийтлэгдсэн бүтээлийн талаар хэвлэлийн тойм бэлтгэх.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Зохиогчийн эрхийн хугацаа, эрх өвлөх

17 дугаар зүйл. Зохиогчийн эрхийн хугацаа

1.Тодорхой бүтээлийн зохиогчийн эрхийн хугацааг уг бүтээлийг туурвисан өдрөөс эхлэн тооцно.

2.Зохиогчийн бүтээлээ ашиглах онцгой эрх нь зохиогчийн насан туршид болон нас барснаас нь хойш 50 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

Зохиогч нас барснаас хойш зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрхийн хугацааг дараа жилийн нэгдүгээр сарын 1-нээс эхлэн тооцно. Хамтын бүтээл зохиогчдын хувьд сүүлчийн зохиогч нас барсны дараа жилийн нэгдүгээр сарын 1-нээс эхлэн уг хугацааг тооцно.

3.Зохиогч нь бүтээлээ зохиомол /нууц/ нэрээр буюу нэргүйгээр нийтийн хүртээл болгосон тохиолдолд ийнхүү бүтээл анх нийтийн хүртээл болсны дараа жилийн нэгдүгээр сарын 1-нээс эхлэн 75 жилийн хугацаанд уг зохиогчийн бүтээл ашиглах онцгой эрх хүчин төгөлдөр байна. Зохиомол /нууц/ нэрээр бүтээлээ нийтэлсэн зохиогчийн жинхэнэ нэр, эсхүл нэргүйгээр нийтлэгдсэн бүтээлийн зохиогч хэн болох нь нийтэд тодорхой болсон

бол зохиогчийн бүтээлээ ашиглах онцгой эрхийн хугацааг энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмын дагуу тооцно.

4.Хуулийн этгээдийн зохиогчийн эрх нь тухайн бүтээлийг туурвисны дараа жилийн нэгдүгээр сарын 1-нээс эхлэн 75 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

5.Зохиогчийн эд хөрөнгийн бус амины эрх хугацаагаар хязгаарлагдахгүй.

18 дугаар зүйл. Бүтээлийг улсын өв хөрөнгө болгон зарлах

Зохиогчийн эрхийн хугацаа дууссан бүтээлийг Засгийн газрын шийдвэрээр улсын өв хөрөнгө болгон зарлаж болно.

19 дүгээр зүйл. Зохиогчийн эрхийг өвлөх

1.Зохиогчийн бүтээлээ ашиглах онцгой эрхийг Монгол Улсын Иргэний хуульд заасан журмын дагуу өвлөнө. Зохиогчийн эд хөрөнгийн бус амины эрх өвлөгдөхгүй боловч өв болон эрх залгамжлагч уг эрхийг хамгаалах үүрэгтэй бөгөөд энэ эрх нь төрийн хамгаалалтад байна.

2.Хамтын бүтээл зохиогчдын бүтээлээ ашиглах онцгой эрхийн өв залгамжлал сүүлчийн зохиогч нас барсан өдрөөс эхлэн үүснэ. Харин уг бүтээлийг ашигласны үнэ, хөлсийг нас барсан зохиогчийн өв залгамжлагч болон үлдсэн зохиогч гэрээний дагуу хуваан авна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Үүсмэл бүтээл туурвигч, дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгч болон радио, телевизийн байгууллагын зохиогчийн эрхтэй холбогдох эрх

20 дугаар зүйл. Үүсмэл бүтээл туурвигчийн зохиогчийн эрхтэй холбогдох эрх

1.Жүжигчин, орчуулагч, эмхтгэгч, түүнчлэн найруулагч, дэглэгч, удирдаач зэрэг үүсмэл бүтээл туурвисан этгээд бүтээлийнхээ хувьд дараахь эрх эдэлнэ:

1/нэр хэрэглэх буюу нэрээ дурдуулах;

2/бүтээл нь халдашгүй байх;

3/бүтээлээ гэрээний үндсэн дээр аливаа арга хэлбэрээр бусдад ашиглуулах, түүний төлөө үнэ хөлс авах;

4/эх бүтээлийн зохиогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан бусад эрх.

2.Үүсмэл бүтээл туурвигчийн зохиогчийн эрхтэй холбогдох эрхийн хугацаа нь тухайн бүтээлийг туурвисны дараа жилийн

нэгдүгээр сарын 1-нээс эхлэн 25 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

3.Албан үүргээ гүйцэтгэх буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх журмаар туурвисан хамтын үүсмэл бүтээлийн туурвигчийн эрхийг гэрээнд өөрөөр заагаагүй бол уг бүтээлийг санхүүжүүлэгч /продюсор/ этгээд эдэлнэ.

21 дүгээр зүйл. Дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгчийн зохиогчийн эрхтэй холбогдох эрх

1.Дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгч зохиогчийн эрхтэй холбогдох дараахь эрх эдэлнэ:

1/дуу авиа, дүрс бичлэгээ хуулбарлах;

2/дуу авиа, дүрс бичлэгээ өөрчлөн найруулах;

3/дуу авиа, дүрс бичлэгээ олшруулан нийтийн хүртээл болгох;

4/дуу авиа, дүрс бичлэгээ гэрээний үндсэн дээр бусдад ашиглуулах, түүний төлөө үнэ хөлс авах;

5/эх бүтээлийн зохиогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан бусад эрх.

2.Дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгчийн зөвшөөрөлгүйгээр, түүнд үнэ хөлс төлөхгүйгээр нийтийн хүртээл болсон дуу авиа, дүрс бичлэгийг орлого олох зорилгогүйгээр ашиглаж болно.

3.Дуу авиа, дүрс бичлэгийн олшруулсан хувийг хөлсөөр эдлүүлэх газраар дамжуулан нийтийн хүртээл болгох эрхийг зөвхөн уг дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгч эдэлнэ.

4.Дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгчийн зохиогчийн эрхтэй холбогдох эрхийн хугацаа тухайн бичлэг анх хийгдсэний дараа жилийн нэгдүгээр сарын 1-нээс эхлэн 25 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Энэ хугацаанд үйлдвэрлэгчийн зөвшөөрөлгүйгээр дуу авиа, дүрс бичлэгээс дахин бичлэг хийхийг хориглоно.

22 дугаар зүйл. Радио, телевизийн байгууллагын зохиогчийн эрхтэй холбогдох эрх

1.Радио, телевизийн байгууллага зохиогчийн эрхтэй холбогдох дараахь эрх эдэлнэ:

1/өөрийн нэвтрүүлгийг нэгэн зэрэг нэвтрүүлэх эрхийг бусад радио болон телевизийн байгууллагад олгох;

2/телевизийн байгууллага радиод, радиогийн байгууллага телевизэд нэвтрүүлэг дамжуулах;

3/нэвтрүүлгийн бичлэгийг хуулбарлах;

4/эх бүтээлийн зохиогчтой байгуулсан гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан бусад эрх.

2.Радио, телевизийн байгууллагын зохиогчийн эрхтэй холбогдох эрхийн хугацаа уг нэвтрүүлгийг анх нэвтрүүлсний дараа

жилийн нэгдүгээр сарын 1-нээс эхлэн 25 жилийн хугацаанд хүчин төгөлдөр байна. Энэ хугацаанд радио, телевизийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр уг нэвтрүүлгийг хуулбарлах, дамжуулан нэвтрүүлэх, бичлэг ашиглан нэвтрүүлэх зэргээр нийтэд танилцуулахыг хориглоно.

23 дугаар зүйл. Дуу авиа, дүрс бичлэг үйлдвэрлэгч, үүсмэл бүтээл туурвигч болон радио, телевизийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр бүтээлийг ашиглах

Үүсмэл бүтээл болон дуу авиа, дүрс бичлэг, радио, телевизийн нэвтрүүлгийг нийтийн тусад нийцүүлэн холбогдох этгээдийн нь зөвшөөрөлгүйгээр, түүнд үнэ хөлс төлөхгүйгээр дараахь тохиолдолд хэсэгчлэн танилцуулж болно:

1/радио, телевизийн нэвтрүүлгээр үүсмэл бүтээл болон дуу авиа, дүрс бичлэг нэвтрүүлэх;

2/сургалт болон эрдэм шинжилгээний ажилд ашиглах;

3/мэдээлэх зорилгоор иш татан хэрэглэх.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

24 дүгээр зүйл. Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1.Зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч 25000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2.Бүтээлд хэрэглэх таних тэмдгийг хуурамчаар үйлдэж хэрэглэсэн, уг таних тэмдгийн хамт бичигдсэн зүйлийг өөрчилсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүгч 25000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3.Бүтээл ашиглах онцгой эрхийг зөрчсөнөөр учирсан эд хөрөнгийн хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг Монгол Улсын Иргэний хуулийн дагуу шийдвэрлэнэ.

4.Иргэдээс нийтийн хүртээл болсон бүтээлийг зохиогчийн зөвшөөрөлгүй, үнэ хөлс төлөхгүйгээр өрх гэрийнхээ хүрээнд ашиглах явдлыг зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомж зөрчсөн гэж үзэхгүй.

25 дугаар зүйл. Зохиогчийн эд хөрөнгийн бус амины эрхийг хамгаалах

Бүтээлийн халдашгүй байдал болон зохиогчийн эд хөрөнгийн бус амины бусад эрхийг зөрчсөн тохиолдолд зохиогч нь, харин зохиогч нас барсан бол түүний өв болон эрх залгамжлагч, харин хууль ёсоор буюу гэрээслэлээр өв залгамжлагч байхгүй, эдгээр өвлөгчид өв залгамжлахаас татгалзсан буюу тэдгээрийн өв залгамжлах эрх хасагдсан бол зохиогчийн эрхийн байгууллага нь зөрчигдсөн эрхийг зохих журмаар сэргээн тогтоохыг уг эрхийг зөрчсөн этгээдээс шаардах, улмаар шүүхэд гомдлоо гаргаж шийдвэрлэх эрхтэй.

26 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

1.Энэ хууль 1993 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2.Энэ хуулийг буцааж хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

1993 оны 6 дугаар сарын 22-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 6 дугаар сарын 25 өдөр

Улаанбаатар хот

ХУУЛИЙН ЗАРИМ ХЭСГИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Патентийн тухай хууль батлагдсантай холбогдуулан БНМАУ-ын Иргэний хуулийн "Шинэ бүтээлийн эрх" гэсэн VI хэсгийг 1993 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

ШУДАРГА БУС ӨРСӨЛДӨӨНИЙГ ХОРИГЛОХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь зах зээл дэх аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөөнд төрөөс хяналт тавих, ноёрхох болон шударга өрсөлдөөнд харш бусад үйл ажиллагааг хориглох, хязгаарлахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомж

Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон Монгол улсын хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Давамгайлах байдал, дангаар ноёрхогч, ноёрхох үйл ажиллагаа

1.Аж ахуйн нэгж дангаараа, эсхүл хэд хэдэн аж ахуйн нэгж хамтдаа тухайн зах зээлд нийлүүлж байгаа нэг буюу ижил төрлийн бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээ /цаашид "бараа" гэх/-ний 50-иас дээш хувийг тогтвортой эзэлж байгааг давамгайлах байдалд тооцно.

2.Тухайн зах зээлд нэг буюу ижил төрлийн барааг ганцаараа нийлүүлж байгаа аж ахуйн нэгжийг дангаар ноёрхогчид тооцно.

Хэрэв дангаар ноёрхогч аж ахуйн нэгж хамгийн бага зардлаар, хэрэглэгчдэд ашигтай хувилбараар нэг буюу ижил төрлийн бараагаар тухайн зах зээлийг хангаж байвал түүнийг зүй ёсны дангаар ноёрхогчид тооцно.

3.Давамгайлах байдлаа хууль бусаар ашиглаж өрсөлдөгчөө зах зээлд гарч ирэхэд саад учруулах, өрсөлдөөнийг болон хэрэглэгчдийг хясан боогдуулахыг ноёрхох үйл ажиллагаанд тооцно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Зах зээлд ноёрхох үйл ажиллагааг хориглох

4 дүгээр зүйл. Аж ахуйн нэгж давамгайлах байдлаа хууль бусаар ашиглахыг хориглох

Давамгайлах байдалтай аж ахуйн нэгж тухайн зах зээлд дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/зохиомлоор барааны хомсдол бий болгож үнийг өсгөх зорилгоор барааны үйлдвэрлэл борлуулалтыг зогсоох, хэмжээг хязгаарлах;

2/ижил нөхцөлд ажиллаж байгаа бусад аж ахуйн нэгжтэй харьцуулахад тухайн аж ахуйн нэгжийг тэгш бус байдалд хүргэж болзошгүй нөхцөлийг хэлцэлд тусгахыг шаардах;

3/бусад аж ахуйн нэгж зах зээлд гарч ирэхэд саад учруулах, тэдгээрийг зах зээлээс шахан зайлуулах зорилгоор бараагаа өөрийн зардлаас доогуур үнээр борлуулах;

4/бусад аж ахуйн нэгжийг зах зээлээс шахан зайлуулах зорилгоор тэдгээртэй аж ахуйн харилцаа тогтоохоос үндэслэлгүйгээр татгалзах;

5/бараагаа борлуулахдаа тухайн худалдан авагчид хэрэгцээгүй, эсхүл иж бүрдэлд ороогүй бараа дагалдуулах;

6/худалдан авагчдаа тухайн барааг цааш борлуулах үнэ, нутаг дэвсгэрийг тогтоож өгөх;

7/бараагаа борлуулахдаа өрсөлдөгчийнхөө барааг худалдан авахгүй байх болзол тулгах;

8/тухайн барааны үйлдвэрлэл, борлуулалтыг бууруулахад хүргэж болох бага үнээр уг барааг өөртөө худалдахыг бусдаас шаардах;

9/өрсөлдөгчөө задрах, тарахыг шаардах.

5 дугаар зүйл. Өрсөлдөөнд саад учруулсан хэлцэл хийхийг хориглох

Хамтдаа давамгайлах байдалтай, өрсөлдөгч аж ахуйн нэгжүүд өрсөлдөөнд саад учруулахын тулд хуйвалдаж дараахь зорилгод чиглэсэн хэлцлийг аливаа хэлбэрээр хийхийг хориглоно:

1/барааны үнэ тогтоох, өөрчлөх, үйлдвэрлэл, борлуулалтыг зогсоох, хэмжээг хязгаарлах;

2/зах зээлийг нутаг дэвсгэр, эсхүл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны нэр төрөл, худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваан авах;

3/аж ахуйгаа ашигтай эрхлэх зорилгоор аль нэг байгууллагад гишүүнээр элсэхэд нь өрсөлдөгчдөө саад тавих;

4/бусад аж ахуйн нэгжийг зах зээлээс шахан зайлуулах зорилгоор тэдгээртэй аж ахуйн харилцаа тогтоохоос үндэслэлгүйгээр татгалзах;

5/бараа худалдах болон худалдан авахад үнээр өрсөлдөхөөс татгалзах.

6 дугаар зүйл. Өрсөлдөгч аж ахуйн нэгжийн удирдлагад ажиллахыг хориглох

Давамгайлах байдалтай аж ахуйн нэгжийн удирдлага өрсөлдөгч бусад аж ахуйн нэгжийн удирдлагад хавсарч ажиллахыг хориглоно.

7 дугаар зүйл. Өрсөлдөгчөө эрхшээлдээ авахыг хориглох

1.Давамгайлах байдалтай аж ахуйн нэгж зах зээлд ноёрхох үйл ажиллагаа явуулах зорилгоор өрсөлдөгчийнхөө хөрөнгө, хувьцааг авч түүний эрх, үүргийг өөртөө шилжүүлэх, эсхүл гүүнтэй хөрөнгөө нийлүүлж аж ахуйн шинэ нэгж болохыг хориглоно.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэг улсын эдийн засагт тэргүүлэх чиглэлийн болон хүн амд нэн шаардлагатай барааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, гадаад зах зээлд тухайн барааны өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зэрэг ашигтай тал нь өрсөлдөөнд учруулах сохирлоос илүүтэй байх тохиолдолд хамаарахгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Шударга өрсөлдөөнд харш үйл ажиллагааг хориглох

8 дугаар зүйл. Аж ахуйн нэгжид хориглох үйл ажиллагаа

Аж ахуйн нэгж шударга өрсөлдөөнд харш дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1/өрсөлдөгчийнхөө болон түүний барааны нэр хүндийг бууруулах, эсхүл түүнийг алдагдалд оруулах зорилгоор худал, зөрүүтэй буюу гуйвуулсан мэдээ тараах;

2/өөрийн болон өрсөлдөгчийн үйлдвэрийн газар, түүний байршил, түүнчлэн бараа үйлдвэрлэсэн арга, хэрэглээний шинж, чанарын гол үзүүлэлт, хэрэглэх аргын талаар худал, зөрүүтэй мэдээлэх, эсхүл үнэн байдлыг гуйвуулах зэргээр бусдыг төөрөгдүүлэх;

3/өөрийн барааг бусдынхтай ижилсгэн сурталчлах;

4/бусдын барааны тэмдэг, шошго, үйлдвэрийн нэр, барааны чанарын баталгааг дур мэдэн хэрэглэх, түүнчлэн барааны нь оноосон нэр, баглаа, боодлыг хуулбарлах;

5/эзэмшигчийнх нь зөвшөөрөлгүйгээр шинжлэх ухаан, технологи, үйлдвэрлэл, худалдааны мэдээлэл, нууцыг худалдах, нийтлэх, бусдад тараах. Энэ нь Монгол Улсын патентийн болон зохиогчийн эрхийн тухай хууль тогтоомжоор хамгаалагдаагүй, зах зээлд чөлөөтэй худалдагдаж байгаа барааг дуурайлган дахин угсран бүтээхэд хамаарахгүй;

6/барааны чанарын доголдол, аюултай шинж чанарыг нуун дарагдуулах.

9 дүгээр зүйл. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн шийдвэр гаргахыг хориглох

1.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд дараахь шийдвэр гаргахыг хориглоно:

1/аж ахуйн нэгж тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах, бараа үйлдвэрлэх, борлуулахыг хориглосон буюу хязгаарласан;

2/аж ахуйн нэгж бараагаа нэг зах зээлээс нөгөөд борлуулахыг хориглосон буюу хязгаарласан;

3/аж ахуйн нэгжид бусдаас илүү нөхцөл бүрдүүлсэн, эсхүл түүнийг ялгаварлан гадуурхсан;

4/аж ахуйн үйл ажиллагааны аливаа чиглэлээр тухайн зах зээлд аж ахуйн шинэ нэгж гарч ирэхийг хориглосон буюу хязгаарласан.

2.Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд өөр хоорондоо болон аль нэг аж ахуйн нэгжтэй урьдчилан тохирч дараахь шийдвэр гаргахыг хориглоно.

1/барааны үнийг өсгөсөн, бууруулсан, эсхүл нэг хэмжээнд барихад чиглэсэн;

2/зах зээлийг нутаг дэвсгэр, эсхүл үйлдвэрлэл, борлуулалтын хэмжээ, барааны нэр төрөл, худалдагч, худалдан авагчийн хүрээгээр хуваарилан өгөхөд чиглэсэн;

3/аж ахуйн нэгж тухайн зах зээлд гарч ирэхийг хязгаарласан, эсхүл түүнийг зах зээлээс шахан зайлуулахад чиглэсэн.

3.Байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюулын улмаас учирсан хохирлыг нөхөхөд зориулж Засгийн газар, түүний эрх, олгосон байгууллагаас бүх төрлийн зээл олгох, тусламж үзүүлэхийг өрсөлдөөнийг хязгаарласанд тооцохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Шударга бус өрсөлдөөнийг хориглох талаарх үйл ажиллагааг хянах, зохицуулах

10 дугаар зүйл. Улсын Их Хурлаас явуулах үйл ажиллагаа

Улсын Их Хурал шударга бус өрсөлдөөнийг хориглох талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/шударга өрсөлдөөнийг дэмжих төрийн бодлогын үндсийг тодорхойлох;

2/аж ахуйн нэгжүүд зах зээлд шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх талаар Засгийн газраас гаргаж байгаа шийдвэр хууль тогтоомжид хэрхэн нийцэж байгаад хяналт тавих;

Засгийн газрын шийдвэр шударга өрсөлдөөнийг хориглосон буюу хязгаарласан гэж үзвэл түүнийг Улсын Их Хурал хүчингүй болгоно.

11 дүгээр зүйл. Засгийн газраас явуулах үйл ажиллагаа

1.Засгийн газар дараахь асуудлаар шийдвэр гаргахдаа Улсын Их Хуралтай зөвшилцөнө:

1/зүй ёсны дангаар ноёрхогч аж ахуйн нэгж үндэслэлгүй хэт өндөр ашиг олохоор байвал төрийн хяналт тогтоож үнийн зохицуулалт хийх;

2/зах зээлд зүй ёсны дангаар ноёрхогчтой өрсөлдөгч орж ирэх нөхцөлийг тогтоох;

3/экспорт, импортын үйл ажиллагааг хязгаарлах буюу зогсоох.

2.Шударга бус өрсөлдөөнийг хориглох, хязгаарлах, хянах, зохицуулах талаар Монгол Улсын сайд бөгөөд Үндэсний хөгжлийн газрын дарга эрхлэх асуудлынхаа хүрээнд дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, түүнийг боловсронгуй болгох, хэрэгжүүлэх журмын талаарх санал боловсруулж Засгийн газарт оруулах;

2/аймаг, нийслэлийн засаг дарга шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомжийг зөрчсөн шийдвэр гаргасан бол уг шийдвэрийг хүчингүй болгуулах тухай санал Ерөнхий сайдад гаргах;

3/аж ахуйн нэгжийг дангаар болон зүй ёсны дангаар ноёрхогч, эсхүл давамгайлах байдалтай гэдгийг, эсхүл энэ байдлаа алдсаныг тогтоолгохын тулд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжээс шаардлагатай мэдээ, баримт гаргуулан авах;

4/дангаар ноёрхогч болон давамгайлах байдлаа хууль бусаар ашиглаж байгаа аж ахуйн нэгжийг задлахыг тухайн аж ахуйн нэгжийн удирдлагаас шаардах;

5/шударга бус өрсөлдөөнийг хориглох, хязгаарлах, хянах, зохицуулах талаар гаргасан шийдвэрийнхээ тухай нийтэд мэдээлэх.

12 дугаар зүйл. Шүүхээс явуулах үйл ажиллагаа

1.Шүүх шударга бус өрсөлдөөнийг хориглохтой холбоотой дараахь асуудлаар шийдвэр гаргана:

1/Засгийн газар, түүний эрх олгосон байгууллагаас гаргаж өгсөн баримт бичгийг үндэслэн аж ахуйн нэгж дангаар болон зүй ёсны дангаар ноёрхогч, давамгайлах байдалтай гэдгийг, эсхүл энэ байдлаа алдсаныг тогтоох, Шүүх шийдвэрээ нийтэд зарлан мэдээлнэ;

2/шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомж зөрчсөн аж ахуйн нэгжийн буруутай үйл ажиллагааг таслан зогсоох, гэрээгээ бүрэн буюу хэсэгчлэн биелүүлэхийг шаардах, эсхүл түүнийг цуцалж, зөрчил гарахаас өмнө байдлыг сэргээх.

2.Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомж зөрчсөн талаарх маргааныг шүүх шийдвэрлэнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

13 дугаар зүйл. Шударга бус өрсөлдөөний талаар гомдол гаргах

Аж ахуйн нэгж, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалах олон нийтийн болон бусад байгууллага, иргэн шударга бус өрсөлдөөний талаарх дараахь гомдлоо дор дурдсан байгууллагад бичгээр гаргана:

1/энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг Засгийн газар зөрчсөн тухай гомдлоо Улсын Их Хуралд;

2/энэ хуулийн бусад зүйлд хориглосон үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгж, төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны талаарх гомдлоо Засгийн газар, түүний эрх олгосон байгууллагад.

14 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1.Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомж зөрчсөнөөс бусдад учруулсан эд хөрөнгийн хохирлыг гэм буруутай этгээдээр хууль тогтоомжийн дагуу нөхөн төлүүлнэ.

2.Шударга бус өрсөлдөөнийг хориглох тухай хууль тогтоомж зөрчсөн дараахь тохиолдолд шүүх дор дурдсан шийтгэл ногдуулна:

1/энэ хуулийн 4,5,7,8 дугаар зүйлийг зөрчсөн аж ахуйн нэгжийн эзэн буюу эрх баригч этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол 25000 хүртэл төгрөгөөр торгох;

2/энэ хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан шийдвэр гарснаас хойш шүүхээс тогтоосон хугацаанд уг шийдвэрийг хүндэтгэх шалтгаангүйгээр биелүүлээгүй буюу биелүүлэхэд саад учруулсан бол энэ хугацаанаас хойш хууль бусаар олсон орлого буюу эд зүйлийг хурааж 10000 хүртэл төгрөгөөр торгох;

3/энэ хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан мэдээ, баримтыг зохих албан тушаалтанд гаргаж өгөөгүй санаатайгаар гуйвуулсан, худал, зөрүүтэй гаргаж өгсөн аж ахуйн нэгжийн эзэн буюу эрх баригч этгээдийг 10000 хүртэл төгрөгөөр торгох.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

1993 оны 7 дугаар сарын 5-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 7 дугаар сарын 5 өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 26 дугаар зүйлийн 1,5,6,12 дахь хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 4,13 дахь хэсгийн 1,5 дахь заалт, 27 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 34 дүгээр зүйлийн 1,4,7,10 дахь хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 4,8 дахь хэсгийн 1,3,5 дахь заалт, 42 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Хувираа эрхлэх аж ахуйг иргэний гаргасан өргөдөл, бусад аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулагчийн бичгээр үйлдсэн гэрээ, дүрмийг үндэслэн Улсын татварын ерөнхий газар, аймаг, нийслэлийн татварын алба, сум, дүүргийн татварын алба /цаашид "бүртгэх байгууллага" гэх/ харьяаллын дагуу бүртгэнэ.

Хууль тогтоомжид заасны дагуу тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвшөөрөл, гэрчилгээг авсан байна."

26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Компанийн эрх барих байгууллага нь бүх гишүүний хурал бөгөөд чөлөөт цагт нь түүний бүрэн эрхийг төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

Компанийн үйл ажиллагааны цар хүрээ, онцлогоос шалтгаалж төлөөлөн удирдах зөвлөлийг байгуулахгүйгээр түүний бүрэн эрхийг Ерөнхий захирал хэрэгжүүлж болно."

26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

"4/төлөөлөн удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүн, Ерөнхий захирлыг сонгох, чөлөөлөх, тэдгээрт олгох цалин хөлс, урамшууллыг тогтоох;"

26 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5.Бүх гишүүний хурлыг төлөөлөн удирдах зөвлөл зарлан хуралдуулах бөгөөд хурлаар хэлэлцэх асуудлыг холбогдох танилцуулгын хамт хурал эхлэх өдрөөс 21-ээс доошгүй хоногийн өмнө гишүүн бүрт хүргэнэ.

Хууль тогтоомж болон гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх гишүүний хурлаар хэлэлцсэн асуудлыг саналыг олонхиор шийдвэрлэнэ."

26 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

"6.Бүх гишүүний хуралд компанийн дүрмийн сангийн 50-иас дээш хувийг эзэмшигчид оролцож байвал хурлыг хүчин төгөлдөр гэж тооцох боловч хэлэлцэх асуудлын төрөл, компанийн гишүүдийн тоо зэргийг харгалзан компанийн дүрэмд өөрөөр тогтоож болно. Ингэхдээ тайлан тэнцэл батлах, ашиг хуваарилах, компанийн удирдлагыг сонгох, компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг хэлэлцэх хурлыг компанийн дүрмийн сангийн 50-иас доош хувийг эзэмшигчдийн ирцтэй хийхээр дүрэмд зааж болохгүй.

Бүх гишүүний хурлыг төлөөлөн удирдах зөвлөлийн дарга удирдах бөгөөд түүний эзгүйд хурлыг удирдах хүнийг дүрэмд заана."

26 дугаар зүйлийн 12 дахь хэсэг:

"12.Бүх гишүүний хурал нь Ерөнхий захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх тухай асуудлыг саналын дийлэнх олонхиор шийдвэрлэнэ.

Ерөнхий захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр тухайн компанийн гишүүн биш хүнийг сонгож болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн нь бүх гишүүний хурлын зөвшөөрөлгүйгээр өөр аж ахуйн нэгжийн удирдлагад байхыг хориглоно.

Төлөөлөн удирдах зөвлөлийг түүний гишүүдийн дотроос сонгосон дарга толгойлно. Ерөнхий захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, даргыг сонгох хугацаа, журам, зөвлөлийн гишүүний тоог дүрэмд заана."

26 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн 1 дэх заалт:

"1/компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, төлөөлөн удирдах зөвлөлд ажлаа тогтмол мэдээлнэ;"

26 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн 5 дахь заалт:

"5/бүрэн эрхийнхээ асуудлаар тушаал гаргана.Ерөнхий захирал төлөөлөн удирдах зөвлөлтэй зөвшилцөн шийдвэрлэх асуудлыг хуульд өөрөөр заагаагүй бол бүх гишүүний хурлаас тогтооно;"

27 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5.Ерөнхий захирлын болон төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан шийдвэртэй холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд хяналтын зөвлөлөөс томилсон хяналтын зөвлөлийн гишүүн нь тухайн компанийг төлөөлөн оролцож болно."

34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:

"1.Компанийн эрх барих байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд чөлөө цагт нь түүний бүрэн эрхийг төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ."

34 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 4 дэх заалт:

"4/төлөөлөн удирдах болон хяналтын зөвлөлийн гишүүнийг сонгох, чөлөөлөх, тэдгээрт олгох цалин хөлс, урамшууллыг тогтоох;"

34 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:

"4.Хувьцаа эзэмшигчдийн хуралд энэ хуулийн 26 дугаар зүйлийн 6,7,9,10 дахь хэсэг, төлөөлөн удирдах зөвлөлд энэ хуулийн 26 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, 26[1] дүгээр зүйлийн 1,2,3,4 дэх хэсэг нэгэн адил хамаарна."

34 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:

"7.Ерөнхий захирлыг төлөөлөн удирдах зөвлөл сонгоно."

34 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 1 дэх заалт:

"1/компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдаж, төлөөлөн удирдах зөвлөлд ажлаа тайлагнана;"

34 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 3 дахь заалт:

"3/компанийн тайлан тэнцэл, эд хөрөнгө, ашиг хуваарилах журмын талаар санал боловсруулж төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ;"

34 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 5 дахь заалт:

"5/бүрэн эрхийнхээ асуудлаар тушаал гаргана."

34 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг:

"10.Ерөнхий захиралд энэ хуулийн 26 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн 3,7 дахь заалт, мөн зүйлийн 14 дэх хэсэг нэгэн адил хамаарна."

42 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид харьяалагдах үйлдвэрийн газрын даргыг тухайн нэгжийн Засаг дарга, бусад үйлдвэрийн газрын даргыг Засгийн газрын гишүүн буюу түүний эрх олгосноор уг үйлдвэрийн газрыг харьяалах дээд байгууллагын удирдлага гэрээний үндсэн дээр тус тус томилно."

2.Аж ахуйн нэгжийн тухай хуульд дор дурдсан агуулгатай 2[1],7[1],26[1] дүгээр зүйл, 26 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн 8 дахь заалт, 26 дугаар зүйлийн 16 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалтыг тус тус нэмсүгэй:

2[1] дүгээр зүйл:

"2[1] дүгээр зүйл. Аж ахуйн нэгжүүд нэгдэх

Салбарын нутаг дэвсгэрийн буюу бусад зарчмыг үндэс болгож, үйл ажиллагаагаа зохицуулах, ашиг сонирхлоо төрийн болон бусад байгууллага, түүнчлэн олон улсын байгууллагад төлөөлөх

зорилгоор аж ахуйн нэгжүүд хуульд заасан үндэслэл, журмын дагуу аливаа хэлбэрээр нэгдэж болно."

7/дүгээр зүйл:

"7/дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

1.Аж ахуйн нэгжийг улсын бүртгэлд бүртгүүлэлгүй ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан бол бүртгэх байгууллага олсон орлогыг хураж 500-10000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

2.Дүрэмд орсон өөрчлөлтийг бүртгэх байгууллагад хуульд заасан хугацаанд мэдэгдээгүй буюу гэрээ, дүрэмд зохих нэмэлт, өөрчлөлт хийж улсын бүртгэлд бүртгүүлэлгүйгээр тэдгээрт заснаас өөр төрлийн ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ явуулсан бол аж ахуйн нэгжийн гэм буруутай албан тушаалтанд бүртгэх байгууллага 500-10000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3.Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 3,28 дугаар зүйлийн 1,3, 36 дугаар зүйлийн 1,4 дэх хэсгүүдэд заасан журмыг зөрчсөн бол бүртгэх байгууллага 1000-25000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна."

26/дүгээр зүйл:

"26/дүгээр зүйл. Төлөөлөн удирдах зөвлөл

1.Төлөөлөн удирдах зөвлөл дор дурдсан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/компанийн эдийн засаг, технологийн бодлого, хэтийн төлөв, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тодорхойлох;

2/компанийн аппаратын зохион байгуулалтын бүтэц, цалингийн сан, урамшууллын журмыг тогтоох;

3/Компанийн өмч хөрөнгийг захиран зарцуулах талаарх Ерөнхий захирлын эрх хэмжээг тогтоох;

4/компанийн гишүүдийн бүртгэлийг хөтлөх /бүртгэлд гишүүний тоо, нэр, хаяг, дүрмийн санд оруулсан хувь хөрөнгө, нэмэлт ажил гүйцэтгэх, үйлчилгээ хийх тухай гишүүний хүлээсэн үүрэг зэргийг бичнэ/, бүртгэлд орсон өөрчлөлтийн талаар бүртгэх байгууллагад мэдээлэх;

5/бүх гишүүний хурлыг зарлан хуралдуулах;

6/компанийн тайлан тэнцэл, ашиг хуваарилалт, дүрмийн сангийн өөрчлөлтийн талаар хэлэлцэх, эдгээр асуудлаар бүх гишүүний хуралд дүгнэлт гаргах;

7/дүрэмд заасан бусад бүрэн эрх.

2.Төлөөлөн удирдах зөвлөл эрх хэмжээнийхээ асуудлыг хурлаараа хэлэлцэж олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хурлаас тогтоол гаргах бөгөөд түүнд зөвлөлийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарна.

3.Төлөөлөн удирдах зөвлөл ажлаа бүх гишүүний хуралд хариуцан тайлагнана.

4.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн орон гарсан бол түүний бүрэн эрхийг төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр бүх гишүүний дараагийн хурал хүртэлх хугацаанд өөр этгээдэд шилжүүлж болно.

5.Ганц гишүүнтэй компанийн үүсгэн байгуулагч нь төлөөлөн удирдах зөвлөлийн холбогдох бүрэн эрхийг хэрэгжүүлж болно."

26 дугаар зүйлийн 13 дахь хэсгийн 8 дахь заалт:

"8/шаардлагатай бол бүх гишүүний хурлыг зарлан хуралдуулах.

26 дугаар зүйлийн 16 дахь хэсэг:

"16.Ерөнхий захирал, төлөөлөн удирдах зөвлөлийн хооронд санал зөрвөл Ерөнхий захирал нь төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэрийг биелүүлэх үүрэгтэй."

33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

"7/хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн буюу төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын протокол, Ерөнхий захирлын тушаал, компанийн санхүүгийн тайлантай танилцах эрхтэй;"

3.Аж ахуйн нэгжийн тухай хуульд "БНМАУ" гэснийг "Монгол Улс" гэж;

Мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "орон нутгийн Ардын Хурлын гүйцэтгэх захиргаанд" гэснийг "бүртгэх байгууллагад";

26 дугаар зүйлийн 4,9 дэх хэсэгт "Ерөнхий захиралд" гэснийг "төлөөлөн удирдах зөвлөлд";

26 дугаар зүйлийн 9,10,11 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, 34 дүгээр зүйлийн 3,6 дахь хэсэгт "Ерөнхий захирал" гэснийг "төлөөлөн удирдах зөвлөл";

39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "компанийг" гэснийг "аж ахуйн нэгжид" гэж тус тус өөрчилсүгэй.

4.Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "харьяалалгүй хүмүүс" гэсний дараа "дангаараа эсхүл Монгол Улсын аж ахуйн нэгж, иргэдтэй хамтран";

3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3, мөн зүйлийн 4 дэх хэсгийн 2, 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтын "эрхлэх ажил" гэсний дараа ",үйлдвэрлэл, үйлчилгээний төрөл,";

3 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн "өргөдлөө гаргана." гэсний дараа "Аж ахуйн нэгжийн оноосон нэр нь урьд улсын бүртгэлд бүртгэгдсэн аж ахуйн нэгжийн оноосон нэртэй давхардсан байж болохгүй. Гэрээ, дүрмийн үндэслэлийг бүртгэх байгууллага шалгах эрхтэй.";

26 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн 2 дахь дэд хэсгийн "Ерөнхий захирал" гэсний дараа ",төлөөлөн удирдах";

33 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Хувьцаа эзэмшигч гэнэ." гэсний дараа "Төрийн өмчийн оролцоотой компанийн төрийн төлөөллийг орон нутгийн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгжийн хувьд тухайн шатны Засаг дарга, улсын төвлөрсөн төсөвтэй харьцдаг аж ахуйн нэгжийн хувьд Засгийн газраас эрх олгосон яам, тусгай газар хэрэгжүүлнэ";

38 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Ерөнхий захирал," гэсний дараа "төлөөлөн удирдах болон" гэж тус тус нэмсүгэй.

5.Аж ахуйн нэгжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 3 дахь хэсгээс "Хөдөө аж ахуйн нэгдэл аж ахуйн нэгжийн аль ч хэлбэрээр зохион байгуулагдаж болно.";

4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгээс "түүнийг зарлан хуралдуулахыг шаардах";

17 дугаар зүйлээс "түүнчлэн гишүүдээс тодорхой хугацаагаар хоршоонд ашиглуулахаар шилжүүлсэн биет зүйлс нь хоршооны эд хөрөнгөд хамаарна.";

26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалт;

26 дугаар зүйлийн 4 дэх хэсгээс "Ерөнхий захирлын зөвшөөрснөөр";

26 дугаар зүйлийн 8 дахь хэсгээс "Энэ нь саналын хувиас шалтгаалан хойшлогдсон хуралд хамаарахгүй";

26 дугаар зүйлийн 14 дэх хэсгээс "гишүүн болон";

34 дүгээр зүйлийн 8 дахь хэсгийн 3 дахь заалтыг тус тус хассугай.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн нарийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 7 дугаар сарын 8 өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэнд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг тогтоох, эрүүл мэндийн даатгалыг бий болгох, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, даатгалын болон эрүүл мэндийн байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж

Эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Эмнэлгийн төлбөргүй тусламж

3 дугаар зүйл. Эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журам

1.Монгол Улсын иргэнд түүний даатгуулсан эсэхийг үл харгалзан эмнэлгийн дараахь тусламжийг төлбөргүй үзүүлнэ:

1/улсын эмнэлгийн поликлиник, амбулатори, өрх /хэсэг, сум/-ийн эмчийн үзлэг, шинжилгээ, үйлчилгээ;

2/эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ;

3/эрүүл ахуй, халдвар судлалын үйлчилгээ, урьдчилан сэргийлэх тарилга, халдварт өвчний голомтын ариутгал, халдваргүйтгэл;

4/жирэмсэн, төрөх, төрсний дараахь үед эмнэлгийн заалтаар хийлгэсэн үзлэг, шинжилгээ, эмчилгээ /зөвхөн жирэмслэлт, төрөлттэй холбоотой шалтгаанаар/;

5/сүрьеэ, бруцеллёз, дархлалын олдмол хомсдол зэрэг архаг халдварт өвчин, удамшлын эмгэг, чихрийн шижин, эдгээртэй адилтгах удаан хугацаанд нөхөх эмчилгээ шаардагдах өвчин, хорт хавдар, сэтгэцийн зарим эмгэгийн эмчилгээ;

6/нийтийг хамрах аюул бүхий байгалийн гамшиг, халдварт өвчний дэгдэлтийн үед гэмтсэн, өвчилсөн хүмүүсийн эмчилгээ;

7/аргагүй хамгаалалт, гарцаагүй байдалд хүний амь нас аврахаар болон их хэмжээний хохирлоос сэргийлж яваад гэмтсэн, өвчилсөн хүмүүсийн эмчилгээ.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эмнэлгийн төлбөргүй тусламжийг улсын эмнэлэг хариуцаж, гарсан зардлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан төлбөргүй тусламж авсан иргэн эрүүл мэнд, амь насаа зориуд бусниулахыг оролдсон болон гэмт хэрэг, зөрчлийн улмаас эмнэлгийн тусламж авахад хүрсэн, эмнэлгийн түргэн тусламжийн үйлчилгээ, эмнэлгийн бусад тусламжийг хувийн ашиг сонирхлын үүднээс урвуулан ашигласан бол гарсан зардлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлнэ.

4.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-4-д заасан эмнэлгийн тусламжийг үзүүлэх заавар, мөн хэсгийн 5-д заасан өвчний нэр, үе шатыг тодорхойлсон жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нөхөн төлбөр гаргуулах зааврыг төсөв, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага гаргана.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Эрүүл мэндийн даатгал

4 дүгээр зүйл. Эрүүл мэндийн даатгал, түүний хэлбэр

1.Эрүүл мэндийн даатгал нь иргэн болон төр, аж ахуйн нэгж, байгууллагаас зохих журмын дагуу даатгалын хураамж төлж, даатгалын санг урьдчилан бүрдүүлэх, даатгуулагчийг хэвтэн /стационарт/ эмчлүүлэхэд гарсан эмчилгээ, үйлчилгээний зардлын төлбөрийг уг сангаас төлөх ажуулга бүхий нийгэм, эдийн засгийн арга хэмжээ мөн.

2.Эрүүл мэндийн даатгал /цаашид "даатгал" гэх/ нь заавал даатгуулах, сайн дураар даатгуулах гэсэн хэлбэртэй байна.

5 дугаар зүйл. Даатгалын зөвлөл

1.Даатгалын орон тооны бус үндэсний зөвлөлийг /цаашид "даатгалын зөвлөл" гэх/ Засгийн газрын дэргэд ажиллуулна. Даатгалын зөвлөлийн дүрмийг Засгийн газар батлаж, даргыг нь томилно.

2.Даатгалын зөвлөл нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/даатгалын сангын ашиглалт, зарцуулалтад хяналт тавих;

2/даатгалтай холбогдсон асуудлаар санал, дүгнэлт гаргаж, холбогдох байгууллагад шийдвэрлүүлэхээр оруулах;

3/даатгалтай холбогдсон асуудлаар зөвлөмж гаргах;

4/даатгалын гэрээний болон гэрчилгээний загварыг батлах.

3.Даатгалын зөвлөл нь дор дурдсан байгууллагуудаас тус бүр тэнцүү тооны төлөөлөгч оролцуулсан бүрэлдэхүүнтэй байна:

1/даатгагч, түүний эрх ашгийг төлөөлсөн байгууллага;

2/даатгуулагч, түүний эрх ашгийг төлөөлсөн байгууллага;

3/эрүүл мэндийн /эмнэлгийн/ байгууллага;

4/төрийн захиргааны төв байгууллага /төсөв, санхүү, [illegible]ль, хөдөлмөр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн/.

4.Даатгалын зөвлөл нь аймаг, нийслэлийн Засаг даргын [illegible]эд орон тооны бус салбар зөвлөлтэй байна.

6 дугаар зүйл. Даатгалыг эрхлэх байгууллага

Даатгалыг Засгийн газраас эрх олгосон даатгалын байгууллага /цаашид "даатгагч" гэх/ эрхэлнэ.

7 дугаар зүйл. Даатгалд хамрагдах хүрээ

1.Монгол Улсын дараахь иргэн эрүүл мэндийн даатгалд заавал даатгуулна:

1/аж ахуйн нэгж, байгууллагын ажилтан;

2/хувиараа хөдөлмөр эрхлэгч, аж ахуйн нэгжийн эзэн;

3/16 хүртэлх насны хүүхэд /ерөнхий боловсролын сургуульд суралцаж байгаа бол 18 нас хүртэлх/;

4/мэргэжлийн сургуульд суралцагч;

5/тэтгэврээс өөр мөнгөн орлогогүй иргэн;

6/хүүхдээ 2 нас /ихэр бол 3 нас/ хүртэл нь өсгөн бойжуулахаар чөлөө авсан эх;

7/тахир дутуугийн I,II зэрэг тогтоолгосон иргэн;

8/хугацаат цэргийн жинхэнэ албан хаагч;

9/малчин.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас бусад Монгол Улсын иргэн, түүнчлэн гадаадын иргэн, харьяалалгүй хүн даатгалд сайн дураар даатгуулна /даатгалд даатгуулсан Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг цаашид "даатгуулагч" гэнэ/.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан даатгуулагч өөрөө хүсвэл сайн дураар давхар даатгуулж болно.

8 дугаар зүйл. Даатгалын хураамжийн хувь хэмжээ, бүрдүүлэх журам

1.Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2-т заасан даатгуулагчийн төлөх даатгалын хураамжийн хувь хэмжээг тэд-

ний цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын 6 хувиас хэтрүүлэхгүйгээр Засгийн газар жил бүр тогтооно.

2.Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-9-д заасан даатгуулагчийн даатгалын зөвлөлөөс оруулсан саналыг үндэслэн жил бүр тогтооно.

3.Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасан даатгуулагчийн төлөх даатгалын хураамжийн 50-иас доошгүй хувийг аж ахуйн нэгж, байгууллага нь төлөх бөгөөд үлдэх хэсгийг нь даатгуулагч өөрөө төлнө.

4.Аж ахуйн нэгж, байгууллагын ажилтныхаа төлөө төлөх даатгалын хураамжийг албан татвар ногдуулах орлогоос нь хасна.

5.Төрийн өмчийн төсөвт байгууллагын ажилтны даатгалын хураамжийн 50-иас доошгүй хувьтай тэнцэх хөрөнгийг тухайн байгууллагын төсөвт нь жил бүр тусгана.

6.Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-9-д заасан даатгуулагчийн даатгалын хураамжийг төр хариуцна. Даатгалын хураамжийг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс тухайн шатны төсвийн захирагч нь улирал бүрийн эхний 14 хоногт баг таан даатгагчид шилжүүлнэ.

7.Хорих ял эдэлж байгаа ялтны даатгалын хураамжийг засан хүмүүжүүлэх байгууллага нь төлнө.

8.Сайн дураар даатгуулагч нь даатгагчтай байгуулсан гэрээнд заасныхаа дагуу даатгалын хураамж төлнө.

9 дүгээр зүйл. Даатгалын сан

1.Даатгалын сан даатгалын хураамж болон бусад эх үүсвэрээс бүрдэнэ.

2.Даатгалын санг даатгуулагчийн хэвтэн /стационарт/ эмчлүүлсэн эмчилгээ, үйлчилгээ /цаашид "эмчилгээ" гэх/-тэй холбогдсон даатгалын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна.

3.Даатгалын сангийн үлдэгдлийг дараа жилийн даатгалын хураамжийн хувь хэмжээг тогтооход харгалзана.

10 дугаар зүйл. Даатгалын гэрээ

1.Даатгуулагч нь даатгагчтай даатгалын гэрээ байгуулна.

Уг гэрээнд дор дурдсан асуудлыг заавал тусгана:

1/гэрээ байгуулагч талуудын хүлээх үүрэг, хариуцлага;

2/даатгалын хураамжийн хэмжээ, түүнийг төлөх хугацаа;

3/даатгалын сангаас төлөх төлбөрийн хэмжээ;

4/гэрээг дүгнэх, сунгах, цуцлах болзол, гэрээний нохцөл.

2.Даатгалын гэрээний үлгэрчилсэн загварыг даатгалын зөвлөл батална.

11 дүгээр зүйл. Даатгалын гэрчилгээ

1.Даатгалын гэрээ байгуулсан даатгуулагчид даатгалын гэрчилгээ олгоно.

2.Даатгалын гэрчилгээ нь нэг талаас даатгуулагч эрүүл мэндээ даатгуулсныг, нөгөө талаас даатгагч тухайн даатгуулагчийг даатгалд авсныг гэрчлэх албан ёсны баримт болно.

3.Даатгалын гэрчилгээ нь даатгалын гэрээнд заасны дагуу хураамж төлсөн тэмдэглэлийг тухай бүр хийлгэсэн тохиолдолд хүчинтэйд тооцогдоно.

4.Гэрчилгээний загварыг даатгалын зөвлөл батална.

12 дугаар зүйл. Даатгуулагчийн эмчилгээний зардлын төлбөрийг төлөх

1.Даатгуулагчийн эмчилгээний зардлын төлбөрийг эмнэлгийн /улсын болон баталгаа бүхий хувийн/ байгууллагаас бүрдүүлсэн төлбөрийн нэхэмжлэлийг үндэслэн даатгалын сангаас төлнө.

2.Эмчилгээний зардлын төлбөрийг даатгалын зөвлөлийн саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон тарифаар тооцно.

3.Эмнэлгийн байгууллага даатгуулагчийн эмчилгээний зардлыг нэгтгэн тооцож сард 2 удаа даатгагчид төлбөрийн нэхэмжлэл гаргана.

4.Даатгагч төлбөрийн нэхэмжлэлийг хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногт багтаан төлбөр хийнэ.

Эмнэлгийн байгууллага, түүний ажилтны буруу үйл ажиллагааны улмаас эмчилгээний нэмэгдэл зардал гарсан нь нотлогдсон тохиолдолд уг зардлын төлбөрийг даатгалын сангаас төлөхгүй байж болно.

5.Даатгуулагч хариуцсан өрх /хэсэг, сум/-ийн эмчийн жороор эмийн сангаас зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад заасан эм авсан бол уг эмийн үнийн 50 хувийг даатгалын сангаас түүнд нөхөн олгоно.

Зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлах нийтэд тогтмол мэдээлнэ.

6.Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан даатгуулагчийн дараахь эмчилгээний зардлын төлбөр, эмийн үнийг даатгалын сангаас төлөхгүй, даатгуулагч өөрөө хариуцна:

1/гоо сайхны үйлчилгээ, засал;

2/бүх төрлийн протез /нүдний шил, сонсголын аппарат, хиймэл шүд гэх мэт/;

3/өөрийн хүсэлтээр хийлгэсэн нэмэлт үйлчилгээ;

4/эмийн сангаас авсан эм /зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад заасан эмийн үнийн 50 хувийг энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу даатгагч нөхөн төлнө/;

5/Засгийн газраас тогтоосон бусад төлбөрт үйлчилгээ.

7.Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2-т заасан даатгуулагч ажилгүй болсон тохиолдолд даатгалтай байсан нийт хугацааных нь 25 хувьтай тэнцэх хугацаанд түүний эмчилгээний зардлын төлбөрийг даатгагч төлнө.

8.Энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан даатгуулагчийн тухайн жилийн төлбөртэй эмчилгээний 100 мянга хүртэл төгрөгийн зардлыг даатгалын сангаас төлөх бөгөөд 100 мянган төгрөгөөс давсан хэсгийг 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-9-д заасан даатгуулагчийн хувьд төрөөс хариуцаж, 1,2-т заасан даатгуулагчийн хувьд сайн дурын даатгалаар болон өөрөө шууд төлнө.

9.Энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан журам сайн дураар даатгуулагчдад хамаарахгүй.

10.Даатгалгүй хүнд эмнэлгийн тусламж үзүүлсний дараа эмчилгээний төлбөрийг тооцно.

13 дугаар зүйл. Даатгалын сангаас гарсан зардлыг нөхөн төлүүлэх

Даатгалын сангаас гарсан дараахь зардлыг дор дурдсан этгээдээр нөхөн төлүүлнэ:

1/гэмт хэрэг, зөрчлийн улмаас эрүүл мэнд нь хохирсон даатгуулагчийн эмчилгээний зардлын төлбөрийг гэм хор учруулсан буруутай этгээдээр;

2/хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны журам зөрчигдсөн, орчинд нь аюул учруулах нөхцөл бүрдсэний улмаас эрүүл мэнд нь хохирсон /осол гэмтэл, хордлогод өртөх мэргэжлээс шалтгаалах өвчнөөр өвчлөх зэрэг/ даатгуулагчийн эмчилгээний зардлын төлбөрийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагаар.

14 дүгээр зүйл. Даатгалын хөнгөлөлт

1.Даатгуулагч 3 жил дараалан даатгалын сангаас төлбөр гаргуулаагүй бол дараагийн нэг жилд төлөх даатгалын хураамжийг 10 хувиар бууруулна.

2.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан болзлыг үргэлжлүүлэн хангасан тохиолдол бүрт хөнгөлөлт 10 хувиар нэмэгдэх боловч түүний дээд хэмжээ нь нэг жилд төлөх даатгалын хураамжийн 50 хувиас хэтэрч болохгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Бусад зүйл

15 дугаар зүйл. Даатгалын хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1.Аж ахуйн нэгж, байгууллага, төсвийн захирагч даатгалын хураамжийг энэ хууль болон гэрээнд заасан хугацаанд шилжүүлээгүй бол уг хураамжийг нөхөн төлүүлж, хугацаа хэтрүүлсэн хоног тутамд зохих хураамжийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг даатгагчид төлнө.

2.Даатгуулагч нь даатгалын гэрээнд заасан хугацаанд даатгалын хураамжийг төлөөгүй бол уг гэрээнд заасан хариуцлага хүлээнэ.

3.Энэ хуулийн 12 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, 13 дугаар зүйлд заасан эмчилгээний зардлын төлбөр, нөхөн төлбөр төлөхөөс зайлсхийвэл учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг шүүхээр шийдвэрлүүлнэ.

4.Даатгагч нь эмнэлгийн байгууллагад төлөх төлбөрийг хугацаа хожимдуулсан бол уг төлбөрийг нөхөн төлүүлж, хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлбөл зохих төлбөрийн 0,1 хувьтай тэнцэх алдангийг тухайн эмнэлгийн байгууллагад төлнө.

5.Энэ зүйлийн 1,2,4 дэх хэсгийг хэрэгжүүлэхтэй холбогдсон гомдол, маргааныг шүүх шийдвэрлэнэ.

6.Даатгалын хураамж, төлбөрийн тооцооны хугацаа хожимдуулсан буюу бүртгэл тооцоог будлиантуулсан албан тушаалтанд Монгол Улсын хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

16 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

1.Энэ хууль 1993 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2.Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан даатгалын хураамж төлөх, 12 дугаар зүйлд заасан эмчилгээний зардлын төлбөр хийх тухай заалтуудыг 1994 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын
дарга Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий нарийн
бичгийн дарга Н.РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 7 дугаар сарын 8-ны өдөр

Улаанбаатар хот

ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ ХУУЛИЙН ЗАРИМ ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль батлагдсантай холбогдуулан Эрүүлийг хамгаалах хуулийн 3 дугаар зүйл, 4 дүгээр зүйлийн 5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

2.Эрүүлийг хамгаалах хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгээс "үнэ төлбөргүй" гэснийг хассугай.

Монгол Улсын Их Хурлын дарга — Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга — Н.РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 7 дугаар сарын 9 өдөр

Улаанбаатар хот

УЛСЫН ХИЛИЙГ ХАМТРАН ШАЛГАХАД БАРИМТЛАХ ЧИГЛЭЛИЙН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1 дүгээр зүйл. Улсын хилийг хамтран шалгах явцад байгалийн нөлөөллөөс шалтгаалан газрын гадаргуу, усны гольдрил өөрчлөгдсөнөөс хилийн шугамын байршлыг тодотгох шаардлага гарсан тохиолдолд хил залгаа улстай хилийн дэглэмийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний дагуу тогтоосон

хилийн шугамыг уул шугамаас аль нэг тийш 200 метр хүртэл зайд өөрчилж тухайн өөрчилсөн газар нутгийг адил чанарын газар нутгаар сольж зохицуулах асуудлыг Монгол Улсын Засгийн газар тухай бүрд нь шийдвэрлэж, хил шалгах ажлын төгсгөлөөр нэгтгэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ.

2 дугаар зүйл. Энэ хуулийн 1 дүгээр зүйлд зааснаас илүү хэмжээний газар нутгийн зохицуулалтын асуудлыг Засгийн газар тухай бүрд нь Улсын Их Хуралд өргөн мэдүүлж шийдвэрлүүлнэ.

3 дугаар зүйл. Энэ хууль батлагдсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 7 дугаар сарын 9 өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН 1993 ОНЫ УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСӨВТ ТОДОТГОЛ ХИЙХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газраас 1993 оны улсын төвлөрсөн төсөвт тодотгол хийх тухай өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын 1993 оны улсын төвлөрсөн төсвийн тухай 1993 оны нэгдүгээр сарын 12-ны өдрийн хуулиар батлагдсан улсын төвлөрсөн төсвийн орлогын нийт дүнг 18411073,6 мянган төгрөгөөр, зарлагын нийт дүнг 19783119,6 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсүгэй.

Хоёр. 1993 оны улсын төвлөрсөн төсвийн орлогын нийт дүн, орлогын нэр төрлийн хэмжээг дор дурдсанаар нэмэгдүүлсүгэй:

/мянган төгрөгөөр/

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ОРЛОГО-БҮГД	18411073,6
1.АЛБАН ТАТВАР	14600757,4
Үүнээс: 1/орлогын албан татвар	8159501,4
2/гаалийн албан татвар	2675000,0
3/худалдааны албан татвар	2894198,9
4/онцгой албан татвар	872057,1
2.ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3810316,2
1/хувьцааны ногдол ашиг	2237972,8
2/бусад орлого	1572343,4

Гурав. 1993 оны улсын төвлөрсөн төсвийн зарлагын нийт дүн, үүний дотор цалин, хөрөнгө оруулалт, удирдлага, батлан хамгаалах арга хэмжээний зардал, Засгийн газраас тогтоосон төвлөрүүлэн захирагчийн төсвийн санхүүжилт, Засгийн газрын тусгай зориулалтын сан, аймаг, нийслэлийн төсөвт өгөх татаасын хэмжээг дор дурдсанаар нэмэгдүүлсүгэй:

/мянган төгрөгөөр/

1.УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ЗАРЛАГА - БҮГД	19783119,6
1/цалингийн сан /нөхөн олговор ороод/	398851,8
2/хөрөнгө оруулалт	500046,7
Үүнээс: шинээр эхлэх барилга объектын төсөвт өртөг	—
3/удирдлагын зардал	1231258,4
4/батлан хамгаалах арга хэмжээний зардал	853796,9
5/шүүхийн байгууллагын зардал	41352,1
6/улсын аюулгүй байдлыг хангах байгууллагын зардал	277719,8
7/Засгийн газрын тусгай зориулалтын санд олгох татаас - бүгд	2752256,0
а/тэтгэвэрийн санд олгох татаас	2672256,0
б/амьдрал ядуу, бага орлоготой айл өрх, иргэдэд туслах санд олгох татаас	80000,0
8/аймаг, нийслэлийн төсөвт өгөх татаас-бүгд	5407266,0

Дөрөв. Улсын төвлөрсөн төсвөөс аймаг, нийслэлийн төсөвт өгөх татаасын хэмжээг дор дурдсанаар нэмэгдүүлсүгэй:

/мянган төгрөгөөр/

Архангай	276652,7	Дундговь	279675,6
Баян-Өлгий	224010,2	Завхан	485705,8
Баянхонгор	425105,9	Өвөрхангай	232230,9
Булган	224706,6	Өмнөговь	145814,1
Говь-Алтай	380318,8	Сүхбаатар	303978,4

Дорноговь	123961,6	Сэлэнгэ	236638,8
Дорнод	110933,6		
Төв	235248,1	Дархан	23614,0
Увс	347205,0	Улаанбаатар	171941,6
Ховд	473393,4	Чойр	54718,9
Хөвсгөл	472500,1	Эрдэнэт	40271,1
Хэнтий	338620,8		

Тав. Энэ хууль батлагдсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 7 дугаар сарын 9 өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ГААЛИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1.Монгол Улсын Гаалийн хуулийн 15 дугаар зүйлд дор дурдсан заалт бүхий хэсэг нэмсүгэй:

"2.Зах зээлийн эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан Засгийн газар ард түмний өдөр тутмын хэрэглээний хүнсний болон өргөн хэрэглээний үндсэн нэрийн барааны гаалийн албан татварыг 100 хүртэл хувиар, үйлдвэрлэл, техникийн зориулалттай барааны гаалийн албан татварыг 50 хүртэл хувиар хөнгөлж болно."

2.Энэ хууль батлагдсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь улсын тэмдэгтийн хураамжийг тогтоох, төлөх, хураахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хууль тогтоомж

Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хууль тогтоомж нь Татварын ерөнхий хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамж

Төрийн зохих байгууллагаас эрх олгох, эрх шилжихтэй холбогдсон баримт бичиг олгох буюу бүртгэх, гэрээ хэлцэл, баримт бичгийг батлан гэрчлэх, иргэний бүртгэл хийх, шүүхээс эрх зүйн маргааныг шийдвэрлэхтэй холбогдсон үйлчилгээ үзүүлсний төлөө зохих этгээдээс төлж байгаа мөнгөн хөрөнгийг улсын тэмдэгтийн хураамж /цаашид "хураамж" гэх/ гэнэ.

4 дүгээр зүйл. Хураамж төлөгч

Энэ хуульд заасан хураамж төлөх үйлчилгээгээр үйлчлүүлж байгаа Монгол Улсын иргэн, гадаадын иргэн, харьяалалгүй хүн болон аж ахуйн нэгж, байгууллага нь хураамж төлөгч байна.

5 дугаар зүйл. Хураамж хураах үйлчилгээний төрөл

Хураамжийг дор дурдсан үйлчилгээнд хураана:

1/шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх;

2/нотариатын үйлчилгээ үзүүлэх;

3/иргэний байдлын бүртгэл хийх, паспорт, зөвшөөрөл, виз олгох;

4/консулын үйлчилгээ үзүүлэх;

5/тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгох;

6/буу бүртгэх;

7/сонин, сэтгүүл бүртгэх;

8/аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэх;

9/гадаадын байгууллагын төлөөлөгчийн газар ажиллуулах, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрөл олгох;

10/тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зөвшөөрөл олгох;

11/шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент, барааны тэмдэгт гэрчилгээ олгох, патентийг хүчинтэй байлгах болон лицензийн гэрээ бүртгэх;

12/зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг бүртгэх;

13/хуулиар хураамж төлөхөөр заасан бусад үйлчилгээ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хураамжийн хэмжээ

6 дугаар зүйл. Шүүхээс эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэхэд хураах хураамжийн хэмжээ

Эрх зүйн маргааныг хянан шийдвэрлүүлэхээр өргөдөл, гомдол, нэхэмжлэл шүүхэд гаргах болон шүүхээс баримт бичиг олгоход дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/эд хөрөнгийн чанартай бөгөөд үнэлж болох нэхэмжлэлд:

Нэхэмжлэлийн үнэ	Хураамжийн хувь хэмжээ
1000 төгрөг хүртэл	20 төгрөг
1001-3000 төгрөг	50 төгрөг
3001-10000 төгрөг	Нэхэмжлэлийн үнийн дүнгийн 2 хувь
10001-50000 төгрөг	Нэхэмжлэлийн үнийн дүнгийн 3 хувь
50001 төгрөг, түүнээс дээш бол	Нэхэмжлэлийн үнийн дүнгийн 4 хувь

2/эд хөрөнгө бус, түүнчлэн үнэлж болохгүй нэхэмжлэлд 50 төгрөг;

3/хэрэгт байгаа нотлох баримтын хуулбар, түүнчлэн шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас дахин олгоход хуудас тутмаас 5 төгрөг.

7 дугаар зүйл. Нотариатын үйлчилгээний хураамжийн хэмжээ

1.Нотариатын үйлчилгээнд дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/үнэ тодорхойгүй гэрээ хэлцлийг батлан гэрчлэхэд 100 төгрөг;

2/эд хөрөнгө хөлслөх, түрээслэх гэрээ хэлцлийг батлан гэрчлэхэд 150 төгрөг;

3/итгэмжлэл батлан гэрчлэхэд 100 төгрөг;

4/гэрээ, хэлцэлд өөрчлөлт оруулсан, хугацааг нь сунгасныг батлан гэрчлэхэд 100 төгрөг;

5/аж ахуйн нэгж үүсгэн байгуулсан гэрээ, баримт бичиг батлан гэрчлэхэд 400 төгрөг;

6/аж ахуйн нэгж үүсгэн байгуулсан гэрээ, баримт бичигт оруулсан нэмэлт, өөрчлөлтийг батлан гэрчлэхэд 100 төгрөг;

7/энэ зүйлийн 1-6-д зааснаас бусад гэрээ хэлцлийг батлан гэрчлэхэд гэрээний үнийн дүнгийн 1 сая хүртэл төгрөгөөс 0,5 хувиар, 1 сая төгрөгөөс давсан хэсгээс 0,2 хувиар;

8/өв хөрөнгийн гэрээслэлийг батлан гэрчлэхэд 100 төгрөг;

9/эд хөрөнгө, хадгаламжийн дансанд байгаа мөнгө, өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгоход үнийн дүнгийн 1 сая хүртэл төгрөгөөс 0,5 хувиар, 1 сая төгрөгөөс давсан хэсгээс 0,2 хувиар;

10/гэрлэгсдийн дундын эд хөрөнгөөс оногдох хувиа өмчлөх эрхийн гэрчилгээ олгоход 50 төгрөг;

11/бичиг баримтын хуулбар батлан гэрчлэхэд хуудас тутмаас 10 төгрөг;

12/орчуулсан бичиг баримтыг батлан гэрчлэхэд хуудас тутмаас 20 төгрөг;

13/бичиг баримтад зурсан гарын үсгийн үнэн зөвийг батлан гэрчлэхэд 10 төгрөг;

14/төлбөр гаргуулахаар нотариатын гүйцэтгэх бичиг олгоход 100 төгрөг;

15/аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн байр, хувийн орон сууцны байшин, зарим эд хөрөнгийг бусдад шилжүүлэхийг хориглох баримт олгоход 20 төгрөг;

16/иргэн амьд буюу тодорхой газарт байгааг батлан гэрчлэхэд 30 төгрөг;

17/бичиг баримтыг ирүүлсэн он, сар, өдрийг батлан гэрчлэхэд 50 төгрөг;

2.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 7,9-д заасан хураамжийн дээд хэмжээ нь 500000 төгрөгнөөс хэтрэхгүй байна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-7-д заасан хэлцлийг батлан гэрчилснийг хураамжийг гэрээнд өөрөөр заагаагүй бол хэлэлцэн тохирогч талууд тэнцүү хуваажтөлнө.

8 дугаар зүйл. Иргэний байдлын бүртгэл хийх, паспорт, зөвшөөрөл, виз олгоход хураах хураамжийн хэмжээ

1.Иргэний байдлын бүртгэл хийхэд дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/төрснийг бүртгэж, гэрчилгээ олгоход 20 төгрөг;

2/гэрлэлтийг бүртгэж, гэрчилгээ олгоход 25 төгрөг;

3/гэрлэлтийг цуцалсан тэмдэглэл хийхэд хүн бүрээс 50 төгрөг;

4/овог, нэр өөрчилсөн баримт бичиг олгоход 20 төгрөг;

5/овог, нэрийг сольсон гэрчилгээ олгоход 50 төгрөг;

6/иргэний баримт бичгийн архиваас лавлагаа олгоход 10 төгрөг.

2.Монгол Улсын иргэний паспорт олгох, түүнд тэмдэглэл хийхэд дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/иргэний паспорт олгоход 300 төгрөг;

2/иргэний паспортын хугацааг сунгахад 15 төгрөг;

3/иргэний паспортод оршин суугаа газрын хаяг, гэрлэлт болон бусад тэмдэглэл хийхэд 10 төгрөг.

3.Гадаадын иргэн, харьяалалгүй хүн /цаашид "Гадаадын иргэн" гэх/-д зөвшөөрөл, виз олгох, түүнийг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/Монгол Улсад байнга оршин суух зөвшөөрөл олгоход 10000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөт валют;

2/байнга оршин суух үнэмлэх олгоход 300 төгрөг;

3/байнга оршин суух хугацаа сунгахад 2000 төгрөг;

4/байнга оршин суух үнэмлэхэд хаягийн болон бусад тэмдэглэл хийх тухай бүрт 10 төгрөг;

5/Монгол Улсад суралцаж байгаа гадаадын иргэнийг бүртгэхэд 100 төгрөг;

6/гадаадын иргэнийг хувийн журмаар Монгол Улсад урих урилга олгоход 500 төгрөг;

7/байнга оршин суух үнэмлэхтэй гадаадын иргэнд Монгол Улсаас гарах орох виз олгоход 500 төгрөг;

8/байнга оршин суух үнэмлэхтэй гадаадын иргэнд Монгол Улсаас гарах виз олгоход 250 төгрөг;

9/дамжин өнгөрөгч Монгол Улсад түр байх зөвшөөрөл авахад 2000 төгрөг;

10/Монгол Улсад зочлох, түр хугацаагаар оршин суух зөвшөөрлийг сунгахад хоног тутам 400 төгрөг.

9 дүгээр зүйл. Консулын үйлчилгээний хураамжийн хэмжээ

1.Гадаад паспорт, буцах үнэмлэх, зорчих зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт олгоход 500 төгрөг;

2/дипломат, албан паспорт олгоход 300 төгрөг;

3/Монгол Улсад буцах үнэмлэх олгоход 2000 төгрөг буюу түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөт валют;

4/Гадаад паспортын хүчинтэй хугацааг сунгахад 20 төгрөг;

5/Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспортаар нэг жилийн хугацаанд олон удаа зорчих зөвшөөрөл олгоход 2000 төгрөг;

6/Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспортаар нэг удаа зорчих зөвшөөрөл олгоход 500 төгрөг;

2.Монгол Улсад зорчих гадаадын иргэнд виз олгоход дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/орох буюу гарах виз олгоход тус бүр АНУ-ын 20 доллар /цаашид "ам. доллар" гэх/ буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

2/орох гарах буюу гарах орох виз олгоход тус бүр 25 ам. доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

3/дамжин өнгөрөх виз олгоход удаа бүр 15 ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

4/6 сар хүртэлх хугацааны олон удаагийн виз олгоход 65 ам. доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

5/визийн хугацааг долоо хүртэл хоногоор анх удаа сунгахад 15 ам.доллар, дараагийн хоног тутамд 2 ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют;

6/нэг визэд хавсрагдсан иргэдийн визийг салгахад 5 ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний бусад валют.

3.Консулын үйлчилгээг яаралтай /8 цагийн дотор/ хийх тохиолдолд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан хураамжийн хэмжээг 100 хувиар нэмэгдүүлэн хураана.

4.Консулын болон дипломат төлөөлөгчийн газрууд нь энэ хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2-д заасан хураамжийг гадаадын валютаар хурааж болох боловч энэ тохиолдолд түүний хэмжээ 1 ам. доллараас доошгүй байна.

5.Консулын байгууллага нь энэ хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2,3,4,7, 8,9,11,12,13,16-д заасан хураамжийг гадаадын валютаар хурааж болох боловч энэ тохиолдолд түүний хэмжээ 1 ам. доллараас доошгүй байна.

6.Баримт бичиг консулын баталгаа гаргахад 1 ам доллар буюу түүнтэй тэнцэх бусад валютын хураамж хураана.

10 дугаар зүйл. Тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг бүртгэх, жолоодох зөвшөөрөл олгоход хураах хэмжээ

1.Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтэр, жолоодох зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ, ашиглалтын дэвтэр олгоход 50 төгрөг;

2/авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийг жолоодох эрхийн үнэмлэх олгоход 150 төгрөг, үнэмлэхийн хавсралт талон олгоход 100 төгрөг.

2.Автомашин, өөрөө явагч хэрэгсэл, мотоциклийн улсын дугаар олгоход дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/автомашины улсын дугаар олгоход 200 төгрөг;

2/өөрөө явагч хэрэгсэл, чиргүүлийн улсын дугаар олгоход 150 төгрөг;

3/мотоциклийн улсын дугаар олгоход 100 төгрөг.

3.Агаарын хөлөг,аэродромыг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэж, гэрчилгээ олгоход 10000 төгрөг;

2/аэродромыг улсын бүртгэлд бүртгэж гэрчилгээ олгоход 10000 төгрөг.

11 дүгээр зүйл. Бууны бүртгэлийн хураамжийн хэмжээ

Буу бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын бууг бүртгэж, үнэмлэх олгоход 50 төгрөг;

2/гадаадын анчдын бууг бүртгэхэд 10 ам. доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөг;

12 дугаар зүйл. Сонин сэтгүүлийг бүртгэхэд хураах хураамжийн хэмжээ

Тус улсын нутаг дэвсгэрт нийтлэгдэн гарах сонин, сэтгүүлийг улсын бүртгэлд бүртгэхэд 2000 төгрөгийн хураамж хураана.

13 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагыг бүртгэхэд хураах хураамжийн хэмжээ

1.Өмчийн бүх төрөлд хамаарах аж ахуйн нэгж, байгууллагыг улсын бүртгэлд бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/компани бүртгэж гэрчилгээ олгоход 5000 төгрөг;

2/хоршоо бүртгэж гэрчилгээ олгоход 3000 төгрөг;

3/хувиараа эрхлэх аж ахуй бүртгэж гэрчилгээ олгоход 2500 төгрөг;

4/банк, даатгалын байгууллага бүртгэж гэрчилгээ олгоход 10000 төгрөг;

5/улс төрийн нам, олон нийтийн байгууллага бүртгэхэд 5000 төгрөг;

6/аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлд өөрчлөлт хийхэд 200 төгрөг.

2.Аж ахуйн нэгж, байгууллагад улсын бүртгэлийн гэрчилгээ дахин олгоход энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1-5-д заасан хураамжийн хэмжээг 1,5 дахин нэмэгдүүлэн хураамж хураана.

14 дүгээр зүйл. Гадаадын байгууллагын төлөөлөгчийн газар ажиллуулах, гадаадын хөрөнгө

оруулалттай аж ахуйн нэгж байгуулах зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээ

1.Гадаадын байгууллагын төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/төлөөлөгчийн газар нээж ажиллуулахад 500 ам. доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөг;

2/ажиллах хугацааг нь сунгахад 200 ам. доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөг.

2.Гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийг байгуулах зөвшөөрөл олгоход дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/гэрчилгээ анх олгох, түүнийг солиход 3000 төгрөг;

2/гэрчилгээний хугацааг сунгахад 1500 төгрөг.

15 дугаар зүйл. Тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зөвшөөрөл олгоход хураах хураамжийн хэмжээ

Хууль тогтоомжид заасны дагуу тодорхой мэргэжил, тусгай зөвшөөрөл шаардах үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах зөвшөөрөл олгоход 2500 төгрөгийн хураамж хураана.

16 дугаар зүйл. Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент, барааны тэмдэгт гэрчилгээ олгох, патентийг хүчинтэй байлгах болон лицензийн гэрээ бүртгэхэд хураах хураамжийн хэмжээ

Шинэ бүтээл, бүтээгдэхүүний загварт патент, барааны тэмдэгт гэрчилгээ олгох, патентийг хүчинтэй байлгах болон лицензийн гэрээг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/патент олгоход 960 төгрөг;

2/барааны тэмдгийг бүртгэж гэрчилгээ олгоход 850 төгрөг;

3/шинэ бүтээлийн патентийг дараахь хугацаанд хүчинтэй байлгахад:

а/эхний 3 жилд 8000 төгрөг;

б/4-6 жилд 14200 төгрөг;

в/7-10 жилд 28800 төгрөг;

г/11-15 жилд 56500 төгрөг;

д/16-20 жилд 94200төгрөг.

4/хугацаа сунгасан шинэ бүтээлийн патентийг дараахь хугацаанд хүчинтэй байлгахад:

а/эхний 5 жилд 98500 төгрөг;

б/5 жилээс дээш 112000 төгрөг.

5/бүтээгдэхүүний загварын патентийг дараахь хугацаанд хүчинтэй байлгахад:

а/эхний 2 жилд 6000 төгрөг;

б/3-5 жилд 9000 төгрөг;

в/6-10 жилд 22000 төгрөг.

6/хугацаа сунгасан бүтээгдэхүүний загварын патентийг хүчинтэй байлгахад /5 жилд/ 18600 төгрөг;

7/барааны тэмдгийн бүртгэлийг дараахь ангиллаар хүчинтэй байлгахад /10 жилд/:

а/нэг ангиллаар 940 төгрөг;

б/нэгээс дээш ангилал тус бүрд 280 төгрөг;

в/лицензийн гэрээ бүртгэхэд 800 төгрөг.

17 дугаар зүйл. Зохиогчийн эрхэд хамаарах бүтээл бүртгэхэд хураах хураамжийн хэмжээ

Зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг бүртгэхэд дор дурдсан хэмжээгээр хураамж хураана:

1/зохиогчийн эрхэд хамаарах бүтээлийг бүртгэхэд 50 төгрөг;

2/уг бүртгэлд өөрчлөлт оруулахад 20 төгрөг.

Тайлбар: Энэ хуулийн 8 дугаар зүйлд заасан овог, нэр сольсон гэрчилгээ, байнга оршин суух үнэмлэх, 9 дүгээр зүйлд заасан Монгол Улсын үндэсний энгийн гадаад паспорт, 10 дугаар зүйлд заасан төрөл бүрийн автомашин, өөрөө явагч хэрэгсэл, мотоцикл жолоодох эрхийн болон бууны үнэмлэх, талон, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл, мотоцикл, чиргүүлийн улсын дугаар, гэрчилгээний үнэ нь энэ хуулиар авах хураамжийн дүнд хамаарахгүй.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

18 дугаар зүйл. Хураамжаас чөлөөлөх, хөнгөлөх

1.Шүүхэд гаргасан дараахь нэхэмжлэлийг хураамжаас чөлөөлнө:

1/тэтгэвэр, тэтгэмжийн талаар гаргасан нэхэмжлэл;

2/патент, зохиогчийн эрхтэй холбогдсон нэхэмжлэл;

3/төсвийн байгууллагын нэхэмжлэл;

4/төсөвт төлөх албан татвар хураамж, төлбөр, торгууль гаргуулах талаар гаргасан нэхэмжлэл;

5/гомдлоор авч хэлэлцэх хэргийн нэхэмжлэл;

6/шүүхийн зардал төлөх хөрөнгөгүй учир шүүхийн шийдвэр, магадлалаар шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдсөн иргэний нэхэмжлэл;

7/гэмт хэргийн улмаас учирсан хохирол арилгуулахаар гаргасан нэхэмжлэл;

8/цэргийн албан хаагчаас цэргийн үүрэг гүйцэтгэхтэй холбогдон гаргасан өргөдөл, нэхэмжлэл;

9/хууль бусаар ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан, таслан шийтгэх арга хэмжээ болгож цагдан хорьсон, захиргааны шийтгэлийн журмаар баривчлах арга хэмжээ авснаас учирсан хохирлыг төлүүлэхээр гаргасан нэхэмжлэл;

10/хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авсан тохиолдолд нөхөх олговор, үнийг төлүүлэхтэй холбогдон гаргасан нэхэмжлэл.

2.Шүүх хуульд заасны дагуу өргөдөл, гомдол, нэхэмжлэл гаргагчдын эд хөрөнгийн байдлыг харгалзан хураамж төлөх хугацааг хойшлуулж, төлнийг хураамжаас чөлөөлөх буюу төлөх хураамжийн хэмжээг багасгаж болно.

3.Дараахь үйлчилгээг хураамжаас чөлөөлнө:

1/гэнэтийн аюул учирсны улмаас үрэгдүүлсэн баримт бичгийг дахин олгох, магадлагаа, лавлагаа гаргахад;

2/улсын болон бусдын эрх ашгийг хамгаалах, иргэний үүргээ биелүүлэх, хууль ёс сахиулах, бусдын амь насыг аврах үйл ажиллагааны улмаас амь үрэгдсэн иргэний хөрөнгийн талаар өвлөгчид гэрчилгээ олгоход;

3/засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлттэй холбогдсон иргэний бүртгэлийн бичиг баримтад тэмдэглэл хийхэд;

4/өвлүүлэгчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчилсэн хүүхэд, эцэг, эхэд эд хөрөнгө болон хадгаламжийн дансанд байгаа мөнгийг өв залгамжлах эрхийн гэрчилгээ олгоход.

4.Иргэн, хувираа эрхлэх ажахуйгаас энэ хуулийн 16 дугаар зүйлийн 3,4,5,6-д заасан хураамж хураахад түүний хэмжээг 60 хувиар хөнгөлнө.

19 дүгээр зүйл. Хураамж төлөх журам

1.Хураамжийг энэ хуульд заасан үйлчилгээ үзүүлж байгаа эрх бүхий байгууллага бэлэн болон бэлэн бус хэлбэрээр хураах бөгөөд хураамж авах албан тушаалтныг байгууллагын эрх бүрэгчийн шийдвэрээр томилон ажиллуулна.

2.Шүүхэд нэхэмжлэл гаргагч хураамжийг бэлэн бус хэлбэрээр төлж энэ тухай баримтыг шүүхэд тушаана.

3.Үйлчилгээ үзүүлэгч байгууллага төсөвт төвлөрүүлэх хураамжийн хэмжээ 10000 төгрөг хүрсэн тухай бүрд төсөвт шилжүүлж байна.

4.Энэ хуулийн тайлбарт заасан гэрчилгээ, үнэмлэх, талон, паспорт, дугаарын үнэд төлсөн мөнгийг төсөвт шилжүүлнэ.

5.Энэ хуулийн биелэлтэд Улсын татварын алба хяналт тавина.

20 дугаар зүйл. Хураамжийн тайлан гаргах

Үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь хураамжийн жилийн тайланг дараа оны 2 дугаар сарын 10-ны дотор Улсын татварын албанд гаргаж өгнө.

21 дүгээр зүйл. Хураамжийг буцаан олгох

Хураамжийн мөнгийг дараахь тохиолдолд буцаан олгоно:

1/тогтоосон хэмжээнээс илүү хураасан;

2/энэ хууль болон хууль тогтоомжийн бусад актад чөлөөлөхөөр заасан үйлчилгээнээс хураасан;

3/үйлчилгээ үзүүлэхээс татгалзсан.

22 дугаар зүйл. Хураамжийн талаар гомдол гаргах

1.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хураамжтай холбогдсон гомдлоо хураамж төлснөөс хойш 14 хоногийн дотор эрх бүхий байгууллага болон шүүхэд гаргах эрхтэй. Гомдлыг эрх бүхий байгууллага хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

2.Шүүхээс хураасан хураамжийн талаар гарсан гомдлыг Иргэний байцаан шийтгэх хуулийн дагуу дээд шатны шүүх хянан шийдвэрлэнэ.

23 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

1.Улсын төмдэгтийн хураамжийн хууль тогтоомжийг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хураамж хураах эрх бүхий байгууллагын зохих албан тушаалтанд татварын байцаагч дараахь шийтгэл ногдуулна:

1/хураамжийг аваагүй буюу дутуу авсан бол уг хураамж, хураамжийн дутууг нөхөн төлүүлж 2000 хүртэл төгрөгөөр торгох;

2/хураамжийн данс баримтыг будлиантуулсан, хураамжийн мөнгийг төсвийн орлогод тогтоосон журмын дагуу тушаагаагүй бол 2000 хүртэл төгрөгөөр торгох;

3/энэ хуулийн 21 дүгээр зүйлд заасны дагуу хураамжийг буцаан олгох боломжгүй болсон бол үндэсгүй буюу илүү хураасан хураамжийг хурааж 2000 хүртэл төгрөгөөр торгох.

2.Хураамж хураах эрх бүхий байгууллага буюу зохих албан тушаалтан энэ хуульд заагаагүй үйлчилгээ үзүүлж хураамж авсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын байцаагч хууль бусаар олсон орлогыг хурааж 10000 хүртэл төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн 3,2 дахь хэсэгт заасан тохиолдолд холбогдох этгээд илүү төлсөн болон хууль бусаар төлсөн хураамжийн мөнгийг эгүүлэн авах тухай нэхэмжлэлийг шүүхэд гаргаж болно.

24 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хууль 1993 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н.РИЧИНДОРЖ**

1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 7 дугаар сарын 15 өдөр

Улаанбаатар хот

ИРГЭНИЙ БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Иргэний байцаан шийтгэх хуулийн 72,75 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

72 дугаар зүйл:

"72 дугаар зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн хувь хэмжээ

Анхны болон сөрөх нэхэмжлэл, түүнчлэн гурав дахь этгээд маргаантай байгаа зүйлийн талаар бие даасан шаардлага тавьж гаргасан нэхэмжлэлийн өргөдөлд дор дурдсан хэмжээгээр улсын тэмдэгтийн хураамж авна:

1/эд хөрөнгийн чанартай бөгөөд үнэлж болох нэхэмжлэлд:

Нэхэмжлэлийн үнэ	Хураамжийн хувь хэмжээ
1000 төгрөг хүртэл	20 төгрөг
1001-3000 төгрөг	50 төгрөг
3001-10000 төгрөг	нэхэмжлэлийн үнийн дүнгийн 2 хувь
10001-50000 төгрөг	нэхэмжлэлийн үнийн дүнгийн 3 хувь
50001 төгрөг түүнээс дээш бол	нэхэмжлэлийн үнийн дүнгийн 4 хувь

2/эд хөрөнгийн бус, түүнчлэн үнэлж болохгүй нэхэмжлэлд 50 төгрөг;

3/хэрэгт байгаа нотлох баримтын хуулбар, түүнчлэн шүүхийн шийдвэр, магадлал, шийтгэвэр, гүйцэтгэх хуудас дахин олгоход хуудас тутмаас 5 төгрөг.

75 дугаар зүйл:

"75 дугаар зүйл. Шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөх

Улсын төмдэгтийн хураамж, хэрэг хянан хэлэлцэх явдалтай холбогдон гарсан дараахь зардал төлөхөөс чөлөөлнө:

1/тэтгэвэр, тэтгэмжийн талаар гаргасан нэхэмжлэл;

2/зохиогч, патентийн эрхтэй холбогдсон нэхэмжлэл;

3/төсвийн байгууллагын нэхэмжлэл;

4/төсөвт төлөх албан татвар, хураамж, төлбөр, торгууль гаргуулах талаар гаргасан нэхэмжлэл;

5/гомдлоор авч хэлэлцэх хэргийн нэхэмжлэл;

6/шүүхийн зардал төлөх хөрөнгөгүй учир шүүхийн шийдвэр, магадлалаар шүүхийн зардал төлөхөөс чөлөөлөгдсөн иргэний нэхэмжлэл;

7/гэмт хэргийн улмаас учирсан хохирол арилгуулахаар гаргасан нэхэмжлэл;

8/цэргийн албан хаагчаас цэргийн үүрэг гүйцэтгэхтэй холбогдон гаргасан өргөдөл, нэхэмжлэл;

9/хууль бусаар ял шийтгэсэн, эрүүгийн хариуцлагад татсан, таслан шийтгэх арга хэмжээ болгож цагдан хорьсон, захиргааны шийтгэлийн журмаар баривчлах арга хэмжээ авснаас учирсан хохирлыг төлүүлэхээр гаргасан нэхэмжлэл;

10/хувийн эд хөрөнгийн дайчлан авсан тохиолдолд нөхөх олговор, үнийг төлөхтэй холбогдон гаргасан нэхэмжлэл.

Хууль тогтоомжоор эдгээрээс өөр үндэслэлээр шүүхийн зардлыг улсын орлогод төлөхөөс зохигчид чөлөөлөгдөж болно.

Шүүх буюу шүүгч зохигчдын эд хөрөнгийн байдлыг харгалзан тэдний аль нэгний буюу хоёулангийн шүүхийн зардал төлөх хугацааг хойшлуулж, хэсэглэн төлүүлэх буюу хэмжээг багасгаж болно.

3.Энэ хууль 1993 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын
дарга **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ, ЗАРЛИГ, ТЭДГЭЭРИЙН БОЛОН ДҮРМИЙН ЗААЛТ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хууль батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараахь хууль, зарлиг, тэдгээрийн болон дүрмийн заалт хүчингүй болсонд тооцсугай:

1) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1965 оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 179 дүгээр зарлигаар батлагдсан БНМАУ-ын Тэмдгийн хураамжийн хууль;

2) "Улсын тэмдгийн хураамжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1968 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 152 дугаар зарлиг;

3) Монгол Улсын 1973 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн Гэр бүлийн хуулийн 27 дугаар зүйлийн "Гэрчилгээ олгоход улсын тэмдгийн хураамж 300 төгрөг байна" гэсэн 2 дахь өгүүлбэр, 31 дүгээр зүйлийн "Гэрлэснийг цуцлуулсан гэрчилгээ олгоход хураах улсын тэмдгийн хураамжийг салахад хүргэсэн шалтгаан болон хэд дэх удаа салж байгааг шүүх харгалзан нэг зуугаас нэг мянган төгрөг хүртэл тогтоож биелэлтийг хангана" гэсэн 1 дэх өгүүлбэр;

4) БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1978 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн 42 дугаар зарлигаар батлагдсан БНМАУ-ын Консулын дүрмийн 56, 57, 58, 59 дүгээр зүйл;

5) "БНМАУ-ын Тэмдгийн хураамжийн хуульд нэмэлт оруулах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1980 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 296 дугаар зарлиг;

6) Монгол Улсын 1985 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Нотариатын хуулийн 32 дугаар зүйл;

7) "Зарим хууль, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1985 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 228 дугаар зарлигийн 1 дүгээр хэсэг;

8) "БНМАУ-ын Тэмдгийн хураамжийн хуульд нэмэлт оруулах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 3 дугаар сарын 5-ны өдрийн 50 дугаар зарлиг;

9) "Зарим хууль, дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1988 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 162 дугаар зарлигийн 3 дугаар хэсэг;

10) 1991 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн БНМАУ-ын Тэмдгийн кураамжийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль;

2. Энэ хууль 1993 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н. РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Монгол Улсын хилийн тухай хуулийн зорилт

Монгол Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах зорилгоор хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хил хамгаалах байгууллагын тогтолцоо, бүрэн эрхийг тодорхойлох, хил хамгаалалтад иргэн, байгууллагыг оролцуулах, хилийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбогдсон харилцааг зохицуулахад энэ хуулийн зорилт оршино.

2 дугаар зүйл. Монгол Улсын хилийн тухай хууль тогтоомж, олон улсын гэрээ

1. Монгол Улсын хилийн тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.Монгол Улсын олон улсын гэрээнд Монгол Улсын хилийн тухай хууль тогтоомжид зааснаас өөр журам тогтоосон нь Үндсэн хуульд харшлаагүй бол олон улсын гэрээний заалтыг баримтална

3 дугаар зүйл. Монгол Улсын хил

Монгол Улсын нутаг дэвсгэрийн хязгаарыг газрын гадаргуу, усны мандал дээр хил залгаа улсын нутаг дэвсгэрийн хязгаараас зааглаж Монгол Улсын олон улсын гэрээгээр тодорхойлж, тогтоосон шугамыг Монгол Улсын хил (цаашид "улсын хил гэх) гэнэ. Уг шугамаас эгц дээш агаарын, мөн шугамнаас эгц доош газрын хэвлийн хил байна.

Улсын хил халдашгүй дархан байна.

4 дүгээр зүйл. Хилийн ус

Улсын хилийн шугам дайран өнгөрч байгаа нуур, гол, мөрөн, горхи болон гадаргын бусад усыг хилийн ус гэнэ. Улсын хилийн шугамаас дотогш орших хилийн ус нь Монгол Улсын усны нэгдмэл сангийн бүрдэл хэсэг байна.

5 дугаар зүйл. Улсын хилийн шугамын асуудлыг шийдвэрлэх Улсын хилийг тодорхойлох, тогтоох, ээрчлэх асуудлыг Монгол Улсын Их Хурал, улсын хилийг хамтран шалгах асуудлыг Монгол Улсын Засгийн газар шийдвэрлэнэ.

6 дугаар зүйл. Улсын хилийг тодорхойлох

Улсын хилийг газар дээр нь тогтоохын тулд хил залгаа улстай хилийн шугамыг тодорхойлж, хилийн гэрээ байгуулна. Уг гэрээг Улсын Их Хурал соёрхон батална.

7 дугаар зүйл. Улсын хилийг тогтоох

1. Улсын хилийг газар дээр нь дараахь зарчим баримтлан тогтоно:

1) хуурай газарт тодорхой тэмдэгт, тогтвортой юмсыг хооронд нь холбосон шулуун шугамаар, эсхүл уул, нурууны усны хагалбараар;

2) гол, мөрөн, горхинд үндсэн урсгалын дундуур, нууранд нуурын эрэгт тулж ирсэн улсын хилийн шугамын хоёр үзүүрийг холбосон шулуун шугамаар;

3) төмөр зам, авто зам, гүүр, далан бусад барилга байгууламжид улсын хилийн шугам бодит байдлаараа хаагуур өнгөрч байгаагаар тогтоогдоно.

Дээр дурдсанаас өөр зарчмаар улсын хил тогтоохыг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

2. Улсын хилийн шугам, хилийн тэмдгийн байршлыг газар дээр нь тогтоох ажлыг хил залгаа улстай хамтран гүйцэтгэнэ.

3. Улсын хил тогтоох Монголын талын бүрэлдэхүүнийг Улсын Их Хурал томилно.

8 дугаар зүйл. Улсын хилийг тэмдэглэх

Улсын хилийг хил залгаа улстай байгуулсан гэрээний дагуу газар дээр нь геодезийн аргаар тодорхойлж, тод харагдах, бат бэх хилийн тэмдгээр тэмдэглэнэ.

9 дүгээр зүйл. Улсын хилийг хамтран шалгах

1. Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээр, протоколд (цаашид "гэрээ" гэх) заасны дагуу тогтоосон улсын хилийн шугам, хилийн тэмдгийн байршлыг хил залгаа улстай хамтран шалгана.

2. Улсын хилийг хамтран шалгах Монголын талын бүрэлдэхүүнийг Засгийн газар томилно. Тус бүрэлдэхүүнд төрөл мэргэжлийн хүмүүсээс гадна тухайн орон нутгийн төлөөлөгч оролцоно.

3. Улсын хилийг хамтран шалгах явцад улсын хилийн шугамыг өөрчилбөл энэ тухай гэрээний заалтыг үндэслэн Улсын Их Хурал хууль баталснаар хүчин төгөлдөр болно.

10 дугаар зүйл. Улсын хилээр нэвтрүүлэх журмыг тогтоох зарчим

Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх журмыг тогтоох, өөрчлөхдөө дараахь зарчим баримтална:

1) үндэсний аюулгүй байдлыг хангах;

2) гадаад улстай харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;

3) Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах.

11 дүгээр зүйл. Хилийн тухай гэрээ, хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналт шалгалт

Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, улсын хилийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд тавих төрийн хяналт шалгалтыг төрийн захиргааны төв болон Улсын хил хамгаалах байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Улсын хилийн дэглэм

12 дугаар зүйл. Улсын хилийн дэглэмийн зорилго

Улсын хилийн дэглэмийн зорилго нь хил залгаа улстай байгуулсан гэрээг үндэслэн улсын хилийг тодорхой байлгах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай

түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэх, хилийн асуудалтай холбогдсон бусад үйл ажиллагааг зохицуулахад оршино.

13 дугаар зүйл. Улсын хилийн дэглэмийн агуулга

Улсын хилийн дэглэмийн агуулга нь улсын хилийг арчлан хамгаалах, улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, хилийн ус, улсын хилийн шугам дээрх зам, холбооны байгууламжийг ашиглах, хил дээр ан агнуур, ажил үйлдвэрлэл явуулах, байгаль орчин, ан амьтныг хамгаалах зэрэг журмаас бүрдэнэ.

14 дүгээр зүйл. Улсын хилийн дэглэмийг тогтоох

Улсын хилийн дэглэмийн эрх зүйн үндсийг хуулиар тодорхойлж Улсын Их Хурал эрх олгосны дагуу Засгийн газар хил залгаа улстай байгуулсан гэрээгээр улсын хилийн дэглэмийг тогтооно.

15 дугаар зүйл. Улсын хилийг арчлан хамгаалах

1. Улсын хилийн шугам, тэмдэг, тэдгээрийн холбоосыг хил залгаа улстай байгуулсан гэрээний дагуу газар дээр нь бүрэн бүтэн байлгана.

2. Улсын хилийн шугам дайран гарсан ойг улсын хил тод харагдахаар зурваслан огтолж, цэвэрлэж байна.

3. Улсын хилийн тэмдгийг арчлан хамгаалах, сэргээх, засварлах, улсын хилийн шугамыг тодотгох, шалгах ажлыг хил залгаа улстай байгуулсан гэрээний дагуу хийнэ.

16 дугаар зүйл. Улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх

1. Улсын хилийг газар, ус, агаараар нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хилийн боомтоор нэвтрүүлнэ.

2. Хилийн боомтыг нээх, хаах, түүгээр нэвтрэх хөдөлгөөнийг түр хязгаарлах, зогсоохыг хуульд өөрөөр заагаагүй бол Засгийн газар шийдвэрлэнэ.

Хилийн хяналтыг явуулахад шаардлагатай барилга, байгууламж, талбай, тэдгээрийн тоног төхөөрөмжийг орон нутгийн болон зам харилцааны байгууллага барьж байгуулсны дараа Улсын хил хамгаалах байгууллага нь хилийн хяналтын бусад байгууллагатай хамтарч тухайн боомтыг нээж ажиллуулна.

3. Агаарын хөлөг нь улсын хилийн тогтоосон агаарын хаалгаар нэвтэрч, зөвшөөрсөн агаарын замаар нисч, зөвхөн хилийн боомт бүхий нисэх буудалд бууж, хөөрнө. Өөр газраар улсын хил нэвтрэх, буух, хөөрөхийг Засгийн газар шийдвэрлэнэ.

Цэргийн зорилгоор агаарын хөлөг улсын хил нэвтрэх, тус улсын нутаг дэвсгэрт буух, хөөрөхийг Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

4. Улсын хилийг усаар нэвтрэх журмыг Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор тогтооно.

5. Зорчигчийг Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн дагуу эрхийн хүчин төгөлдөр баримт бичгийг үндэслэн улсын хилээр нэвтрүүлнэ.

6. Тээврийн хэрэгсэл, барааболон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн дагуу улсын хилээр нэвтрүүлнэ.

7. Байгалийн гамшиг, хүн, мал, амьтан, ургамлын халдварт өвчин, осол сүйрлийн улмаас үүссэн хор хөнөөлийг арилгахад туслах гадаадын хүчнийг Монгол Улсын олон улсын гэрээ, Засгийн газрын шийдвэрээр улсын хилээр нэвтрүүлнэ.

8. Тухайлсан хуульгүйгээр гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглоно.

17 дугаар зүйл. Улсын хилээр нэвтрүүлэх үеийн хяналт шалгалт

1. Зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хяналт шалгалт хийх зорилгоор хилийн боомтод Хилийн цэргийн шалган нэвтрүүлэх алба, хилийн эрүүл ахуй, халдвар судлал, гааль зэрэг хяналтын байгууллага (цаашид "хилийн хяналтын байгууллага "гэх) ажилладаг.

Хилийн хяналтын бусад байгууллагын үйл ажиллагааг тухайлсан хуулиар зохицуулна.

2. Хилийн хяналтын байгууллагын шалгалтыг тухайн тээврийн хэрэгслийн хувааръят хугацаанд багтаан дуусгана. Зайлшгүй тохиолдолд уг хугацааг холбогдох байгууллагатай тохиролцон сунгаж болно.

3. Улсын хилийн шугамаас хилийн боомт хүртэлх хэсэг нь хилийн цэргийн, агаарын зай нь агаарын довтолгооноос хамгаалах цэргийн хяналтанд байна.

4. Хилийн хяналтын байгууллага нь улсын хилээр нэвтрэх тээврийн хэрэгслийг шалгалтын зорилгоор бүхий талбайд зогсоон үзлэг хийнэ.

18 дугаар зүйл. Хилийн ус ашиглах

1. Хилийн усны Монголын талын хэсэгт улсын хил хамгаалалтад ашиглаж байгаагаас бусад хөвөх хэрэгсэл зөвхөн гэгээтэй цагт явна. Аргагүй тохиолдлоос бусад үед улсын хилийн шугам дээр хөвөх хэрэгсэл зогсохыг хориглоно. Хөвөх хэрэгсэл хөдөр хажуудаа таних тэмдэг, дугаартай байна.

2. Хилийн усыг цэвэр байлгах, усны түвшин, үндсэн урсгалыг өөрчлөхгүй байх, гол, мөрөн, нуурын эргийг хамгаалах арга хэмжээ авна.

3. Хилийн ус ашиглах журмыг Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор тогтооно.

19 дүгээр зүйл. Улсын хилийн шугам дээрх зам, холбооны байгууламжийг ашиглах

Улсын хилийн шугам дээрх төмөр зам, авто зам, холбооны болон бусад барилга байгууламжийг ашиглах журмыг Монгол Улсын олон улсын гэрээгээр зохицуулна.

20 дугаар зүйл. Улсын хил дээр ан агнах, ажил, үйлдвэрлэл явуулах

Улсын хил дээр ан агнах, загас барих, байгалийн баялаг олборлох, мал аж ахуй эрхлэх, эрэл хайгуул, бусад үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагаа явуулах журмыг Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор тогтооно.

21 дүгээр зүйл. Улсын хил орчмын байгаль орчин, ан амьтныг хамгаалах

1. Улсын хил орчмын байгалийн унаган төрхийг хадгалах, амьтан, ургамлыг хамгаалах зорилгоор тодорхой хэмжээний газар нутгийг хил залгаа улстай тохиролцсоны үндсэн дээр улсын тусгай хамгаалалттай газрын ангилалд хамруулж болно.

2. Улсын хил орчмын байгаль орчин, ан амьтныг хамгаалах үүргийг засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн болон Улсын хил хамгаалах байгууллагын удирдлага хамтран гүйцэтгэнэ.

3. Хүн, мал, амьтан, ургамлын халдварт өвчин манай улсын болон хил залгаа улсын нутагт тархах аюулыг хязгаарлах зорилгоор улсын хил дээр өвчин гарсан голомтын хэсэгт иргэний хөдөлгөөнийг түр зогсоох, хязгаарлах, зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох арга хэмжээ Засгийн газраас авна.

4. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, иргэн нь ой, хээрийн түймэр гарахаас урьдчилан сэргийлж, гарсан түймрийг унтраах арга хэмжээ авна.

22 дугаар зүйл. Хилийн зөрчил, хил зөрчсөнд тооцох

1. Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, энэ хууль, хууль тогтоомжийн бусад акт, тэдгээртэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас тогтоосон журам зөрчсөн үйлдлийг хилийн зөрчилд тооцно.

2. Улсын хил нэвтрэх журмыг дараахь үйлдлээр зөрчсөн эт-гээдийг хил зөрчигч гэнэ:

1) хилийн боомтоос өөр газраар улсын хилийг газар, ус, агаараар нэвтэрсэн, нэвтрэхийг завдсан;

2) хилийн боомтоор улсын хил нэвтрэх эрхийн хүчин төгөлдөр бус баримт бичигтэйгээр нэвтэрсэн, нэвтрэхийг завдсан;

3) улсын хилийг газрын хэвлийгээр нэвтэрсэн.

23 дугаар зүйл. Монгол Улсын хилийн төлөөлөгч

1. Хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг улсын хилийн тодорхой хэсэгт хэрэгжүүлэх, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх зорилготой хилийн төлөөлөгч, орлогчийг Засгийн газар томилно.

2. Хилийн төлөөлөгч нь туслагч, нарийн бичгийн дарга, орчуулагч, мэргэжилтэнг томилох эрхтэй.

3. Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийг удирдлага болгоно.

4. Хилийн зөрчил, түүнтэй холбогдсон асуудлаар хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нь хэрэг бүртгэх эрх эдэлнэ.

5.Хилийн төлөөлөгч, орлогч, туслагч нь хил зөрчсөн гадаадын иргэн болон харьяалалгүй хүнийг хил залгаа улсын хилийн байгууллагад хүлээлгэн өгөх хүртэлх хугацаанд саатуулна.

6. Хилийн төлөөлөгч нь хил залгаа улсын хилийн төлөөлөгчтэй хэлэлцээ хийх журмаар ажлаа явуулна. Хилийн төлөөлөгч хэлэлцээ хийж шийдвэрлэх шаардлагагүй гэж үзсэн асуудлыг хилийн төлөөлөгчийн орлогч, туслагчийн уулзалтаар шийдвэрлэнэ.

7. Хилийн төлөөлөгч, дагалдан яваа ажилтан нь хил нэвтрэхдээ улсын хил нэвтрэх эрхийн үнэмлэхийг биедээ авч явах бөгөөд Монгол Улсын төрийн далбааг автомашиндаа мандуулна.

8. Хилийн төлөөлөгч албан үүргээ гүйцэтгэхэд нь иргэн, байгууллага, аж ахуйн нэгж туслалцаа үзүүлнэ. Хилийн төлөөлөгчийн зохицуулж чадаагүй асуудлыг дипломат шугамаар шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад шилжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Улсын хил орчмын дэглэм

24 дүгээр зүйл. Улсын хил орчмын дэглэмийн зорилго

Улсын хил орчмын нутаг дэвсгэрт улсын хилийн дэглэмийг сахиулах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хил хамгаалах үйл ажиллагаа явуулахад улсын хил орчмын дэглэмийн зорилго

25 дугаар зүйл. Улсын хил орчмын дэглэмийн агуулга

Улсын хил орчмын дэглэмийн агуулга нь хилийн бүс, зурвас, боомтод мөрдөх журмаас бүрдэнэ.

26 дугаар зүйл. Улсын хилийн бүс, түүнд мөрдөх журам

1. Улсын хил хамгаалах, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор тусгай журам тогтоосон нутаг дэвсгэрийг хилийн бүс гэнэ. Түүний өргөнийг улсын хилийн шугамаас дотогш 30 км-ээр тогтооно.

2. Улсын хилийн бүсэд дараахь журмыг мөрдөнө:

1) хил орчмын нутаг дэвсгэрт оршин суугч нь иргэний паспортдаа хаягийн тэмдэглэлтэй байна.

2) оршин суугч нь улсын хилийн зурвас хүртэл чөлөөтэй зорчиж, нутаглаж, ажил, үйлдвэрлэл эрхэлнэ.

3) улсын хилийн бүсэд оршин суудаггүй иргэн нь хилийн бүсэд нэвтрэхдээ иргэний паспорттай байна.

4) хил орчмын нутаг дэвсгэрт оршин суудаггүй иргэн, байрладаггүй байгууллага, аж ахуйн нэгж нь улсын хилийн бүсэд ажил, үйлдвэрлэл явуулах тохиолдолд Улсын хил хамгаалах байгууллагаас зөвшөөрөл авна.

5) хуульд өөрөөр заагаагүй бол улсын хилийн бүсэд гадаадын иргэн, харьяалалгүй хүн байнга оршин суухыг хориглоно.

6) хил орчмын нутаг дэвсгэрт зорчих эрхийн хүчин төгөлдөр баримт бичгээр улсын хилийг нэвтэрсэн гадаадын иргэн тухайн сумын нутаг дэвсгэрээс өөр газар явахыг хориглоно.

3. Улсын хилийн бүсийн журмын биелэлтэд нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага Улсын хил хамгаалах байгууллагатай хамтран хяналт тавьж шалгалт хийнэ. Улсын хилийн бүсэд оршин суугчийн ёс заншлыг хүндэтгэн хуулиар олгогдсон эрхийг хөндөхгүй.

27 дугаар зүйл. Улсын хилийн зурвас, түүнд мөрдөх журам, хориглох зүйл

1. Улсын хилийн бүсэд хилийн дэглэмийг сахиулах, улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны зориулалттай хилийн инженер, техникийн байгууламж барих зорилгоор улсын хилийн шугамаас дотогш 5 км-ээс илүүгүйгээр Улсын хил хамгаалах байгууллагаас тогтоосон нутаг дэвсгэрийг улсын хилийн зурвас гэнэ.

2. Иргэн нь улсын хилийн зурваст Улсын хил хамгаалах байгууллагын зөвшөөрөлтэйгээр нэвтэрч энэ хууль, хууль тогтоомжийн бусад актаар хориглосноос өөр ажил, үйлдвэрлэл явуулж болно.

3. Улсын хилийн зурваст иргэн, байгууллага, аж ахуйн нэгжээс дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

1) улсын хилийн тэмдэг, холбоосыг эвдэх, гэмтээх, хөдөлгөх, шилжүүлэх;

2) хуульд зөвшөөрснөөс бусад үндэслэлээр газар хагалах, суваг шуудуу татах, барилга байгууламж барих;

3) Улсын хил хамгаалах байгууллагын зөвшөөрөлгүйгээр хилийн инженер, техникийн байгууламжийн цаана гарах, улсын хилийн шугам, тэмдэг дээр очих;

4) Монгол Улсын эрх ашигт хохирол учруулсан ажил, үйлдвэрлэл явуулах, Улсын хил хамгаалах байгууллагад урьдчилан мэдэгдэхгүйгээр тэсэлгээ хийх;

5) цацраг идэвхт, химийн хорт бодис байрлуулах, тараах;

6) улсын хилийн шугамаас 2000 метрийн дотор ан агнах, ан амьтныг хөөж хил давуулах;

7) харнулгагүй мал байлгах, зөвшөөрөлгүй айл нутаглуулах;

8) улсын хилийн шугамын дагуу урсаж байгаа гол, мөрний усыг боох, суваг шуудуу татаж усны урсгалын гольдрол, түвшин, чиглэлийг өөрчлөх;

9) Монгол Улсын хуулиар хориглосон арга, хэрэгслээр ан агнах, загас барих;

28 дугаар зүйл. Хилийн бөөмт, түүнд мөрдөх журам

1. Улсын хилээр нэвтрэх зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд хилийн хяналтын байгууллага хяналт шалгалт хийх зорилгоор тусгайлан тогтоож, төхөөрөмжилсөн газрыг хилийн бөөмт гэнэ.

2. Улсын хил хамгаалах байгууллага нь хилийн хяналтын байгууллага хяналт шалгалт явуулах боломцоог бүрдүүлэх зорилгоор тухайн бөөмтөд мөрдөх журмыг тогтооно.

Уг журам нь зорчигч, тээврийн хэрэгслийг хяналт шалгалтад оруулах, гаргах, тээврийн хэрэгслэлийг зогсоолд зогсоох, журам сахиулах зэрэг арга хэмжээнээс бүрдэнэ.

3. Зорчигч, тээврийн хэрэгсэл эзэмшигч нь тухайн бөөмтөд тогтоосон замаар орж, гарна.

Үйлчлэх бүрэлдэхүүн нь хилийн хяналтын байгууллагын ажилтанд тээврийн хэрэгслийг шалгуулах үүрэгтэй.

4. Хилийн хяналтын байгууллагын хяналт шалгалт явагдаж байгаа үед гадны хүн тээврийн хэрэгсэлд нэвтрэхийг хориглоно.

5. Улсын хил нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийн хөдөлгөөний чиглэл, байрлалыг өөрчлөх, зорчигчийг суулгах, буулгах, ачаа тээш, шуудангаа ачиж буулгахыг Улсын хил хамгаалах байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ.

6. Шаардлагатай үед Улсын хил хамгаалах байгууллага бөөмтөд мөрдөх журмыг холбогдсон нэмэлт арга хэмжээ авч болно.

29 дүгээр зүйл. Хил орчмын нутаг дэвсгэр

Хил залгаа улстай хиллэж байгаа сумын нутаг дэвсгэрий хил орчмын нутаг дэвсгэр гэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Улсын хил хамгаалалт, Улсын хил хамгаалах байгууллага, түүний тогтолцоо, чиг үүрэг, бүрэн эрх

30 дугаар зүйл. Улсын хил хамгаалалт

1. Улсын хил хамгаалалт нь үндэсний аюулгүй байдал, улсы батлан хамгаалах арга хэмжээний салшгүй хэсэг мөн.

Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хилий асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хилий тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, хилийн зэрчлийг ил рүүлэх, таслан зогсоох зорилгоор улсын хилийн бүс, зурвас Улсын хил хамгаалах байгууллагаас улсын хилийн болон хи орчмын дэглэмийг сахиулах, цэргийн, инженер-техникийн зэрэ арга хэмжээг хослуулан явуулж байгаа үйл ажиллагааг улсы хил хамгаалалт гэнэ.

2. Газар, усан дээрхи улсын хилийг хилийн цэрэг, агаары хилийг агаарын довтолгооноос хамгаалах цэрэг хамгаална.

3. Шаардлагатай үед Зэвсэгт хүчний ерөнхий командлагчий зөвшөөрснөөр ерөнхий зориулалтын цэргийн зарим анги салбары улсын хил хамгаалах зорилгоор ашиглаж болно.

31 дүгээр зүйл. Улсын хил хамгаалах байгууллага, түүний үйл ажиллагаа

1. Улсын хил хамгаалалтыг улс орны хэмжээнд удирдан зохио байгуулах үүрэг бүхий Хилийн цэргийг удирдах төрийн захир-гааны байгууллага, түүний харьяа тусгай анги, салбарыг Улсы хил хамгаалах байгууллага гэнэ.

Улсын хил хамгаалах байгууллага нь үйл ажиллагаагаа хэвийн явуулахад шаардлагатай штаб, зэвсэглэл, техник, ар тал, хангалт үйлчилгээ, сургалт, эрдэм шинжилгээний нэгжтэй байна.

2. Хилийн цэргийн улсын хил хамгаалах салбарын тоо, байршлы тогтоохдоо хил залгаа улстай тэгш эрхтэй харилцан ажиллах, улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах эрх ашигт нийцүүлэн тэдгээрийн хилийн салбартай харьцангуй ижил хэм-жээнд байх зарчим баримтална.

32 дугаар зүйл. Улсын хил хамгаалах байгууллагын чиг үүрэг

Улсын хил хамгаалах байгууллага дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1) улсын хил хамгаалалтын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлж, улсын хил хамгаалалтыг зохион байгуулах;

2) Монгол Улсын олон улсын гэрээнд хилийн асуудлаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;

3) улсын хилийн шугам, тэмдэг, холбоосны байршлыг хууль бусаар өөрчлөх явдал гаргуулахгүй байж, хилийн асуудлыг хууль зүйн дагуу шийдвэрлэх;

4) улсын хилийн болон хил орчмын дэглэмийг сахиулж, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх;

5) улсын хилээр зорчигч, тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу нэвтрүүлэх.

33 дугаар зүйл. Улсын хил хамгаалах байгууллагын бүрэн эрх

1. Улсын хил хамгаалах байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) улсын хилийн шугам, тэмдэг, холбоосны байршил, тэдгээрийг арчлан хамгаалах, хилийн тэмдгийг засварлах, сэргээх, босгох, улсын хил дээр үүссэн зөрчлийг зохицуулах;

2) улсын хил хамгаалалтын эрх ашгийн үүднээс улсын хилийн бүсэд хүч хэрэгслээ байрлуулах, инженер, техникийн болон зам харилцааны байгууламж барьж байгуулах, албан үүргээ гүйцэтгэхдээ уг бүсийн аль ч хэсгээр явах, шаардлагатай үед иргэний баримт бичгийг шалгах, хил зөрчигч, завдагчийг илрүүлэх зорилгоор тээврийн хэрэгсэл, тээвэрлэж байгаа бараанд үзлэг хийх, манаагаар дагалдуулах;

3) хилийн боомтоор зорчигч, тээврийн хэрэгсэл, бараа болон мал, амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг нэвтрүүлэхдээ баримт бичгийг шалгах, тэмдэглэл хийх, зөрчилтэй баримт бичгийг хураан авч холбогдох газарт шилжүүлэх;

4) улсын хилээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгсэл, бараанд хил зөрчигчийг илрүүлэх зорилгоор үзлэг хийх явцад илэрсэн улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон зүйлийг хураан авч холбогдох байгууллагад мэдээлэх;

5) хил зөрчигчийг саатуулах зорилгоор хилийн эрэл явуулах;

6) хилийн эрлийн үед иргэн, байгууллагын байр, орон сууцанд нэвтрэх, үзлэг хийх, эрэл явагдаж байгаа зурвас дахь төмөр замын өртөө, зөрлөг, нисэх буудал, тээврийн товчоо, хилийн

бооmтод орох, гарах, тээврийн хэрэгслийн жөдөлгөөнийг зайлшгүй гэж үзвэл түр зогсоох, шалгах;

7) хил зөрчигчийг эрэх, саатуулах үед зайлшгүй тохиолдолд иргэн, байгууллага, аж ахуйн нэгжийн тээврийн хэрэгслийг дайчлах, холбооны хэрэгслийг дараалал харгалзахгүйгээр ашиглаж зохих хөлс, зардлыг олгох;

8) хилийн зөрчил, түүнтэй холбогдсон асуудлыг шуурхай шалгаж шийдвэрлэх;

9) хэрэг бүртгэх эрх бүхий албан тушаалтан нь улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчсөн этгээдийг тэмдэглэл үйлдэх зорилгоор гурван цаг хүртэл, зөрчил гаргагчийн хувийн байдлыг тогтоох, зөрчлийн шинж байдлыг тодорхойлохын тулд энэ тухай прокурорт бичгээр мэдэгдэж гурав хоног хүртэл, хэрэв зөрчил гаргагчийн хувийн байдлыг нотлох баримт бичиггүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлтэйгээр арав хоног хүртэл хугацаагаар албадан саатуулах, саатуулагдсан этгээдийн биед үзлэг хийх, түүнчлэн зайлшгүй шаардлагатай тохиолдолд түүний өмчлөлд буюу эзэмшилд байгаа эд зүйлд үзлэг хийх, эд зүйл, баримт бичгийг хураан авах, албадан саатуулсан, саатуулагдсан этгээдийн бие болон эд зүйлд үзлэг хийсэн, эд зүйл баримт бичгийг хураан авсан тохиолдол бүрд хуульд заасны дагуу тэмдэглэл үйлдэх;

10) хилийн зөрчилтэй холбогдуулан түүний шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллагад мэдэгдэл өгөх;

11) улсын хилийн болон хил орчмын дэглэм, хилийн боомтоор нэвтрүүлэх журмыг сахиулахад хяналт тавихын тулд зайлшгүй шаардлагатай бүртгэл хөтөлж энэ зорилгоор Үндсэн хуульд харшлахгүй мэдээллийн төгтөлцөөг ашиглах;

12) Монгол Улсын нутаг дэвсгэрт цөмөрсөн зэвсэгт халдлагыг няцаах, улсын хил дээр үүссэн ёдөөн хатгалга, хорлон сүйтгэх ажиллагааг таслан зогсоох.

2. Шаардлагатай үед дээр дурдсан бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Аюулгүй байдлыг хангах болон Цагдаагийн байгууллагатай хамтран ажиллаж болно.

34 дүгээр зүйл. Хилийн цэргийг удирдах байгууллагын даргын бүрэн эрх

1. Хилийн цэргийг удирдах байгууллагын дарга нь Засгийн газрын гишүүний удирдлагад ажиллана.

2. Хилийн цэргийг удирдах байгууллагын дарга нь дараах бүрэн эрхтэй өөлнө:

1) хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн хүрээнд улсын хил хамгаалалтын бодлогыг хэрэгжүүлэх;

2) улсын хил хамгаалах удирдамж,улсын хил хамгаалалтын үйл ажиллагааны талаар тушаал гаргаж, Хилийн цэргийн тусгай анги салбарууд хэрхэн биелүүлж байгаад хяналт тавьж, үйл ажиллагааг нь удирдах;

3) улсын хил хамгаалалтын дүрэм, зааврыг батлуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн барих;

4) хилийн цэргийн боловсон хүчнийг бэлтгэх, томилох, чөлөөлөх;

5) төсөв хөрөнгийг захиран зарцуулах;

6) улсын хил хамгаалалттай холбогдсон асуудлаар төрийн захиргааны төв байгууллага, аймгийн засаг даргатай хамтран шийдвэр гаргаж хэрэгжүүлэх.

35 дугаар зүйл. Улсын хил хамгаалалтад агаарын довтолгооноос хамгаалах цэргийн чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх

1. Агаарын довтолгооноос хамгаалах цэрэг нь улсын хил хамгаалах талаар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1) агаарын хилийн дэглэмийг холбогдох байгууллагатай хамтран сахиулах;

2) агаарын хөлгөөр агаарын хилийг хууль бусаар нэвтрэхээс урьдчилан сэргийлэх;

3) агаарын хөлөг агаарын хилийг хууль бусаар нэвтэрсэн тохиолдолд нислэгийг таслан зогсоох арга хэмжээ авах.

2. Агаарын хөлөг улсын хилийг зөрчсөн тохиолдолд агаарын довтолгооноос хамгаалах цэргийн анги, салбар дараахь арга хэмжээ авна:

1) буух газрыг зааж шаардах, анхааруулж дохио өгөх;

2) зөрчил үргэлжилбэл уг агаарын хөлгийг албадан буулгаж, нисэх багийг холбогдох байгууллагад шилжүүлж, зөрчигчийн ажуулгүй байдлыг хангах;

3) агаарын хөлгийг албадан буулгах талаар авсан арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга, түүний эзгүйд орлож байгаа хүний тушаалаар байлдааны зэвсэг хэрэглэх.

36 дугаар зүйл. Улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа цэргийн албан хаагч, иргэний эрх зүйн баталгаа

1. Цэргийн албан хаагч, иргэн нь улсын хилд албан үүрэг гүйцэтгэж байгаа үедээ төрийн төлөөлөгч байж, улсын эрх

ашгийн үүднээс иргэн, албан тушаалтанд хууль ёсны шаардлага тавьж биелэлтийг хангуулах эрхтэй.

2. Улсын хилд албан үүргээ биечлэн гүйцэтгэж байгаад амь насаа алдвал түүний гэр бүлд тухайн ажилтны сарын үндсэн цалингийн дунджаар тооцож таван жилийн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн буцалтгүй тэтгэмж олгоно.

3. Албан үүрэг гүйцэтгэж байгаад гэмтсэн, эрүүл мэнд нь хохирсон бол эмчилгээний зардал, тахир дутуу болсон тохиолдолд тэтгэмж, үндсэн цалингийн зөрүү, хиймэл эрхтэн хийлгэсэн зардлыг тус тус улсаас олгоно.

4. Улсын хил дээр алба хааж байгаа офицер, ахлагчийн гэр бүлийг тэргүүн ээлжинд ажлаар хангах бөгөөд тэднийг ажлаар хангаагүй нөхцөлд ажилгүй байсан хугацааны эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед мөрдөж байгаа цалингийн доод хэмжээгээр тооцож улсаас олгоно.

5. Хилийн хороо, суманд алба хааж байгаа офицер, ахлагч тэдний гэр бүлийг ээлжийн амралтаараа (нөхөр, эхнэрийн) нутагтаа амарвал 2 жилд 1 удаа ирэх, очих унааны зардлыг улсаас олгоно.

6. Улсын хилд таван жилээс дээш хугацаагаар алба хааж байгаа офицер, ахлагчид нэг удаагийн мөнгөн урамшууллыг тэдний сарын үндсэн цалингаас хилийн суманд 50 хувь, суурин бус газар байрладаг хилийн хороонд 35 хувь, нийслэл, аймгийн төв, улсын чанартай хотоос бусад суурин газарт байрладаг хилийн хороо, агаарын довтолгооноос хамгаалах салбарт 25 хувиар бодож нэгтгэн таван жил тутамд олгоно.

7. Энэ зүйлийн 2, 3 дугаар заалтанд хамаарагдах иргэн, хугацаат цэргийн албан хаагчийн сарын үндсэн цалинг хилийн цэргийн ахлагчийн цалинтай адилтган тооцно.

8. Энэ зүйлийн 2, 3, 4, 5 дугаар заалтад заасан хөнгөлөлтийг бусад хууль тогтоомжид заасан хөнгөлөлттэй давхардуулж хэрэглэхгүй.

37 дугаар зүйл. Улсын хилийг хамгаалахад зэвсэг хэрэглэх

1. Хилийн цэргийн тусгай анги, салбар, хилийн маяа урьдчилан анхааруулахгүйгээр дараахь тохиолдолд байлдааны зэвсэг, техник хэрэглэнэ:

1) Монгол Улсын нутаг дэвсгэрт цоморсон зэвсэгт халдлагыг няцаах;

2) улсын хил дээр үүссэн зэвсэгт өдөөн хатгалга, хөрлон сүйтгэх ажиллагааг таслан зогсоох;

3) хил зөрчигчийн зэвсэгт эсэргүүцлийг таслан зогсоох.

2. Хилийн манаа нь урьдчилан анхааруулах дохио өгсний араа уг халдлага, довтолгоон үргэлжилбэл дараахь тохиолдолд айлдааны зэвсэг хэрэглэнэ:

1) хилчин иргэний амь нас, аюулгүй байдалд заналхийлсэн ь зэвсэг хэрэглэхгүйгээр зогсоох бололцоогүй бол;

2) иргэний өмчийг зэвсэгт халдлагаас хамгаалах арга хэмжээ эсан боловч таслан зогсоогдохгүй бол;

3) улсын хил дээр үүссэн өдөөн хатгалаг, хил зөрчигчийн йлдлийг өөр арга, хэрэгслээр зогсоох боломжгүй бол.

3. Хилийн манаа нь зэрлэг амьтнаас өөрийгөө болон бусдыг амгаалахын тулд зэвсэг хэрэглэж болно.

4. Хилийн манаа ан хийх, хил давуулан буудахыг хориглоно

5. Улсын хил хамгаалалтад албан үүрэг гүйцэтгэж байгаа илчин нь тусгай техник, хэрэгсэл, албаны нохой, бие хамгаалах ргыг хэрэглэж болно.

ТАВДУГААР БҮЛЭГ

Улсын хил хамгаалалтад иргэн, байгууллага оролцох

38 дугаар зүйл. Төрийн захиргааны төв байгууллагын үүрэг

1. Гадаад харилцааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны өв байгууллага нь:

1) төрийн эрх барих дээд байгууллагын шийдвэрийг үндэслэн илийн асуудлаар байгуулах олон улсын гэрээ, хэлэлцээрийг элтгэх, байгуулах;

2) улсын хил хамгаалалтын гадаад улс төрийн болон олон лсын эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэх;

3) хилийн төлөөлөгчийн шугамаар шийдвэрлэж чадаагүй асуудыг зохицуулах.

2. Улсын аюулгүй байдлыг хангах асуудал эрхэлсэн төрийн ахиргааны төв байгууллага нь:

1) улсын хилд гарч болзошгүй зөрчлийн тухай Улсын хил амгаалах байгууллагад цаг тухайд нь мэдээлж, бичгээр батал аажуулах;

2) гадаадын тусгай алба, бусад байгууллага улсын хилийн рчим болон улсын хилийг ашиглан явуулж болох тагнан турших ажиллагаа, хилийн гадаад, дотоод нөхцөл байдлыг судалж улсын хил хамгаалалтад ач холбогдол бүхий асуудлаар Улсын хил амгаалах байгууллагатай мэдээлэл солилцож, харилцан ажиллах

3) хил орчмын нутаг дэвсгэрт явагдах олон улсын болон улсын чанартай нийтийг хамарсан арга хэмжээний үед улсын аюулгүй байдлыг хангах ажил зохион;

4) улсын хилийг гүйцэтгэх ажлын шугамаар хамгаалах, бусад үйл ажиллагаа явуулах.

3. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь:

1) улсын агаарын хил хамгаалалтыг удирдах;

2) улсын хил дээр гарсан зөвсөгт халдлага, түрэмгийллийг таслан зогсоох ажиллагааг удирдах.

4. Нийгмийн хэв журам хангах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь:

1) улсын хил орчмын дэглэмийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох талаар Улсын хил хамгаалах байгууллагатай харилцан ажиллах;

2) цагдаагийн орон нутгийн байгууллагыг улсын хил орчмын дэглэмийн биелэлтэд хяналт тавихад Улсын хил хамгаалах байгууллагад туслалцуулах;

3) хил орчмын нутаг дэвсгэрт гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам сахиулах;

4) улсын хил дээр зохиогдох нийтийг хамарсан арга хэмжээний үед журам сахиулах;

5) улсын хил дээр болон хилийн боомтод гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх, нийгмийн хэв журам сахиулах;

6) улсын хилээр нэвтэрч байгаа гадаадын зорчигчийн тухай мэдээллийг Улсын хил хамгаалах байгууллагаас авч хяналт тавих.

5. Төрийн захиргааны бусад төв байгууллага, аж ахуйн нэгж нь улсын хилийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэн, Улсын хил хамгаалах байгууллагад дэмжлэг, туслалцаа үзүүлж, улсын хил хамгаалалтад шаардагдах бүтээгдэхүүнээр тэргүүн ээлжинд хангана.

39 дүгээр зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн засаг даргын бүрэн эрх

1. Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг эдэлнэ:

1) өөрийн нутаг дэвсгэрт байгаа Улсын хил хамгаалах байгууллагын хангалт үйлчилгээнд туслалцаа үзүүлж улсын хилийн тухай хууль тогтоомжийг иргэн, албан тушаалтан, байгууллага, аж ахуйн нэгжээс сахин биелүүлж байгаад хяналт тавих;

2) улсын хил орчмын дэглэмийн биелэлтэд хяналт тавьж, түүнийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авах;

3) иргэнийг сайн дурын нь үндсэн дээр улсын хил хамгаалалтад тан оролцуулах;

4) улсын хил хамгаалахад туслах хүчнийг ажил үйлдвэрлэл, таг дэвсгэрийн байрлалаар нь байнгын болон түр хугацаагаар хион байгуулж улсын хил хамгаалалтад оролцуулах;

5) хилийн сумын төсөвт улсын хил хамгаалалтад зориулсан мэгдэл зардал тусгах.

2. Дээрхи бүрэн эрхээ хэрэгжүүлэхийн тулд өөрийн дэргэд он тооны бүс зөвлөл ажиллуулна.

40 дүгээр зүйл. Монгол улсын иргэний үүрэг

Монгол улсын иргэн дараахь үүргийг хүлээнэ:

1) улсын хилийн болон хил орчмын дэглэмийн шаардлагыг елүүлэх;

2) улсын хил хамгаалахад туслах;

3) улсын хилийн бүс, зурваст байнга болон түр оршин суудаг л ажил, үйлдвэрлэл явуулж байгаа байрлалаараа улсын хил амгаалалтад оролцох;

4) улсын хилийн болон хил орчмын дэглэм зөрчсөн үйлдлийн алаар Улсын хил хамгаалах байгууллагад мэдээлэх.

41 дүгээр зүйл. Улсын хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа иргэний эрх

Улсын хил хамгаалалтад үүрэг гүйцэтгэж байгаа иргэн дараахь рхийг эдэлнэ:

1) хил зөрчигчийг саатуулж, нэн даруй мэдээлэх;

2) улсын хилийн бүс, зурваст зорчин явагчийн баримт бичгийг алгах;

3) улсын хилийн зурваст чөлөөтэй зорчих;

4) зөвсөг хэрэгсэл, уналга, хүнсээр хангагдах;

5) улсын хил хамгаалалтад идэвхтэй оролцсоны шагнал, мөнгөн рамшуулал авах;

6) улсын хил хамгаалалттай холбогдсон санал, хүсэлтээ Улсын ил хамгаалах байгууллагын удирдлагад уламжлах.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Хүлээлгэх хариуцлага

42 дугаар зүйл. Хариуцлага хүлээлгэх үндэслэл

1. Улсын хилийн тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд үүний гэм буруу, хууль бус үйл ажиллагаанаас учирсан хохирлын эмжээг харгалзан хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2. Дараахь үйлдлийг хилийн тухай хууль тогтоомж зөрчсөнд тооцож хариуцлага хүлээлгэх үндэслэл болгоно:

1) энэ хуулийн 22 дугаар зүйл, 27 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үйлдэл;

2) энэ хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 28 дугаар зүйлд заасан журам зөрчсөн;

3) улсын хилээр нэвтрэх эрхийн хүчин төгөлдөр баримт бичгийг тогтоосон журмын дагуу үзүүлээгүй, хуурамч бичиг баримт үзүүлсэн;

4) хил зөрчихөд тусалсан, дэмжлэг үзүүлсэн;

5) улсын хил давж ирсэн мал, хууль бусаар улсын хил давуулж ирсэн бусад зүйлийг нуун дарагдуулсан;

6) улсын хилийн тухай хууль тогтоомжийг зөрчсөн бусад үйлдэл.

43 дугаар зүйл. Улсын хилийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Улсын хилийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь гэмт хэргийн шинжгүй бол "Монгол Улсын захиргааны хариуцлагын тухай хууль"-д зааснаар хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Их Хурлын дарга **Н. БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н. РИНЧИНДОРЖ**

1993 оны 10 дугаар сарын 21-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1973 оны 7 дугаар сарын 16-ны өдрийн 161 дүгээр зарлигаар

батлагдсан "БНМАУ-ын Хил хамгаалах хууль"-ийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Монгол Улсын Хилийн тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын
дарга Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 10 дугаар сарын 21-ний өдөр

Улаанбаатар хот

ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГЫН ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт дараахь заалт нэмсүгэй:

"Улсын хилийн дэглэм зөрчигчийн хувийн байдлыг нотлох баримт бичиггүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлтэйгээр 10 хоног хүртэл хугацаагаар саатуулж болно."

Монгол Улсын Их Хурлын
дарга Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын
Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга Н. РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1993 оны 10 дугаар
сарын 21-ний өдөр

Улаанбаатар
хот

ИРГЭНИЙ ЦЭРГИЙН ҮҮРГИЙН БОЛОН ЦЭРГИЙН АЛБАН ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 5 дугаар зүйл, 26 дугаар зүйлийн 1 дэх заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

5 дугаар зүйл:

"5 дугаар зүйл. Цэргийн тангараг

1. Монгол Улсын иргэн цэргийн жинхэнэ албанд орохдоо:

"Монгол Улсын иргэн Би Монгол Улсын Үндсэн хуулиар хүлээсэн иргэний цэргийн үүргээ үнэнчээр биелүүлж, өвөг дээдсийнхээ ариун гал голомт болсон Монгол Улсынхаа халдашгүй дархан байдлыг амь бие үл хайрлан батлан хамгаалахаа эх орон, төр, ард түмэндээ андгайлан тангараглая.

Би ард түмнийхээ үндэсний эв нэгдэл, Монгол цэргийн шилдэг уламжлалаа эрхэмлэн хүндэтгэж, цэргийн эрдэмд шамдан боловсорч, улсын нууцыг найдвартай хадгалж, Монгол Улсын хууль, цэргийн дүрмийг чанд сахин биелүүлэхээ батлан тангараглая.

Эх орноо батлан хамгаалагч дайчин Би өргөсөн тангарагаасаа няцваас төрийн хууль ёсны цээрлэл хүлээнэ" гэж цэргийн тангараг өргөнө.

2. Цэргийн тангараг өргөх журмыг Монгол Улсын Ерөнхийлөгч тогтооно".

26 дугаар зүйлийн 1 дэх заалт:

"1) Монгол Улсын зэвсэгт хүчин, бусад цэргийн жинхэнэ албан хаагчид;"

2 дугаар зүйл. Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн "Зэвсэгт хүчний" гэснийг "Зэвсэгт хүчин, бусад цэргийн" гэж тус тус өөрчилсүгэй.

Монгол Улсын Их Хурлын дарга Н.БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н.РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН БАТЛАН ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоо, зэвсэгт хүчин, бусад цэргийн бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, удирдлагын үндсийг тогтоож, төр, түүний байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эх орноо батлан хамгаалах талаар хүлээх үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Батлан хамгаалах тухай хууль тогтоомж

Батлан хамгаалах тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Батлан хамгаалах үйл ажиллагаа

1. Батлан хамгаалах нь улс орны үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг мөн.

2. Батлан хамгаалах нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улс орны бэлэн байдлыг хангах, хамгаалах зорилго бүхий улс төр, эдийн засаг, нийгэм, эрх зүй, цэргийн цогцолбор арга хэмжээ мөн.

3. Улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангах, хүн амыг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, үйл олноор устгах зэвсгийн хөнөөлөөс хамгаалах нь батлан хамгаалах үйл ажиллагааны бүрэлдэхүүн хэсэг байна.

4. Дайн бүхий байдал, дайны байдал зарласан үе дэх батлан хамгаалах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

4 дүгээр зүйл. Улс орныг батлан хамгаалах төрийн үүрэг

1. Эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдлыг хангах нь төрийн үүрэг мөн. Төр нь улс орны батлан хамгаалах нэгдмэл, уян хатан тогтолцоог бүрдүүлж бэхжүүлнэ.

2. Монгол Улс гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс эх орноо өөрийн зэвсэгт хүчнээр, ард түмний оролцоотойгоор хамгаална. Шаардлагатай тохиолдолд Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн дагуу бусад улсын тусламжийг авч болно.

5 дугаар зүйл. Батлан хамгаалах хамтын ажиллагаа

Монгол Улс батлан хамгаалах хүч чадал, цэргийн харилцан итгэлцлийг бэхжүүлэх зорилгоор Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан бусад улстай батлан хамгаалах хамтын ажиллагааг хэрэгжүүлнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Батлан хамгаалах талаарх Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

6 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын бүрэн эрх

1. Монгол Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) батлан хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тогтоож, зэвсэгт хүчин, бусад цэргийн үйл ажиллагаанд иргэний хяналт тавих;

2) дайны аюулыг сэрэмжлэх, бусад улс өөртэй маргаантай асуудлыг улс төрийн аргаар шийдвэрлэх;

3) Монгол Улсын батлан хамгаалах бодлого, цэргийн номлолыг тодорхойлох;

4) Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн өргөн мэдүүлснээр зэвсэгт хүчин, бусад цэргийн бүтэц, зохион байгуулалтыг болон тэдгээрийг бие бүрэлдэхүүнээр нөхөн хангах журмыг тогтоох;

5) цэргийн тангарагийг батлах;

6) улс орныг батлан хамгаалах арга хэмжээний төсвийг батлах, батлан хамгаалах хүч чадлыг бэхжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлох;

7) цэргийн албан хаагчдад онцгой эрх олгох, тэдний эрх, эрх чөлөөг хязгаарлах талаар зэвсэгт хүчин, бусад цэргийн нийтлэг дүрмүүдийн хэм хэмжээний эрх зүйн үндсийг тогтоох;

8) онц байдлын үеийн зэвсэгт хүчин, бусад цэргийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох;

9) зэвсэгт хүчин, бусад цэрэгт тайван цагт алба хаах цэргийн албан хаагчдын тоог Засгийн газрын саналыг үндэслэн тогтоох;

10) цэргийн албан хаагчдын нийгмийн хамгаалалт, эрх зүйн баталгааны үндсийг тодорхойлох;

11) батлан хамгаалах хамтын ажиллагааны талаарх Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах;

12) цэргийн дээд цол бий болгох;

13) гадаадын цэргийн хүчнийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байрлуулах, дамжин өнгөрүүлэх асуудлыг шийдвэрлэх.

2. Монгол Улсын Их Хурал хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

7 дугаар зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх

1. Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн хувьд Ерөнхийлөгчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Монгол Улсын батлан хамгаалах бодлого, цэргийн номлолын хэрэгжилт, улс орныг батлан хамгаалахад зайлшгүй шаардагдах материаллаг нөөцийн бүрдүүлэлтэд хяналт тавих;

2) батлан хамгаалах арга хэмжээний төсвийн талаар Улсын Их Хуралд санал дүгнэлт оруулах;

3) Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дүрмийг батлах;

4) зэвсэгт хүчин, бусад цэргийн офицер, ахлагчид цэргийн цол олгох журмыг тогтоох;

5) цэргийн дүрэмт хувцас, цол, ялгах тэмдгийн загвар батлах;

6) онцгой нөхцөл бий болсон үед байлдагч, түрүүчийн албаа хаах хугацааг гурван сараас дээш хугацаагаар сунгах саналыг Улсын Их Хуралд оруулах.

2. Монгол Улсын Ерөнхийлөгч хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

8 дугаар зүйл. Монгол Улсын Засгийн газрын бүрэн эрх

1. Монгол Улсын Засгийн газар нь Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан бүрэн эрхээс гадна дараахь тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) улс орныг батлан хамгаалах асуудлаар төрийн захиргааны гүйцэтгэх байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

2) батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

3) цэргийн анги, байгууллагыг байгуулах, татан буулгах асуудлыг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн шийдвэрлэх, цэргийн анги, байгууллагын байршлыг тогтоох, батлан хамгаалах хэрэгцээний эзэмшил газрын зөвшөөрөл олгох;

4) төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгаврыг батлах;

5) улсын болон зэвсэгт хүчний дайчилгааны материаллаг нөөцийн хэмжээг тогтоож, түүнийг бүрдүүлэх, зарцуулах арга хэмжээг зохион байгуулах;

6) тайван цагт улсын дайчилгааны бэлтгэлийг хангах, шаардлагатай үед Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн шийдвэрийн дагуу улс орныг дайны байдалд шилжүүлэх;

7) жил бүр цэргийн жинхэнэ албанд татах, дайчилгааны сургуулилт, цугларалтад оролцуулах хүний тоо, цэрэг татлага явуулах хугацаг Зэвсэгт хүчний ерөнхий командлагчтай зөвшилцөн тогтоох;

8) цэрэг, цэрэг-техникийн хамтын ажиллагааны асуудлаар өөрийн бүрэн эрхийн хүрээнд бусад улсын Засгийн газартай хэлэлцээр байгуулах;

9) хилийн болон иргэний хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудыг байгуулах, тэдгээрийн дарга нарыг Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн томилох, чөлөөлөх;

10) зэвсэгт хүчин, бусад цэргийг зайлшгүй шаардлагатай бүтээгдэхүүнээр хангах асуудлыг шийдвэрлэх;

11) гадаад улсаас авах цэргийн зэвсэг, байлдааны техникийн төрөл, тоог тогтоож, Улсын Их Хурлын зөвшөөрснөөр санхүүжүүлэх.

2. Монгол Улсын Засгийн газар хуульд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

9 дүгээр зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний бүрэн эрх

1. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) улсыг батлан хамгаалах, цэргийн бодлогыг боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

2) батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг тэргүүлж, үүнтэй холбогдсон бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

3) батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгох, зэвсэгт хүчин, хилийн цэргийг бэхжүүлэх саналыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд оруулах, Зэвсэгт хүчний ерөнхий командлагчид өргөн мэдүүлэх;

4) улсын хилийн болон иргэний хамгаалалтын байгууллагуудын үйл ажиллагааг чиглүүлэн удирдах;

5) батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, улсын хилийн болон иргэний хамгаалалтын байгууллагуудын харилцан ажиллагааг зохицуулах;

6) батлан хамгаалах асуудлаар бусад улстай хамтран ажиллах талаар Засгийн газраас олгосон эрхийн хүрээнд хэлэлцээр байгуулах;

7) батлан хамгаалах арга хэмжээний төсвийн төслийг Засгийн газарт оруулах, батлагдсан төсвийг захиран зарцуулах;

8) зэвсэгт хүчин, хилийн цэргийг бие бүрэлдэхүүн, зэвсэг техник, материал, хэрэгслээр нөхөн хангах ажлыг удирдан зохион байгуулах;

9) батлан хамгаалах хууль тогтоомж, батлан хамгаалах асуудлаарх Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон өөрийн шийдвэрийн биелэлтийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжид шалган танилцаж, биелэлтийг хангах талаар үүрэг даалгавар өгч гүйцэтгүүлэх.

2. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн үүрэг

10 дугаар зүйл. Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг

Батлан хамгаалах асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь чиг үүрэг хэрэгжүүлнэ:

1) улсыг батлан хамгаалах, цэргийн бодлогыг хэрэгжүүлэх, зэвсэгт хүчнийг захиргааны удирдлагаар хангах;

2) зэвсэгт хүчнийг зэвсэг техник, бусад материал, хэрэгслээр хангах асуудлыг боловсруулах, энэ талаар гарсан шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулах;

3) цэргийн боловсон хүчнийг сургаж бэлтгэх, цэргийн албан хаагчдын эрх, ашиг сонирхлыг хамгаалах;

4) батлан хамгаалах салбарт техник, технологийн дэвшлийг хангаж, цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх;

5) зэвсэгт хүчний болон төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагын дайчилгааны даалгаврын биелэлтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулах;

6) улсыг батлан хамгаалах арга хэмжээний төлөвлөлтөд шаардагдах мэдээ, судалгааны нэр төрлийг тогтоож, төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллагаас гаргуулж авах;

7) цэргийн цугларалт, хээрийн сургууль, дадлагад өмчийн хэлбэр харгалзахгүйгээр иргэдээс тээврийн хэрэгсэл, барилга

байгууламжийг зохих хөлсийг төлж түр хугацаагаар дайчлан гаргуулах ажлыг зохион байгуулах.

11 дүгээр зүйл. Төрийн захиргааны бусад төв байгууллагын үүрэг

Төрийн захиргааны бусад төв байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

1) өөрийн үндсэн чиг үүргээрээ улсыг батлан хамгаалах зорилтыг хэрэгжүүлэхэд оролцох, энэ ажлыг харьяа байгууллагууддаа зохион байгуулах;

2) зэвсэгт хүчин, бусад цэргийн дайчилгааны болон иргэний хамгаалалтын даалгаврыг биелүүлэх.

12 дугаар зүйл. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг даргын үүрэг

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн Засаг дарга дараахь үүрэг хүлээнэ:

1) нутаг дэвсгэртээ батлан хамгаалах арга хэмжээ, хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

2) цэргийн тоо бүртгэлийг хөтлөх, цэрэг татлагыг зохион байгуулах, цэргийн үүрэгтний дайчилгааны сургууль, цугларалтын бэлтгэлийг хангах;

3) нутаг дэвсгэртээ байгаа аж ахуйн нэгж, иргэдээс цэргийн байгууллагын хэрэгцээнд бэлтгэхээр захиалсан гэрээт бүтээгдэхүүний үйлдвэрлэлт, нийлүүлэлтэд хяналт тавих;

4) дайчилгааны даалгавраар тогтоосон хүнс, эд хөрөнгийн нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангах;

5) иргэний хамгаалалтын арга хэмжээг зохион байгуулж хэрэгжүүлэх;

6) нутаг дэвсгэртээ байрлаж байгаа зэвсэгт хүчний болон бусад цэргийн анги, байгууллага, бие бүрэлдэхүүний албан үүргээ гүйцэтгэх нөхцөлийг хангах асуудлаар харилцан ажиллах, байгаль орчныг хамгаалах болон холбогдох бусад хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих.

13 дугаар зүйл. Аж ахуйн нэгж, байгууллагын үүрэг

Аж ахуйн нэгж, байгууллага дараахь үүрэг хүлээнэ:

1) дайчилгааны даалгаврыг биелүүлж, үйл ажиллагаагаа дайны байдалд шилжүүлэх бэлтгэлтэй байх;

2) иргэний хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

3) ажиллагсаддаа иргэний цэргийн үүргээ биелүүлэх боломж олгох, цэргийн үүрэгтнийг дайчилгааны сургууль, цугларалтад оролцуулах.

14 дүгээр зүйл. Иргэдийн үүрэг

Монгол Улсын иргэд нь эх орноо хамгаалах үүрэгтэй. Энэ үүрэг нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, Иргэний

цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хууль, тэдгээртэй нийцүүлж гаргасан хууль тогтоомжийн бусад актаар тодорхойлогдоно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Зэвсэгт хүчин, бусад цэрэг

15 дугаар зүйл. Зэвсэгт хүчин, бусад цэрэг

1. Монгол Улсын зэвсэгт хүчин нь улс орныг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс цэргийн хүчээр батлан хамгаалах зорилт бүхий төрийн цэргийн байгууллагуудын тогтолцоо мөн.

2 Бусад цэрэгт хилийн болон дотоодын цэрэг багтана.

3. Зэвсэгт хүчин, бусад цэргийг Үндсэн хуулиар тогтоосон төр, нийгмийн байгууллын үндэс, иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын эсрэг аливаа хэлбэрээр ашиглахыг хориглоно.

16 дугаар зүйл. Зэвсэгт хүчин, бусад цэргийн байгуулалтын үндэс, зарчим

1. Монгол Улсын зэвсэгт хүчин, бусад цэргийн байгуулалтын үндэс нь төрийн хууль тогтоомж, батлан хамгаалах бодлого, цэргийн номлолоор тодорхойлогдоно.

2. Зэвсэгт хүчин, бусад цэргийн байгуулалт нь дараахь зарчимд тулгуурлана:

1) зэвсэгт хүчин, бусад цэргийг төрөөс удирдах;

2) зэвсэгт хүчин, бусад цэргийн үйл ажиллагаа иргэний хяналтад байх;

3) зэвсэгт хүчин, бусад цэргийн бүтэц, зохион байгуулалт, бэлэн байдал, зэвсэглэл нь түүний тайван цагт болон дайны үед гүйцэтгэх үүрэгт зохицсон байх;

4) зэвсэгт хүчин, бусад цэрэг үндсэн үүргээ биелүүлэхэд байнга бэлэн байх;

5) зэвсэгт хүчин, бусад цэргийн бүх төрлийн хангалтыг төрөөс баталгаажуулах;

6) зэвсэгт хүчин, бусад цэргийн бие бүрэлдэхүүнийг цэрэг татлагаар болон гэрээгээр сайн дурын үндсэн дээр нөхөн хангах;

7) цэргийн албан хаагч бүрийг цэргийн мэргэжилд заавал сургах;

8) хууль дээдлэх, чанд сахилга, өндөр зохион байгуулалттай байх;

9) төвлөрсөн удирдлага, нэгдмэл захирамжийг хэрэгжүүлэх.

17 дугаар зүйл. Зэвсэгт хүчний бүтэц

Монгол Улсын зэвсэгт хүчний бүтцэд ерөнхий зориулалтын, улсыг агаарын довтолгооноос хамгаалах, барилгын, иргэний хамгаалалтын цэрэг, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн багтана. Дайн бүхий байдал, дайны байдлын үед зэвсэгт хүчний бүтцэд бусад цэрэг орж үүрэг гүйцэтгэнэ.

18 дугаар зүйл. Зэвсэгт хүчин, бусад цэргийн зохион байгуулалт

1. Зэвсэгт хүчин нь цэргийн удирдлагын байгууллага, төрөл мэргэжлийн цэргийн болон ар тал, техникийн нэгтгэл, ангиуд, цэргийн сургууль, эрдэм шинжилгээ, соёл урлаг, эмнэлэг, аж ахуй, үйлчилгээний байгууллагатай байна.

2. Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиуд нь тайван цагт бүрэн, хураангуй, нэн хураангуй зохион байгуулалттай байж болно.

3. Бусад цэргийн зохион байгуулалт, чиг үүргийг хуулиар тогтооно.

19 дүгээр зүйл. Зэвсэгт хүчин, бусад цэргийн бие бүрэлдэхүүн

1. Зэвсэгт хүчин, бусад цэргийн бие бүрэлдэхүүн нь цэргийн албан хаагч, цэргийн үүрэгтэн болон цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллаж байгаа ажилтнаас бүрдэнэ.

2. Цэргийн алба хаахтай холбогдсон харилцаа, цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлыг хуулиар зохицуулна.

3. Цэргийн анги, байгууллагад гэрээгээр ажиллаж байгаа ажилтны эрх зүйн байдал, хөдөлмөрийн харилцааг холбогдох хууль тогтоомжийн актаар зохицуулна.

20 дугаар зүйл. Зэвсэгт хүчний чиг үүрэг

1. Монгол Улсын зэвсэгт хүчин нь дор дурдсан үндсэн чиг үүрэгтэй:

1) эх орныхоо тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах;

2) улсын агаарын хилийн халдашгүй дархан байдлыг хангах;

3) цэргийн насны болон цэргийн бэлтгэл үүрэгтэн иргэдэд цэргийн бэлтгэл эзэмшүүлэх, цэргийн мэргэжлийг нь дээшлүүлэх сургалт явуулах.

2. Зэвсэгт хүчин нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндсэн чиг үүргээс гадна дор дурдсан үүрэг хүлээнэ:

1) байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, үй олноор хөнөөх зэвсгийн хор хөнөөлийг арилгах ажилд шаардлагатай тохиолдолд оролцох;

2) цэргийн барилга, инженерийн анги, байгууллагаас барилга, байгууламжийн ажлыг гэрээлэн гүйцэтгэгчийн үүргийг биелүүлэх.

3. Зэвсэгт хүчний ерөнхий командлагчийн зөвшөөрөл, Ба[illegible] хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрийн

дагуу зэвсэгт хүчний бэлэн байдлыг алдагдуулахгүйгээр цэргийн зарим анги, байгууллагыг аж ахуйн бүтээн байгуулалтын ажилд оролцуулж болно. Цэргийн анги, байгууллагыг ийнхүү ажилд оролцуулах журмыг Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч тогтооно.

21 дүгээр зүйл. Зэвсэгт хүчин, бусад цэргийн удирдлага

Зэвсэгт хүчин, бусад цэргийн удирдлага нь ерөнхий болон цэргийн мэргэжлийн удирдлагаас бүрдэнэ.

22 дугаар зүйл. Зэвсэгт хүчин, бусад цэргийн ерөнхий удирдлага

1. Зэвсэгт хүчин, бусад цэргийн ерөнхий удирдлагыг Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд хэрэгжүүлж, иргэний хяналт тавина.

2. Зэвсэгт хүчин, бусад цэрэгт тавих иргэний хяналт нь батлан хамгаалах тухай хууль тогтоомжийн биелэлт, зэвсэгт хүчин, бусад цэргийн мэргэжлийн удирдлагыг болон батлан хамгаалах төсвийн санхүүжилт, зарцуулалтыг хянах үйл ажиллагаа мөн.

23 дугаар зүйл. Зэвсэгт хүчин, бусад цэргийн мэргэжлийн удирдлага

1. Зэвсэгт хүчин, бусад цэргийн мэргэжлийн удирдлагыг Зэвсэгт хүчний Ерөнхий штаб, бусад болон төрөл мэргэжлийн цэргийн дарга, штабууд, нэгтгэл, ангийн захирагч, штаб, аймаг, нийслэл, дүүргийн цэрэг, иргэний хамгаалалтын штабууд тус тусын эрх хэмжээний дотор хэрэгжүүлнэ.

2. Зэвсэгт хүчний Ерөнхий штаб нь цэргийн удирдлагын төв байгууллага байж, дарга нь Зэвсэгт хүчний ерөнхий командлагч, Батлан хамгаалах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний удирдлагын дор ажиллана.

3. Зэвсэгт хүчний Ерөнхий штабын эрх, бусад болон төрөл мэргэжлийн цэргийн штабуудтай харилцах хэм хэмжээг Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дүрмээр тогтооно.

24 дүгээр зүйл. Зэвсэгт хүчний Ерөнхий штабын чиг үүрэг

1. Зэвсэгт хүчний Ерөнхий штаб дараахь чиг үүрэг хэрэгжүүлнэ:

1) зэвсэгт хүчин, бусад цэргийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах, тэдгээрийг дайнд ашиглах ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх бэлтгэлийг нь хангах;

2) цэргийн алба, сургалт бэлтгэлийг зохион байгуулж, нэгтгэл, ангиудын байлдааны болон дайчилгааны бэлэн байдал, байлдах чадварыг хангах;

3) зэвсэгт хүчний бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, түүнийг бэхжүүлэх талаар санал боловсруулах;

4) Монгол Улсын хилийн халхлалт, нутаг дэвсгэрийн хамгаалалтын төловлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх;

5) зэвсэгт хүчний цэргийн анги, байгууллагыг иргэний хамгаалалтын чиглэлээр томилгоожуулан сургаж, ашиглах;

6) хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын агаарын зайд нислэг үйлдэх журам тогтоож биелэлтийг хянах;

7) цэрэг татах, халах ажлыг зохион байгуулах;

8) олон улсын болон бүс нутгийн цэрэг, улс төрийн байдал, цэргийн аюул заналыг судлан төрийн дээд болон зэвсэгт хүчний удирдлагыг зохих мэдээллээр хангах;

9) зэвсэгт хүчин, бусад цэргийн хэмжээнд нууцын хадгалалт, хамгаалалтыг зохион байгуулах.

2. Зэвсэгт хүчний Ерөнхий штабын дарга нь Ерөнхий штабын чиг үүрэгтэй холбогдсон асуудлаар бусад цэргийн дарга, штаб, аймаг, нийслэлийн цэрэг, иргэний хамгаалалтын байгууллагууд тушаал, үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах, бусад болон төрөл мэргэжлийн цэргийн штабууд, төрөл мэргэжлийн цэргийн харилцан ажиллагааг зохион байгуулна.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

25 дугаар зүйл. Батлан хамгаалах арга хэмжээний санхүүжилт

Улс орныг батлан хамгаалах арга хэмжээг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

26 дугаар зүйл. Батлан хамгаалах тухай хууль тогтоомжийг зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Батлан хамгаалах хууль тогтоомжийг зөрчигчид Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу эрүүгийн, захиргааны, сахилгын, материалын хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Их Хурлын дарга Н. БАГАБАНДИ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н. РИНЧИНДОРЖ

1993 оны 10 дугаар сарын 12-ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 09-ний өдөр | Дугаар 59 | Улаанбаатар хот

ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ЦАЛИНГИЙН САНГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Прокурорын газрыг Монгол Улсын ерөнхий прокурорын газар болгон өөрчилж, аймаг, нийслэлийн прокурорын газруудыг 1 дүгээр хавсралт, сум болон сум дундын, дүүргийн прокурорын газруудыг 2 дугаар хавсралт, дагнасан прокурорын газрыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус шинэчлэн байгуулсугай.

2. Прокурорын газруудын 1993 оны цалингийн санг 4 дүгээр хавсралтын ёсоор батлсугай.

3. Прокурорын газруудыг шинэчлэн байгуулсантай холбогдуулан одоо ажиллаж байгаа аймаг, хот, район, орон нутгийн хотын болон Улаанбаатар Төмөр замын прокурорын газруудыг энэ тогтоолыг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс, цэргийн прокурорын газрыг 1993 оны 7 дугаар сарын 25-ны өдрөөс тус тус татан буулгасанд тооцсугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан цэргийн прокурорын газруудын орон тоо, цалингийн санг тээврийн хэрэгсэл, эд хөрөнгийн хамт Улсын ерөнхий прокурорын газарт 1993 оны 8 дугаар сарын 1-ний дотор шилжүүлэхийг засгийн газарт даалгасугай.

5. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн мөрдөхөөр тогтоосугай.

Дарга Н. БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н. РИНЧИНДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 1993 оны
59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ПРОКУРОРЫН ГАЗРУУД

Прокурорын газрын нэр	Байрших газрын нэр
1.Нийслэлийн прокурорын газар	Улаанбаатар хот
2.Архангай аймгийн прокурорын газар	Цэцэрлэг хот
3.Баян-Өлгий аймгийн прокурорын газар	Өлгий хот
4.Баянхонгор аймгийн прокурорын газар	Баянхонгор хот
5.Булган аймгийн прокурорын газар	Булган хот
6.Говь-Алтай аймгийн прокурорын газар	Алтай хот
7.Дорноговь аймгийн прокурорын газар	Сайншанд хот
8.Дорнод аймгийн прокурорын газар	Чойбалсан хот
9.Дундговь аймгийн прокурорын газар	Мандалговь хот
10.Завхан аймгийн прокурорын газар	Улиастай хот
11.Өвөрхангай аймгийн прокурорын газар	Арвайхээр хот
12.Өмнөговь аймгийн прокурорын газар	Даланзадгад хот
13.Сүхбаатар аймгийн прокурорын газар	Баруун-Урт хот
14.Сэлэнгэ аймгийн прокурорын газар	Сүхбаатар хот
15.Төв аймгийн прокурорын газар	Зуунмод хот
16.Увс аймгийн прокурорын газар	Улаангом хот
17.Ховд аймгийн прокурорын газар	Ховд хот
18.Хөвсгөл аймгийн прокурорын газар	Мөрөн хот
19.Хэнтий аймгийн прокурорын газар	Өндөрхаан хот
20.Дархан хот дахь прокурорын газар	Дархан хот
21.Эрдэнэт хот дахь прокурорын газар	Эрдэнэт хот
22.Чойр хот дахь прокурорын газар	Чойр хот

Монгол Улсын Их Хурлын 1993 оны
59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

СУМ БОЛОН СУМ ДУНДЫН, ДҮҮРГИЙН ПРОКУРОРЫН ГАЗРУУД

Прокурорын газрын нэр	Байрших газрын нэр	Нутаг дэвсгэрийн харьяалал
Нэг. Сумын прокурорын газар		
1. Дорноговь аймаг дахь сумын прокурорын газар	Замын-Үүд хороо	Эрдэнэ сум, Замын-Үүд хороо

2.Дорнод аймаг дахь сумын прокурорын газар	Сүмбэр сум	Сүмбэр сум
3.Увс аймаг дахь сумын прокурорын газар	Тэс сум	Тэс сум
4.Хөвсгөл аймаг дахь сумын Прокурорын газар	Хатгал хот	Алаг-Эрдэнэ сум, Хатгал хот
5.Хэнтий аймаг дахь сумын 1 дүгээр прокурорын газар	Хэрлэн хороо	Дархан сум, Хэрлэн хороо
6.Хэнтий аймаг дахь сумын 2 дугаар прокурорын газар	Бэрх хороо	Батноров сум, Бэрх хороо

Хоёр. Сум дундын прокурорын газар

1.Завхан аймаг дахь сум дундын прокурорын газар	Булнай сум	Булнай, Их-Уул, Тэлмэн, Идэр, Нөмрөг сум
2.Дорноговь аймаг дахь сум дундын прокурорын газар	Зүүнбаян хороо	Улаанбадрах, Хатанбулаг, Хөвсгөл сум, Зүүнбаян хороо
3.Өвөрхангай аймаг дахь сум дундын прокурорын газар	Хархорин сум	Хархорин, Бат-Өлзийт Хужирт, Бүрд, Есөн зүйл Өлзийт, Баян-Өндөр сум
4.Төв аймаг дахь сум дундын прокурорын газар	Жаргалант сум	Жаргалант, Борнуур, Батсүмбэр, Сүмбэр, Баянчандмань, Угтаал цайдам, Баянцогт, Цээл, Заамар сум
5.Сэлэнгэ аймаг дахь сум дундын прокурорын газар	Зүүнхараа хот	Мандал, Баянгол сум, Зүүнхараа хот, Түнхэл хороо
6.Ховд аймаг дахь сум дундын прокурорын газар	Булган сум	Булган, Алтай, Үенч, Мөст, Цэцэг, Мөнххайрхан сум

Гурав. Дүүргийн прокурорын газар

1.Сүхбаатар дүүргийн прокурорын газар	Сүхбаатар дүүрэг	Сүхбаатар дүүрэг
2.Чингэлтэй дүүргийн прокурорын газар	Чингэлтэй дүүрэг	Чингэлтэй дүүрэг
3.Баянзүрх, Гачуурт дүүргийн прокурорын газар	Баянзүрх дүүрэг	Баянзүрх, Гачуурт дүүрэг

4.Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн прокурорын газар	Сонгинохайрхан дүүрэг	Сонгинохайрхан, Жаргалант дүүрэг
5.Хан-Уул, Туул дүүргийн прокурорын газар	Хан-Уул дүүрэг	Хан-Уул, Туул дүүрэг
6.Баянгол дүүргийн прокурорын газар	Баянгол дүүрэг	Баянгол дүүрэг
7.Налайх дүүргийн прокурорын газар	Налайх дүүрэг	Налайх дүүрэг
8.Багануур дүүргийн прокурорын газар	Багануур дүүрэг	Багануур дүүрэг
9. Багахангай дүүргийн прокурорын газар	Багахангай дүүрэг	Багахангай дүүрэг

Монгол Улсын Их Хурлын 1993 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

ДАГНАСАН ПРОКУРОРЫН ГАЗАР

Прокурорын газрын нэр	Байрших газрын нэр	Харьяалах салбар нэр
1.Тээврийн прокурорын газар	Улаанбаатар хот	Агаарын болон Төмөр замын тээвэр

Монгол Улсын Их хурлын 1993 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ПРОКУРОРЫН ГАЗРУУДЫН ЦАЛИНГИЙН САН

(төгрөгөөр)

Прокурорын газрын нэр	Сарын цалингийн сан	Жилийн цалингийн сан
1.Улсын ерөнхий прокурорын газар	405865	4870380
2.Аймгийн прокурорын газар	2102600	25231200

3.Сум, сум дундын прокурорын газар	190200	2282400
4.Нийслэлийн прокурорын газар	365830	4389960
5.Дүүргийн прокурорын газар	468300	5619600
6.Тээврийн прокурорын газар	66330	795960
ДҮН	3599125	43189600

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр Дугаар 60

Улаанбаатар хот

ШҮҮХИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газарт дор дурдсан арга хэмжээ авахыг даалгасугай:

1) Үндсэн хууль, Шүүхийн тухай хуулийн дагуу байгуулсан сумын болон сум дундын, дүүргийн шүүхүүдийг шүүн таслах ажиллагаагаа явуулах нөхцөл бүхий контор, зохих тавилга, тоног төхөөрөмжөөр хангах арга хэмжээг 1993 онд багтаан авах;

2) сум дундын шүүхийг нүүдэллэн ажиллах боломжоор хангахын тулд тэдгээрт 1993-1995 онд багтаан зохих тооны автомашин хуваарилан олгох;

3) Цэргийн тусгай шүүх, Улаанбаатар Төмөр замын тусгай шүүхийг татан буулгасантай холбогдуулан тэдгээрийн ашиглаж байсан тавилга, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, эд хөрөнгө, 1993 оны төсвийн үлдэгдэл болон Улаанбаатар хүрээний цэргийн тусгай шүүхийн конторын барилгыг Шүүхийн ерөнхий зөвлөлд шилжүүлэн өгөх;

4) шүүгч, шүүхийн ажилтнуудыг бэлтгэх, давтан бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх зардлыг шүүхийн жил бүрийн төвлөрсөн төсөвт тусган санхүүжүүлэхийн хамт шинээр томилогдсон шүүгчдийн 7 хоногийн семинарыг энэ оны 3, 4 дүгээр улиралд зохион байгуулахад шаардагдах зардлыг гаргаж өгөх;

5) бүх шатны шүүхийн шүүгчдийг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн албан ёсны эхээр хангах арга хэмжээг 1993 онд багтаан авч хууль тогтоомжийн нэгдсэн сан байгуулах;

6) иргэдийн төлөөлөгчдийн шүүхэд ажилласан хугацааны цалин, түүнчлэн шүүгчдийг хууль тогтоомжийн албан ёсны эхээр хангахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шүүхийн жил бүрийн төвлөрсөн төсвийн төсөлд тусгаж байх;

7) шүүхийн тогтоол гүйцэтгэгч, хуягийг албаны дүрэмт хувцас, ялгах тэмдэг, бие хамгаалах хэрэгслээр хангах арга хэмжээг 1993 онд багтаан авах.

2. Шүүхийн тогтоол гүйцэтгэлийн тухай хуулийн төслийг энэ оны 9 дүгээр сард багтаан боловсруулж өргөн мэдүүлэхийг Хууль зүйн байнгын хороонд даалгасугай.

3. Иргэдийн төлөөлөгчдийн шүүхэд ажилласан хугацааны цалинг тэдний гүйцэтгэж байгаа ажлын хэмжээг үндэслэн шүүхийн батлагдсан төсөвт багтаан санхүүжүүлж байхыг Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгасугай.

4. Үндсэн хуулийн хэм хэмжээ, зарчимд нийцүүлэн шүүх эрх мэдэл хэрэгжүүлдэг буюу түүнд оролцдог байгууллагуудын зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгон бэхжүүлэх хэтийн болон ойрын хугацааны нийгэм, эдийн засаг, эрх зүйн шинжтэй цогцолбор арга хэмжээний тухай асуудал боловсруулж Улсын Их Хурлын энэ оны намрын чуулганд өргөн мэдүүлэхийг Засгийн газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын ерөнхий прокурор, Монголын өмгөөлөгчдийн холбоонд даалгасугай.

5. Энэ тогтоолыг батлагдсан өдрөөс нь эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай.

дарга **Н.БАГАБАНДИ**

Тамгын газрын ерөнхий
нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 61 | Улаанбаатар хот

ТӨРИЙН МӨНГӨНИЙ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Төрийн мөнгөний бодлогын хэрэгжилтийн явц, цаашдын зорилтын тухай хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Төрөөс мөнгөний бодлогын талаар 1993 онд баримтлах чиглэл"-ийг хэрэгжүүлэх хүрээнд дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монголбанк (Д. Моломжамц)-нд даалгасугай:

1) төлбөр тооцооны шуурхай байдлыг хангах зорилгоор банк хоорондын мэдээлэл, тооцооны автоматжуулсан "цахилгаан шуудан" сүлжээг 1993 оны 3 дугаар улиралд багтаан ашиглалтанд оруулах;

2) аж ахуйн нэгж, байгууллага, хоорондын ор, авлагыг барагдуулах ажлыг засгийн газартай хамтран энэ оны 3 дугаар улиралд багтаан зохион байгуулах;

3) үйлдвэрлэлийн үйл ажиллагааны чиглэлээс нь хамааруулан аж ахуйн нэгжид түүхий эд бэлтгэх болон бусад шаардлагатай тохиолдолд хөнгөлөлттэй зээл олгох зорилгоор арилжааны банкуудад зохих хэмжээний зээлийн эх үүсвэр гаргаж өгөх;

4) төлбөр тооцоонд үнэт цаас гаргах (чек, вексель, хадгаламжийн сертификат зэрэг), бэлэн бус төлбөр тооцооны дэвшилтэт хэлбэрийг нэвтрүүлэх замаар зээлийг хорогдуулж тооцоог хурдасгах;

5) гүйлгээнд яваа бэлэн мөнгийг татаж авах оновчтой арга замыг бүрдүүлж, "Төрөөс мөнгөний бодлогын талаар 1993 онд баримтлах чиглэл"-ийн дагуу бэлэн мөнгөний зохистой хэмжээг алдагдуулахгүйгээр мөнгөний зузаатгал хийх замаар иргэдээс улсын төвлөрсөн хэрэгцээнд нийлүүлсэн бэлтгэлийн зүйлийн үнэ, хөдөлмөрийн хөлс, тэтгэвэр, тэтгэмж, нөхөх олговорт зориулан арилжааны банкуудыг бэлэн мөнгөөр тасралтгүй хангаж энэ зориулалтаар олгосон мөнгөнөөс төлбөр, шимтгэл авдаг явдлыг зогсоох.

2. Энэ тогтоолын хэрэгжилтийн явцын талаар 1993 оны 10 дугаар сард Улсын Их Хуралд мэдээлэхийг Монголбанк (Д. Моломжамц)-д даалгасугай.

Дарга Н.БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н.РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 62 | Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээг 1993 оны 9 дүгээр сарын 1-ний дотор авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) Монгол Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд Засгийн газрын болон яам, тусгай газрын шийдвэрийг нийцүүлэх;

2) хууль тогтоомжид заагаагүй хураамжийг авах тухай төрийн захиргааны төв, түүнчлэн нутгийн захиргааны болон бусад байгууллагын шийдвэрийг хянаж, хууль тогтоомж зөрчсөнийг хүчингүй болгох.

Дарга Н.БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н.РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 63 | Улаанбаатар хот

АЖ АХУЙН НЭГЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛЖ АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан дараахь арга хэмжээг энэ оны гуравдугаар улиралд багтаан авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийг Аж ахуйн нэгжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд нийцүүлэх;

2) улсын бүртгэлд бүртгэгдсэн аж ахуйн нэгжүүдийн оноосон нэрийн давхардлыг арилгах.

2. Улсын Их Хурлын 1994 оны хаврын чуулганаар хэлэлцүүлэхээр тооцож Монгол Улсын Компанийн тухай болон Хоршооллын тухай хуулийн төслийг боловсруулж өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасугай.

3. Аж ахуйн нэгжийн тухай хуулийг оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тусган бүрэн эхээр нь энэ оны 8 дугаар сарын 1-ний дотор хэвлүүлэхийг Улсын Их Хурлын Тамгын газарт даалгасугай

Дарга Н.БАГАБАНДИ

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Н.РИНЧИНДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 64 | Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХУУЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын хууль батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1) Монгол Улсын Иргэний эрүүл мэндийн даатгалын хуульд заасны дагуу Засгийн газрын дэргэд Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах, даатгалыг эрхлэх байгууллагыг тогтоож, эрх олгох, холбогдох журам, заавар, жагсаалтыг батлан гаргах, даатгалын гэрээ, гэрчилгээний маягтыг хэвлүүлэх түүнчлэн эрүүл мэндийн даатгалын тухай хууль тогтоомжийг сурталчлах зэрэг ажлыг энэ оны 10 дугаар сард багтаан зохион байгуулах;

2) 1 дэх хэсэгт дурдсан бэлтгэл ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг энэ оны улсын төсөв болон гадаад орнуудын зээл тусламжийн хөрөнгөөс гаргах;

3) 1994 оны даатгалын хураамжийн хувь хэмжээг энэ оны 11 дүгээр сард багтаан тогтоох.

2. Энэ хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын явц, зохион байгуулалтад хяналт тавьж дүнг энэ оны 4 дүгээр улиралд авч хэлэлцэх, шаардлагатай гэж үзвэл Улсын Их Хуралд мэдээлж холбогдох арга хэмжээ авахыг Хүн ам зүй, эрүүл мэнд, хөдөлмөр, нийгэм хангамжийн байнгын хороо, Төсөв, санхүү, мөнгө, зээлийн бодлогын байнгын хороонд даалгасугай.

Дарга **Н.БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 65 | Улаанбаатар хот

АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Орон сууц хуваарилалт, хувьчлалын ажилд хяналт тавих, иргэдийн орон сууцны хангамжийг сайжруулах асуудал боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1) Д. Батбаатар — Улсын Их Хурлын гишүүн
2) Ш. Батбаяр ____
3) Ж. Бямбажав ____
4) Б. Ганболд ____
5) Г. Ганболд ____
6) Т. Ганди ____
7) Ж. Жадамбаа ____
8) С. Зориг ____
9) Г. Зуунай ____
10) Д. Мөнхөө ____
11) С. Төмөр ____
12) Н. Тогтох ____
13) Ж. Уртнасан ____
14) Р. Цагаанхүү ____

2. Ажлын хэсгийн ахлагчаар Ш. Батбаярыг томилсугай.

Дарга **Н.БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 66 | Улаанбаатар хот

ХҮНИЙ ЭРХИЙН ДЭД ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3, 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хүний эрхийн дэд хороог Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны дотор дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

1) Ш. Батбаяр
2) Н. Баяртсайхан
3) Х. Володя
4) Г. Ганболд
5) Р. Гончигдорж
6) С. Зориг
7) Д. Мөнхөө
8) Ц. Элбэгдорж

2. Хүний эрхийн дэд хороо нь хүний эрх, эрх чөлөө, түүний баталгааг хангах, энэ тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, холбогдох асуудлыг Хууль зүйн байнгын хороонд бэлтгэж оруулах үндсэн үүрэгтэй байхаар тогтоосугай.

3. Р. Гончигдоржийг Дотоод асуудлын байнгын хорооны, С. Зоригийг Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байнгын хорооны бүрэлдэхүүнээс тус тус чөлөөлсүгэй.

Дарга **Н.БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 67 | Улаанбаатар хот

ХЭЭЛ ХАХУУЛЬ АВАХ, АЛБАН ТУШААЛАА УРВУУЛАН АШИГЛАХ ЯВДАЛТАЙ ТЭМЦЭХ ДЭД ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 3, 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хээл хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах явдалтай тэмцэх дэд хороог Улсын Их Хурлын Дотоод асуудлын байнгын хорооны дотор дараахь бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1) Ж. Болдбаатар
2) Ж. Бямбадорж
3) Ч. Дашдэмбэрэл
4) Д. Дэмбэрэл
5) С. Зориг
6) Г. Зуунай
7) М. Зэнээ
8) С. Нарангэрэл
9) Ж. Норовсамбуу

2. Дэд хороо нь хээл хахууль авах, албан тушаалаа урвуулан ашиглах явдалтай тэмцэх талаар төрөөс баримтлах бодлогын үндсийг боловсруулах, үүнд чиглэсэн хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, холбогдох асуудлыг Дотоод асуудлын хороонд бэлтгэн оруулах үндсэн үүрэгтэй байхаар тогтоосугай.

3. Г. Зуунайг Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байнгын хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлсүгэй.

Дарга **Н.БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 68 | Улаанбаатар хот

ӨМЧ ХУВЬЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Өмч хувьчлах тухай хууль тогтоомжийн биелэлт, төрийн өмчид байгаа эд хөрөнгийг хувьчлах ажлын явцыг Засгийн газарт шалгаж танилцсан дүнг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Дараах арга хэмжээ авахыг Засгийн газарт даалгасугай:

1) өмч хувьчлах ажлын талаар Засгийн газар болон Засгийн газрын Өмч хувьчлах комиссоос гаргасан тогтоол, шийдвэр, хөтөлбөрийн биелэлт, түүнчлэн бүх шатны өмч хувьчлах комиссын хувьчлалын сангийн зарцуулалт болон Монголын хөрөнгийн бирж, түүний харьяа брокерийн үүсүүдийн санхүүгийн ажиллагаанд баримтын шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж дүнг 1993 оны 4 дүгээр улиралд Улсын Их Хуралд танилцуулах;

2) өмч хувьчлалын тухай хууль тогтоомжийг зөрчсөн, төрийн болон хөдөө аж ахуйн нэгдлийн өмчийг хууль бусаар ашиглан завшсан, эзэнгүйдүүлж үрэгдүүлсэн явдлыг шалгаж буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх асуудлыг хууль хяналтын болон холбогдох бусад байгууллагаар шийдвэрлүүлэх;

3) өмч хувьчлалын явцтай уялдуулан уг ажлыг хөрөнгө оруулалтын эрхийн бичгээр хийж дуусгах хугацааг шинэчлэн тогтоох.

2. Бүх шатны шүүхийн шүүгчдийг аж ахуйн эрх зүйн чиглэлээр мэргэшүүлэх арга хэмжээ авахыг Шүүхийн ерөнхий зөвлөлд даалгасугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавих, Өмч хувьчлалын тухай хуульд Засгийн газар болон Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын тогтоол, шийдвэр хэрхэн нийцэж байгааг хянаж дүгнэлтээ 1993 онд багтаан Улсын Их Хуралд танилцуулахыг Эдийн

засгийн хөгжил, дэд бүтцийн бодлогын байнгын хороо, Хуул зүйн байнгын хороонд даалгасугай.

Дарга **Н.БАГАБАНДИ**

Тамгын газрын Ерөнхий
нарийн бичгийн дарга **Н.РИНЧИНДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 18-ны өдөр | Дугаар 1 | Улаанбаатар хот

Б. ДАШЦЭРЭНГ ЭЛЧИН САЙДЫН ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Буянтын Дашцэрэнг Монгол улсаас Бүгд Найрамдах Филиппин Улс, Бүгд Найрамдах Сингапур Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 18-ны өдөр | Дугаар 2 | Улаанбаатар хот

Б. ДОЛЖИНЦЭРЭНГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Бадам-Очирын Должинцэрэнг Монгол улсаас Бүгд Найрамдах Филиппин Улс, Бүгд Найрамдах Сингапур Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 3 | Улаанбаатар хот

ШҮҮГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЖУРМЫГ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасныг үндэслэн "Монгол Улсын шүүхийн шүүгчийн тангараг өргөх журам"-ыг хавсралтын ёсоор батлалсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 3 дугаар зарлигийн хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ТАНГАРАГ ӨРГӨХ ЖУРАМ

1. Монгол Улсын шүүхийн шүүгч бүр томилогдсоноос хойш 30 хоногийн дотор Монгол Улсын шүүгчийн тангаргийг ёс төртэйгээр өргөнө.

2. Шүүгч өөр албан тушаалд шилжин ажилласны дараа шүүгчээр томилогдсон, түүнчлэн шүүгчийн тангараг өөрчлөгдсөн тохиолдолд шүүгчийн тангараг дахин өргөнө.

3. Тухайн шүүхийн тамгын газар, хэлтсийн дарга шүүгчийн тангараг өргөх газар, хугацаа (өдөр, цаг)-г тухайн шүүхийн ерөнхий шүүгчтэй зөвшилцөн тогтоож, тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэлийг хангаж зохион байгуулна.

4. Шүүгчийн тангараг өргөх ёслолын ажиллагаанд төр, захиргааны байгууллагын удирдах албан тушаалтан буюу тэдний төлөөлөгчид, түүнчлэн нам, олон нийтийн болон хэвлэл, мэдээллийн байгууллага, иргэдийн төлөөлөгчдийг урилгаар оролцуулж болно.

5. Шүүгчийн тангараг өргөх байрыг ёслол төгөлдөр тусгайлан бэлтгэж Монгол Улсын төрийн сүлд, төрийн далбааг хүндэтгэлтэйгээр байрлуулна.

6. Тангараг өргөх шүүгч тогтоосон цагт тусгайлан бэлтгэсэн байранд хүндэтгэлтэйгээр орж Монгол Улсын төрийн сүлд рүү харан цэх зогсоно.

7. Шүүгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг тухайн шүүхийн тамгын газар, хэлтсийн дарга буюу түүний томилсон албан тушаалтан удирдана. Шүүгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан тангараг өргөх ёслолын ажиллагааг нээж, ерөнхий шүүгч, шүүгчээр томилогдсон хүмүүсийг танилцуулан Монгол Улсын шүүхийн шүүгчийн тангаргийн хуудсыг шүүгч бүрд гардуулна.

8. Шүүгчийн тангаргийг хамтаар буюу ганцаар өргөж болох бөгөөд хамтаар өргөхөд хамгийн ахмад шүүгч нь Монгол Улсын шүүхийн шүүгчийн тангаргийг цээжээр дээдлэн дуудаж бусад нь дагалдана. Шүүгчийн тангараг өргөж байх үед урилгаар оролцогчид босож хүндэтгэнэ.

9. Шүүгч Монгол Улсын Үндсэн хууль дээр баруун гараа тавиад Монгол Улсын шүүгчийн тангаргийг цээжээр дээдлэн дуудаад Монгол Улсын төрийн сүлдэнд мэхийн ёслож зүүн өвдөг сөхрөн Монгол Улсын төрийн далбаанаас адис авна.

10. Шүүгчийн тангараг өргөсөн шүүгч нүүрэн талдаа Монгол Улсын төрийн сүлдтэй, түүний дор "Монгол Улсын шүүгчийн тангараг" гэсэн үгтэй, дотор талдаа Монгол Улсын шүүхийн шүүгчийн тангаргийн бүрэн бичвэртэй тангаргийн хуудсанд тангараг өргөсөн он, сар, өдөр, газар, овог, нэр, албан тушаалаа бичиж гарын үсэг зурна.

11. Шүүгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааг удирдаж байгаа албан тушаалтан шүүгчдэд баяр хүргэж тангараг өргөх ёслолын ажиллагааг хаана.

12. Шүүгчийн тангаргийн хуудсыг тухайн шүүгчийн хувийн хэрэгт хавсарган хадгална.

13. Тангараг өргөх ёслолын ажиллагааны талаар тодорхой тэмдэглэл хөтөлнө.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 4 | Улаанбаатар хот

Г.БАХДАЛЫГ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Гомбодорж овогтой Бахдалыг Улсын Ерөнхий прокурорын албан тушаалаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 5 | Улаанбаатар хот

УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫГ ТОМИЛОХ ТУХАЙ

Улсын Их Хуралтай зөвшилцсөнийг үндэслэн Канзад овогтой Ганбаярыг 6 жилийн хугацаагаар Монгол Улсын Ерөнхий прокуророор томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 26-ны өдөр | Дугаар 6 | Улаанбаатар хот

Ц. САКЕЙГ НАЙРАМДАЛ МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Монголын соёл урлагийг сурталчлах, түүнийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг үнэлж Япон улсын Ямаха компанийн Хөгжмийн фондын дарга Цутому Сакейг Найрамдал медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 28-ны өдөр | Дугаар 7 | Улаанбаатар хот

ДЭЭД ШҮҮХИЙН ДАРГА, ОРЛОГЧ ДАРГА, КОЛЛЕГИЙН ДАРГА, ГИШҮҮДИЙГ АЛБАН ТУШААЛААС НЬ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Дашдоржийн Дэмбэрэлцэрэнг Дээд шүүхийн даргын, Сүрэнгийн Цэрэндоржийг Дээд шүүхийн нэгдүгээр орлогч дарга бөгөөд Эрүүгийн хэрэг эрхэлсэн шүүх коллегийн даргын, Намжилын Чинбатыг Дээд шүүхийн орлогч дарга бөгөөд Иргэний хэрэг эрхэлсэн шүүх коллегийн даргын, Чоймжуурын Дашнямыг Дээд шүүхийн аж ахуйн хэрэг эрхэлсэн шүүх коллегийн даргын, Даниагийн Алтангэрэл, Дашдоржийн Алтанцэцэг, Даваажавын Батсайхан, Цэрэнбалжирын Бүжинлхам, Чимэдлхамын Ганбат, Чүлтэмийн Ганболд, Гомбосүрэнгийн Ганзориг, Дамбын Данзандорж, Жадамбаагийн Дашдорж, Бадраагийн Долгор, Алтангэрэлийн Доржготов, Дарамширийн Минжүүр, Дэмчигжавын Намсрайжав, Балжирын Пүрэвдорж, Тогтохын Уранцэцэг, Баасангийн

Цогням, Пүрэвийн Цэцгээ нарыг Дээд шүүхийн гишүүний албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 28-ны өдөр Дугаар 8 Улаанбаатар хот

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн, Даниагийн Алтангэрэл, Даваажавын Батсайхан, Чимидлхамын Ганбат, Чүлтэмийн Ганболд, Гомбосүрэнгийн Ганзориг, Мөнхнасангийн Дамирансүрэн, Баасайн Дангаасүрэн, Дамбын Данзандорж, Алтангэрэлийн Доржготов, Дашдоржийн Дэмбэрэлцэрэн, Рэгзэнгийн Жамъянчойжил, Дэмчигжавын Намсрайжав, Балжирын Пүрэвдорж, Найдангийн Төрбат, Дагвадоржийн Тунгалаг, Баасангийн Цогням нарыг Улсын дээд шүүхийн шүүгчээр томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 6 дугаар сарын 29-ний өдөр | Дугаар 9 | Улаанбаатар хот

УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Улсын дээд шүүхийн саналыг үндэслэн Дашдорж овогтой Дэмбэрэлцэрэнг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчээр 6 жилийн хугацаагаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 11 | Улаанбаатар хот

Б. ТҮМЭНГ АЛБАН ТУШААЛААС НЬ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Өөр ажилд шилжих болсонтой нь холбогдуулан Бүдсүрэн овогтой Түмэнг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын даргын албан тушаалаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 12 | Улаанбаатар хот

М. ЭНХСАЙХАНЫГ ТАМГЫН ГАЗРЫН ДАРГААР ТОМИЛОХ ТУХАЙ

Мэндсайхан овогтой Энхсайханыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн тамгын газрын даргаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 13 | Улаанбаатар хот

М. ОДОНХҮҮГ АЛБАН ТУШААЛААС НЬ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Мүүзээ овогтой Одонхүүг Улсын ерөнхий прокурорын 1 дүгээр орлогчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 14 | Улаанбаатар хот

М.АЛТАНХУЯГИЙГ АЛБАН ТУШААЛААС НЬ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Өөрийнх нь хүсэлтийг үндэслэн Монгол овогтой Алтанхуягийг Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 16 | Улаанбаатар хот

ЗАРИМ ХҮНД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЖҮЖИГЧИН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Ардын уламжлалт урлагийн гайхамшигт бүтээл болсон уртын дуу, морин хуурын баялаг өв санг өвлөн эзэмших, сурталчлан дэлгэрүүлэх хэрэгт өндөр хувь нэмэр оруулж байгааг үнэлж дараах хүмүүст Монгол Улсын Гавьяат жүжигчин цол олгосугай.

1.Чүлтэмийн Батсайхан - Улсын ардын дуу, бүжгийн чуулгын хөгжимчин
2.Долгорын Баттөмөр - Мөн чуулгын дуучин
3.Адилбишийн Нэргүй - Мөн чуулгын дуучин
4.Ишданзангийн Цогбадрах - Мөн чуулгын хөгжимчин

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 17 | Улаанбаатар хот

М.ЦЭРЭНХАНДАД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ БАГШ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Ерөнхий боловсролын сургуулийн хөдөлмөрийн хичээлийн заах аргын ажуулгыг боловсронгуй болгох, хүүхэд залуучуудад оёдол, хатгамлын уламжлалт аргыг зааж сургахад оруулсан хувь нэмрийг өндөр үнэлж нийслэл хотын Шинжлэх ухаан боловсролын газрын судалгаа арга зүйн төвийн багш Мижиддоржийн Цэрэнхандад Монгол Улсын Гавьяат багш цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 18 | Улаанбаатар хот

М.ШАТАРЫГ "ШУДАРГА ЖУРАМ" МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Эр зориг, авхаалж самбаа гарган онц идэвхтэй ажиллаж галын аюулаас 2 хүүхдийн амь аварч иргэний үүргээ нэр төртэй биелүүлснийг үнэлж Үйлдвэр худалдааны "Өртөө" компанийн жолооч Мажигийн Шатарыг "Шударга журам" медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 3-ны өдөр | Дугаар 19 | Улаанбаатар хот

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Гэмт хэрэг, хэв журмын зөрчлийг илрүүлэх, гал түймэртэй тэмцэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүнийг Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1.Буянтогтохын Энх-Амгалан -Цагдаагийн ерөнхий газрын эрүүгийн хэлтсийн ахлах төлөөлөгч

2.Гомбын Бадамжав -Төв аймгийн Цагдаагийн газрын хэсгийн байцаагч

3.Гэндэнсүрэнгийн Гармаа -Мөн аймгийн мөн газрын орлогч дарга

4.Аюурзанын Даваажав -Мөн аймгийн Гал түймэртэй тэмцэх албаны жолооч

5.Дамбачойдорын Цэрэндамба -Мөн аймгийн Цагдаагийн газрын цагдаа

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Догсмаагийн Ганхүү -Улаанбаатар хотын Сүхбаатар дүүргийн цагдаагийн хэлтсийн төлөөлөгч

2. Лувсан-Осорын Адъяахүү -Төв аймгийн Цагдаагийн газрын төлөөлөгч

3. Жамбын Батсайхан -Мөн аймгийн Гал түймэртэй тэмцэх албаны байцаагч

4. Цэндийн Ганбаатар -Мөн аймгийн Цагдаагийн газрын байцаагч

5. Чойн Загдсүрэн -Мөн аймгийн мөн газрын ахлах төлөөлөгч

6. Пуглайн Мэгшээ -Мөн аймгийн мөн газрын байцаагч

7. Доржийн Оюун-Эрдэнэ -Хэнтий аймгийн Байгалийн гамшигтай тэмцэх салбарын шүхэр десантын гал сөнөөгч

8.Бааварын Доржготов -Завхан аймгийн Цагдаагийн хэлтсийн ахлах офицер

9.Дарамрагчаагийн Доржпалам -Мөн хэлтсийн цагдаа.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Дугаар 20 Улаанбаатар хот

Ж.ЭНХНАСАНГ УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧООР ТОМИЛОХ ТУХАЙ

Улсын Их Хуралтай зөвшилцсөнийг үндэслэн Жамсран овогтой Энхнасанг Улсын ерөнхий прокурорын орлогчоор 6 жилийн хугацаагаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 21 | Улаанбаатар хот

ДЭЭД ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН АЛБАН ТУШААЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Балжир овогтой Пүрэвдорж Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр томилогдсон тул түүнийг Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 22 | Улаанбаатар хот

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХОТ, ТУСГАЙ ШҮҮХИЙН БОЛОН ХЭСЭГ, ДҮҮРЭГ, ОРОН НУТГИЙН ХОТЫН ШҮҮХИЙН ДАРГА, ОРЛОГЧ ДАРГА, ГИШҮҮН, ШҮҮГЧДИЙГ АЛБАН ТУШААЛААС НЬ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн хавсралтад дурдсан аймаг, нийслэл, хот, тусгай шүүхийн болон хэсэг, дүүрэг, орон нутгийн хотын шүүхийн дарга, орлогч дарга, гишүүн, шүүгчдийг албан тушаалаас нь чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993
оны 22 дугаар зарлигийн хавсралт

1. Архангай аймгийн шүүхийн дарга Дугажийн Дамдиндорж, гишүүн Дансрангийн Наранцэцэг, хэсгийн ардын шүүхийн шүүгч Бодьгэрэлийн Бямбасүрэн.

2. Баян-Өлгий аймгийн шүүхийн дарга Зодогийн Нацаг, орлогч дарга Райханы Асхабил, гишүүн Асылханы Сауле, Мусаханы Айнагул, хэсгийн ардын шүүхийн шүүгч Уашбайн Байтурсан, Каманы Зулкаш, Силамын Сайран, Автокеримын Рота, Быхыягийн Ханат, Самдангийн Цэрэндорж.

3. Баянхонгор аймгийн шүүхийн дарга Ламжавын Цэдэндамба, орлогч дарга Ванчигдоогийн Жавхлан, гишүүн Дамдинсүрэнгийн Нацаг, хэсгийн ардын шүүхийн шүүгч Пүрэвдаваагийн Цэрэнбалжир, Цэнд-Аюушийн Ичинхорлоо, Сампилын Уранчимэг, Лоогийн Бумцэнд.

4. Булган аймгийн шүүхийн дарга Сандагийн Нямжав, орлогч дарга Дансрангийн Түвшинжаргал, гишүүн Лхам-Янжингийн Оюун, Махгалын Найдан, хэсгийн ардын шүүгч Шадийн Загдаа, Гомбожавын Оюунбаатар.

5. Бүх цэргийн тусгай шүүхийн дарга Мөнхнасангийн Дамирансүрэн, орлогч дарга Чимэдийн Сануйдагва, гишүүн Самдангийн Баасансүх, Атангийн Чимэдцогзол, Улаанбаатар хүрээний цэргийн тусгай шүүхийн дарга Цээнэнгийн Цэрэнжээ, орлогч дарга Сэрээтэрийн Цэдэндамба, шүүгч Натаагийн Володя, Лувсаншаравын Даваасүрэн, Загдын Цэнгэнбаяр, Дашдаваагийн Чулуунхүү, Дашдэндэвийн Хуяг, Гомбожавын Жадамбаа, Пүрэвдоржийн Донид, Зүүнбаян хүрээний цэргийн тусгай шүүхийн дарга Батцогтын Энхтайван, шүүгч Бадамцоогийн Идэрчулуун, Чойбалсан дахь цэргийн тусгай шүүхийн дарга Доржжодовын Ганбат, Даланзадгад дахь цэргийн тусгай шүүхийн дарга Цэрэндуламын Дарьбат, Ховд дахь цэргийн тусгай шүүхийн дарга Доржийн Тайванхүү, Эрдэнэт дахь цэргийн тусгай шүүхийн дарга Гэндэнжамцын Цэрэннадмид.

6. Говь-Алтай аймгийн шүүхийн орлогч дарга Рагчаагийн Сүрэнжав, гишүүн Бавалын Баатар, Ширчингийн Оюунцэцэг, хэсгийн ардын шүүхийн шүүгч Базаррагчаагийн Оюунбилэг, Чойжилын Алтанцоож.

7. Дархан хотын шүүхийн дарга Дуламын Пунцаг, орлогч дарга Дарамын Мягмаржав, гишүүн Лхүндэвийн Атарцэцэг, Бадам-Оригийн Рэнчинтогмид, хэсгийн ардын шүүхийн шүүгч Цэгмидийн Дэлгэрмаа, Цэдэн-Ишийн Туяа, Базаргүрийн Нүрзэдмаа, Батсэнгээгийн Энхээ.

8. Дорнод аймгийн шүүхийн дарга Тэрбишийн Энхтуяа, гишүүн Балдангийн Загдхорлоо, Норовын Лхагвадорж, хэсгийн ардын шүүхийн шүүгч Нацагдоржийн Баяраа, Намхайн Цогоо.

9. Дорноговь аймгийн шүүхийн дарга Лувсангийн Баяраа, орлогч дарга Гэрэлийн Тэгшсуурь, хэсгийн ардын шүүхийн шүүгч Думын Бямбаа, Мангалын Оюунчимэг, Арвинбуянгийн Энхбаатар.

10. Дундговь аймгийн шүүхийн дарга Лувсандоржийн Батчулуун, орлогч дарга Тогооборын Бямбажав, гишүүн Жаалын Батхүү, хэсгийн ардын шүүхийн шүүгч Борын Дэнсмаа, Шагдаргомбын Төмөрбаатар.

11. Завхан аймгийн шүүхийн дарга Пүрэвийн Загдаа, орлогч дарга Баянтөгсийн Намхайдорж, гишүүн Юнгэрэнгийн Ганбат, хэсгийн ардын шүүгч Дэнзэнгийн Гомбодорж, Доржийн Ням, Оросоогийн Нарангэрэл, Эрдэнэбаярын Мягмардорж, Сэрээнэнгийн Оюунцэцэг, Ёндонгийн Цогтзандан, Ишдоржийн Чимэдбадам, Дэмбэрэлийн Оюунчимэг, Батын Санжсүрэн, Тосонцэнгэл хотын шүүхийн дарга Бадамгаравын Цэрэнбат.

12. Сүхбаатар аймгийн шүүхийн дарга Дамдинсүрэнгийн Гансүх, гишүүн Содномтүнрэвийн Буд, хэсгийн ардын шүүхийн шүүгч Батсүхийн Батзориг, Нацагдоржийн Оюунчимэг.

13. Сэлэнгэ аймгийн шүүхийн дарга Норовын Хүрэлбаатар, гишүүн Мянгаагийн Наранцэцэг, Дулмаагийн Оюундарь, хэсгийн ардын шүүхийн шүүгч Гантөмөрийн Нарантуяа, Ёндонравжаагийн Оюунчимэг, Чойнорын Алтанцэцэг, Жанчивын Энхжаргал, Батаагийн Тэгшээ, Зүүнхараа хотын ардын шүүхийн дарга Содномбалжирын Цоодол.

14. Төв аймгийн шүүхийн дарга Цэрэндоржийн Раашээвэг, орлогч дарга Чүлтэмийн Төмөрпүрэв, гишүүн Намсрайн Түвшинжаргал, Дамдинжамцын Буянтогтох, хэсгийн ардын шүүгч Норовын Баяр, Лувсанхайдавын Баатар-Эрдэнэ, Жамбалын Мөнхтуяа, Доржгочоогийн Эрдэнэсүрэн.

15. Өвөрхангай аймгийн шүүхийн орлогч дарга Цэдэвийн Дашням, гишүүн Нацагдоржийн Төмөрбаатар, хэсгийн ардын шүүхийн шүүгч Ширчингийн Алтанцэцэг, Сүхийн Баатар, Гомбын Лхагвамаа, Дэмбэрэлийн Нэргүй, Гончигийн Цагаан, Түдэвийн Тэрхэнбэ, Раднаагийн Шүрхүү, Самдангийн Батсуурь.

16. Өмнөговь аймгийн шүүхийн дарга Цэвэгмидийн Сумъяа, гишүүн Боронхойн Содномцэрэн, Руламын Авирмэд, хэсгийн ардын шүүхийн шүүгч Надмидын Бямбаа, Рэнцэндоржийн Хадчулуун, Шагдарын Энхмаа.

17. Ховд аймгийн шүүхийн дарга Лавсангийн Сүхээ, гишүүн Дэлэгдоржийн Алимаа, Бандийн Одонцэцэг, хэсгийн ардын шүү-

хийн шүүгч Готовдоржийн Цагаанцоож, Капитаны Майра, Цэвгээгийн Ганбат, Наянбуугийн Чулуунжав.

18. Хөвсгөл аймгийн шүүхийн дарга Дамбын Галсанпунцаг, орлогч дарга Ширэндэвийн Бат-Эрдэнэ, гишүүн Бүдрагчаагийн Сарантуяа, Нямын Мөнхөө, хэсгийн ардын шүүхийн шүүгч Сандагийн Цэцэгмаа, Хүрлээгийн Болормаа, Төмөрбаатарын Ганбат.

19. Хэнтий аймгийн шүүхийн дарга Жамбалсүрэнгийн Энхчулуун, гишүүн Бадарчийн Сайханцэцэг, Доржготовын Түдэв, хэсгийн ардын шүүхийн шүүгч Гэндэндоржийн Болормаа, Дашнямын Мөнхбаяр, Дашзэвэгийн Энхжаргал.

20. Увс аймгийн шүүхийн дарга Дэлгэрэхийн Цэвээнцэрэн, орлогч дарга Жаргалын Сүрэнжав, гишүүн Цогнямын Балжинням, Цэдэвийн Санжаа, хэсгийн ардын шүүхийн шүүгч Лхагвын Энхтайван, Чантуугийн Элдэв-Очир, Янживын Сүрэн, Чойндонгийн Дулмаа.

21. Улаанбаатар хотын шүүхийн дарга Найдангийн Төрбат, орлогч дарга Мятавын Могноон, гишүүн Түмээгийн Гариймаа, Норовын Дашжамц, Лувсан-Очирын Жаргал, Даваахүүгийн Мөнхтуул, Цэрэнгийн Сайнбаяр, Хажидын Түдэв, Чимэдрэгзэнгийн Оюунцэцэг, Цэвэгмидийн Зориг, Долгорсүрэнгийн Энхээ, Сүхбаатар дүүргийн ардын шүүхийн дарга Дагвадоржийн Тунгалаг, дүүргийн ардын шүүхийн шүүгч Цэсэнжавын Алтанцол, Үржинбадамын Түмэнжаргал, Наасийн Батхолбоо, Пүрэвийн Бямбадорж, Жамбалын Баярсайхан, Раднаабазарын Ганчулуун, Цэдэнноровын Тогоохүү, Очирбатын Гэрэл, Баянгол дүүргийн ардын шүүхийн дарга Намжилдоогийн Чадраабал, дүүргийн ардын шүүхийн шүүгч Дадалын Завуд, Төмөржавын Доржбат, Базарсүрэнгийн Сарантуяа, Лхан-аажавын Оюунчимэг, Дашзэвэгийн Бадарч, Батсүрэнгийн Ундрах, Намширын Нарантуяа, Содномдаржаагийн Батдэлгэр, Цэгмэдийн Түмэндэлгэр, Хан-Уул дүүргийн ардын шүүхийн дарга Жамбалын Цэрэндолгор, дүүргийн ардын шүүхийн шүүгч Мижидийн Цэрэнбалжир, Тогтохын Туяа, Бямбаагийн Мөнхтуяа, Халтарын Батбаяр, Балдандоржийн Нарандолгор, Лхайжавын Сарангэрэл, Баянзүрх дүүргийн ардын шүүхийн дарга Сономын Ичинхорлоо, дүүргийн ардын шүүхийн шүүгч Раашийн Аззаяа, Даахарын Цэрэнпил, Довжилжамцын Энхтуяа, Мижидийн Баярсүрэн Багануур дүүргийн ардын шүүхийн дарга Дамдинсүрэнгийн Дамдин-Од, дүүргийн ардын шүүхийн шүүгч Дамдинсүрэнгийн Оюунбат, Налайх дүүргийн ардын шүүхийн дарга Тавхайн Жигжидсүрэн.

22. Улаанбаатар төмөр замын тусгай шүүхийн дарга Балдангийн Зэнэмядар, гишүүн Осоржамаагийн Эрдэнэчимэг, Дурангийн Жаргалсайхан, Пүрэвдоржийн Нэргүй, Дашзэвэгийн Чулуунбаатар.

23.Чойр хотын шүүхийн дарга Намсрайн Ваанчиг, гишүүн Дээвийн Сайжидмаа, хэсгийн ардын шүүхийн шүүгч Бадамгаравын Тогмид.

24. Эрдэнэт хотын шүүхийн дарга Түгжийн Долгорсүрэн, гишүүн Бадарчийн Байгал, Жигдэнгийн Энхтуяа, Рэнцэндоржийн Үйтүмэн, хэсгийн ардын шүүхийн шүүгч Аюушийн Оюунчимэг, Дашдаваагийн Энхбаяр, Ядамсүрэнгийн Туул, Дарамжавын Солонго.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 23 | Улаанбаатар хот

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДАРХАН, ЭРДЭНЭТ ХОТЫН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИД; СУМ, СУМ ДУНДЫН, ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор аймаг, нийслэл, Дархан, Эрдэнэт хот дахь давж заалдах шатны шүүхийн шүүгчдийг 1 дүгээр хавсралтаар; сум, сум дундын, дүүргийн шүүхийн шүүгчдийг 2 дугаар хавсралтаар тус тус томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 23 дугаар зарлигийн 1 дүгээр хавсралт

АЙМАГ, НИЙСЛЭЛ, ДАРХАН, ЭРДЭНЭТ ХОТЫН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХИЙН ШҮҮГЧИД

1. Архангай аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Дугажийн Дамдиндорж
Шийрэвдоржийн Батнасан

Дансрангийн Наранцэцэг
2. Баян-Өлгий аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч
Зодогийн Нацаг
Райханы Асхабил
Мусаханы Айнагул
Асылханы Сауле
3. Баянхонгор аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч
Ламжавын Цэдэндамба
Цэнд-Аюушийн Ичинхорлоо
Ванчигдоогийн Жавхлан
Сампилын Уранчимэг
4. Булган аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Сандагийн Нямжав
5. Говь-Алтай аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч
Рагчаагийн Сүрэнжав
Бавалын Баатар
Бамбарын Баасанхүү
Ширчингийн Оюунцэцэг
6. Дорноговь аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Лувсангийн Баяраа
Гэрэлийн Тэгшсуурь
7. Дорнод аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Тэрбишийн Энхтуяа
Балдангийн Загдхорлоо
Норовын Лхагвадорж
Жигжидийн Сүрэн
8. Дундговь аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Жаалын Батхүү
Тогооборын Бямбажав
Борын Дэнсмаа
9. Завхан аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Пүрэвийн Загдаа
Юнгэрэнгийн Ганбат
Ёндонгийн Цогтзандан
Доржийн Ням
Сэрээнэнгийн Оюунчимэг
10. Өвөрхангай аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүг
Пагамын Адъяасүрэн
Гомбын Адъяатогтох
Ширчингийн Алтанцэцэг
Цэдэвийн Дашням
11. Өмнөговь аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:

Цэвэгмидийн Сумъяа
Руламын Авирмэд
Боронхойн Содномцэрэн
12. Сүхбаатар аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Дамдинсүрэнгийн Гансүх
Батсүхийн Батзориг
Нацагдоржийн Оюунчимэг
13. Сэлэнгэ аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Норовын Хүрэлбаатар
Мянгаагийн Наранцэцэг
Магсарын Нямжанцан
Дулмаагийн Оюундарь
14. Төв аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Цэрэндоржийн Раашзэвэг
Дагвын Оюунчулуун
Намсрайн Түвшинжаргал
Чүлтэмийн Төмөрпүрэв
Гончигийн Мооноцагаан
15. Увс аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Дэлгэрэхийн Цэвээнцэрэн
Цогнямын Балжинням
16. Ховд аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Доржийн Тайванхүү
Дэлэгдоржийн Алимаа
Бандийн Одонцэцэг
Лавсангийн Сүхээ
17. Хөвсгөл аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Дамбын Галсанпунцаг
Нямын Мөнхөө
Бүдрагчаагийн Сарантуяа
18. Хэнтий аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Жамбалсүрэнгийн Энхчулуун
Бадарчийн Сайханцэцэг
Доржготовын Түдэв
19. Дархан хотын давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Дуламын Пунцаг
Лхүндэвийн Атарцэцэг
Дарамын Мягмаржав
Бадам-Оригийн Рэнчинтогмид
20. Эрдэнэт хотын давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Түгжийн Долгорсүрэн
Бадарчийн Байгал
Дарамжавын Солонго

Рэнцэндоржийн Үйтүмэн
21. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн шүүгч:
Балжирын Пүрэвдорж
Цэндийн Амарсайхан
Содномдаржаагийн Батдэлгэр
Түмээгийн Гариймаа
Очирбатын Гэрэл
Лувсан-Очирын Жаргал
Цэвэгмидийн Зориг
Мятавын Могноон
Чимэдрэгзэнгийн Оюунцэцэг
Цэрэнгийн Сайнбаяр
Хээмчигийн Сонинбаяр
Загдын Цэнгэнбаяр
Атангийн Чимидцогзол
Дашдаваагийн Чулуунхүү
Долгорсүрэнгийн Энхээ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны
23 дугаар зарлигийн 2 дугаар хавсралт

СУМ, СУМ ДУНДЫН, ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧИД

1. Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч:
Бодьгэрэлийн Бямбасүрэн
Бямбын Даваасүрэн
Сономдоржийн Пүрэвсүрэн
2. Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч:
Силамын Сайран
Пүрэвийн Дүгэрээ
Каманы Зулкаш
Хабыкэйгийн Жардемхан
Нурасылийн Тапал
Самдангийн Цэрэндорж
Сайдын Өнөр
3. Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч:
Дамдинсүрэнгийн Нацаг
Ламжавын Бор

Батаагийн Гэрэлмаа
Пүрэвдаваагийн Цэрэнбалжир
Содномсамбуугийн Цэрмаа
Готовын Уламбаяр

4. Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч:
Дансрангийн Түвшинжаргал
Шадийн Загдаа
Махгалын Найдан

5. Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч:
Баянтогсийн Намхайдорж
Базаррагчаагийн Оюунбилэг

6. Дорноговь аймгийн Чойр хот дахь сумын шүүхийн шүүгч:
Намсрайн Ваанчиг
Баасанжавын Лхагвацэрэн

7. Дорноговь аймгийн Сайншанд дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч:
Мангалын Оюунчимэг
Баянжавын Сумъяа

8. Дорнод аймгийн Чойбалсан дахь сумын шүүхийн шүүгч:
Намхайн Цогоо
Шунуугийн Дуламжав

9. Дорнод аймгийн Чойбалсан дахь сум дундын шүүхийн шүүгч:
Доржжодовын Ганбат
Бадарчийн Түмэнбаяр
Нацагдоржийн Баяраа

10. Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч:
Шагдаргомбын Төмөрбаатар
Раднаагийн Бизъяа

11. Завхан аймгийн Улиастай дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч:
Дэнзэнгийн Гомбодорж
Ишдоржийн Чимидбадам
Оросоогийн Нарангэрэл
Авирмэдийн Оюун

12. Завхан аймгийн Булнай дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч:
Бадамгаравын Цэрэнбат
Дэмбэрэлийн Оюунчимэг

13. Өвөрхангай аймгийн Арвайхээр дэх сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч:
Нацагдоржийн Төмөрбаатар
Цэрэндоржийн Амарсайхан
Ёндонгийн Ичинхорлоо

Очирын Цагаанхүү
Гончигийн Цагаан
14. Өвөрхангай аймгийн Хархорин дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч:
Гомбын Лхагвамаа
Даваасамбуугийн Болдбаатар
Түндэвийн Даваасүрэн
Дэмбэрэлийн Нэргүй
15. Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч:
Шагдарын Энхмаа
Рэнцэндоржийн Хадчулуун
16. Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч:
Содномтүнрэвийн Буд
Дорждэрэмийн Байгалмаа
17. Сэлэнгэ аймгийн Сүхбаатар дахь сум дундын1 дүгээр шүүхийн шүүгч:
Батхуягийн Батбаатар
Гантөмөрийн Нарантуяа
18. Сэлэнгэ аймгийн Зүүнхараа дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч:
Содномбалжирын Цоодол
Чойнорын Алтанцэцэг
Жанчивын Энхжаргал
19. Төв аймгийн Зуунмод дахь сум дундын 1 дүгээр шүүххийн шүүгч:
Лувсанхайдавын Баатар-Эрдэнэ
Дамдинжавын Буянтогтох
Жамбалын Мөнхтуяа
20. Төв аймгийн Жаргалант дахь сум дундын 2 дугаар шүүххийн шүүгч:
Норовын Баяр
21. Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч:
Жаргалын Сүрэнжав
Замбын Минжирмаа
Лүүрэвийн Жавзмаа
22. Ховд аймгийн Ховд дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч:
Готовдоржийн Цагаанцоож
Капитаны Майра
23. Ховд аймгийн Булган дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч:
Цэвгээгийн Ганбат
24. Ховсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч:
Ширэндэвийн Бат-Эрдэнэ

Сандагийн Цэцэгмаа
Бэасанжавын Нансалмаа
25. Хэнтий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч:
Дашзэвэгийн Энхжаргал
Гэндэндоржийн Болормаа
Дашнямын Мөнхбаяр
26. Дархан хот дахь сум дундын шүүхийн шүүгч:
Цэгмидийн Дэлгэрмаа
Цэвэгмидийн Булганхишиг
Мижидийн Догсомжав
Цэцэгтийн Төмөрцэцэг
Цэдэн-Ишийн Туяа
Батсэнгээгийн Энхээ
27. Эрдэнэт хот дахь сум дундын шүүхийн шүүгч:
Гэндэнжамцын Цэрэннадмид
Даваасүрэнгийн Ариунцэцэг
Эрдэнэжаргалын Ариунаа
Ядамсүрэнгийн Туул
Цэвээндоогийн Өрнөндэлгэр
Дашдаваагийн Энхбаяр
28. Нийслэл дэх Баянгол дүүргийн шүүхийн шүүгч:
Намжилдоогийн Чадраабал
Дашзэвэгийн Бадарч
Батсүрэнгийн Ундрах
Дадалын Завуд
Тогтохын Туяа
Цэгмэдийн Түмэндэлгэр
Пүрэвдоржийн Нэргүй
Осоржамаагийн Эрдэнэчимэг
29. Нийслэл дэх Баянзүрх, Гачуурт дүүргийн шүүхийн шүүгч:
Лувсаншаравын Даваасүрэн
Натаагийн Володя
Цэрэнхүүгийн Батчимэг
Довжилжамцын Энхтуяа
Шадравын Төгсгэрэл
Ванчингийн Дэлгэрмөрөн
Мижидийн Баярсүрэн
Балдандоржийн Нарандолгор
30. Нийслэл дэх Багануур, Багахангай дүүргийн шүүхийн шүүгч
Дамдинсүрэнгийн Дамдин-Од
Дамдинсүрэнгийн Оюунбат
Самбуугийн Оюунгэрэл
Санжаагийн Жамсран

31. Нийслэл дэх Налайх дүүргийн шүүхийн шүүгч:
Тавхайн Жигжидсүрэн
Нямсүрэнгийн Гэрэлсүрэн
32. Нийслэл дэх Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн шүүхи шүүгч:
Базарсүрэнгийн Сарантуяа
Үржинбадамын Түмэнжаргал
Бадамцоогийн Идэрчулуун
Пүрэвдоржийн Сарантуяа
Дашзэвэгийн Чулуунбаатар
Нямдоржийн Ичинхорлоо
Төмөржавын Доржбат
33. Нийслэл дэх Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгч:
Тогтохын Уранцэцэг
Цэсэнжавын Алтанцол
Цэдэнноровын Тогоохүү
Пүрэвийн Бямбадорж
Мижидийн Цэрэнбалжир
34. Нийслэл дэх Хан-Уул, Туул дүүргийн шүүхийн шүүгч:
Лхамжавын Сарангэрэл
Хажидын Түдэв
Лханаа-жавын Оюунчимэг
Лхайжавын Сарангэрэл
Бямбаагийн Мөнхтуяа
Халтарын Батбаяр
Раднаабазарын Ганчулуун
35. Нийслэл дэх Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгч:
Даваахүүгийн Мөнхтуул
Ранашийн Азаяа
Лувсандоржийн Бямба
Сономын Ичинхорлоо
Дашдэндэвийн Хуяг
Жигдэнгийн Энхтуяа
Насийн Батхолбоо

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 24 | Улаанбаатар хот

ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ БОЛОН СУМ, СУМ ДУНДЫН, ДҮҮРГИЙН ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор аймаг, нийслэл, Дархан, Эрдэнэт хот дахь давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчдийг 1 дүгээр хавсралтаар; сум, сум дундын, дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчдийг 2 дугаар хавсралтаар тус тус 6 жилийн хугацаагаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 24 дүгээр зарлигийн 1 дүгээр хавсралт

1. Архангай аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Дугажийн Дамдиндорж.
2. Баян-Өлгий аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Зодогийн Нацаг.
3. Баянхонгор аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Ламжавын Цэдэндамба.
4. Булган аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Сандагийн Нямжав.
5. Дорноговь аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Лувсангийн Баяраа.
6. Дорнод аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Тэрбишийн Энхтуяа.
7. Завхан аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Пүрэвийн Загдаа.
8. Өвөрхангай аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Пагамын Адъяасүрэн.
9. Өмнөговь аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Цэвэгмидийн Сумъяа.

10. Сүхбаатар аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Дамдинсүрэнгийн Гансүх.

11. Сэлэнгэ аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Норовын Хүрэлбаатар.

12. Төв аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Цэрэндоржийн Раашзэвэг.

13. Увс аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Дэлгэрэхийн Цэвээнцэрэн.

14. Ховд аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Доржийн Тайванхүү.

15. Хөвсгөл аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Дамбын Галсанпунцаг.

16. Хэнтий аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Жамбалсүрэнгийн Энхчулуун.

17. Дархан хотын давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Дуламын Пунцаг.

18. Эрдэнэт хотын давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Түгжийн Долгорсүрэн.

19. Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр Балжирын Пүрэвдорж.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны
24 дүгээр зарлигийн 2 дугаар хавсралт

1. Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Силамын Сайран.

2. Баянхонгор аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Дамдинсүрэнгийн Нацаг.

3. Булган аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Дансрангийн Түвшинжаргал.

4. Говь-Алтай аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Баянтөгсийн Намхайдорж.

5. Дорноговь аймгийн Чойр хот дахь сумын шүүхийн ерөнхий шүүгчээр Намсрайн Ваанчиг.

6. Дорноговь аймгийн Сайншанд дахь сум дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчээр Мангалын Оюунчимэг.

7. Дорнод аймгийн Чойбалсан дахь сумын шүүхийн ерөнхий шүүгчээр Намхайн Цогоо.

8. Дорнод аймгийн Чойбалсан дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Доржжодовын Ганбат.

9. Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Шагдаргомбын Төмөрбаатар.

10. Завхан аймгийн Улиастай дахь сум дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчээр Дэнзэнгийн Гомбодорж.

11. Завхан аймгийн Булнай дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчээр Бадамгаравын Цэрэнбат.

12. Өвөрхангай аймгийн Арвайхээр дэх сум дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчээр Нацагдоржийн Төмөрбаатар.

13. Өвөрхангай аймгийн Хархорин дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчээр Гомбын Лхагвамаа.

14. Өмнөговь аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Шагдарын Энхмаа.

15. Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Содномтүнрэвийн Буд.

16. Сэлэнгэ аймгийн Зүүнхараа дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчээр Содномбалжирын Цоодол.

17. Төв аймгийн Жаргалант дахь сум дундын 2 дугаар шүүхийн ерөнхий шүүгчээр Норовын Баяр.

18. Увс аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Жаргалын Сүрэнжав.

19. Ховд аймгийн Ховд дахь сум дундын 1 дүгээр шүүхийн ерөнхий шүүгчээр Готовдоржийн Цагаанцоож.

20. Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Ширэндэвийн Бат-эрдэнэ.

21. Хэнтий аймаг дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Дашзэвэгийн Энхжаргал.

22. Дархан хот дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Цэгмидийн Дэлгэрмаа.

23. Эрдэнэт хот дахь сум дундын шүүхийн ерөнхий шүүгчээр Гэндэнжамцын Цэрэннадмид.

24. Нийслэл дэх Баянгол дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Намжилдоогийн Чадраабал.

25. Нийслэл дэх Баянзүрх дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Лувсаншаравын Даваасүрэн.

26. Нийслэл дэх Багануур, Багахангай дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Дамдинсүрэнгийн Дамдин-Од.

27. Нийслэл дэх Налайх дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Тавхайн Жигжидсүрэн.

28. Нийслэл дэх Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Базарсүрэнгийн Сарантуяа.

29. Нийслэл дэх Сүхбаатар дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Тогтохын Уранцэцэг.

30. Нийслэл дэх Хан-Уул, Туул дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Лхамжавын Сарангэрэл.

31. Нийслэл дэх Чингэлтэй дүүргийн шүүхийн ерөнхий шүүгчээр Даваахүүгийн Мөнхтуул.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 25 | Улаанбаатар хот

Т. ЛУВСАНЦЭРЭНД МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Газар тариалангийн үйлдвэрлэлд үр бүтээлтэй ажиллан, тогтвортой арвин ургац хураан авч хүн амын хүнсний хэрэгцээг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь өндөр үнэлж Төв аймгийн Эрдэнэсант сумын "Буянт" хувьцаат компанийн трактор чкомбайнч Тэрбишийн Лувсанцэрэнд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол олгож, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 26 | Улаанбаатар хот

ЗАРИМ ХҮНД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл болон биеийн тамир, спортыг хөгжүүлэх үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь өндөр үнэлж дор дурдсан хүмүүст Монгол Улсын гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЭДИЙН ЗАСАГЧ ЦОЛООР:

Очирын Дашдэндэв - Төв аймгийн Цээл сумын "Залуучууд" хувьцаат компанийн ерөнхий захирал

МОНГОЛ УЛСЫН СПОРТЫН ГАВЬЯАТ ДАСГАЛЖУУЛАГЧ ЦОЛООР:

Цэрэнгийн Чанцал - Төв аймгийн Залуучууд, спортын хорооны дугуй, тэшүүрийн спортын дасгалжуулагч

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 5-ны өдөр | Дугаар 27 | Улаанбаатар хот

ТӨВ АЙМГИЙН ЗАРИМ ХҮНИЙГ ШАГНАХ ТУХАЙ

Аймаг, орон нутгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэхэд үр бүтээлтэй ажиллаж байгааг нь үнэлж Төв аймгийн дор дурдсан хүмүүсийг тус аймаг байгуулагдсаны 70 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР:

1.Дэмбэрэлийн Дамдин-сүрэн	- Цээл сумын "Залуучууд" хувьцаат компанийн ерөнхий агрономич
2.Цагааны Сүрэнхорлоо	-Баянцогт сумын "Гуна" хувьцаат компанийн захирал
3.Батсуурийн Наянтай	- Мөн сумын "Хайрхан" хувьцаат компанийн тракторч комбайнч

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Гарамын Будёнон	- Баянцогт сумын "Хайрхан" хувьцаат компанийн механикч
2. Балчингийн Борхүү	- Цээл сумын "Залуучууд" хувьцаат компанийн агрономич
3. Тувааны Дашбал	- Мөн компанийн бригадын дарга
4. Дамбын Ноорон	- Усны аж ахуйг удирдах газрын инженер
5. Үзэгийн Сагараажав	- Аймгийн нэгдсэн эмнэлгийн тасгийн эрхлэгч, их эмч
6. Данзангийн Дамба	- Аймгийн Засаг даргын тамгын газрын хэлтсийн дарга
7. Балжиннямын Жадамба	- Мөн газрын тасгийн дарга

АЛТАН ГАДАС ОДОНГООР:

1.Ширнэнгийн Баттулга	- Батсүмбэр сумын Засаг дарга
2.Намжилын Зоригт	- Мөн сумын "Ардын зориг" хувьцаат компанийн тракторч
3.Дамбын Наранцэцэг	- Мөн сумын "Эрдэнэтолгой" хувьцаат компанийн саальчин
4.Доошингийн Сэлэнгэ	- Мөн сум дахь зөгийн аж ахуйн эрдэмшинжилгээ-үйлдвэрлэлийн станцын захирал
5.Навааншаравын Чулуунжав	- Баян сумын Засаг дарга
6.Мишигийн Гомбожав	- Баянцагаан сумын дунд сургуулийн захирал
7.Дагдангийн Оюунсүрэн	- Мөн сумын "Өрнөх-амьдрал" хувьцаат компанийн хоньчин

8.Балдангийн Гунанбат	-Борнуур сумын "Дэвшил" хувиараа эрхлэх аж ахуйн агрономич
9.Даринчулууны Дагва	-Бүрэн сумын малчин
10.Чойжамцын Нэргүй	-Мөн сумын дунд сургуулийн багш
11.Найдангийн Дашзэвэг	-Жаргалант сумын "Жаргалант" хувьцаат компанийн дэд захирал
12.Дэжидийн Наранхүү	-Заамар сумын "Заамар" хувьцаат компанийн трактерч
13.Дэндэвийн Цэрэв	-Мөн компанийн дэд захирал
14.Доржийн Дагдан	-Лүн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
15.Цэдэндугарын Хүрэл	-Өндөрширээт сумын "Наранбилэг" хувьцаат компанийн адуучин
16.Ламжаагийн Баасанцэрэн	-Сэргэлэн сумын дунд сургуулийн багш
17.Зэсэмийн Нэргүй	-Мөн сумын "Баянбулаг" хувьцаат компанийн саальчин
18.Ахтанхожагийн Сейтхан	-Угтаалцайдам сумын "Угтаал" хувьцаат компанийн хоньчин
19.Шарын Дэгиддорж	-Цээл сумын "Залуучууд" хувьцаат компанийн бригадын дарга
20.Дамдингийн Магсаржав	-Мөн компанийн бригадын дарга
21.Жамцын Пүрвээ	-Мөн компанийн трактерч комбайнч
22.Эрдэнэ-Очирын Төмөрбаатар	-Мөн компанийн трактерч комбайнч
23.Дэндэвийн Цэрэннадмид	-Мөн сумын хүний их эмчийн салбарын эрхлэгч их эмч
24.Уртнасангийн Хандсүрэн	- Эрдэнэ сумын "Туяа" хувьцаат компанийн үхэрчин

25.Жуудайн Сүрэнхорлоо	-Эрдэнэсант сумын "Буянт" хувьцаат компанийн захирал
26.Өлзийбаярын Пүрэвсүрэн	-Барилга угсралтын "Оргил" компанийн сантехникч
27.Шагдарсүрэнгийн Цэрэндоо	-Аймгийн хэвлэл мэдээллийн албаны дарга
28.Чойдоржийн Өвгөнхүү	-Ходоо аж ахуйн банкны захирал
29.Дашдаваагийн Дэнсмаа	-Хөгжимт драмын театрын жүжигчин
30.Доржсүрэнгийн Үржинлхам	-Нэгдсэн эмнэлгийн их эмч
31.Чойжавын Доржгочоо	-IV дунд сургуулийн захирал
32.Лувсанбатын Норовренчин	-"Зуун мод" импекс пүүсийн захирал
33.Анирын Чогдон	-Үйлдвэрчний эвлэлийн холбооны зохион байгуулагч
34.Сономын Цэвнням	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан
35.Гомбожавын Эрдэнэбат	-Орон нутгийг судлах музейн эрхлэгч
36.Самдангийн Аюуш	-Барилга захиалагчийн товчооны дарга
37.Гүрсэдийн Юндэн	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан
38.Самбын Бажаахүү	-Заамар сум дахь Хайлаастын алтны үйлдвэрийн боловсон хүчин

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1.Цэндсүрэнгийн Батсайхан	-Алтанбулаг сумын Засаг дарга
2.Дашдоржийн Баяраа	-Аргалант сумын "Нохорлол" хувьцаат компанийн захирал
3.Чимэдбальдрын Насандорж	-Мөн компанийн трактормч, комбайнч
4.Цэрэндоржийн Бат-Өлзий	-Архуст сумын "Шунхлай" хувьцаат компанийн трактор
5.Лодонгийн Дашзэвэг	-Мөн сумын хүний их эмчийн салбарын эрхлэгч их эмч
6.Осорын Төмөр-Очир	-Мөн сумын "Ноён шанд" хувьцаат компанийн дэд захирал

7.Дугарсүрнгийн Шарав	-Мөн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга
8.Нямын Бадарч	-Батсүмбэр сумын "Ардын зориг" хувьцаат компанийн трахторч комбайнч
9.Гарамрагчаагийн Жамбал	-Мөн сумын "Баянбадрах" хувьцаат компанийн дэд захирал
10.Лувсанбалдангийн Дорж	-Баян сумын "Цацралт" хувьцаат компанийн дэд захирал
11. Очирын Дэмбэрэл	-Мөн компанийн малчин
12. Мижидийн Дэнсмаа	-Баяндэлгэр сумын "Хэрлэн" хоршооны худалдагч
13. Чойжавын Наранцэцэг	-Мөн сумын "Цацрал" хувьцаат компанийн саальчин
14. Гүрсэдийн Цэвээнпүрэв	-Мөн сумын "Хэрлэнбаян" хувьцаат компанийн трактор
15. Гэлэгжамцын Бат-Очир	-Баянжаргалан сумын засаг даргын тамгын газрын байцаагч
16. Цэдэнгийн Гомбо	-Мөн сумын дунд сургуулийн багш
17. Янжмаагийн Цэрэнбат	-Мөн сургуулийн багш
18. Дэмбэрэлийн Цэрмаа	-Баянхангай сумын дунд сургуулийн багш
19. Базарын Батмөнх	-Баянцагаан сумын "Өрнөх-амьдрал" хувьцаат компанийн малчин
20. Дэндэвийн Даваатөмөр	-Мөн компанийн малчин
21. Луугийн Лхагвасүрэн	-Мөн сумын "Дэлгэрэх" хувьцаат компанийн малчин
22. Сэнгийн Энхжаргал	-Мөн сумын "Өрнөх-амьдрал" хувьцаат компанийн малчин
23. Жамъянгийн Оскок	-Баянцогт сумын "Жуулчин" хувьцаат компанийн жолооч
24. Санжидын Сүхээ	-Мөн сумын Засаг дарга
25. Жүрмэдийн Цогтбаатар	-Мөн сумын "Есөн-эрдэнэ" хувьцаат компанийн малчин

26.Лханаажавын Цэвэгдорж	-Мөн сумын "Жуулчин" хувьцаат компанийн дэд захирал
27.Сэр-Одын Юмсүрэн	-Мөн компанийн тогооч
28.Дашийн Банк	-Баянчандмань сумын "Чандмань-Уул" хувьцаат компанийн эдийн засагч
29.Аюурзанын Бэгзсүрэн	-Мөн сумын ҮЭ-ийн холбооны дарга
30.Хайдавын Банзрагч	-Борнуур сумын дунд сургуулийн захирал
31.Шаравын Даваажав	-Мөн сумын "Борнуур" хувьцаат компанийн цехийн эрхлэгч
32.Дашдоржийн Нацагдорж	-Мөн сумын "Шар хоолой" хувьцаат компанийн саальчин
23. Рэнчинбатын Ванчиндорж	- Аймгийн "Үнэн" сонины мастер
24. Дэжидбалын Гриш	- Аймгийн "Эв санаа" хоршооны гуталчин
25. Жигжидийн Өлзийбат	- Аймгийн Өндөр уулын бүсийн мал эмнэлгийн эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн лабораторийн бага эмч
26. Долгорын Авирмэд	- Аймгийн "Гурван тамир" компанийн гагнуурчин
27. Ванчингийн Сайрхүү	- Мөн компанийн цахилгааны мастер
28. Ишийн Банзрагч	- Аймгийн нэгдсэн эмнэлгийн сувилагч
29. Бэгзийн Доржсан	- Аймгийн эд хэрэглэгчдийн хоршооллын холбооны ерөнхий нягтлан бодогч
30. Бэгзжавын Довдонням	- Аймгийн хөдөө аж ахуйн даатгалын салбарын захирал
31. Дабаанямын Сэнгэжав	- Аймгийн багшийн коллежийн Монгол хэл уран зохиолын багш
32. Циенгийн Тогтохбаатар	- Эрдэнэбулган сумын 10 жилийн I дунд сургуулийн биеийн тамирын багш
33. Ламзавын Даваа	- Аймгийн хүнсний үйлдвэрийн машинист
34. Доржийн Дуламжав	- Аймгийн нэгдсэн эмнэлгийн эмийн сангийн эрхлэгч
35. Наваантаагийн Лхагваа	- Аймгийн эрчим хүчний нэгдсэн үйлдвэрийн мастер
36. Өлзийбатын Агаанов	-Их тамир сумын засаг дарга
37.Банзайн Батанов	- Аймгийн үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга

38. Уужаагийн Жүгдэр	- Өгий нуур сумын банкны салбарын нягтлан бодогч
39. Банзарын Лхамаахүү	- Мөн сумын хүн эмнэлгийн асрагч
40. Архадын Лхагвасүрэн	- Өндөр-улаан сумын Засаг даргын тамгын газрын дарга
41. Нямдаваагийн Шинуудаваа	- Хайрхан сумын малын бага эмч
42. Магсарын Юмжир	- Аймгийн зам барилга ашиглалтын конторын жолооч
43. Гонгорын Дашдорж	- Аймгийн материал, техникийн хангамжийн газрын ахлах мэргэжилтэн
44. Зэгвийн Жаргалсайхан	- Аймгийн засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 16-ны өдөр

Дугаар 46

Улаанбаатар хот

Т. СУГАРТ МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ НИСГЭГЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Эх орныхоо хил хязгаарыг хамгаалах болон байгалийн гамшигал, усны аюултай тэмцэхэд мэргэжлийн өндөр ур чадвар гарга ажиллаж байгааг нь үнэлж Хилийн цэргийн нисэх эскадрилийн зохирагч, МИ-8 нисдэг тэрэгний багш нисгэгч, дэд хурандаа Төгсий Сугарт Монгол Улсын Гавьяат нисгэгч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 47 | Улаанбаатар хот

Т. ЭРДЭНЭ-ОЧИРТ МОНГОЛ УЛСЫН УРЛАГИЙН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Хилчин дайчдыг урлагаар үйлчлэх, монголын хөгжмийн болон киноны урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь өндөр үнэлж Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулгын хөгжмийн зохиолч, хошууч Тогтмолын Эрдэнэ-Очирт Монгол Улсын Урлагийн гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 48 | Улаанбаатар хот

ХИЛИЙН ЦЭРГИЙН ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Улсын хил хамгаалах үйлсэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүнийг Хилийн цэргийн 60 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Балдандоржийн Ванчигсүрэн - Хилийн цэргийн 0151 дүгээр ангийн салааны захирагч-багш, хошууч
2. Дамдинсүрэнгийн Жоний - 0119 дүгээр ангийн барилгачин, ахлагч
3. Чогын Сандр - Улсын аюулгүй байдлыг хангах ерөнхий газрын тэргүүн дэд бөгөөд Хилийн цэргийн дарга, хошууч

генерал

4.Чойжилсүрэнгийн Пэлжээ - Ахмад хилчин

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1.Эрдэнэдалайн Бүрнээбаяр - Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулгын гоцлол дуучин, ахлах ахлагч

2.Цэдэнгийн Дугар - УАБХЕГ-ын төв эмнэлгийн дотрын их эмч

ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:

1.Самбуугийн Самдандовжид - Хилийн 1-р хорооны захирагч, дэд хурандаа

2.Тунгалагийн Энхжаргал - Мөн хорооны 3 дугаар сумангийн захирагч, ахмад

3.Сүхээгийн Владимир - Мөн хорооны жолооч, ахлах ахлагч

4.Күлмисханы Огон - Мөн хорооны жолооч, ахлах ахлагч

5.Амартайваны Баатарсүрэн - 5 дугаар хорооны инженерийн албаны дарга, хошуу

6.Дампилын Шараа - Мөн хорооны жолооч, ахлах ахлагч

7.Сангидоржийн Думаахүү - Хилийн 7-р хорооны жолооч, ахлах ахлагч

8.Дагдангийн Ганжууржав - Хилийн 8-р хорооны захирагч, дэд хурандаа

9.До дивын Эрдэнээ - Мөн хорооны захирагчийн боловсон хүчин хариуцсан туслах, хошуу

10.Осорын Пүрэвдорж - Хилийн 9-р хорооны барилга орон сууцны албаны дарга, хошуу

11.Дамба-Яримпилийн Бямбадорж - Мөн ангийн хувцасны албаны дарга, хошуу

12.Ядамсүрэнгийн Батмөнх - Замын-Үүдийн шалган нэвтрүүлэх тусгай боомтод ахлах ажилтан, хошуу

13.Долгорын Сандагдорж - Хилийн 17-р хорооны 2-р сумангийн дарга, дэд хурандаа

14.Шарын Хүрэлбаатар - Хилийн 20-р хорооны санхүүгийн албаны дарга, дэд хурандаа

15.Жадамбын Төмөрбаатар - Хилийн 24-р хорооны Барилга орон сууцны албаны дарга, хошууч

16.Лувсандоржийн Мөнхбаатар - Мөн хорооны штабын хилийн албаны ахлах офицер, хошууч

17.Дамдинсүрэнгийн Ганболд - Мөн хорооны гүйцэтгэх албаны дарга, хошууч

18.Дуламын Чулуунбаатар - Хилийн 31-р хорооны уурын зуухны механикч, ахлах ахлагч

19.Дагвийбазарын Олзвой - Хилийн 0286-р ангийн ар талын дарга, дэд хурандаа

20.Төмөрбаатарын Үнэнбаяр - Хилийн 0275-р ангийн автогражийн дарга, дэслэгч

21.Сандагийн Мөнхдалай - Хилийн 0257-р ангийн ар талын дарга, хошууч

22.Будын Чулуунбат - Хилийн 0243-р ангийн санхүүгийн дарга, хошууч

23.Гомбосүрэнгийн Махбариад - Хилийн 0101-р ангийн шалгагч, ахлах ахлагч

24.Юндэнгийн Хөнхөр - Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулгын үлээвэр хөгжмийн зааварлагч, хошууч

25.Дарьсүрэнгийн Энхбаатар - Мөн чуулгын дарга, хошууч

26.Лэгдэнгийн Дагважамц - Хилийн 0276-р ангийн захирагч, дэд хурандаа

27.Давхайн Бүлтэн - Мөн ангийн орлогч, дэд хурандаа

28.Азадын Баатарцогт - Хилийн цэргийн штабын шалган нэвтрүүлэх хэлтсийн дарга, хошууч

29.Лувсандашийн Намхайноров -Мөн хэлтсийн ахлах ажилтан, хошууч

30.Өлзийцоогийн Гончиг - Хилийн 0252-р ангийн удирдлага, нууц, боловсон хүчний офицер, хошууч

31.Дашнямын Төмөрхав - Мөн ангийн засварын бүлгийн дарга, хошууч

32.Нэргүйн Даваадорж - Хилийн 0164-р ангийн бэлтгэл хангалтын офицер, ахлах дэслэгч

33.Шанжмятавын Доржбал	- "Эх орны манаа" сонины эрхлэгч, дэд хурандаа
34.Загдын Ганболд	- 0200-р ангид АН-24 онгоцны дарга, хошууч
35.Гончигчүлтэмийн Базаррагчаа	- 0253-р тусгай салбарын захирагч, дэд хурандаа
36.Шагжийн Цэдэн	- Хилийн цэргийн үлээвэр хөгжмийн "Сонор" хамтлагийн хөгжимчин, ахлах ахлагч
37.Тувааанжавын Бат-Өлзий	- Хилийн 0151- ангийн ротын захирагч, хошууч
38.Лувсаншаравын Цэдэн	- Тамгын хэлтсийн хилийн цэргийн боловсон хүчний ахлах ажилтан, хошууч
39.Диваанансалын Доржпалам	- Хилийн цэргийн ар талын дарга, дэд хурандаа
40.Дондовын Ганбаатар	- Мөнар талын хувцасны албаны дарга, дэд хурандаа
41. Кайсагийн Кулантай	- Аж ахуйн хэлтсийн барилга захиалагчийн төвчооны ахлах инженер, хошууч
42.Мөнхийн Чойжилсүрэн	- Ахмад хилчин
43.Далхаажавын Лхамжав	- 0119-р ангийн барилгын засалчин, ахлах ахлагч
44.Гоогормаагийн Цэрэнбаатар	- Мөн ангийн жолооч, ахлах ахлагч
45.Цэвээний Товуужав	- Хилийн 31-р хорооны гүйцэтгэх албаны дарга, дэд хурандаа

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Самбуугийн Байгалмаа	- 0119-р ангийн барилгын засал чимэглэгч, ахлах ахлагч
2.Нямжавын Идэр	- Мөн ангийн гагнуурчин, ахлах ахлагч
3.Хандын Зоригоо	- Мөн ангийн жолооч, ахлах ахлагч
4.Ламжавын Оюунчимэг	- Хилийн 8-р хорооны холбооны залгагч
5.Бямбын Цэвэл	- Мөн хорооны нягтлан бодогч
6.Пүрэвжалын Өлзийцогт	- Ерөнхий газрын үйлчлэгч

7.Хүүхэнжавын Цэрэндорж - Мөн газрын сантехникийн слесарьч

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1.Өнөржавын Амгалан - Хилийн 1-р хорооны жолооч, ахлах ахлагч

2.Сахайн Бакытхан - Мөн хорооны штабын дарга, хошууч

3.Расулын Казбек - Мөн хорооны холбооны ахлах офицер, хошууч

4.Зейнелын Мэльс - Мөн хорооны мал эмнэлгийн албаны ахлах офицер, хошууч

5.Дашдаваагийн Баатарсүрэн - Хилийн 5-р хорооны жолооч, ахлах ахлагч

6.Халидолдогийн Жекей - Мөн хорооны захирагч, дэд хурандаа

7.Очирын Пүрэв - Мөн хорооны Зөөлөн тоног хэрэгслийн засварчин, ахлах ахлагч

8.Даншийн Ретов - Хилийн 6-р хорооны засварын дарга, ахмад

9.Чогдовын Энхтайван - Мөн хорооны жолооч, ахлах ахлагч

10.Ядамсүрэнгийн Гомбосүрэн - Хилийн 7-р хорооны хилийн албаны дарга, ахмад

11.Балжингийн Үнэнбүрэн - Мөн хорооны жолооч, ахлах ахлагч

12.Дэмбэрэлийн Чулуунбаатар - Мөн хорооны ротын захирагч, хошууч

13.Бат-Очирын Батаа - Хилийн 8-р хорооны хүн эмнэлгийн албаны дарга, хошууч

14.Батжанцангийн Төрбат - Мөн хорооны соёлын төвийн дарга, ахмад

15.Мижиддоржийн Ширмэнбаатар - Мөн хорооны холбооны дарга, хошууч

16.Бямбажавын Буянжав - Мөн хорооны орлогч, хошууч

17.Жалцавын Батхуяг - Хилийн 9-р хорооны 4-р сумангийн дарга, хошууч

18.Нямбуугийн Лхагвадорж - Мөн хорооны засварын бүлгийн дарга, ахлах ахлагч

19.Цэрэндоржийн Төмөр - Мөн хорооны хилийн ал-

баны дарга, ахмад

20.Балжиннямын Уганбаяр - Мөн хорооны штабын дарга, хошууч

21.Вандансэнгээгийн Баярсайхан - Хилийн 12-р хорооны хүн эмнэлгийн албаны дарга, хошууч

22.Лувсандагвын Ганбат - Мөн хорооны жолооч, ахлах ахлагч

23.Пүрэвжалын Ганхуяг - Мөн хорооны санхүүгийн албаны дарга хошууч

24.Содномпилийн Насанжаргал - Хилийн 17-р хорооны жолооч, ахлах ахлагч

25.Төмөрбаатарын Сундуйжав - Мөн хорооны сумангийн дарга, ахмад

26.Шаравын Гончиг - Хилийн 20-р хорооны мал эмнэлгийн албаны дарга, хошууч

27.Дайрийн Мягмаржав - Мөн хорооны агтны салааны захирагч, ахмад

28.Дашийн Цолмон - Хилийн 24-р хорооны сумангийгн захирагч, ахмад

29.Цэндийн Батчулуун - Хилийн 31-р хорооны цэргийн дайчилгаа, тоо бүртгэлийн офицер, хошууч

30.Цэдэвийн Удвал - Мөн хорооны засварын бүлгийн дарга, дэслэгч

31.Жамбалдоржийн Цэрэндаваа - Мөн хороонд жолооч, ахлах ахлагч

32.Дадалын Гаажав - 0286-р ангийн штабын дарга, хошууч

33.Доржбалын Алтангэрэл - 0245-р ангийн шалгагч, ахлах ахлагч

34.Орсоогийн Даваадорж - Мөн ангийн жолооч, ахлах ахлагч

35.Юндэнгийн Дэнсмаа - Мөн ангийн нууцын эрхлэгч, ахлах ахлагч

36.Будекейн Кендебай - 0285-р ангийн жолооч, ахлах ахлагч

37.Үрчигийн Нацагдорж - Мөн ангийн хилийн албаны офицер, ахлах дэслэгч

38.Чимэдийн Бадамсэрээжид - 0243-р ангийн ар талын орлогч, хошууч

39.Өлзийбатын Лхагва - Мөн ангийн суманд хэсэг

	хариуцагч, ахлах ахлагч
40.Жамбалын Нацагдорж	- 277-р ангийн хилийн албаны ахлах офицер, хошууч
41.Цэрэнлхамын Доржтовуу	- Мөн ангийн хилчин, ахлах ахлагч
42.Жамбын Чулуунгомбо	- 0101-р ангийн шалгагч, ахлах ахлагч
43.Жанцангийн Оюун	- Мөн ангийн шалгагч, ахлах ахлагч
44.Лувсангомбын Алтанцэцэг	- Замын Үүдийн шалган нэвтрүүлэх тусгай боомтын шалгагч, ахлах ахлагч
45.Рэгзэнгийн Пүрэв	- Мөн боомтын хангалтын ахлах ажилтан, хошууч
46.Бадамын Хүрэлбаатар	- Мөн боомтын боловсон хүчин, хошууч
47.Дугарын Төмөрбаатар	- Хилийн 0275-р ангийн шалгагч, ахлах ахлагч
48.Шагжийн Жүгдэр	- Хилийн 0257-р ангийн нууцын эрхлэгч, ахлах ахлагч
49.Гэлгээгийн Загд	- Мөн ангийн хилийн хэсэг хариуцагч, ахлах ахлагч
50.Жамбалдоржийн Жаргал	- Хилийн 0287-р ангийн удирдлага, нууцын дарга, ахмад
51.Гэнэнгийн Батбаяр	- Хилийн цэргийн дуу, бүжгийн чуулгын гоцлол дуучин, ахлах ахлагч
52.Жарантайн Бямбадорж	- Мөн чуулгын бүжигчин, ахлах ахлагч
53.Мягмарын Ганболд	- Мөн чуулгын хөгжимчин, ахлах ахлагч
54.Дамчаагийн Сарантуяа	- Мөн чуулгын хөгжимчин, ахлах ахлагч
55.Цэвэгжавын Ганхуяг	- Мөн чуулгын бүжигчин, ахлах ахлагч
56.Бат-Өрнөхийн Гонгорсүрэн	-0276-р ангийн моторчин, ахлах ахлагч
57.Тогнингийн Хүрэлбаатар	- Мөн ангийн жолооч, ахлах ахлагч
58.Банзрагчийн Дорж	- 0151-р ангийн холбооны засварын бүлгийн дарга, хошууч
59.Бямбацэрэнгийн Хишигмаа	-Мөн ангийн холбооны

	залгагч, ахлах ахлагч
60.Гомбосүрэнгийн Лувсанбазар	- Хилийн цэргийн штабын холбооны албаны инженер, хошууч
61.Норовын Наранжамц	- Мөн штабын хилийн хэлтэст ахлах офицер, хошууч
62.Лүндэнгийн Манжийлаа	- Мөн штабын сургалтын ажилтан, ахмад
63.Мягмарсүрэнгийн Батчулуун	- 0164-р ангийн ахлах нягтлан бодогч, ахмад
64.Дашдондовын Жамбал	- 0242-р ангийн их эмч, хошууч
65.Баатарын Төмөр	- Мөн ангийн ахлах нягтлан бодогч, дэд хурандаа
66.Содномын Наранбат	- Хилийн цэргийн ар талын мал эмнэлгийн албаны дарга хошууч
67.Жамсрангийн Жадамбаа	- Мөн ар талын барилга орон сууцны албаны офицер, хошууч
68.Амьтны Наранцэцэг	- Газрын зэвсэг техникийн хэлтсийн дизель хүнд механизмын инженер, дэслэгч
69.Ойдовсамбуугийн Алтанцэцэг	- Хилийн түүх судлалын секторын бичээч, бичиг хэргийн эрхлэгч, ахлах ахлагч
70.Галсанцэрэнгийн Нямцэрэн	- Хилийн цэргийн "Сонор" хамтлагийн хөгжмийн жагсаалын дарга, ахлах ахлагч
71.Дашзэвэгийн Лувсандаш	- Газрын санхүү бүртгэлийн албаны мэргэжилтэн, хошууч
72.Дамбын Баттулга	- Хилийн цэргийн "Сонор" хамтлагийн хөгжимчин, ахлах ахлагч
73.Чимэддоржийн Гантөмөр	- 0200-р ангийн борт техникч, ахмад
74.Сэдийн Очир	- Мөн ангийн штабын туслах холбооны дарга, хошууч
75. Далайн Цэнгэлмаа	- Мөн ангийн шатах тослох материалын лабораторийн эрхлэгч, ахлах ахлагч
76. Гомбын Баянбилэг	- 0253-р тусгай салбарын жо

	лооч, ахлах ахлагч
77.Жамбалын Эрдэнэбаатар	- ХЦ-ийн удирдлага, нууцын тасгийн дарга, дэд хурандаа
78.Мөнхөогийн Баяраа	- 0119-р ангийн заслалчин, ахлагч
79.Бавуугийн Ганбат	- Мөн ангийн штабын дарга, хошууч
80.Чимэдцэрэнгийн Мөнгөнсэлэм	- Мөн ангийн барилгын техникч, ахмад
81.Шавирайн Цогтсайхан	- Мөн ангийн кранчин, ахлах ахлагч
82.Сандуйжавын Алтангэрэл	- Хилийн 5-р хорооны гүйцэтгэх албаны ажилтан, хошууч
83.Сэржийн Жаргалсайхан	- 0101-р ангийн гүйцэтгэх албаны ажилтан, хошууч
84.Ханджавын Батчулуун	- Хилийн 17-р хорооны шифрийн ажилтан, хошууч

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 49 | Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЕРӨНХИЙ ШТАБЫН ДАРГЫГ ТОМИЛОХ ТУХАЙ

Хошууч генерал Рашмаа овогтой Гавааг Монгол Улсын Зэвсэгт Хүчний Ерөнхий штабын даргаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 50 | Улаанбаатар хот

ТУСЛАМЖ ОЛГОЖ БАЙХ ТУХАЙ

Өндөр насны тэтгэвэрт гарч байгаа офицер, ахлагчдын амьдралын баталгааг хангах шаардлагыг харгалзан Зэвсэгт хүчин, улсын аюулгүй байдлыг хангах, цагдаагийн болон хорих ял эдлүүлэх байгууллагад 25-аас доошгүй жил ажилласан эрэгтэй офицер, ахлагч, 20-иос доошгүй жил ажилласан эмэгтэй офицер, ахлагч нарыг насны тэтгэвэрт гарахад нь улсын хууль тогтоомж, өргөсөн тангаргаа хэлбэрэлтгүй биелүүлж, үнэнч шударгаар, үр бүтээлтэй ажилласан байдлыг нь харгалзан 1994 оноос эхлэн буцаан хэрэглэхгүй байх нөхцөлөөр тэдний 18-36 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тусламж олгож байх журам тогтоож мөрдүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт чиглэл болгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 17-ны өдөр | Дугаар 51 | Улаанбаатар хот

ЦАГДААГИЙН БОЛОН ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГЫН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлаас баталсан "Монгол Улсад нийгмийн дэг журам хангах талаар төрөөс явуулах үйл ажиллагааны үндсэн чиглэл"-ийг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэхтэй холбогдуулан цагдаагийн болон хорих ял эдлүүлэх байгууллагын талаар дор

дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт чиглэл болгосугай.

1) цагдаагийн болон хорих ял эдлүүлэх байгууллагын материаллаг бааз, техник хэрэгслийн хангамжийг сайжруулах, үйл ажиллагаагаа явуулах зохих нөхцөл бололцоогоор хангах, боловсон хүчнийг бэлтгэх, мэргэшлийг нь дээшлүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний нийгмийн баталгааг хангах, цагдаагийн ажилтнуудын үндсэн цалингийн хэмжээг хэвийн ажиллаж, амьдрах нөхцөлийг нь хангахуйцаар нэмэгдүүлэх, цагдаагийн байгууллагад сар бүр олгох шатахууны лимитийг 1990 оны хоос буурууллахгүй байх талаар цогцолбор арга хэмжээ авч 1993-1994 онд хэрэгжүүлэх;

2) цагдаагийн байгууллагын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын 1993 оны намрын чуулганаар хэлэлцүүлэх бэлтгэлийг хангах.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 52 | Улаанбаатар хот

ШИРЧИНЖАВЫН ЮМЖАВЫГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Ширчинжавын Юмжавыг Монгол улсаас Ватикан улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

ЛУВСАНДОРЖИЙН МУНДАГБААТАРЫГ ЭЛЧИН САЙДЫН ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Лувсандоржийн Мундагбаатарыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Португал Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот

ХАСБАЗАРЫН БЭХБАТЫГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Хасбазарын Бэхбатыг Монгол Улсаас Бүгд Найрамдах Португал Улсад суух Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайдаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 55 | Улаанбаатар хот

ЛУВСАНДОРЖИЙН МУНДАГБААТАРЫГ ЭЛЧИН САЙДЫН ҮҮРЭГТ АЖЛААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Лувсандоржийн Мундагбаатарыг Монгол Улсаас Испанийн Вант Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 7 дугаар сарын 19-ний өдөр | Дугаар 56 | Улаанбаатар хот

ХАСБАЗАРЫН БЭХБАТЫГ ЭЛЧИН САЙДААР ТОМИЛОХ ТУХАЙ

Хасбазарын Бэхбатыг Монгол Улсаас Испанийн Вант Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 8 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 60 | Улаанбаатар хот

ЗАРИМ ШҮҮГЧИЙГ АЛБАН ТУШААЛААС НЬ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Монгол улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Азиусэдийн Мөнхзулыг Архангай аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, Сэмжидийн Нолхоосүрэнг Сэлэнгэ аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, Надмидын Мөнхжаргалыг Увс аймгийн шүүхийн гишүүний, Балжирхүүгийн Энхтайваныг Хөвсгөл аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, Гомбожавын Туулхүүг Дархан хотын шүүхийн гишүүний албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 8 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 61 | Улаанбаатар хот

ЗАРИМ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Надмидын Мөнхжаргалыг Увс аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр, Балжирхүүгийн Энхтайваныг Хөвсгөл аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр, Гомбожавын Туулхүүг Дархан хот дахь давж заалдах шатны шүүхийн шүүгчээр, Азиусэдийн Мөнхзулыг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Ядамсүрэнгийн Алтаннавчийг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Сэмжидийн Нолхоосүрэнг Сэлэнгэ аймаг дахь

сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчээр, Дагвадоржийн Цолмонг Булган аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Жигжидсүрэнгийн Сэлэнгэ, Барьнын Сарантуяа нарыг нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчээр, Дагаагийн Байгалмааг нийслэлийн Сонгинохайрхан, Жаргалант дүүргийн шүүхийн шүүгчээр; Лхам-Янжингийн Оюуныг нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчээр, Батдоржийн Нармандахыг нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгчээр тус тус томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 8 дугаар сарын 9-ний өдөр | Дугаар 62 | Улаанбаатар хот

ЗАРИМ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧДИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор Бамбарын Баасанхүүг Говь-Алтай аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр, Дамдинжамцын Буянтогтохыг Төв аймгийн Зуунмод дахь сум дундын нэгдүгээр шүүхийн ерөнхий шүүгчээр 6 жилийн хугацаагаар тус тус томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 8 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 65 | Улаанбаатар хот

Г. ЭРДЭНЭЖАВЫГ "АЛТАН ГАДАС" ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Эрдэм шинжилгээний байгууллагад үр бүтээлтэй ажиллаж малын тэжээлийн олон наст ургамлыг тариалжуулж үйлдвэрлэлд нэвтрүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Шинжлэх ухааны академийн Ботаникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор, профессор Гүрийн Эрдэнэжавыг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 8 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 66 | Улаанбаатар хот

Ш. БАТБАЯРЫГ "АЛТАН ГАДАС" ОДОНГООР ШАГНАХ ТУХАЙ

Үйлдвэр, аж ахуй, үйлчилгээний салбарт хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, нормчлол, цалин хөлс, урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох, улс орон зах зээлийн харилцаанд шилжих шилжилтийн үед МҮЭ-үүдийн гүйцэтгэх үүрэг, зорилтыг тодорхойлох, түүнийг хэрэгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсын Их хурлын гишүүн Шийлэгийн Батбаярыг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 8 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 69 | Улаанбаатар хот

Д. Т. ЦЫРЕМПИЛОВЫГ "НАЙРАМДАЛ" МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Монгол, Буриадын соёлын харилцааг хөгжүүлэх, Монгол, Орос хийгээд Монгол, Буриадын парламент хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Дээд Зөвлөлийн тэргүүлэгч гишүүн Доржи Тибочкиевич Цыремпиловыг "Найрамдал" медалиар шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 8 дугаар сарын 10-ны өдөр | Дугаар 73 | Улаанбаатар хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын прокурорын байгууллагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Прокурорын сахилгын дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны
73 дугаар зарлигийн хавсралт

ПРОКУРОРЫН САХИЛГЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Прокурорыг урамшуулах, түүнд сахилгын шийтгэл оногдуулахад Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хууль болон түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, энэ дүрмийг баримтална.

2. Прокурор хуулиар тогтоосон чиг үүрэг, бүрэн эрхийг хэрэгжүүлэхдээ гаднын нөлөөнд үл автан, гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан Улсын ерөнхий прокурорын шийдвэрийг удирдлага болгох, хуулийг нэг мөр хэрэглэх явдлыг өөрийн чиг үүргийн хэмжээнд хангах, дээд шатны прокурорын шийдвэрийг заавал биелүүлэх, албан үүрэгт ажилдаа үнэнч шударга, санаачилгатай хандах, мэдлэг, мэргэшлээ байнга дээшлүүлэх, прокурорын ёс зүйн хэм хэмжээг сахих үүрэгтэй. Прокурор нь байгууллагынхаа хөдөлмөрийн дотоод журмыг чанд сахина.

Хоёр. Урамшуулал

3. Ажилдаа идэвх зүтгэл, үр бүтээл гаргасан прокурорыг дор дурдсанаар урамшуулна:

1) сайшаах;

2) хоёр хүртэл сарын үндсэн цалингийн хэмжээний мөнгөн шагналаар шагнах;

3) Прокурорын байгууллагын хүндэт үнэмлэхээр шагнах;

4) Прокурорын байгууллагын хүндэт дэвтэрт нэрийг нь бичих;

5) "Прокурорын хүндэт ажилтан" тэмдгээр шагнах.

4. Улсын ерөнхий прокурор энэ дүрмийн 3 дугаар зүйлд заасан бүх урамшуулал олгох эрхтэй.

5. Улсын ерөнхий прокурорын орлогч нь Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, хяналтын прокурор, аймаг, нийслэл, тээврийн болон сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газрын прокурор; Улсын ерөнхий прокурорын туслах нь өөрийн удирдсан нэгжийн прокурор, аймаг, нийслэл, тээврийн болон сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газрын прокурор; аймаг, нийслэлийн прокурор нь өөрийн удирдсан прокурорын газар болон харьяа сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газрын прокурор; тээврийн прокурор нь өөрийн удирдсан прокурорын газрын прокурорыг шагнаж урамшуулах тухай саналаа Улсын ерөнхий

прокурорт уламжилж болно. Сум, сум дундын буюу дүүргийн ахлах прокурор өөрийн удирдлагад байгаа прокурорыг шагнаж урамшуулах тухай саналаа дээд шатныхаа прокуророор дамжуулан Улсын ерөнхий прокурорт уламжилж болно.

6. Урамшууллыг тушаалаар олгож энэ тухай хамт олонд нь мэдээлнэ.

7. Энэ дүрмийн 3 дугаар зүйлийн 3, 4, 5-д заасан урамшуулал олгох журмыг Улсын ерөнхий прокурор тогтооно.

8. Улсын ерөнхий прокурор эрхэлсэн ажилдаа онцгой амжилт гаргасан прокурорыг улсын цол, одон, медалиар шагнуулахаар холбогдох байгууллагад зохих журмын дагуу уламжилна.

Гурав. Сахилгын шийтгэл

9. Улсын ерөнхий прокурор Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан үндэслэлээр прокурорт сахилгын шийтгэл оногдуулна.

10. Улсын ерөнхий прокурорын орлогч нь Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, хяналтын прокурор, аймаг, нийслэл, тээврийн болон сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газрын прокурорт; Улсын ерөнхий прокурорын туслах прокурор нь өөрийн удирдсан нэгжийн прокурор, аймаг, нийслэл, тээврийн болон сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газрын прокурорт; аймаг, нийслэлийн прокурор нь өөрийн удирдсан прокурорын газар болон харьяа сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газрын прокурорт; тээврийн прокурор нь өөрийн удирдсан прокурорын газрын прокурорт сахилгын шийтгэл оногдуулах тухай санал гаргаж болно. Сум, сум дундын буюу дүүргийн ахлах прокурор нь өөрийн удирдлагад байгаа прокурорт сахилгын шийтгэл оногдуулах тухай саналаа дээд шатныхаа прокуророор дамжуулан Улсын ерөнхий прокурорт гаргаж болно.

11. Прокурорт сахилгын шийтгэл оногдуулах тухай саналыг дараахь тохиолдолд гаргана:

1) прокурор хууль болон байгууллагын дотоод журмыг зөрчсөн, прокурорын ёс зүйн хэм хэмжээ, хуульд заасан албан үүргээ үл биелүүлсэн;

2) прокурорын шийдвэр хүчингүй болсон буюу өөрчлөгдсөн нь түүний гэм буруугаас шалтгаалсан бол.

12. Сахилгын шийтгэл оногдуулах үндэслэлийг заавал шалгаж тогтоосон байна. Шалгалт явуулсны дараа прокурорт сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл тогтоогдсон гэж үзвэл энэ дүрмийн 10 дугаар зүйлд заасан прокурорууд сахилгын шийтгэл оногдуулах тухай санал, шалгалтын баримт сэлтийг Улсын ерөнхий прокурорт

ирүүлнэ. Ийнхүү ирүүлэхийн өмнө тэдгээрийг зөрчил гаргасан прокурорт танилцуулна. Зөрчил гаргасан прокурор уг баримт сэлтгэй танилцаад нэмэлт тайлбар гаргах, нэмэлт шалгалт явуулахыг хүсэж болно.

13. Улсын ерөнхий прокурор, сахилгын шийтгэл оногдуулах тухай санал, холбогдох баримт сэлтийг хүлээн аваад дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

1) зөрчлийн шинж байдал, зөрчил гаргасан шалтгаан болон зөрчил гаргагчийн хувийн байдлыг харгалзан Прокурорын байгууллагын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан сахилгын шийтгэлийн аль нэгийг оногдуулах;

2) нэмэлт шалгалт хийлгэх, нэмэлт баримт сэлт шаардан авах;

3) прокурорт сахилгын шийтгэл оногдуулах тухай саналыг хэрэгсэхгүй орхих. Энэ тохиолдолд санал ирүүлсэн прокурорт үндэслэл бүхий хариу өгнө.

14. Улсын ерөнхий прокурор сахилгын шийтгэл оногдуулах нь зүйтэй гэж үзвэл энэ тухай тушаал гаргана. Тушаалыг сахилгын шийтгэл хүлээсэн прокурорт танилцуулж хувийн хэрэгт нь хавсаргах бөгөөд шаардлагатай гэж үзвэл сахилгын шийтгэл хүлээлгэсэн тухай хамт олонд мэдээлнэ.

Прокурорт сахилгын шийтгэл оногдуулсан тухай хөдөлмөрийн дэвтэрт нь тэмдэглэхгүй.

15. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш гурван сар (зөрчил гаргасан прокурор өвчтэй, ээлжийн амралт, чөлөөтэй байсан, түүнчлэн зөрчил гаргасан байдлыг шалгасан хугацааг энэ хугацаанд оруулахгүй), зөрчил гаргаснаас хойш нэг жилээс илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл оногдуулж болохгүй. Сахилгын шийтгэлийг давхардуулан оногдуулахгүй.

16. Сахилгын шийтгэл оногдуулснаас хойш нэг жилийн хугацаа өнгөрсөн бөгөөд энэ хугацаанд дахин зөрчил гаргаагүй бол сахилгын шийтгэлгүйд тооцно.

Сахилгын шийтгэл хүлээсэн прокурор үүрэгт ажлаа үлгэр жишээчээр биелүүлж гаргасан зөрчилд дүгнэлт хийж чадсанаа харуулсан бөгөөд шийтгэл оногдуулснаас хойш зургаан сарын хугацаа өнгөрсөн бол Улсын ерөнхий прокурор уул шийтгэлийг сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаа дуусахаас өмнө арилгаж болно.

Албан тушаал бууруулах шийтгэлийг сахилгын шийтгэлгүйд тооцсон, сахилгын шийтгэлгүйд тооцох хугацаанаас өмнө арилгасан нь прокурорыг өмнөх албан тушаалд эгүүлэн томилох үндэслэл болохгүй.

17. Сахилгын шийтгэл хүлээсэн прокурор энэ тухай түүнд танилцуулснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар 74 | Улаанбаатар хот

ЗАРЛИГИЙН ЗААЛТЫГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

"Хүн амын хүнс, өдөр тутмын зайлшгүй хэрэгцээт барааны хангамжийг зохицуулах тухай" Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1992 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 82 дугаар зарлигийн 4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхий сайд **П. ЖАСРАЙ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр | Дугаар 75 | Улаанбаатар хот

ЗАРИМ ШҮҮГЧИЙГ АЛБАН ТУШААЛААС НЬ ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Дамдингийн Одонцэцэгийг Дорноговь аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, Лхасүрэнгийн Нанзадсүрэнг Дундговь аймгийн хэсгийн ардын шүүхийн шүүгчийн, Осоржамаагийн Эрдэнэчимэгийг нийс-

лэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр Дугаар 76 Улаанбаатар хот

ЗАРИМ ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 6-р зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн санал болгосноор Балдангийн Зэнэмэдэрийг Дундговь аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр, Пэрэнлэйн Төмөрбаатарыг Булган аймгийн давж заалдах шатны шүүхийн шүүгчээр, Төмөрийн Баясгаланг Дорноговь аймаг дахь сум дундын I шүүхийн шүүгчээр, Бадамгаравын Тогмид, Дамдингийн Одончэцэг нарыг Дорноговь аймаг дахь сум дундын II шүүхийн шүүгчээр, Лувсандашийн Гансүхийг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчээр, Намширын Нарантуяаг нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчээр тус тус томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр | Дугаар 77 | Улаанбаатар хот

ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙГ ТОМИЛОХ ТУХАЙ

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн Шүүхийн Ерөнхий зөвлөлийн санал болгосноор Балдангийн Зэнэмэдэрийг Дундговь аймгийн давж заалдах шатны шүүхийн ерөнхий шүүгчээр, Бадамгаравын Тогмидийг Дорноговь аймаг дахь сум дундын II шүүхийн ерөнхий шүүгчээр 6 жилийн хугацаагаар тус тус томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 18-ны өдөр | Дугаар 80 | Улаанбаатар хот

ДҮРЭМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Прокурорын зэрэг дэв олгох дүрмийг хавсралтын ёсоор баталсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны
80 дугаар зарлигийн хавсралт

ПРОКУРОРЫН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОХ ДҮРЭМ

1. Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу прокурор нь төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх, төрийн хууль цаазын шадар зөвлөх, хууль цаазын итгэмжит зөвлөх, хууль цаазын ахлах зөвлөх, хууль цаазын зөвлөхийн зэрэг дэвтэй байх бөгөөд Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх, төрийн хууль цаазын шадар зөвлөхийн зэрэг дэвийг Ерөнхийлөгчийн зарлигаар, бусад зэрэг дэвийг Улсын ерөнхий прокурорын тушаалаар албан тушаалын ангилал, ажилласан хугацаа, мэргэшлийн түвшинг харгалзан олгоно.

2. Прокурорт зэрэг дэв олгохдоо албан тушаалын ангиллыг дараахь байдлаар харгалзана:

Зэрэг дэв	Албан тушаал
Төрийн хууль цаазын тэргүүн зөвлөх	Улсын ерөнхий прокурор
Төрийн хууль цаазын шадар зөвлөх	Улсын ерөнхий прокурорын орлогч
Хууль цаазын итгэмжит зөвлөх	Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, аймаг, нийслэл, тээврийн прокурор
Хууль цаазын ахлах зөвлөл	Улсын ерөнхий прокурорын хяналтын прокурор, аймаг, нийслэл, тээврийн прокурорын орлогч, туслах прокурор, сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газрын ахлах прокурор
Хууль цаазын зөвлөх	Аймаг, нийслэл, тээвэр, сум, сум дундын буюу дүүргийн прокурорын газрын хяналтын прокурор

3. Прокурорт зэрэг дэв олгохдоо прокуророор ажилласан хугацааг дараахь байдлаар харгалзана:

1) хууль цаазын итгэмжит зөвлөх -5 жилээс доошгүй

2) хууль цаазын ахлах зөвлөх -3 жилээс доошгүй

3) хууль цаазын зөвлөх -1 жилээс доошгүй

Бусад байгууллагад хуулийн мэргэжлээр ажиллаж байсан хүн прокуророор томилогдвол түүний ийнхүү ажилласан хугацаа, томилогдох албан тушаал, мэргэжлийн түвшинг харгалзан тухайн зэрэг дэв олгож болно.

4. Прокурорт зэрэг дэв олгохдоо мэргэшлийн түвшингийн нь талаар мэргэжлийн зөвлөлийн гаргасан дүгнэлтийг харгалзана.

5. Зэрэг дэв олгох хугацаа болсон бөгөөд уул зэрэг дэв нь тухайн прокурорын албан тушаалд тохирч байгаа боловч мэргэшлийн түвшин хангалтгүй байвал тухайн зэрэг дэвийг олгохгүй байж болно.

6. Зэрэг дэв бүхий прокурорт жилд нэг удаа түүний албан тушаалын нэг сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгоно.

7. Улсын ерөнхий прокурор үр бүтээлтэй ажиллаж байгаа, өндөр мэргэшлийн прокурорт энэ дүрмийн 3 дугаар зүйлд заасан хугацаанаас өмнө буюу түүний албан тушаалынхаас дээгүүр зэрэг дэв олгож болно.

8. Өөрөө хүсэлт гаргасан, өөрийнх нь зөвшөөрснөөр өөр ажил, албан тушаалд томилсон буюу сонгосон, биеийн эрүүл мэндийн байдлаар үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон үндэслэлээр прокурорын үүрэгт ажлаас чөлөөлөгдсөн хүн прокуророор томилогдвол урьд олгогдсон зэрэг дэвээ хэвээр эдэлнэ.

9. Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсноор буюу сахилгын шийтгэл хүлээж ажлаас халагдсан прокурорын зэрэг дэв нь түүнийг ажлаас халсан өдрөөс эхлэн хасагдсанд тооцно.

10. Ажлаас халахаас бусад сахилгын шийтгэл хүлээсэн, түүнчлэн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд эрхэлсэн ажилдаа тэнцэхгүй тухай мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт гарсан тохиолдолд прокурорын зэрэг дэвийг бууруулж болно.

Мэргэжлийн түвшингийн хувьд тэнцэж байгаа албан тушаалын ангиллаас доогуур албан тушаалын ажилд өөрийн хүсэлтээр шилжин ажилласан прокурорын зэрэг дэвийг бууруулахгүй.

11. Энэ дүрэмд зааснаас бусад тохиолдолд прокурорын зэрэг дэвийг бууруулах буюу хасч болохгүй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 27-ны өдөр | Дугаар 81 | Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Прокурорын мэргэжлийн зөвлөлийн ажиллах журмыг хавсралтын ёсоор батлалсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1993 оны 81 дүгээр зарлигийн хавсралт

ПРОКУРОРЫН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

1. Прокурорын мэргэжлийн зөвлөл (цаашид энэ журамд "зөвлөл" гэнэ) нь Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 37 дугаар зүйлд зааснаар прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж дүгнэнэ.

2. Зөвлөл нь дарга, нарийн бичгийн дарга, 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд түүнд өндөр мэргэшилтэй, ажил, амьдралын туршлагатай прокуроруудыг оруулна.

Зөвлөлийн дарга нь Улсын ерөнхий прокурор байна. Зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдийг ерөнхий прокурор батална.

Улсын ерөнхий прокурорын түр эзгүйд түүний даалгасан зөвлөлийн гишүүн зөвлөлийн даргын үүргийг гүйцэтгэнэ.

3. Зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) Улсын ерөнхий прокурорын шийдвэрийг үндэслэн нийт прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж хүн нэг бүр дээр дүгнэлт гаргах;

2) Улсын ерөнхий прокурор шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тухайн прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж дүгнэлт гаргах.

4. Зөвлөлийн дарга нь гишүүний бүрэн эрхээс гадна дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгах бүрэлдэхүүнийг зөвлөлийн гишүүд дотроос томилох;

2) зөвлөлийн хуралдааныг товлон зарлах, бэлтгэлийг нь хангуулж удирдах;

3) шаардлагатай гэж үзвэл холбогдох мэргэжлийн хүмүүсийг үндсэн байгууллагатай нь тохиролцсон үндсэн дээр шалгалтын ажилд татан оролцуулах.

5. Зөвлөлийн гишүүн дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1) прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин шалгах;

2) зөвлөлийн хуралдаанд таслах эрхтэй оролцох;

3) үүргээ гүйцэтгэхтэй холбогдож илэрхий болсон, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн нууцыг чанд хадгалах.

6. Зөвлөл прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгаж дүгнэхдээ Прокурорын байгууллагын тухай хууль, хууль тогтоомжийн бусад акт, энэхүү журам болон Улсын ерөнхий прокурорын холбогдох тушаалыг мөрдлөг болгоно.

Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинд хийх шалгалтыг бичгээр, сонжуураар шалгах, ярилцлага хийх, тухайн прокурорын хянаж шийдвэрлэсэн хэрэг, өргөдөл, гомдол, мэдээлэл, эрхэлсэн ажлын үндсэн үзүүлэлт, холбогдох бусад бичиг баримттай танилцах, түүнчлэн прокурорын газрын удирдлага, хамт олны болон шаардлагатай гэж үзсэн бусад байгууллага, ажилтны үнэлэлтийг сонсох зэрэг аргаар явуулна. Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг шалгасан тухай Улсын ерөнхий прокурорт танилцуулна.

7. Зөвлөл өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлыг нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн ирцтэй хэлэлцэнэ.

Шалгах бүрэлдэхүүний ахлагч, эзгүйд нь түүний даалгасан гишүүн шалгалтын талаар зөвлөлийн хуралдаанд танилцуулах бөгөөд гишүүд шалгах бүрэлдэхүүнээс асуулт тавьж хариулт авах, шалгалтын дүн, бусад баримт сэлтгэй сайтар танилцсаны эцэст тухайн прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинд өгөх дүгнэлтийн талаар санал хураалт явуулна. Санал хураалтын дүнг хуралдааны тэмдэглэлд тусгана.

Хуралдааны тэмдэглэлд зөвлөлийн дарга, тэмдэглэл хөтөлсөн ажилтан гарын үсэг зурна.

8. Зөвлөлийн дүгнэлтийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар гаргана.

Дүгнэлтэд прокурор мэргэшил, ажил хэргийн чадварын хувьд ямар түвшинд байгаа, эрхэлсэн ажилдаа тэнцэх эсэх талаар тодорхой үндэслэл зааж дурдсан байна.

Дүгнэлтэд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга гарын үсэг зурж, тэмдэг дарна.

Прокурорын үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн талаар гаргасан зөвлөлийн дүгнэлт эцсийн байна.

9. Зөвлөлийн хуралдааны дэгийг Улсын ерөнхий прокурор батална.

10. Зөвлөлийн ажилд оролцсон байдлыг харгалзан гишүүдэд Улсын ерөнхий прокурорын шийдвэрээр жилд нэг удаа мөнгөн урамшуулал олгож болно.

11. Зөвлөлийн үйл ажиллагаанд шаардагдах зардлыг прокурорын байгууллагын төсөвт тусгайлан тусгана.

Зөвлөлийн бичиг хэрэг, техникийн бусад үйлчилгээг Улсын ерөнхий прокурорын газар хариуцна.

12. Зөвлөл нь Улсын ерөнхий прокурорын газрын тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудсыг хэрэглэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр | Дугаар 82 | Улаанбаатар хот

Г. АЛТАНХУЯГ, Д. БАТТӨМӨР НАРТ МОНГОЛ УЛСЫН УРЛАГИЙН ГАВЬЯАТ ЗҮТГЭЛТЭН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Ард түмний сэтгэл зүрхэнд хоногшсон нийтийн дууны олон ая туурвин монголын хөгжмийн урлагийг хөгжүүлэхэд өндөр амжилт гаргаж байгааг нь үнэлж хөгжмийн зохиолч Гаадангийн Алтанхуяг, Дашдаваагийн Баттөмөр нарт Монгол улсын урлагийн гавьяат зүтгэлтэн цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Дугаар 83 Улаанбаатар хот

А. ДОЛГОРТ МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЖҮЖИГЧИН ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Мэргэжлийн урлагийн байгууллагад үр бүтээлтэй ажиллаж монголын болон дэлхийн сонгодог урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь өндөр үнэлж Дуурь, бүжгийн улсын академик театрын гоцлол дуучин Аюурзанын Долгорт Монгол улсын гавьяат жүжигчин цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Дугаар 84 Улаанбаатар хот

УРЛАГИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРИМ ХҮМҮҮСИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Мэргэжлийн урлагийн байгууллагуудад ажиллаж уран бүтээлийн амжилт гаргаж байгааг нь үнэлж дор дурдсан хүмүүсийг Монгол улсын одон, медалиар шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР

Р: Гончигийн Бирваа Хөгжмийн зохиолч

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Жамъянжавын Намнанбаяр - Дуурь, бүжгийн улсын академик театрын гоцлол бүжигчин
2. Сүрэнгийн Отгонням - Балетын үндэсний театрын гоцлол бүжигчин
3. Цэнгийн Цэрэндорж - Монголын морин хуурын төвийн дэд ерөнхийлөгч

4.Гэндэнсүрэнгийн Магдаа - Улсын циркийн жүжигчин

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1.Цэдэвийн Баатаржав - Дуурь, бүжгийн улсын академик театрын удирдаач

2.Галтайн Балжинням - Нийслэлийн "Октябрь" дүүргийн "Од" клубын хөгжмийн багш, хөгжмийн зохиолч

3.Батын Батчулуун - Дуурь, бүжгийн улсын академик театрын гоцлол хөгжимчин

4.Самбуугийн Боорой - Ахмадын "Дайчин алдар" чуулгын гоцлол дуучин

5.Адилбишийн Дашпэлжээ - Дуурь, бүжгийн улсын академик театрын гоцлол дуучин

6.Лувсанчойдорын Мөнхцэцэг - Мөн театрын гоцлол хөгжимчин

7.Дамдингийн Иш - Мөн театрын гэрлийн техникч

8.Цэвэлмаагийн Хүрэлбаатар - Эрдэнэт хотын хүүхэлдэйн театрын дарга

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1.Далхжавын Баасанхүү - Дуурь, бүжгийн улсын академик театрын балетмейстер

2.Нямбуугийн Баяраа - Балетын үндэсний театрын бүжигчин

3.Чинзаяатын Мөнхшүр - Дуурь, бүжгийн улсын академик театрын гоцлол дуучин

4.Шагдарын Цэвэлмаа - Мөн театрын оёдлын мастер

Монгол Улсын Ерөнхийлөгч П. ОЧИРБАТ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 30-ний өдөр Дугаар 85 Улаанбаатар хот

ЛХАСРАНГИЙН ПЭРЭНЛЭЙД МОНГОЛ УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БААТАР ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Сонгино дахь Биокомбинатад олон жил үр бүтээлтэй ажиллаж үхрийн салст бүрхүүлийн вирусын гаралтай үрэвсэл, хамрын

хөндий, цагаан мөгөөрсөн хоолойн үрэвсэл, төлийн аденовирусын халдварт өвчнийг манай орны нөхцөлд анх оношлож, тэдгээрээс урьдчилан сэргийлэх болон оношлох, эмчлэх биобэлдмэлүүдийг бий болгож, мал, амьтдын галзуу, бог малын шөвөг яр зэрэг өвчнөөс сэргийлэх тарилгуудыг орчин үеийн эсийн өсгөврийн аргаар бэлтгэх үндэсний технологи боловсруулж биотехнологийн шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн мал сүргийг элдэв халдварт өвчнөөс сэргийлэх, эрүүлжүүлэх, улмаар мал аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх үйл хэрэгт гарамгай хувь нэмэр оруулсныг үнэлж Мал эмнэлгийн биобэлдмэлийг шалгах улсын нэгдсэн лабораторийн зөвлөх эмч, Монгол Улсын төрийн соёрхолт Лхасрангийн Пэрэнлэйд Монгол Улсын хөдөлмөрийн баатар цол олгож, Сүхбаатарын одон, "Алтан соёмбо" тэмдгээр шагнасугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 30-ний өдөр | Дугаар 86 | Улаанбаатар хот

ГОМБЫН ДАШНЯМД МОНГОЛ УЛСЫН МАЛЫН ГАВЬЯАТ ЭМЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Улсын мал эмнэлгийн албыг удирдан зохион байгуулах, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд олон жил үр бүтээлтэй ажиллаж мал эмнэлгийн материаллаг баазыг бэхжүүлэх, эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн ажлыг зохистой хослуулан мал, амьтдын халдварт болон паразиттах өвчинтэй тэмцэх ажлыг боловсронгуй болгож улсын хэмжээнд тархмал байсан ям, бруцеллёз, сүрьеэ, шүлхий, цэцэг, гуур, цагаан хорхой зэрэг өвчнүүдийг оношлох, урьдчилан сэргийлэх, эмчлэх иж бүрэн арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэхэд их гавьяа байгуулсныг үнэлж Хөдөө аж ахуйн үндэсний их сургуулийн багш, мал эмнэлгийн ухааны дэд доктор,

дэд профессор Гомбын Дашнямд Монгол Улсын малын гавьяат эмч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 30-ний өдөр | Дугаар 87 | Улаанбаатар хот

АГЧБАЗАРЫН ЁНДОНДОРЖИД МОНГОЛ УЛСЫН МАЛЫН ГАВЬЯАТ ЭМЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Мал эмнэлгийн албаны үйлдвэрлэл, эрдэм шинжилгээний байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, мал, амьтдын халдварт өвчнүүдийг оношлох, бог малыг иж балнад өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх арга зүйг боловсруулж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, мал эмнэлгийн мэргэжилтэн, эрдэм шинжилгээний ажилтнуудад нарийн мэргэшил эзэмшүүлэхэд их зүтгэл бүтээлтэй ажиллаж байгааг үнэлж Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн нян судлалын лабораторийн эрхлэгч, мал эмнэлгийн ухааны дэд доктор Агчбазарын Ёндондоржид Монгол Улсын малын гавьяат эмч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 30-ний өдөр | Дугаар 88 | Улаанбаатар хот

ГЭНДЭНГИЙН БАТСҮХЭД МОНГОЛ УЛСЫН ГАВЬЯАТ ЗООТЕХНИКЧ ЦОЛ ОЛГОХ ТУХАЙ

Монгол хонины үүлдэр угсааг сайжруулахын төлөө олон жил эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийж, манай орны байгаль, цаг

уурын нөхцөлд тохирсон ашиг шим ихтэй мах-ноосны чиглэлийн нарийвтар ноост "Тал нутгийн цагаан" шинэ үүлдэр бий болгосныг үнэлж хөдөө аж ахуйн ухааны дэд доктор Гэндэнгийн Батсүхэд Монгол Улсын гавьяат зоотехникч цол олгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч **П. ОЧИРБАТ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

1993 оны 9 дүгээр сарын 30-ний өдөр | Дугаар 89 | Улаанбаатар хот

МАЛ АЖ АХУЙН МЭРГЭЖИЛТЭН ЗАРИМ ХҮНИЙГ ОДОН, МЕДАЛИАР ШАГНАХ ТУХАЙ

Мал аж ахуйн үйлдвэрлэлд үр бүтээлтэй ажиллаж мал сүргийг эрүүлжүүлэх, үүлдэр угсааг сайжруулан өсгөж үржүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж дор дурдсан хүмүүсийг Монгол Улсын одон, медалиар шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР:

Галиндэвийн Сандаг - Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Хандгайт" компанийн мал зүйч

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1.Нурпатын Бадила - Баян-Өлгий аймгийн Үржил селекцийн улсын станцын мал зүйч

2.Шарын Адъяадорж - Дундговь аймгийн Дэрэн сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч, их эмч

3.Даваагийн Начин - Увс аймгийн Үржил селекцийн улсын станцын мал зүйч

4.Сэдбазарын Чогсомжав -Ховд аймгийн Үржил селек-

	цийн улсын станцын мал зүйч
5.Жамъянгийн Мягмар	- Эрдэм шинжилгээ үйлдвэрлэлийн "Шинэ эхлэл" компанийн захирал
6.Хашбатын Тумбаа	- Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
7.Дамдинрагчаагийн Цэрэндорж	- Мөн хүрээлэнгийн зөвлөх их эмч
8.Лхамсүрэнгийн Югмэд	- Биокомбинатын нярав

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1.Намдагийн Цэрэнчимэд	- Архангай аймгийн Мал эмнэлгийн газрын их эмч
2.Жапарханы Сейтмурат	- Баян-Өлгий аймгийн Бугат сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
3.Тлейханы Болат	- Мөн аймгийн Сагсай сумын малын бага эмч
4.Хызайбайн Хурманхан	- Мөн аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны салбарын малын их эмч
5.Аюушийн Сүрэнхорлоо	- Баянхонгор аймгийн Жаргалант сумын "Байдраг" хувьцаат компанийн ерөнхий мал зүйч
6.Лувсангийн Сэндрээ	- Мөн компанийн мал зүйч
7.Дамирангийн Баатаржав	- Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын дарга
8.Арьяабазарын Ваанчиг	- Мөн газрын байцаагч их эмч
9.Гэндэнгийн Намсрай	- Мөн газрын их эмч
10.Гэндэнжамцын Ойдов	- Булган аймгийн Рашаант сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
11.Доржийн Нармандах	- Мөн аймгийн Хангал сумын мал зүйч
12.Дамдинсүрэнгийн Цэдэндамбаа	- Говь-Алтай аймгийн Цогт сумын малын бага эмч
13.Сүрэнгийн Жагдал	- Мөн аймгийн Шарга сумын ерөнхий мал зүйч
14.Баярын Шарав	- Мөн аймгийн Үржил селек-

	цийн улсын станцын мал зүйч
15.Жанчивын Даваа	- Дорноговь аймгийн Далан-жаргалан сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
16.Цэвээнсодномын Жигжиджав	- Дорнод аймгийн Булган сумын мал зүйч
17.Нурманханбекийн Икранбек	- Мөн аймгийн Сүмбэр сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
18.Ланганы Хүүхэнмөнх	- Дундговь аймгийн Сайнцагаан сумын мал эмнэлгийн тасгийн их эмч
19.Лхамын Батсүх	- Мөн аймгийн Үржил селекцийн улсын станцын дарга
20.Дашдаваагийн Пэлжир	- Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын бага эмч
21.Лочингийн Даваасүрэн	- Завхан аймгийн Алдархаан сумын бага эмч
22.Жанчивын Согсоо	- Мөн аймгийн Булнай сумын малын бага эмч
23.Дэжидийн Цэрэндаш	- Мөн аймгийн Сантмаргаз сумын ерөнхий мал зүйч
24.Ёндонгийн Зоригт	- Өвөрхангай аймгийн Хужирт сумын ерөнхий мал зүйч
25.Цэдэннямын Цэдэнбалжир	- Мөн аймгийн Төгрөг сумын ерөнхий мал зүйч
26.Дашдоржийн Төмөрхуяг	- Мөн аймгийн Арвайхээр сумын үржлийн албаны эрхлэгч мал зүйч
27.Осорын Очирбат	- Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын их эмч
28.Галсанбазарын Банзрагч	- Өмнөговь аймгийн Баяндалай сумын мал зүйч
29.Лхамсүрэнгийн Шоожуу	- Мөн аймгийн Гурвантэс сумын мал зүйч
30.Гажидын Жүд	- Мөн аймгийн Ноён сумын мал зүйч
31.Сономын Хишигцогт	- Мөн аймгийн Сэрвэй сумын мал зүйч
32.Намхайн Даваажав	- Мөн аймгийн Цогт-Овоо сумын мал эмнэлгийн тасгийн

	эрхлэгч их эмч
33.Балжидын Лувсан	- Мөн аймгийн Булган сум дахь говийн бүсийн бэлчээрийн мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан байсан, өндөр настан
34.Дамдинсүрэнгийн Саарал	- Сүхбаатар аймгийн Асгат сумын "Соёмбо" компанийн ерөнхий мал зүйч
35.Монхооройн Шараа	- Мөн аймгийн Халзан сумын ерөнхий мал зүйч
36.Тарвийн Даваа	- Мөн аймгийн Баруун-Урт сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
37.Моононгийн Бишхүү	- Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын бага эмч
38.Жигжидийн Аюуш	- Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын мал зүйч
39.Дамдинбатын Бүдрагчаа	- Төв аймгийн Мал эмнэлгийн газрын их эмч
40.Хатараны Амин	- Увс аймгийн Ховд сумын Мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
41.Хайнзангийн Лхайжав	- Мөн аймгийн Хяргас сумын ерөнхий мал зүйч
42.Сүрэнхорын Батсуурь	- Мөн аймгийн Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны салбарын мал зүйч
43.Тогтохын Жаргалжав	- Мөн аймгийн Мал эмнэлэг, ариун цэврийн станцын эрхлэгч их эмч
44.Жамъянсүрэнгийн Цэрэн	- Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын мал зүйч
45.Чингисийн Тогтал	- Ховд аймгийн Ховд сумын Мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
46.Цэрэнгийн Цэндхүү	- Мөн аймгийн Чандмань сумын малын бага эмч
47.Норовын Сүхээ	- Мөн аймаг дахь Алтайн бүсийн Хөдөө аж ахуйн эр-

	дэм шинжилгээний хүрээлэнгийн секторын эрхлэгч
48.Дэмбэрэлийн Мянганцэвээн	- Мөн аймгийн Үржил селекцийн улсын станцын мал зүйч
49.Гүррагчаагийн Дорждүдэл	- Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын мал зүйч
50.Долгорын Цэгмид	- Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын мал зүйч
51.Цэдэндамбын Монхоодой	- Хэнтий аймгийн Биндэр сумын малын их эмч
52.Мэндбаярын Чулуунбат	- Шувууны аж ахуйн "Бөхөг" компанийн малын их эмч
53.Цэвэгжавын Василь	- Гахайн заводын дарга
54.Жалбуугийн Лувсан	- Биокомбинатын цехийн эрхлэгч их эмчээр ажиллаж байсан, өндөр настан
55.Довчингийн Санжаажав	- Мөн Биокомбинатын дэд дарга
56.Цэрэндоржийн Гунгаа	- Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторийн тасгийн эрхлэгч, их эмч байсан, өндөр настан
57.Рашилын Лувсанцэрэн	- Мөн лабораторийн их эмч
58.Аюурын Хөхөө	- Мөн лабораторийн захирал
59.Жамбалдоржийн Пүрэвжав	- Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн лабораторийн эрхлэгч
60.Намнангийн Цэдэв	- Мөн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
61.Цогнийн Цэндсүрэн	- Мөн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан
62.Ёндонгийн Лантуу	- Хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбооны ерөнхий зөвлөлийн мэргэжилтэн, мал зүйч
63.Норовын Баясгалан	- Хүнс, хөдөө аж ахуйн яамны мал аж ахуйн газрын дарга
64.Лувсангийн Доржсамбуу	- Улсын мал эмнэлгийн албаны ерөнхий газрын дарга
65.Лодойдамбын Цэрэнбат	- Мал эмнэлгийн хилийн хя-

налтын Буянт ухаа дахь салбарын байцаагч их эмч

66.Жамбалдоржийн Уртнасан - Улсын Их Хурлын гишүүн

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1.Доржийн Жамбал - Архангай аймгийн Төвшрүүлэх сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч

2.Бавуугийн Дашдаваа - Мөн аймгийн Эрдэнэмандал сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч

3.Даваажавын Доёддорж - Мөн аймаг дахь Өндөр уулын бүсийн мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

4.Махабалын Асхар - Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын мал зүйч

5.Сахабагийн Даукен - Мөн аймгийн Буянт сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч

6.Таханы Жаших - Мөн аймгийн Дэлүүн сумын малын бага эмч

7.Кегений Хусман - Мөн аймгийн Ногооннуур сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч

8.Азимханы Сануар - Мөн аймгийн Улаанхус сумын малын бага эмч

9.Ахметын Дамер - Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын их эмч

10.Сейлханы Дөлдөнбай - Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын дарга

11.Бадмаашинийн Цэдэнпил - Баянхонгор аймгийн Жаргалант сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч

12.Гомбожавын Ваша -Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын байцаагч их эмч

13.Бямбацэрэнгийн Дагвадорж - Мөн аймгийн Баянхонгор сумын малын их эмч

14.Юндэнгийн Энэбиш - Мөн аймгийн Мал эмнэлэгариун цэврийн станцын бага эмч

15.Дамдинжавын Чоймбол - Булган аймгийн Бугат сумын "Баян бугат" компанийн

	мал зүйч
16.Санжмятавын Жаргалсайхан	-Мөн аймгийн Гурванбулаг сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
17.Чоймболын Алтангэрэл	- Мөн аймгийн Орхон сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
18.Дамдинсүрэнгийн Баяраа	- Мөн аймгийн мөн сумын ерөнхий мал зүйч
19.Сундуйн Онол	- Мөн аймгийн Сэлэнгэ сумын ерөнхий мал зүйч
20.Санжидын Цэнд	- Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын дарга
21.Базархүүгийн Цэнд-Аюуш	- Говь-Алтай аймгийн Жаргалан сумын малын бага эмч
22.Бат-Очирын Мялхаа	- Мөн аймгийн Тайшир сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
23.Довжийн Бадарч	- Мөн аймгийн Халиун сумын мал эмнэлгийн тасгийн жолооч
24.Хоржоогийн Хартааш	- Мөн тасгийн эрхлэгч их эмч
25.Лхагважавын Гомбосүрэн	- Мөн аймгийн Хөхморьт сумын малын бага эмч
26.Ванчингийн Даваадорж	- Мөн аймгийн Үржил селекцийн улсын станцын мал зүйч
27.Зулзагын Долзодмаа	- Дорноговь аймгийн Мандах сумын малын бага эмч
28.Дагдангийн Дашзэвэг	- Мөн аймгийн Эрдэнэ сумын малын бага эмч
29.Борхүүгийн Уул-Өвгөн	- Мөн аймгийн Мал эмнэлгийн лабораторийн их эмч
30.Гончигийн Ядамсүрэн	- Дорнод аймгийн Булган сумын малын бага эмч
31.Балжиннямын Дулмаа	- Мөн аймгийн Цагаан-Овоо сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч, их эмч
32.Ядамжавын Амарсайхан	- Мөн аймгийн Үржил селекцийн улсын станцын мал зүйч
33.Хуягийн Халзан	- Мөн аймгийн мөн станцын

	мал зүйч
34.Сосорын Загдсүрэн	- Мөн станцын дарга
35.Базарын Гонжид	- Дундговь аймгийн Сайн-цагаан сумын ерөнхий мал зүйч
36.Одогийн Бархас	- Мөн аймгийн Сайхан-Овоо сумын малын бага эмч
37.Бурмаагийн Цэрэндорж	- Мөн сумын "Оргил" хувьцаат компанийн мал зүйч
38.Жигжидсүрэнгийн Чулуунтогтох	- Завхан аймгийн Баянтэс сумын малын бага эмч
39.Дамбийбалжирын Цэнд-Аюуш	-Мөн аймгийн Булнай сумын мал зүйч
40.Загдын Дашжаргал	- Мөн аймгийн Мал эмнэлгийн бактери шинжилгээний лабораторийн их эмч
41.Доржийн Баяраа	- Өвөрхангай аймгийн Баянгол сумын мал зүйч
42.Сосорын Лхагваа	- Мөн аймгийн Хужирт сумын оношлох кабинетын их эмч
43.Гунгаагийн Загдсүрэн	- Мөн аймгийн Мал эмнэлгийн бактери шинжилгээний лабораторийн шинжлэгч их эмч
44.Эрдэнэдэндэвийн Ёндонсамбуу	- Мөн аймгийн Үржил селекцийн улсын станцын дарга
45.Думаагийн Равжир	- "Монгол адуу" нийгэмлэгийн Өвөрхангай аймаг дахь салбарын дарга
46.Будын Амгалан	- Өмнөговь аймгийн Булган сумын малын бага эмч
47.Нацагийн Бийчээ	- Мөн аймаг дахь Говийн бүсийн бэлчээрийн мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн секторын эрхлэгч
48.Жамбалын Очирхуяг	- Сүхбаатар аймгийн Асгат сумын ерөнхий мал зүйч
49.Санжийн Монхоорой	- Мөн аймгийн Онгон сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
50.Чойжинцогийн Даваасүрэн	- Мөн аймгийн Уул-Баян

	сумын малын бага эмч
51.Түвдэнгийн Дашсүрэн	- Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын дарга
52.Товуугийн Ооёо	- Мөн аймгийн мөн газрын их эмч
53.Готовын Нямсамбуу	-Сэлэнгэ аймгийн Баянгол суммын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
54.Равжавын Зоригт	-Мөн аймгийн Ерөө сумын мал зүйч
55.Даржаагийн Шараа	-Мөн аймгийн Зүүнбүрэн сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
56.Раднаагийн Батсуурь	-Мөн аймгийн Орхон сумын ерөнхий мал зүйч
57.Түдэвийн Батмөнх	-Мөн аймгийн Сайхан сумын мал зүүйч
58.Банзрагчийн Налжирмаа	-Мөн аймгийн Мал эмнэлгийн Бактерии шинжилгээний лабораторийн бага эмч
59.Лувсанзэвэгийн Лувсаншарав	-Мөн аймгийн Үржил селекцийн улсын станцын мал зүйч
60.Цогтын Доржготов	-Төв аймгийнн Алтанбулаг сумын ерөнхий мал зүйч
61.Бат-Очирын Гүрбазар	-Мөн аймгийнн Аргалант сумын ерөнхий мал зүйч
62.Цэвэгдоржийн Бибиш	-Мөн аймгийнн Батсүмбэр сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
63.Пунцагийн Наранбаатар	-Мөн сумын Саалийн механикжсан фермийн зохиомол хээлтүүлгийн техникч
64.Бямбажавын Адилцэцэг	-Мөн аймгийнн Мал эмнэлгийн бактерии шинжилгээний лабораторийн бага эмч
65.Равжаагийн Мөнгөнхайч	-Мөн газрын их эмч
66.Бамбарын Бал	-Увс аймгийнн Өмнөговь сумын ерөнхий мал зүйч

67.Цэндийн Янжив	-Мөн сумын малын бага эмч
68.Чулууны Идэрээ	-Мөн аймгийн Сагил сумын ерөнхий мал зүйч
69.Лхагвын Тогоо	-Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын дарга
70.Дээмээгийн Басан	-Мөн газрын малын их эмч
71.Дамбын Цэдэв	-Мөн аймгийн Улаангом сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
72.Мятавын Ониука	- Мөн аймгийн Тэс сумын мал зүйч
73.Готовын Гүржав	- Ховд аймгийн Дуут сумын ерөнхий мал зүйч
74.Надмидын Бат-Очир	- Мөн аймгийн Эрдэнэбүрэн сумын малын бага эмчээр ажиллаж байсан, өндөр настан
75.Хойшбайн Шайздаа	- Мөн аймгийн Мал эмнэлгийн газрын ариун цэврийн станцын эрхлэгч их эмч
76.Зумбаагийн Тоодой	- Мөн аймаг дахь Хөдөө аж ахуйн коллежийн багш, мал зүйч
77.Цэндийн Басан	- Мөн аймгийн Мөнх-хайрхан сумын мал эмнэлгийн тасгийн эрхлэгч их эмч
78.Довдоннямын Элсхээ	- Мөн аймгийн Цэцэг сумын малын бага эмч
79.Пэрэнлэйн Баттөмөр	- Мөн аймгийн Мөст сумын малын бага эмч
80.Нацагийн Аюурзана	- Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл сумын малын бага эмч
81.Нанзадын Дабааням	- Мөн сумын ерөнхий мал зүйч
82.Чойжамцын Цэрэнпүрэв	- Мөн аймгийн Арбулаг сумын ерөнхий мал зүйч
83.Самбуугийн Бор	- Нийслэлийн Мал эмнэлгийн газрын малын бага эмч
84.Намралын Чоймоо	- Шувууны аж ахуйн "Бөхөг" компанийн мал зүйч

85.Жалцавын Нэрэвжид	- Биокомбинатын биобэлдмэлчин
86.Мичээгийн Очир	- Мөн Биокомбинатын цехийн эрхлэгч, малын бага эмч
87.Шаравын Самбилдондов	- Мөн Биокомбинатын ерөнхий нягтлаан бодогч
88.Гомбын Юнгэрэл	- Мөн биокомбинатын цехийн эрхлэгч их эмч
89.Төмөрчөдөрийн Бумчин	- Мал эмнэлгийн биобэлдмэлшалгах улсын нэгдсэн лабораторийнн бага эмч
90.Балдандоржийн Гүнжалам	- Мөн лабораторийн нягтлан бодогч
91.Шагдарын Чүлтэмсүрэн	- Монголынн эрдэм дэлгэрүүлэх нийгэмлэгийн референт
92.Сэтэвийн Дүгэрсүрэн	- Мал аж ахуйн эрдэм шинжилгээнийй хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
93.Содномдаржаагийн Жигжидсүрэн	- Мөн хүрээлэнгийн төслийн удирдагч
94.Доожхүүгийн Лхагвасүрэн	- Мөн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
95.Лувсаншаравын Цэрэндорж	- Мал эмнэлгийн эрдэм шинжилгээнийй хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан
96.Бузуухайн Дорж	- Мөн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан
97.Ишдоржийн Батаа	- Улсын малл эмнэлэг, ариун цэврийн төвв лабораторийн малын их эмч
98.Дүгэрийн Батсүх	- Мөн лабораторийн лаборант бага эмч
99.Жигжидийн Даидинсүрэн	- Мөн лабораторийн тасгийн эрхлэгч их эмч
100.Рагчаагийн Эрдэнээ	- Мөн лабораторийн лаборант бага эмч

Монгол Улсын Ерөнхийлөгч **П.ОЧИРБАТ**

БНМАУ
ТӨРИЙН СОЁРХОЛ ХҮРТЭЭХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

1993 оны 7 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 03 | Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН 1993 ОНЫ ТӨРИЙН СОЁРХОЛ ХҮРТЭЭХ ТУХАЙ

I. Монгол Улсын Төрийн соёрхолд 1993 онд нэр дэвшсэн бүтээлүүдээс Төрийн соёрхол хүртээх зөвлөл сонгон авч "Ардын эрх", "Засгийн газрын мэдээ" сонинд нийтэлж олон түмнээр хэлэлцүүлсний эцэст зөвлөлийн бүх гишүүдийн хурлаас гаргасан шийдвэрийг үндэс болгон дараахь бүтээлийн зохиогчдод Монгол Улсын Төрийн соёрхол хүртээсүгэй. Үүнд:

Шинжлэх ухаан, техник, технологийн салбарт:

1. "Монгол Улсад уураг тархины голомтот зарим өвчний оношлогоо, мэс заслын эмчилгээг үндэслэж хөгжүүлсэн нь" гэдэг хамтын бүтээлийн зохиогчид Анагаах Ухааны Их Сургуулийн багш, Шастины нэрэмжит клиникийн Ш эмнэлгийн уураг тархины мэс заслын салбарын зөвлөх Монгол Улсын хүний гавьяат эмч, дэд профессор Жалилын Хайрулла, мөн эмнэлгийн уураг тархины мэс заслын салбарын эрхлэгч, дэд доктор Пунцагийн Дондов, дэд доктор Бямбажавын Оюун, эмч Банзрагчийн Батчулуун, эмч Аниварын Нота, эмч Бямбын Эрдэнэ, эмч Доржийн Жавзмаа.

2. "Бог малын энтеробактериоз өвчнөөс сэргийлэх вакцин, дээрхи өвчнийг эмчлэн сэргийлэхийлдэс", "Бог малын дотрын халдварт хордлого ба брадзот өвчнөөс сэргийлэх олон цэнэт вакцин" бүтээж үйлдвэрлэлд нэвтрүүлсэн Мал эмнэлгийн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, дэд доктор Бадамын Баатар.

Соёл урлаг, утга зохиол, уран барилгын салбар

3. "Цэнхэрлэн харагдана", "Хулангийн шанд", "Ус уухын заяа" түүвэр зохиол туурвисан зохиолч Балжирын Догмид.

4. "Сүүтэй чулуу", "Эрдэнэ засгийн унага" роман, "Нас тогтох сайхан", "Тоодог шандын зүлэг" шүлэг, дууны үг туурвисан зохиолч, яруу найрагч Зундуйн Дорж.

5. "Тэнгэрийн хаяа", "Шөнийн талд адуу янцгаана" түүвэр зохиол туурвисан яруу найрагч Долгорын Нямаа.

6. "Нарны домог" бүжгэн жүжиг, "Торгууд нутгийн дуулал" бүжгийн чуулбар, "Дөрвөн тунсаг" бүжиг зэрэг бүтээл дэглэж

найруулсан Улсын ардын дуу бүжгийн чуулгын бүжиг дэглэгч Сэвжидийн Сүхбаатар.

7. "Үүлэн заяа" дуурь, IV симфони, "Ходоогийн сайхан" симфони чуулбар зэрэг бүтээл туурвисан хөгжмийн зохиолч Цогзолын Нацагдорж.

II. Монгол Улсын Төрийн соёрхолын дүрмийн 8 дугаар зүйлийг үндэслэн "Монгол Улсад уураг тархины голомтот зарим өвчний оношлогоо, мэс заслын эмчилгээг үндэслэж хөгжүүлсэн нь" гэдэг хамтын бүтээлийн үндсэн зохиогчоор хамтлагийн ахлагч Ж. Хайруллыг тооцож соёрхолын шагналын 40 хувийг, хамтлагийн бусад гишүүдийг хамтран зохиогчоор тооцож шагналын үлдсэн мөнгийг тэнцүү хэмжээгээр хуваж олгосугай.

Дарга Ж.БАТСУУРЬ

Нарийн бичгийн дарга М.ТӨМӨРЖАВ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ЗАХИРАМЖ

1993 оны 8 дугаар сарын 14-ны өдөр | Дугаар 30 | Улаанбаатар хот

АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛЖ АЖИЛЛУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 6 дахь заалтыг үндэслэн шийдвэрлэх нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд тахир дутуу иргэдийн талаар баримтлах бодлого, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний үндсэн чиглэлийг боловсруулах ажлын түр хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, 1993 оны 8 дугаар сарын 16-наас эхлэн ажиллуулсугай.

Ажлын хэсгийн дарга - Ж. Баасандаш-Ерөнхийлөгчийн эдийн засгийн бодлогын зөвлөхийн туслах

Ажлын хэсгийн зохион байгуулагч - Б. Шүхэрт-Монголын хараагүй, дүлий иргэдийн холбооны дарга

Гишүүд:
- Д. Алгаа-Монголын тахир дутуу иргэдийн холбооны дарга
- Ц. Ганболд-Мөн холбооны тэргүүлэгч гишүүн
- Д. Баатарчулуун-Мөн холбооны тэргүүлэгч гишүүн
- П. Чойжил-Монголын хараагүй, дүлий иргэдийн нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн
- Т. Чойжил-Мөн нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн
- Г. Эрдэнэбилэг-Мөн нийгэмлэгийн хариуцлагатай нарийн бичгийн дарга
- П. Туул-Монголын хараагүйчүүдийн нийгэмлэгийн дарга
- С. Радна-Мөн нийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн, хараагүй хүмүүсийн хөдөлмөр сургалтын

төвийн дарга
- Д. Дашзэвэг-Мөнхийгэмлэгийн тэргүүлэгч гишүүн
- Ж. Батнов-Мөнхийгэмлэгийн хотын салбарын дарга
- Д. Адилбиш-МҮЭЖ-ны мэдээлэл арга зүйн танхимын мэдээллийн арга зүйч
- Дамдин-Хүн амын бодлого, хөдөлмөрийн яамны нийгэм хангамжийн газрын түшмэл
- Туул-МУҮИС-ийн багш

2. Ажлын хэсгийн явцад хяналт тавьж, түүнтэй холбогдсон асуудлыг шуурхай зохион байгуулж ажиллахыг Ерөнхийлөгчийн эдийн засгийн бодлогын зөвлөх н. Я. Жаргалсайханд үүрэг болгосугай.

Тамгын газрын дарга М.ЭНХСАЙХАН

ИРГЭНИЙ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ХУУЛИЙН ТУХАЙ

Монгол Улсын Их Хурал (УИХ)-ын 1993 оны хаврын (3-р) чуулганаар (1993 оны 7-р сард) Монгол улсын иргэний эрүүл мэндийн даатгал (ЭМД)-ын хууль батлагдаж уг хуулийн 8-р зүйлд заасан даатгалын хураамж төлөх, 12-р зүйлд заасан эмчилгээний зардлын төлбөр хийх тухай зааалтуудаас бусад нь 1993 оны 8-р сарын 1-нээс мөрдөгдөж эхлэв.

Зах зээлийн орнуудад эрүүл мэндийн даатгалыг албан журмын (заавал даатгуулах) үндсэн ба нэмэгдэл, сайн дурын ба холимог хэлбэрээр зохион байгуулах даатгалын улсын болон хувийн байгууллага, нийгэмлэг хариуцан гүйцэтгэдэг систем тогтжээ. Гэхдээ улс орон бүрт өөр байна. Ж нь: АНУ-д эрүүл мэндийн албан журмын (заавал) даатгал гэж байдаггүй, ЭМД-ыг сайн дурын үндсэн дээр дагнан хэрэгжүүлж байхад Англид хүн бүхэн эмнэлгийн төлбөргүй тусламж авдаг улсын албатай, Францад эрүүл мэндийн бүх нийтийг хамарсан даатгал байдаг байна. Албан журмын (заавал даатгуулах) даатгалд гол төлөв улсын ба хувийн, хувь нийлүүлсэн байгууллага газар, тэдгээрийн ажиллагсад хамрагдах бөгөөд сайн дурын даатгалыг ямар ч байгууллага, иргэд өөрсдөө (гэрээний үндсэн дээр) даатгалын газар, эмнэлэг, эмчтэй хийж болдог байна. Гэхдээ зах зээлийн орнуудад эрүүл мэндийн даатгал нь гол төлөв байгууллага ба хувийн даатгалын хосолсон хэлбэрээр зохион байгуулагдаж, төрийн зохицуулалт (хяналт)-ын дагуу (АНУ-аас бусад) улсаас ихээхэн хэмжээний дэмжлэг үзүүлдэг байна.

Эрүүл мэндийн даатгалыг сайн дурын хэлбэрээр дагнан хэрэгжүүлдэг орон одоо дэлхийд ганцхан байгаа нь АНУ юм. Энэ тогтолцоо нь хүн бүр эрүүл мэндийнхээ төлөө их санаа тавьдаг, чөлөөт өрсөлдөөнөөр эмнэлгийн тусламжийн чанар гойд сайжирдаг зэрэг эерэг үр дүнтэй боловч эмнэлгийн тусламжийн үнэ байнга өсөх хандлагатай, хүн амын тодорхой хэсэг даатгалд огт хамрагдаагүй (тийм боломжгүй) учир хувь заяаныхаа эрхээр л яваа зэрэг сул талтай тул ихээхэн шүүмжлэл хүлээж, Клин тоны шинэ засаг уг асуудлыг дотооддоо шинэчлэл хийх нэг гол чиглэл гэж үзэж байна. Канад улс АНУ-ынхтай адил эрүүл мэндийн сайн дурын даатгалыг дагнаж байснаа 1957 оноос өөрчилж, бүх нийтийн албан даатгалд шилжсэн байна.

Эрүүл мэндийн албан журмын (заавал даатгуулах) даатгалыг анх Германд Отто Бисмарк (1815-1898) 1883 онд үйлдвэрийн ажилчдын эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээ болгон нэвтрүүлжээ.

Даатгалын энэ хэлбэр одоо хүн амын бага, дунд орлоготой хэсгийг хамарсан хэлбэрээр дэлхийн ихэнх оронд хэрэглэгдэж буй боловч, дагнан хэрэглэж буй орон алга байна. Харин холимог хэлбэр нэлээд оронд дэлгэрчээ. Үүний давуу тал нь хүн амын дийлэнх хэсэг буюу бага, дунд орлоготой хүмүүс албан журмын даатгалд, үлдэх хэсэг (чинээлэг) нь сайн дурын даатгалд хамрагдаг бөгөөд эрүүл мэндийн даатгал нэвтэрсэн орон энэ зарчмыг баримталж байна. Монгол Улс ч энэ хувилбарыг сонгон авсан болно.

Зах зээлийн эдийн засгийн үед хүний хамгийн эмзэг хэрэгцээ-эрүүл мэндийг байнгын ашиг орлого олох эх үүсвэр, өрсөлдөөн болгон хувиргах хандлага ямагт давамгайлж байдаг тул төрийн зохицуулалт зайлшгүй шаардагддаг бөгөөд эрүүл мэндийн даатгалыг урт удаан хугацаанд олон хэлбэрээр тодорхой үе шат, дэс дараалалтай хэрэгжүүлдэг ажээ. Жнь: БНСУ, Япон зэрэг орнуудад зөвхөн ажиллагсдыг эрүүл мэндийн заавал даатгуулах даатгалд хамруулах асуудлыг 20-27 жилд, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, өндөр настан, оюутан, хугацаат цэргийн албан хаагч нарыг хамруулах ажлыг 10-12 жилд багтаан хэрэгжүүлжээ. Хятадад хөдөө аж ахуйд ажиллагсад, хувиараа жижиг аж ахуй эрхлэгчдийг одоо ч хамруулаагүй ба энэ давхаргынханд эмнэлгийн төлбөртэй үйлчилгээ үзүүлж байна. Энэ эмзэг асуудлыг бид Иргэний эрүүл мэндийн даатгалын хуулиар өөрмөц байдлаар шийдэв.

Энэхүү шинэ хуулиар бид заавал даатгуулаж даатгалд хамрагдах хүмүүсийг 9 бүлгээр (хуулийн гуравдугаар бүлгийн 7 дугаар зүйлийн 1-д), сайн дураар даатгуулах хүмүүсийг 3 бүлгээр (мөн зүйлийн 2-т) тодорхойлж үндсэндээ ЭМД-д хүн ам бараг 100 хувь хамрагдах боломжийг нээж өгсөн болно. Даатгалд хамрагсад мөнгөн хураамж төлнө:

Даатгалын хураамжийн хэлбэр, хэмжээ харилцан адилгүй байдаг байна. Практикаас үзэхэд:

а) даатгуулагч бүрээс ижил хэмжээгээр,

б) даатгуулагчийн цалингаас тогтмол хувиар,

в) даатгуулагчийн биеийн эрүүл мэндийн байдал, өрхийн ам бүл, ажлын нөхцөлөөс шалтгаалсан ялгавартай хувиар;

г) хураамжийг даатгуулагчаас дангаар нь,

д) хураамжийг даатгуулагч болон ажил олгогчоос нь хувь ногдуулан авах гэх мэт олон хувилбартай байдаг байна.

Эрүүл мэндийн албан журмын даатгал хэрэгжүүлж буй бүх оронд даатгуулагчийн цалингийн тогтмол хувиар даатгал ногдуулаж, ажиллагч, ажил олгогч хоёр хувь хувааж төлөх хэлбэр хэрэглэж байна.

Даатгуулагчийн биеийн эрүүл мэндийн байдалтай холбож хураамжийн хэмжээг тогтоох хэлбэр нь сайн дурын, хувийн даатгалд голдуу хэрэглэгддэг бөгөөд энэ хэлбэр АНУ-д өндөр хөгжсөн, хэрэгжүүлэхийн тулд техникийн өндөр түвшин шаарддаг, өртөг ихтэй хэлбэр юм.

Бид дээрх хувилбаруудаас "б", "д" хувилбарыг сонгон авч ажил олгогч нь даатгалын нийт хураамжийн 50 хувийг заавал төлөх, хөдөлмөрийн гэрээгээр тохиролцсон нөхцөлд 100 хувь хүртэл төлж болох боломжийг нээлттэй үлдээсэн. Энэ нь өндөр мэргэжлийн ур чадвартай хүмүүсийг байгууллага, аж ахуйн нэгж, нийгмийн хамгаалалтын арга хэмжээгээрээ татах нэг нөхцөл гэж үзэж байна. Мөн хуульд аж ахуйн нэгж, байгууллага ажилтныхаа төлөө төлөх даатгалын хураамжийг албан татвар ногдуулах орлогоос нь хасч тооцохоор заасан нь мөн энэхүү урамшилтай холбоотой болно.

Зах зээл хөгжсөн орнуудад даатгалын хураамжийн хэмжээ нь улс орны эдийн засгийн байдал, эмнэлгийн тусламжийн чанар, хүн амын төлбөрийн чадавхи зэргээс шалтгаалан 30 хувь хүртэл (ихэнх оронд 8-10%) байдаг байна.

Дээрх хуулийн анхны төсөлд даатгалын хураамжийг 8 хувиар тооцож оруулсныг УИХ-ын чуулган 6 хувиас хэтрүүлэхгүйгээр Засгийн газар жил бүр тогтоож байхаар хуульчилсан. Гэхдээ урьдчилан тооцооноос үзэхэд эхний үед 5 хувиас доош бууруулж болохгүй болов уу?

Хуулийн төслийг хэлэлцүүлэх явцад "даатгал нэртэй албан татвар буй боллоо" гэж олон гишүүд тал бүрээс нь шүүмжлэн ярилцсан. Бидний ойлголтоор даатгалын хураамж бол Монгол улсын татварын ерөнхий хуульд тодорхойлсон албан татвар, төлбөр, хураамжаас үлэмж ялгаатай юм. Татварын ерөнхий хуульд тодорхойлсноор: албан татвар бол хууль тогтоомжийн дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллага орлого, эд хөрөнгө бараа, ажил, үйлчилгээнд тодорхой хугацаанд тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж хариу төлбөргүйгээр улс орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгө, хураамж бол хууль тогтоомжийн дагуу төрийн зохих байгууллагаас иргэд аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлсний төлөө төднээс тухай бүр авч байгаа мөнгөн хөрөнгө, төлбөр бол төрийн өмчийг ашиглуулсны төлөө иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас авч байгаа мөнгөн хөрөнгө юм. Гэхдээ эдгээрийн аль аль нь улс, орон нутгийн төсөв буюу төрийн тусгай зориулалтын санд төвлөрүүлж байгаа хөрөнгө билээ.

Даатгалын хураамж бол улсын төвлөрсөн болон орон нутгийн төсөв, тусгай санд орохгүй, зориулалтынхаа санд хуримтлагдаж эргээд түүндээ зарцуулагдана. Үүгээрээ магадгүй төсөв, төрийн тусгай сан дампуурсан байхад, даатгалын хураамж дампуурахгүй баталгаатай байх болно. Ер нь даатгал бол алив болзошгүй осол аюул, гэнэтийн явдлаас сэргийлэн хамгаалаах буюу түүнээс учирсан хохирлыг тодорхой хэмжээгээр нөхөөн төлөх зорилго бүхий арга хэмжээг мөнгөн хөрөнгөөр баталгаажуулж байгаа үйл ажиллагаа шүү дээ.

Бид онгоцонд суухдаа амь даатгалын хураамж төлөх буюу эд хөрөнгийн даатгалд өгсөн мөнгөө "би амьд баайна", "миний юм шатсангүй" гээд буцаагаад авдаггүй, харин аюулд осол тохиолдвол даатгалын гэрээнд тохиролцсон хэмжээгээр нөхөөн төлүүлдэг билээ.

ЭМД зарчим, агуулгын хувьд түүнтэй яг адилл. Өвчин бол хэлж ирдэггүй, хийсч ирдэг. Хэн ч хэзээ ч өвчилж болно. Тэр үедээ өөрийн оруулсан болон өрөөлийн төлсөн даатгалын хөрөнгийг баталгаатай хэрэглээд, өөрөө өвчлөөгүй үедээ бусдын эрүүл мэндийн төлөө хураамжаа зориулах хүнлэг энэрэнгүй үйл явдалд тулгуурлана.

ЭМД хүмүүст ямар ашигтайг дараах жижиг тооцооноос үзэж болно. Засгийн газраас даатгалын хураамжийн хэмжээг 6 хувиар тогтоожээ гэж үзвэл 5000 төгрөгийн цалинтай ажилчин ЭМД-д сард (3%)=150 төгрөг жилд 150х12=1800 төгрөгг хураалгана. Уг ажилчин тухайн жилд 2 удаа эмнэлгийн түргэн тусламж дуудаж, 5 удаа эмнэлэгт үзүүлж, 1 удаа 12 хоног эмнэлэгт хэвтжээ гэж үзвэл:

а) түргэн тусламжийн дуудлага (хотын дүүрэгт 50 км-т үйлчилнэ. 1 км-ийн үнэ 22 төгрөг гэвэл) 1100х2=2200 төг;

б) амбулаторид 5 удаа үзүүлэхэд (улсын эмнэлгийн 1 үзлэгийн дундаж өртөг 15 төг) 5х15=75 төг. Бүгд 2200+75=22275.

Гэхдээ а, б-д дурдсан энэхүү зардлыг Монголл улсын иргэний ЭМД-ын хуульд заасан ёсоор таны төлсөн даатгалын хураамжаас нөхөн төлөхгүй цөмийг нутаг дэвсгэр, байгууллагын харьяаллын дагуу улсын төв, төвлөрсөн буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ. (Хуулийн хоёрдугаар бүлгийн 1, 2-р заалт);

в) Та эмнэлэгт 12 хоног хэвтэхэд одоогийн хаанаар улсын эмнэлгийн нэг ор хоногийн дундаж өртөг 764 төгрөөг 12х76=9168 төг болно. Энэ зардлыг ЭМД-ын хуулийн гуравдугаар бүлгийн 4-р зүйлийн 1-д заасны дагуу даатгалын сангаас эмнэлэгт нөхөн төлнө. Гэхдээ энэ зардлаас Таны төлсөн хураамж 1800 төгрөг (19,6%), таныг ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага 18000 төгрөг (19,6%)-ийг төлнө. (Даатгалын хуулийн дагуу тус бүр даатгалын

хураамжийн 50 хувийг төлсөн шүү дээ) Энэ нь Таны 12 хоногт эмнэлэгт хэвтэж эмчлүүлэх зардлын 39,2% (19,1+ 19,1) болох бөгөөд үлдсэн 60,8% буюу 5668 төгрөгийг даатгалын байгууллага даатгалын сангаас таныг эмчлүүлсэн эмнэлэгт нөхөн төлнө. Эдгээрийг нэгтгэж үзвэл: Таны нэг жилийн эмчилгээний бүх зардал (2275+9168=11443 төг) 100 хувь гэвэл түүний 19,8% буюу 2275 төгрөгийг улсын төвлөрсөн буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлж үлдэх 80,2% буюу 9168 төгрөгийг даатгалын сангаас нөхөн төлнө. Даатгалын сангаас санхүүжүүлэх энэ хөрөнгийн 19,6%-ийг Таны төлсөн хураамж, 19,6%-ийг Таны ажилладаг аж ахуйн нэгж буюу байгууллагын хураамж нөхөж, үлдэх 60,8%-ийг даатгалын сан нөхөн төлөх болно. Үүний дээр Та 5 удаа эмнэлэгт үзүүлэхдээ (дээр дурдсан жишээгээр) өөрийн хэсгийн (өрхийн) эмчийн жороор эмийн сангаас зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтанд заасан 1000 төгрөгийн эм авчээ гэж үзэхэд ЭМД-ын хуулийн гуравдугаар бүлгийн 12 дугаар зүйлийн 5-д заасны дагуу уул эмийн үнийн 50% буюу 500 төгрөгөө даатгалын сангаас эргүүлэн авах болно. (Эсвэл Та уг эмийг 50 хувийн хөнгөлөлттэй үнээр авна). Ингэснээр ЭМД-д даатгуулах нь даатгуулахгүйгээр эмчилгээний зардлыг шууд төлснөөс үлэмж ашигтай болох нь тодорхой байна.

Монгол улсын иргэний ЭМД-ын хуульд: даатгалын хураамжийн хувь хэмжээ, бүрдүүлэх журмыг 3-р бүлгийн 8-р зүйлд, даатгуулагчийн эмчилгээний зардлын төлборийн төлөх журмыг мөн бүлгийн 12-р зүйлд, даатгалын сангаас гарсан зардлыг нөхөн төлүүлэх журмыг 13-р зүйлд тодорхойлж заасан. Харин даатгуулагчийг урамшуулах эрүүл мэнддээ тавих анхаарал хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор бусад улсын ЭМД-ын хуульд байдаггүй нэгэн шинэ заалт (14-р зүйлд даатгалын хөнгөлөлт) оруулсан бөгөөд мөн хуулийн 3-р бүлгийн 9-р зүйлийн 3-д: даатгалын сангийн үлдэгдлийг дараа жилийн даатгалын хураамжийн хувь хэмжээг тогтооход харгалзаж байхаар тусгасан болно.

Даатгалын байгууллага.

а) даатгуулагчийн эмнэлгийн тусламжийн бүх зардлыг нөхөн төлөх;

б) эмнэлгийн нэр заасан тусламжийн зардлыг л нөхөн төлөх;

в) тодорхой хязгаарын дотор (жилдээ 10000 ам. доллар хүртэлгэх мэт) нөхөн төлөх гэсэн хувилбаруудтай байдаг байна.

Манай орны ЭМД-ын хуульд эдгээр хувилбарын "а", "б" хувилбарыг сонгон авч тусгасан болно. Гэхдээ хуульд зааснаар (III бүлэг, 4-р зүйлийн 1) даатгуулагчийн стацонарын эмчилгээ үйлчилгээний бүх зардлыг даатгагч нөхөн төлөх боловч тухайн жилийн төлбөртэй эмчилгээний 100000 хүртэл төгрөгийн зардлыг

нөхөн төлөх бөгөөд (хуулийн III бүлэг 12-р зүйлийн 8) түүнээс хэтэрсэн нөхцөлд хуулийн гуравдугаар бүлгийн 7-р зүйлийн 3-9-д заасан эмзэг бүлгийн зардлыг төр хариуцаж 1, 2-рт заасан хөдөлмөр эрхэлж байгаа хүмүүс өөрсдөө шууд нэмж төлөх буюу сайн дурын даатгалд давхар даатгуулж шийдвэрлэнэ. Сайн дураар даатгуулагч нь даатгалынхаа хураамжийн хувь хэмжээг шууд тохиролцох (гэрээгээр) учир энэ зүйлд хамаарахгүй болно. Харин даатгалгүй иргэдэд аль ч эмнэлгийн байгууллага үзүүлэх шаардлагатай тусламжийг шууд үзүүлээд дараа нь төлбөрийн тооцоо хийж байхаар хуульд тусгасан болно. (III бүлэг 12-р зүйлийн 9, 10-р заалт)

Хуулийн энэхүү бүлэгт тусгасан 100000 төгрөг хэмээх хязгаарыг хууль боловсруулах ажлын хэсэг өөрсдийн санаа зоргоор тавиагүй дараах зүйлд үндэслэснийг товч дурьдахад:

а) төгрөгийн одоогийн ханшаар (1992 он) улсын эмнэлгийн нэг ор хоногийн зардал 764,1 төгрөг байгаагаас үндэслэн тооцоход даатгуулагч эмнэлэгт 131 хоног буюу 4 сар гаруй хугацаанд хэвтэж эмчлүүлэх боломжтой (100000:764=131);

б) одоогийн мөрдөж буй хуулиар эмчилгээний хугацаа 3 сараас хэтэрсэн нөхцөлд ул хүнийг тахир дутуугийн аль нэг группт оруулах ёстой;

в) манай оронд одоогоор хийгдэж байгаа эмчилгээний төрлүүдийн дотроос хамгийн үнэтэй нь зүрх судасны мэс засал юм. 100000 төгрөг бол манай оронд зүрх судасны мэс заслын аль ч төрлийн эмчилгээг нэг удаа хийлгэх бүрэн хүрэлцэхүйц хөрөнгө гэдгийг үндэслэсэн болно.

Үйлчилгээний төлбөрийг тооцохдоо зах зээлийн орнуудад:

а) тогтоосон үнийн тарифаар;

б) үйлчилж буй хүний тоогоор;

в) нэг өдрөөр тогтоосон тарифаар; ажиглагдаж байна.

Манай орны ЭМД-ын хуульд эдгээр хувилбаруудаас "а", "б", "в" хувилбарыг сонгон авч эмчилгээний зардлын төлбөрийг даатгалын үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон нэг ор хоногийн ялгавартай тарифаар тооцох, (хуулийн III бүлэг 12-р зүйл 2) даатгагч, даатгуулагчийн хүлээх тодорхой үүргийг даатгалын гэрээ (хуулийн 10-р зүйл)-гээр зохицуулахаар хуульд тусгасан болно. Гэхдээ эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн бол эмчилгээ үйлчилгээний бүх зардлыг (100000 төгрөг дотор), амбулатори-поликлиникээр үйлчлүүлсэн бол өрхийн эмчийн жороор эмийн сангаас авсан зайлшгүй шаардлагатай эмийн 50 хувийн үнийг даатгалын сангаас нөхөн төлж байх болно.

ЭМД-ыг эрхлэн хэрэгжүүлэх байгууллагын хувьд: зах зээлийн орнуудад:

а) (аль нэг (голдуу эрүүл мэндийн буюу нийгэм хангамжийн асуудал хариуцсан) яамны мэдэлд тусгай албаны хэлбэрээр,

б) улсын нийгмийн даатгалын бүрэлдэхүүнд;

в) яамны харьяалалгүй, Засгийн газрын шууд харьяа байгууллагын хэлбэрээр;

г) Засгийн газрын бус байгууллагын хэлбэрээр;

д) Засгийн газрын бус хэд хэдэн байгууллагын хамтын удирдлагад;

е) нийгэмлэг, хувийн компанийн хэлбэрээр гэх мэт олон хувилбарууд байдаг байна.

Ер нь ЭМД нь нийгмийн даатгалын нэг бүрэлдэхүүн хэсэг байдаг боловч ихэнх улс оронд ЭМД-ыг бие даасан байгууллага эрхлэн явуулж бодолгын хувьд нийгмийн даатгалын тогтолцоонд хамруулан үздэг байна.

Монгол улсын иргэний ЭМД-ын хуулийн 3-р бүлгийн 6-р зүйлд "даатгалыг Засгийн газраас эрх олгосон даатгалын байгууллага (цаашид даатгагч гэх) эрхлэн явуулахаар" тогтоож мөн хуулийн 5-р зүйлд: даатгалын орон тооны бус үндэсний зөвлөлийг Засгийн газрын дэргэд ажиллуулахаар заасан болно. Даатгалын үндэсний зөвлөл нь:

1. Даатгагч, түүний эрх ашгийг төлөөлсөн байгууллага
2. Даатгуулагч, түүний эрх эшгийг төлөөлсөн байгууллага.
3. Эрүүл мэндийн (эмнэлгийн) байгууллага.
4. Төрийн захиргааны төв байгууллага (төсөв, санхүү, хууль, хөдөлмөр, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн)-уудаас бүрэлдэж даатгалын сангийн ашиглалт, зарцуулалтад хяналт тавих, даатгалтай холбогдсон асуудлаар санал дүгнэлт гаргаж холбогдох байгууллагад шийдвэрлүүлэхээр оруулах, зөвлөмж гаргах, даатгалын гэрээний болон гэрчилгээний загварыг батлах эрх эдэлнэ.

Бидний тоймлож байгаагаар бол ЭМД нэвтрүүлэх эхэн үед уг асуудлыг "Монгол даатгал" компанид хариуцуулж нэлээд зүгширсэн хойно нь нийгмийн даатгалын нэгдсэн тогтолцоонд нэгтгэх эсэх тухай асуудлыг авч үзэх нь зүйтэй юм. УИХ-ын батлсан төлөвлөгөөгөөр ойрын ирээдүйд нийгмийн даатгалын ерөнхий хууль үйлдвэрлэлийн ослын даатгалын хууль, ажилгүйдлийн даатгалын хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн хуулиуд боловсрогдож батлагдах болно.

Монгол улсын иргэний эрүүл мэндийн даатгалын хууль 4 бүлэг 16 зүйлтэй болно.

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл 1-2-р зүйл. Хуулийн зорилт. ЭМД-ын тухай хууль тогтоомжийн үйлчлэх хүрээг заасан

заалтуудад тусгайлан тайлбарлалтгүй ойлгогдохгүй гэдэгт итгэж байна.

Хоёрдугаар бүлэг. Эмнэлгийн төлбөргүй тусламж, 3-р зүйл.

Эмнэлгийн төлбөргүй тусламжаар хамрах үйлчилгээний төрөл хэлбэр, түүнийг санхүүжүүлэх үндсэн зарчмыг зааж, гарч болох зөрчлийг хэрхэн зохицуулах харилцааны механизмын чиглэлийг тодорхойлсон юм. Энд нэгэн зүйлийг тайлбарлахадд:

Эмнэлгийн төлбөргүй тусламжийг зөвхөн улсын эмнэлгийн байгууллага үзүүлэх үү?, хувийн эмнэлгүүд ямарр байдлаар оролцох вэ? гэсэн асуудал бий. Үүнийг хуулийн төслийг хэлэлцэх явцад, УИХ-ын олон гишүүд хөндөж тал бүрээс нь ярилцсан (хувийн эмнэлэг бол БНМАУ-ын аж ахуйн нэгжийн хуулиар хуулийн этгээд учир байгууллагын бүх эрхийг эдэлнэ, хувийн эмнэлгийг төлбөргүй тусламжид оруулах нь үйлчилгээний хүрээг өргөтгөнө. Ирээдүйд сумдад хувийн эмнэлэг ббайгуулагдахыг үгүйсгэхгүй. Хувийн эмнэлэг төлбөргүй тусламж үзүүлэхийг хязгаарлах нь өмчийн олон хэлбэрийг зөвшөөрсөн. Үндсэн хуулийн заалтыг зөрчиж байна гэх мэт). Энэ мэт олон асуудлыг тал бүрээс нь тусгаж үзээд хуулийн хоёрдугаар бүлгийн 2-р заалтад "энэ зүйлийн нэг дэх хэсэгт заасан төлбөргүй тусламжийг улсын эмнэлэг хариуцаж гарсан зардлыг улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ" хэмээн заасан болой. Энд "хариуцаж" гэдэг үгийг өргөн утгаар ойлгохыг зөвлөе. "Хариуцлага" гэдэг "гүйцэтгэнэ", "хэрэгжүүлнэ" гэдгээс өргөн утгатай бөгөөд үйлс амьдралд улсын эмнэлгийн байгууллага эмнэлгийн тусламжийн тодорхой төрөл, хэлбэрийг гэрээ, хэлэлцээрийн үндсэн дээр хувийн эмнэлгийн байгууллагаар гүйцэтгүүлж болно. Гэхдээ эцсийн хариуцлагыг Улсын эмнэлгийн байгууллагад хүлээнэ. Үүнийхээ төлөө улсын төсвөөс санхүүжүүлнэ гэсэн утга санааг агуулж буй болно. Үүний хамт хувийн эмнэлэгт ажиллаж байгаа аль ч мэргэжлийн эмч, ажилчид өөрийн санаачилгаар иргэдэд төлбөргүй тусламж үзүүлэх хүнлэг энэрэнгүй сэтгэлээ хэрэгжүүлэхэд нь ямарч хориг саад тавиагүй бөгөөд "Монгол Улсын Үндсэн хуулийн (1992 он) 17-р зүйлд зааснаар "хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг "бөгөөдҙ" Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх" нь Монгол улсын иргэний үндсэн үүрэг шүү дээ.

Гуравдугаар бүлэг. Эрүүл мэндийн даатгал. 4-14-р зүйл.

Монгол оронд ЭМД-ыг ямар хүрээнд ойлгох, юунд зориулагдах, хэнийг хамрах, даатгалын санг яаж бүрдүүлэх, хэрхэн зарцуулах, тооцох бүх арга ажиллагааны гол зарчим, чиглэл, үзэл баримт-

лалыг тодорхойлон заасан уг хуулийн үндсэн хэсэг болно. Энд ганц нэгхэн зүйлийг тайлбарлахад:

а) даатгалын сангаас төлөх нөхөн төлбөр даатгуулагчийн эмнэлэгт (стационарт) хэвтэж эмчлүүлэхэд гарсан шууд зардал болон үүнтэй холбогдсон даатгалын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулагдана. (хуулийн III бүлэг, 9-р зүйлийн 2). "Хэвтэж эмчлүүлэх" гэсэн үгийн ард "стационарт" хэмээх тодотгол нь анагаах ухааны нийтлэг ойлголтоор "стационар гэдэгт өвчтөнийг оношлох, эмчлэх, сувилах нөхөн сэргээх зорилттой ор бүхий эмчлэх сэргийлэх байгууллагын ойлгодог "өргөн утгыг хамааруулж заасан нь болой. Энэ утгаар уг ойлголтод: өдрийн гэрийн стационар эмнэлэгт хэвтүүлэх, эмнэлгийн зайлшгүй шаардлагаар сувилалд эмчлүүлснийг багтааж ойлгоно;

б) хуулийн энэ бүлгийн 10, 11-р зүйлд заагдсан даатгалын гэрээ, гэрчилгээ бол уг хуулийн амьдрах практикт хэрэгжихийн гол баталгаа юм. Хэвлэлийн материал болон газар дээр нь очиж судалсан зарим хүмүүсийн мэдээллээс үзэхэд АНУ мэтийн зарим орнуудад гудамжны гэнэтийн ослоор нас барсан хүний цогцосыг цагдаа нар үзэхдээ, эхлээд халаасанд нь даатгалын гэрчилгээ байгаа эсэхийг үздэг. Хэрэв уг хүн даатгалын гэрчилгээтэй бол асуудлыг хууль зүйн дагуу тавьж шийдвэрлүүлдэг, гэрчилгээгүй бол "үзчихээд орхиод явчихдаг" гэнэлээ. Манай оронд ийм болчихно гэж итгэхэд бэрх ч гэсэн, ийм болчихгүй гэх баталгаа бас алга. Энэ ч учраас ЭМД-ын хуулийн энэ бүлгийн 11-р зүйлийн 3-т" даатгалын гэрчилгээ нь даатгалын гэрээнд заасны дагуу хураамж төлсөн тэмдэглэлийг тухай бүр хийлгэсэн тохиолдолд хүчинтэйд тооцогдоно" хэмээн заасныг иргэдэд сайтар ойлгуулах нь чухал. Нөгөө талаар, даатгалын гэрчилгээ нь ЭМД-д хамрагдсан иргэн тус улсын дэвсгэр нутгийн аль ч өнцөг буланд эмнэлгийн тусламжийг аль ч эмнэлгийн байгууллагаас авах бүрэн эрхийг хангах цорын ганц баримт болно.

Дөрөвдүгээр бүлэг. Бусад зүйл. 15-16-р зүйл.

Монгол улсын иргэний эрүүл мэндийн даатгалын хууль зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг хууль хүчин төгөлдөр болох хугацааг тодорхойлсон нь хэн бүхэнд ойлгомжтой. Гэхдээ хуулийн энэ бүлэгт заасан хариуцлагын асуудал нь Монгол улсын их хурлаар батлагдсан захиргааны хариуцлагын тухай хууль, эрүү, иргэний хуулиудын холбогдох заалтуудаар мөрдөгдөнө гэдгийг Та өөрөө ухаандаа болгоон шингээх бизээ!

Улсын Их хурлаар "Монгол улсын иргэний эрүүл мэндийн даатгалын хууль" батлагдсантай холбогдуулж 1993 оны 7-р сарын 8-ны "Монгол улсын хууль"-иар БНМАУ-ын Эрүүлийг хамгаалах хуулийн 3-р зүйл, 4-р зүйлийн 5 дахь заалт тус тус хүчингүй

болсонд тооцогдож, 6-р заалтын 2 дахь хэсгээс "үнэ төлбөргүй" гэсэн үг хасагдаж УИХ-ын 1993.07.15-ны 64 дүгээр тогтоолоор "Монгол Улсын иргэдийн эрүүл мэндийн даатгалын хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээ" батлагдан хэрэгжиж байгаа болно.

УИХ-ЫН ГИШҮҮН АКАДЕМИЧ Б. ДЭМБЭРЭЛ

ИРГЭДИЙН ЭРЭЛТ ХҮСЭЛТИЙГ СОНСОХОД

Манай ард иргэд төрийн эрх барих дээд байгууллагад хандсан санал хүсэлтээ гол төлөв бичиг, захидлаар ирүүлж байгаа боловч өөрийн биеэр ирж уулзах буюу утсаар илэрхийлэх нь цөөнгүй байна.

Энэ оны 9 дүгээр сарын байдлаар УИХ, түүний Тамгын газар 1162 иргэдийн 1390 санал гомдол, эрэлт хүсэлтийг хүлээн авч барагдуулсны 50,3 хувь буюу 585 иргэд хүлээн авах байраар ирж, 645 санал хүсэлт гаргажээ.

Санал хүсэлтийн байдлаас үзэхэд манай иргэд төрийн эрх барих дээд байгууллагад хандаж чуул-ганаар хэлэлцэж байгаа хуулиас эхлээд одоо дагаж мөрдөж буй хуулийн заалттай холбогдсон болон төр, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжийн албан тушаалтны үйл ажиллагааны талаар, тэрчлэн улс төр, эдийн засаг, нийгмийн олон асуудлыг хөндсөн эрэлт хүсэлт тавьж уулзсан байна.

Эрэлт хүсэлтийг утгаар нь ангилан тоймловол хүлээн авч уулзсан нийт иргэдийн 6,4 хувь буюу 38 нь амьжиргааны доройтлыг гэтлэн давах, 3,2 хувь буюу 19 нь сахилга, дэг журмыг бэхжүүлэх, архидан согтуурагчидтай хийх тэмцлийг чангатгах, 4,1 хувь буюу 24 нь хууль дүрмийн хэрэгжилт хангалтгүй, биелэлтэд нь тавих хяналт муу, зөрчил гаргагчдад хүлээлгэх хариуцлага сул байгааг шүүмжилж, хариуцлагыг чангатгах талаар эрэлт хүсэлт гаргасан байна. Ард иргэдээс гаргаж байгаа эрэлт хүсэлтийн дотор УИХ-ын дарга, дэд дарга, гишүүдтэй биечлэн уулзах хүсэлт багагүй хувийг эзэлж байна.

Оны эхний 9 сард УИХ-ын дарга, гишүүдтэй 294 иргэд уулзах хүсэлт гаргасны 47,2 хувь буюу 139 нь биечлэн уулзаж санал хүсэлтээ илэрхийлжээ. (Зөвхөн хүлээн авах байраар) Мөн энэ хугацаанд чуулганы нээлттэй хуралдааны ажиллагаатай танилцах гэсэн 46 иргэдийн хүсэлтийг биелүүлсэн байна.

Хүлээн авах байраар ирж байгаа санал, хүсэлт, гомдлын дийлэнх нь дээр дурдсан чиглэлийн эрэлт хүсэлт эзэлж байгаа боловч чуулганаар хэлэлцэх хуулийн төсөлд мөн батлагдан гарсан хуулиудтай холбогдсон олон арван санал хүлээн авч байна.

Зөвхөн Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн төсөл боловсруулах, хэлэлцэх үеэр энэ хуулийн төсөлтэй холбогдуулан 21 иргэд 40-өөд санал гаргажээ. Тэрчлэн "Газрын хууль", "Эрүүгийн хууль", "Архидалт, дангаар ноёрхлын эсрэг", "Гадаадын хөрөнгө оруулалтын хууль"-ийн төслүүдтэй холбогдсон санал хүсэлт цөөнгүй байна.

Эдгээр санал хүсэлтээс заримыг дурдвал Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны иргэн Цэрэнбямбаа "Цагдаагийн хууль", "Дангаар ноёрхолын эсрэг" болон "Цагдаагийн байгууллагын тухай хууль" нэн шаардлагатай байгааг дурдаад, газрыг гадаадын иргэдэд 100 жилээр ашиглуулах тухай заалт хуульд орж байгааг эсэргүүцэж, газрыг гадаадын иргэдэд богино хугацаатай түрээсээр ашиглуулах, хугацааг сунгаж болохоор заах, цагдаагийн ажилтны эрх мэдэл, нийгмийн баталгааг интерполийн гишүүн орны цагдаагийн байгууллагын ажилтны хэмжээнд хүргэж баталгаажуулах, илрүүлсэн гэмт хэргийн улс нийгэмд учруулсан хохирлын байдлыг харгалзан тэдэнд олгох шагнал, урамшлыг хуульчлан зааж өгөх тухай санал гаргасан байна.

Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны иргэн С. Чимиддорж, Сонгинохайрхан дүүргийн 39 дүгээр хорооны иргэн Ц. Олзвой, Баянзүрх дүүргийн 15 дугаар хорооны иргэн Лхамсүрэн нар "Тэтгэврийн болон тэтгэмжийн хууль, хүн амын орлогын албан татварын хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах, мөн Хан-Уул дүүргийн 2 дугаар хорооны иргэн Нямдаваа цэргийн хугацаат албан хаагчид цэргээс халагдаж ирээд урьд ажиллаж байсан газартаа ажиллах баталгаагүйгээс ажилгүй болж хохирч байгааг анхаарч ажлын нь байрыг цэргийн алба хаах хугацаанд хадгалж байх заалтыг "цэргийн үүргийн тухай"буюу "Хөдөлмөрийн хуульд" оруулж өгөх, Баянзүрх дүүргийн 4 дүгээр хорооны иргэн Г. Цэрэндорж, Сүхбаатар дүүргийн 16 дугаар хорооны иргэн Мөнхдалай, Чингэлтэй дүүргийн 18 дугаар хорооны иргэн Н. Жадамбаа нарын олон иргэд архидан согтуурах явдал газар авч нийгмийн хэв журам, иргэдийн амгалан тайван байдал алдагдаж, ард иргэд согтуучуудаас айж амгалан явж чадахгүйд хүрч байгаа тухай ярьж, хатуу заалттай хууль гаргаж өгөхийг төрийн эрх барих дээд байгууллагаас хүсчээ.

Ард иргэдийн санал, хүсэлтээс үзэхэд үнийн өсөлтийг дагаж бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар сайжрахгүй байгаад болон өдөр тутмын өргөн хэрэглээний хүнсний бараагаар таслах, зохи-

...ол хомсдол бий болгож, хүнсний зарим барааг (талх, ундаа, ...зайрмаг, нарийн боов гэх мэт) дэлгүүрээс авч өндөр үнээр дамлах, ...засаг захиргааны анхан шатны болон аж ахуйн нэгж, худалдаа, ...үйлчилгээний зарим хүмүүсийн шударга бус, хариуцлагагүй байд-...лаас олон түмэн хохирч байгаад бухимдсан санал хүсэлт их гарч ...байна.

Яам, албан газар, аймаг, хот, сум, дүүргийн засаг дарга, түүний ...Тамгын газар эрх хэмжээнийхээ дагуу хянан шийдвэрлэх асуудлыг ...ургэд олон тавьж ирдэгээс үзэхэд эдгээр газар хөдөлмөрчидтэй ...байнга тодорхой ажиллаж тэдний санал хүсэлтийг шуурхай ...шийдвэрлэж байх нь чухал байна.

Ц. ДАШПЭЛЖЭЭ — **УИХ-ын ТАМГЫН ГАЗРЫН ЗАХИДАЛ ХАРИЛЦААНЫ ХЭСГИЙН ЗИХИОН БАЙГУУЛАГЧ**